

# АРДЧИЛЛЫН ТЭМЦЭЛ СОРИЛТЫН ЖИЛҮҮДЭД: МОНГОЛ БА ДЭЛХИЙН УЛС ОРНУУД ТУРШЛАГАЖИЖ ЭХЭЛСЭН НЬ

Эмхэтгэсэн Кристиан Сүтэр, Стевен Броун,  
Алдарын Долгион, Чүлтэмсүрэнгийн Тамир





Ардчиллын тэмцэл сорилтын жилүүдэд:  
Монгол ба Дэлхийн улс орнууд туршлагажиж  
ЭХЭЛСЭН НЬ

Эмхэтгэсэн Кристиан Сүтэр, Стевен Броун,  
Алдарын Долгион, Чүлтэмсүрэнгийн Тамир

Эх бэлтгэл: Фотокрафт ХХК  
Дизайнер: Батбаярын Жавхлан

Зохиогчийн эрх © 2022 World Society Foundation ба  
IRIM Хараат бус судалгааны хүрээлэн

Хэвлэсэн: World Society Foundation, c/o Cultur Prospectiv, Stadelhoferstrasse 26, CH-8001 Zurich, Switzerland.  
IRIM Хараат бус судалгааны хүрээлэн, Монгол Улс,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо,  
Pro One Building, 1503 тоот.

Эх хувилбарыг Англи хэл дээр боловсруулав. Ном зүй:  
Christian Suter, Stephen Brown, Dolgion Aldar and Tamir  
Chultemsuren (eds). 2021. *Democratic Struggles in Chal-  
lenging Times: Insights from Mongolia and Around the World.*  
Ulaanbaatar: WSF/IRIM. Монгол хэл рүү орчуулгыг:  
Дашнямын Сэнгэлмаа, Дэмидийн Ганхуяг, Бүмбэйгийн  
Дашням нар гүйцэтгэв.

ISBN 978-9919-0-0190-2 (хэвлэмэл)  
ISBN 978-9919-0-0191-9 (цахим)

Номын цахим хувилбарын холбоос:  
[irim.mn/conference/1903](http://irim.mn/conference/1903)

DOI: 10.54520/i18070912

Жон Хопкинс Их Сургуулийн Хэвлэлийн зохиогчийн  
эрхийн мэдэгдэл. Fish, M. Steven and Michael  
Seeberg. "The Secret Supports of Mongolian Democracy."  
*Journal of Democracy* 28:1 (2017), 129-143.

©2017 National Endowment for Democracy and Johns  
Hopkins University Press. [Стивен Фиш, Майкл Сийберг  
нарын "Монголын ардчиллыг тэтгэгч далд хүчин  
зүйлс", *Ардчиллын Сэтгүүл* 28:1 (2017), 129-143.

© 2017 National Endowment for Democracy and Johns  
Hopkins University Press]. Жон Хопкинс Их Сургуулийн  
Хэвлэлийн зөвшөөрлөөр дахин хэвлэв.

Монгол Улс, Улаанбаатар хотод хэвлэв

---

## Агуулга

Дэлхийн нийгмийн сангийн тухай	v
Өмнөх үг ба талархал	vii
Оршил: Ээдрээтэй он жилүүдэд ардчиллыг судлах нь <i>Стевен Броун</i>	1
<b>Хэсэг I—Монгол Улс дахь ардчилал</b>	9
1 Монголын ардчиллыг тэтгэгч далд хүчин зүйлс <i>Стевен Фиш, Майкл Сийберг</i>	11
2 Социализмын дараах үеийн Монголын иргэний <i>Далайбуяны Бямбажав</i>	31
3 Монголын ардчилал: Үндсэн сорилт ба хэтийн боломж <i>Ойдовын Хатанболд</i>	53
4 Монголын ардчиллын өдөр тутмын дүр зураг: Улаанбаатар хотын гэр хороололд амьдрах хугацаандаа ардчиллын үйл явцыг антропологийн үүднээс судалсан нь <i>Элизабет Фокс</i>	75
<b>Хэсэг II—Ардчиллын тэмцлийн талаар харьцуулсан судалгаа ба байгалийн нөөцийн үүрэг</b>	95
5 Зүүн өмнөд Азийн байгалийн нөөцийн менежмент: Авлигатай тэмцэх, хууль сахиулах болон үр ашигт тулгарч буй сорилтууд <i>Андреа Хэфнер</i>	97

6	Өөрчлөлтийн мөч үү? Орлогын сөрөг цочрол ба дэлхийн улс орнуудын улс төрийн дэглэмийн өөрчлөлт <i>Увшийн Дэлгэржаргал</i>	113
7	Байгалийн баялгийн ашгаараа сонгуулийн санал худалдан авах нь: Эдийн засгийн популизм ба байгалийн баялгаас хамааралтай ардчилсан орнууд дахь клиентелизм <i>Самбуугийн Болдсайхан</i>	135
8	Ардчилах үйл явцад олон улсын харилцааны, үзүүлсэн нөлөөлөл, 1972–2005 <i>Матиас Де Роек, Ронан Ван Россем</i>	167
9	Каталоны 10 сарын 1-ний ардчиллын төлөөх тэмцэл <i>Нурия Суэро Комеллас</i>	205
	Ном бүтээхэд хувь нэмрээ оруулагчид	227

---

## Дэлхийн Нийгмийн Сангийн тухай

Дэлхийн Нийгмийн Сан (ДНС) байгууллагыг Питер Хайнз дэлхийн нийгэм, түүний ойлголтыг тодорхойлох, түүхэн хөгжил, бүтэц, хөдөлгөөн хийгээд одоогийн өөрчлөгдөж буй үйл явцын талаарх судалгааг дэмжих зорилгоор 1982 онд үүсгэн байгуулсан билээ. Энэхүү сангийн тэтгэлгүүдийн үндсэн зорилго нь 2003 он хүртэл дэлхий дахины тогтолцоо, тэр дундаа соёл, эдийн засаг, улс төр, улс орнуудын засгийн газар хоорондын тогтолцоон дахь нийгмийн нэгдэл, задралын олон янзын үйл явц хийгээд тэдгээрийн талаарх дэлхийн хүн ам, оролцогч талуудын тухай ойлголт, үйл хөдлөлд хэрхэн нөлөөлж буй талаарх өргөн хүрээтэй, цогц судалгааны төслүүдийг санхүүжүүлэхэд оршиж байв. Харин өнөөгийн дэмжлэг, санхүүжилтийн бодлого нь эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд зориулсан тэтгэлэгт хөтөлбөр хийгээд “дэлхийн нийгмийн” сэдвийн хүрээнд олон улсын хурал зохион байгуулахад чиглэж байна. Энэхүү шинэ бодлогын хүрээнд “ДНС Шагнал”, “Дэлхийн нийгэм” сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг шалгаруулж байна. Мөн үндэстэн дамнасан, дэлхийн судалгааны сэдвийг хөндөж буй тэргүүлэх эрдэмтдийн сүлжээ, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор олон улсын цуврал хурлыг зохион байгуулсаар ирсэн. DNS нь “Дэлхийн нийгэм судлал” хэмээх цуврал номыг хэвлэн гаргадаг бөгөөд Швейцар улсын Цюрих хотод байрладаг. Одоогоор уг сангийн удирдах зөвлөлийн гишүүнээр Волкер Борншер, Марк Херкенрат, Ханс-Петер Мэйр ба Кристиан Сүтер (Ерөнхийлөгч) нар ажиллаж байна. Өмнө нь, Питер Хайнз, Карл В. Датч, Ханс-Жоаким Хоффман-Новотни, Бруно Фритч нар удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байжээ. Та бүхэн, 2007-2019 оны хооронд тэтгэлэг авсан судлаач, судалгаа шинжилгээний ажил, DNS-ийн цуврал бүтээл “Дэлхийн нийгэм судлал”, мөн сүүлд зарлагдсан хурал хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний өгүүллийн шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, тус сангийн албан ёсны цахим хуудас болох [www.worldsociety.ch](http://www.worldsociety.ch) –д хандах боломжтой юм.





---

## Өмнөх үг ба талархал

Монголын ардчилсан тогтолцооны гучин жилийн ой, түүхэн чухал үе 2019 онд тохиов. Хүний амьдралаар бол монголын ардчилал дөнгөж сургуулиа төгсөөд ажил амьдралын гараагаа эхлээд байгаа насныхан. Өргөн тархсан даяаршил ба эргэн сэргэсэн үндэсний үзэл хоёрын дунд өөрийн сонголт хийх зам мөрийг эрж хайн тэмцэгч, Монголын нийгэм нь харьцангуй өндөр боловсролтой ч туршлага багатай, бүрэн торниогүй нэг үеийнхний нийгэм юм. Коммунист засаглалтай болсон дэлхийн хоёр дахь орон, мөн коммунизмаас чөлөөт ардчилсан нийгэмд шилжин орсон Азийн анхны улс гэдгээрээ дэлхийн нийтийн анхаарлыг татаж, бахархлыг хүлээдэг билээ.

Ардчиллын үйл явц нь дэлхий нийтээр үндсэрхэг ба шашны явцуу итгэл үнэмшил зэрэг шинэ сорилттой тулгарч байна. Ийм цаг үед IRIM Хараат бус судалгааны хүрээлэн нь Швейцарын “Дэлхийн нийгмийн сан”-тай хамтран (ДНС) “XXI зууны ардчилал: Сорилтууд ба цаашдын хандлага” сэдэвт олон улсын хурлыг 2018 оны 7 дугаар сарын 9-10-ны өдөр Монголын уламжлалт наадмын өмнөхөн, Улаанбаатар хотод, хуучны хэв загвар бүхий Улаанбаатар зочид буудалд зохион байгуулсан билээ. Хамгийн ачаалалтай жуулчлалын үед энэ ажлыг зохион байгуулах нь амархан биелүүлчих даалгавар биш байлаа.

Уг хурал ардчиллын үйл явцын өнөөгийн байдлыг үнэлж, энэ талаарх ойлголтыг нэгтгэж, шинэ мэдлэгийг бий болгох зорилготой байв. Нийт 15 орны 34 эрдэмтэн судлаачид “Ардчилал”-ын сэдвээр дагнан илтгэл тавьж, 14 судлаач бүрэн тэтгэлэг, 4 судлаач олон улсын аяллын тэтгэлэг тус тус авсан юм. Хурлыг “Хот-хөдөөгийн ялгаа ба ардчилал”, “Иргэний нийгэм ба ардчилал”, “Олборлох эдийн засаг, нөөц баялаг ихтэй улс орнууд ба ардчилал” гэсэн гурван дэд сэдвийн хүрээнд онцлон зохион байгуулав. Түүнчлэн, уг хурал нь энэ чиглэлийн анхны бие даасан судалгааны хүрээлэн, мэдлэгийн төв болж чадсан Хараат бус судалгааны хүрээлэнгийн арван жилийн ойтой давхацсанаараа бэлгэдэлтэй байлаа. Тус хүрээлэнгийн зорилго нь монголын мэдлэгийн үр шим, зөвлөх үйлчилгээг дэлхийд гаргахад гүүр болох явдал юм.

Өнөөдөр бид, хурлаар хэлэлцсэн олон улсын болон дотоодын илтгэлүүдээс шигшин түүвэрлэж, DNS-аас эрхлэн гаргадаг “Дэлхийн

нийгмийн судалгаа” цуврал бүтээлд монгол, англи хэлээр нийтлэн гаргаж байна. Илтгэлүүдийг хоёр хэлд буулган хэвлэж байгаа тул их дээд сургууль, хэвлэл мэдээллийн байгууллага, ахмад, залуу судлаач, төрийн бус байгууллагын идэвхтэн, төрийн албан хаагч гээд хэн бүхэнд хүртээмжтэй байх болно. Энэхүү төсөл нь швейцар ба монголын судлаачдын монголын ардчиллын “эмзэг” туршлагыг Швейцарын шууд ардчиллын “хур” их туршлагатай хослуулсан хамтын ажиллагааны санаачилгаас эхтэй бөгөөд анх төлөвлөснөөс хойш хэвлэгдэх хүртэл бараг гурван жилийг үджээ.

Юуны түрүүнд, уг хурал болон хэвлэлийн бүхий л зардлыг санхүүжүүлсэн ДНС байгууллагад гүнээ талархаж байна. Мөн хурлыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг олгосон Швейцарын хөгжлийн агентлагт талархал илэрхийлье.

Хурлын нээлтэд, Швейцарын Элчин сайд Жан Жак де Дардел (Jean-Jacques de Dardel) “Хоёр улс ардчиллын өмнө тулгарч байгаа ижил асуудлаа хуваалцаж” байгааг тэмдэглээд, цаашид ардчиллын боловсролыг сайжруулах шаардлагатай гэсэн санааг дэвшүүлсэн. Монголын Гадаад харилцааны сайд хатагтай Б.Батцэцэг ардчиллыг хөгжүүлэхэд олон талын оролцоо чухал болохыг онцолсон бол, Хууль зүйн дэд сайд асан, УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Монголын төрийн бус байгууллага (ТББ)-дын эрх зүйн зохицуулалтын талаар илтгэл тавьсан нь оролцогчдын дунд сонирхолтой хэлэлцүүлэг болж өрнөсөн юм. Хурлыг нээж, үг хэлсэн эдгээр төлөөлөгчид талархал илэрхийлье.

Хуралд үндсэн илтгэгчээр уригдан оролцсон АНУ-ын Калифорнийн Их Сургуулийн профессор Стевен Фиш (Steven Fish), Монголын Улс төрийн боловсролын академийн захирал, доктор Д.Ганбат, Австралийн Гриффетийн их сургуулийн Олон улсын бизнес - Ази судлалын профессор Тапан Саркер (Tapan Sarker) нарт тун их талархаж байна.

Энэхүү оюуны гол ажлыг хийсэн Эрдмийн зөвлөлийн гишүүд болох “Дэлхийн нийгмийн сан”-гийн Ерөнхийлөгч, доктор Кристиан Сутер, IRIM-ийн ТУЗ-ийн гишүүн А.Долгион, Удирдлагын академийн “Удирдахуйн ухаан”-ы сургуулийн захирал, дэд профессор Я.Бямбасүрэн, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор О.Хатанболд, IRIM-ийн ТУЗ-ийн дарга, МУИС-ийн багш, доктор Ч.Тамир нарт талархал илэрхийлье.

Мөн, ДНС-ийн Гүйцэтгэх захирал Кристиан Сутер, хуралд илтгэгчээр оролцсон Оттавагийн Их сургуулийн доктор Стевен Браун болон А.Долгион, Ч.Тамир нар эмхэтгэх, хянах ажлыг хийв. Өгүүллүүдийг англи, монгол хэлнээ хянан тохиолдуулж ажилласан дээр нэрлэсэн хүмүүст талархаж байна. Хурал болон энэхүү бүтээлийг хэвлүүлэх хүнд хүчир

ажлыг чадварлагаар зохион байгуулсан Д.Эрдэнэцэцэгийн хувь нэмрийг тун их үнэлж байна.

Энэ бүхий л үйл явцад IRIM-ийн арав гаруйхан жилийн туршлага, ур чадвар нимгэдэж байсан ч, Швейцарын талын халуун дэмжлэг, уйгагүй тэвчээрийн ачаар бид хамтдаа энэ томоохон ажлын ард гарсан билээ. Зохион байгуулах зөвлөлийн гишүүд болох Д.Нарантуяа, IRIM хүрээлэнгийн гүйцэтгэх захирал асан Ц.Батсугар, үйл ажиллагаа хариуцсан захирал асан Н.Минжирмаа, судлаач Э.Цэрэндорж, зөвлөх, ТУЗ-ийн гишүүн Ц.Болд нарын цөхрөлтгүй хөдөлмөрт талархъя.

Түүнчлэн, хурлын үндсэн санаа, дизайныг боловсруулахад чухал хувь нэмэр оруулсан Л.Булганыг дурдах хэрэгтэй. Уг хуралд оролцож, хэвлэлд өгүүлээ ирүүлсэн бүх зохиогчдод, орчуулагч Д.Сэнгэлмаа, Д.Ганхуяг, Б.Дашням нарт ихээр талархаж байна.

Эцэст нь, олон улс туршлагаа хуваалцсан энэхүү бүтээлийг та бүхний өмнө өргөн барьж байгаадаа баяртай байна. Энэхүү хурал ба түүгээр хэлэлцсэн бүтээлүүд нь өнөөдрийн ардчиллын үйл явцад тулгарч байгаа сорилтод тодорхой шийдлийг гаргаж, олон улсын туршлагыг Монголын тал нутгийн хэтийн төлөвтэй нэгтгэн, хамтын хүчин чармайлтыг харуулахад тусална гэж найдаж байна.

IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч, Элчин сайд, доктор Хасбазарын Бэхбат.



---

**Оршил:**

## **Ээдрээтэй он жилүүдэд ардчиллыг судлах нь**

**Стивен Броун**

### **Ардчилагдах үйл явц ба ардчилал судлалын чиг хандлага**

Ардчиллын үйл явцын чиг хандлага давалгаа байдлаар явагддаг. Хамгийн сүүлийн, томоохон давалгаа нь 1989-1990 онд хуучин социалист орнууд, үүний тоонд Төв болон Зүүн Европ төдийгүй, Монгол Улсад эхэлснээр, Коммунист намын удирдан чиглүүлж байсан улс төрийн тогтолцоо, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас татгалзаж, улс төр, эдийн засгийн либералчлалыг угтан авсан юм. Энэ цаг үетэй давхцан, Африкийн Сахарын бүс нутгийн улс орнууд олон намын системд шилжиж, сонгууль зохион байгуулж байв. Гэсэн хэдий ч, эдгээр орон бүгд ардчилалд шилжиж чадаагүй юм. Хосолмол, эсвэл хагас авторитари улс төрийн тогтолцоотой орнуудын удирдагчид өөрсдийгөө дахин төрсөн ардчилагч хэмээн тунхаглан, шударга, чөлөөт өрсөлдөөний шалгуурт нийцээгүй сонгуулийг санаатайгаар зохион байгуулж, ялагдлаас мултарч байв. Тэд улс төрийн тогтолцоог либералчилсан ч, эрх мэдлээ алдах эрсдэл хүлээх хэмжээнд чөлөөлөөгүй юм. Харин бусад удирдагчийн хувьд, өөрчлөлт хийхээс татгалзан, эрх мэдлээ хадгалан үлдэх бүхий л хүчин чармайлт гаргаж, зарим тохиолдолд нийтийг хамарсан хүчирхийлэл, цус урсгасан иргэний дайн өдөөж байлаа.

Ардчиллын судалгаа мөн л давалгаа адил өөрчлөгдөж байдаг. Ардчилал үүсэн хөгжих боломжийн талаарх гутранги үзэл 1950, 1960-аад оны үед хөгжиж буй орнуудад давамгайлж байв. Ази, Африкийн колоничлогч улс орнууд өөрийн хяналт захиргаанд байсан орнуудыг орхин гарч тусгаар тогтнол олгохоос өмнө тэдгээр орнууддаа улс төрийн ардчилсан тогтолцоог тогтоосон хэдий ч, энэ тогтолцоо нь удаан үргэлжлээгүй юм. Тухайлбал, энэ цаг үед Латин Америк бүхэлдээ дарангуйлагч авторитари дэглэмтэй болсон юм. Тиймээс академик судалгаанд ардчилал бий болоход бүтцийн урьдач нөхцөл, тодруулбал, эдийн засгийн өндөр түвшний өсөлт, бичиг үсэг тайлагдалт, хотжилт зэргийг багтаан үзэх болжээ (Lipset, 1959). Эрдэмтдийн үзэж байгаагаар, аливаа улс орон ардчиллыг бий болгож, тогтвортой хадгалахын тулд, юуны өмнө барууны либерал ардчиллыг хэд хэдэн салбар чиглэлд ижил

байдлаар хөгжүүлэх хэрэгтэй юм. Харин тэр түвшинд бүрэн хүрэхийн тулд олон үе шатыг дамжих шаардлагатай юм.

Ардчиллын давалгаа 1970-аад оны дунд үеэс дахин үүсэв. Өмнөд Европ (Грек, Испани, Португал) болон Латин Америкийн (Аргентин, Бразил, Уругвай зэрэг) орнуудад удаан хугацаанд тогтож байсан дарангуйлал ээлж дараалан нуран унаснаар ардчилал тогтож эхэлсэн бөгөөд энэ тогтолцоо эдгээр орны заримд нь өнөөг хүртэл оршсоор байна.

Тиймээс эрдэмтэн судлаачид ардчиллын давалгаа тэдний төсөөлсөн шиг хатуу тогтсон, урьдач нөхцөлийн дагуу явагддаггүй болохыг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй болсон. Тэд, “гүн гүнзгий” бүтцэд төвлөрөхөөс илүүтэйгээр юу ч, хаана ч тохиож болох “санаандгүй” тохиолдлыг онцолж эхэлсэн. Ингэхдээ тухайн улс төрийн дэглэмийн үр дүн нь авторитари тогтолцооноос шилжилт хийхээр хэлэлцэн тохиролцож буй элит талуудын стратегийн хариу үйлдлээс хамаардаг хэмээн үзэх болов (O'Donnell and Schmitter, 1986).

Хүйтэн дайны төгсгөлийг дагаж үүссэн ардчилсан хөдөлгөөний олон тооны жишээ нь судлаачдад энэ чиглэлээрх үл тоомсорлосоор ирсэн хүчин зүйл болох олон улсын нөхцөл байдлыг судлахын чухлыг харуулжээ. Энэ үйл явдал нь ардчилал гарцаагүй бөгөөд зогсолтгүй тархана гэсэн үзэл бодол давамгайлахад хүргэсэн. Гэвч, удалгүй өнгөц тогтсон ардчилсан институцийн цаадах авторитари дэглэм ил гарч эхлэхэд, энэхүү өөдрөг үзэл нь талаар болжээ. Хуучин коммунист, нэг нам залан чиглүүлдэг төрийн албатууд эрх мэдлээ хадгалж үлдэх, эсвэл эргүүлэн олж авснаар өөрсдөд нь ямар нэг аюул, сорилт тулгарахгүй байх нөхцөлөө баталгаажуулж эхлэв. Өнөөг хүртэл тогтсон тэдний эрх мэдлийн монополыг эсэргүүцэх олон нийтийн хөдөлгөөн бүс нутагт тархан 2000-аад оны эхээр хуучин ЗХУ-ын улс орнууд (Гүрж, Киргизстан, Серби болон Украин зэрэг) дахь эрх баригч элитүүдийн эсрэг тэмцэл болох “өнгөт хувьсгал” болон түгж ирсэн юм.

Үүнтэй зэрэгцэн, ардчилагдах үйл явцыг судлах судлаачид ийнхүү өөрчлөгдөж буй улс төрийн нөхцөл байдалд дасан зохицох шаардлага үүссэн юм. Учир шалтгааныг хялбаршуулан тайлбарлах загвар нь цаашид тохиромжгүй нь тодорхой болж эхлэв. Хувь хүмүүсийн үйлдэл мэдээж өөрийн гэсэн ач холбогдолтой ч, өргөн хүрээний авлигыг өөгшүүлж, зарим тохиолдолд ардчилалд саад тотгор болсон ашиг хайгч төрийг санхүүжүүлэх боломж олгодог байгалийн баялаг зэрэг шинж бүтцийн чанар чухал аж. Онолын үндэслэл гаргахад хэд хэдэн хүчин зүйлсийг нэгтгэх шаардлагатай болсон. Үүнд, үзэл санааны тархалт, бусад орны туршлагаас суралцах, нийтийн дайчилгаа (мобилизаци) хийхэд ашиглагддаг тактик (жишээ нь нийгмийн сүлжээний хэрэглээ), мөн олон улсаас үзүүлэх нөлөөлөл (шууд дарамт шахалт, шууд бус холбоо сүлбээ...) зэрэг хүчин зүйлсийг дурдаж болно. Ардчиллын өмнөх

тогтолцооны нөхцөл байдал зэрэг ардчилалд нөлөөлөгч хүчин зүйлсийн тоо нэмэгдэхийн хэрээр судлаачдын зүгээс ардчиллын нийтлэг, түгээмэл онолыг боловсруулах оролдлого хийх нь багасжээ. Харин, ардчиллын судалгаа олон чиглэлд салбарлаж, эрдэмтэн судлаач бүр өөр өөрийн сонирхлын хүрээнд оролцогч талууд, хувьсагчууд, өөрчлөлт хэрхэн бий болдог талаарх үзлийг дагнан судалж, өргөн хүрээний тоон ба чанарын арга зүйг ашиглах болжээ.

Улс төрийн орчин нөхцөл сүүлийн жилүүдэд улам ээдрээтэй болж байна. Дэлхийн хамгийн ардчилсан бус бүс нутаг болох Ойрх Дорнод, Хойд Африкийн хэд хэдэн оронд 2011 оны “Арабын хаврын” үеэр томоохон хөдөлгөөн өрнөсөн хэдий ч, ардчиллыг тогтоох чиглэл нь бүрэн хаягдаж, зарим орон, ялангуяа Сири улс улам доройтсон нь бүс нутаг, улмаар үүнээс ч гадагшаа асар их сөрөг нөлөөлөл үзүүлж, ялангуяа дүрвэгчдийн урт цуваа Европыг зүглэж, гадаадынхныг үзэн ядах (xenophobia), исламын шашныг үзэн ядах (islamophobia) болон тусгаарлалтыг дэмжсэн үзлийг улам дэвэргэх болжээ. Орос, тэр дундаа Хятад зэрэг улс орон дэлхий даяарх авторитари дэглэмд дэмжлэг үзүүлж, ардчилсан хөдөлгөөнийг нухчин дарахад нь туслах болжээ. Оросын зүгээс Европын орнууд, АНУ-д ардчиллыг бүрхэгдүүлэхээр зохион байгуулалттайгаар оролдож байгаа бол, Хятадын зүгээс Африк, Азийн авторитари дэглэм, ноёлогч улс төрийн хүчнүүдэд дэмжлэг үзүүлэхүйц их хэмжээний зээл олгох, хөрөнгө оруулалт хийх, тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээг авч байна. Түүнчлэн, хэдэн арван жилийн турш тасралтгүй эдийн засгийн өсөлтийг хангасан амжилтыг тогтоосон авторитари дэглэмтэй орон болохынхоо хувьд Хятад улс, эдийн засгийн хөгжил нь ардчилалд хөтөлдөг, мөн ардчилсан чөлөөт байдал нь урт хугацааны эдийн засгийн өсөлтийн бат бэх тулгуур болдог хэмээх хуучин нотолгооны эсрэг загвар, жишээ болж байна.

Уламжлалт улс төрийн намуудын нэр хүнд буурч, популизм дахин сэргэсэн нь ардчиллын бат бэх суурьтай гэгдэж байсан Европ, АНУ-д ч тогтворгүй байдлыг бий болгож, тэрхүү бат бэх байдлыг нь сорих болжээ. Дэлхий дахинд олон нийтийн улс төрийн институцид итгэх итгэл, сэтгэл ханамж бууран, нийгмийн тэгш бус байдал даамжирч, тэр ч байтугай өсөн нэмэгдэж буй нь ардчиллыг хүсэмжлэх хүмүүсийн итгэлийг хөсөрдүүлэх болжээ. Дэлхий даяар авторитари дэглэмүүд нь хуульт засаглалыг үл тоомсорлож, олон улсын дэг журмыг тогтворгүйтүүлэх болов. Өнгөрөгч 10 гаруй жилийн туршид ардчилал нь “ухралтын” байдалтай байж иржээ (Freedom House, 2019). Ийнхүү ардчилал нь бодит сорилтын цаг үед ирээд байна.

## Өгүүллүүдийн тойм

Энэхүү номд сорилтын үе дэх ардчиллын үйл явцыг тал бүрээс нь судалсан мэргэжил, карьерын өөр өөр түвшинд яваа олон орны эрдэмтэн судлаачийн судалгааны бүтээлийг нэгтгэсэн юм. Тэд судалгаандаа өөр өөр арга зүй, хандлагыг ашигласан нь энэхүү бүтээлийг бие биеэ нөхсөн цогц шинжтэй болгожээ. Эдгээр өгүүлэлд бүхнийг өөртөө агуулсан ямар нэг нэгдсэн, нийтлэг онол боловсруулах оролдлого хийгээгүй, харин ардчиллын бага судлагдсан тэрхүү хэсгүүдэд анхаарал хандуулж олон өнцгөөс судалсан аж.

Энэхүү ном нь хоёр хэсгээс бүрдсэн. Нэгдүгээр хэсэг нь Хүйтэн дайны дараах ардчилах үйл явцын хамгийн бага судлагдсан жишээнүүдийн нэг, Монгол Улсад явагдсан ардчилалд шилжих үйл явцыг авч үзнэ. Хэдийгээр Монгол дахь ардчилах үйл явцын талаарх судалгаа цөөн ч, авлигын түвшин өндөр хэмжээнд хүрсэн (Fritz, 2007), уул уурхайн салбараас хэт хамааралтай байхын улс төрийн нөлөөлөл (Bulag, 2009), ардчиллын урьдач нөхцөл (Fish, 1998; Fritz, 2002) ба ардчиллын улс төрийн соёлын үндэс дутмаг байдал (Sabloff, 2002) зэрэг асуудлыг судалгаанууд онцолж байна. Эдгээр судалгаанд хоёр түгээмэл сэдвийг давтан дурддаг ба эдгээрийн ихэнхийг ардчилсан шилжилтийн дараах арван хоёр жилд бичжээ. Эхний сэдэв нь Орос, худалдааны хувьд өндөр хамаарал бүхий Хятад гэсэн хоёр улсын дунд хавчуулагдсан Монгол орон ардчиллыг хэрхэн хөгжүүлж буй талаар, хоёр дахь нийтлэг сэдэв нь Монголын ардчиллын ололт амжилт ямар хэврэг болохыг тусган харуулжээ. Нэгдүгээр хэсэгт багтсан бүлгүүдэд ардчиллын үйл явц хэрхэн тэсэн үлдсэн тухай, түүний сул тал, тулгарч буй аюулуудыг онцолсон. Эдгээр бүлэг нь өмнө хийгдсэн судалгаа шинжилгээг гүнзгийрүүлж, хамрах хугацааг 20 гаруй жилээр өргөжүүлсэн юм.

Эхний бүлэгт “Ардчиллын сэтгүүл”-д (Journal of Democracy) анхлан нийтлэгдэж байсан **Стивен Фиш** (M. Steven Fish) болон **Майкл Сийберг** (Michael Seeberg) нарын 2016 онд Монгол Улсад болсон сонгуулийн талаарх шинжилгээг танилцуулсан. Хэдий зарим нэг хүндрэл бэрхшээлтэй тулгарч байсан ч, тухайн үеийн сонгууль чөлөөтэй, шударга болж, Монгол Улсад үүсэн тогтсон ардчилал 25 дахь жилдээ тогтвортой явж ирснийг харуулжээ. Геополитикийн орчин ээлтэй бус, хөгжлийн хурдац удаан, өөр бусад олон саад бэрхшээлийг үл харгалзах энэхүү амжилтын гол үндэслэл юу байж болох вэ? Улс төрийн намууд нь эрх мэдлийн шилжилтийг хүлээн зөвшөөрч буй явдал үүнд хамаарах хариултын нэг хэдий ч, судлаачдын зүгээс Монгол дахь хүчирхэг иргэний нийгэм гол үүрэг гүйцэтгэж буй талаарх санааг дэвшүүлжээ. Иргэний нийгмийн байгууллагууд нь төр болон улс төрийн үйл явц тогтсон хэм хэмжээ, дүрэм журмыг даган мөрдөх “хоточ нохойн” үүргийг гүйцэтгээд



зогсохгүй, ил тод байдлыг хангах, эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах, тухайлбал, уул уурхайгаас үзүүлж буй сөрөг нөлөөллийн эсрэг арга хэмжээ авах зэрэг шинэчлэл хийхийг шаарддаг ажээ. Гэсэн ч Монгол дахь ардчилал эмзэг, ялангуяа олборлох салбараас хэт хамааралтай хэвээр буй нь авлигыг өөгшүүлж, үндэстэн дамнасан хүчирхэг компаниудын дарамт шахалтад орох болсныг цохон тэмдэглэжээ.

Дараагийн бүлэгт, судлаач **Далайбуяны Бямбажав** Монгол Улс дахь иргэний нийгмийн үүргийг онцолж авч үзэхдээ илүү түүхэн үүднээс ханджээ. Өмнөх бүлэгт иргэний нийгмийн байгууллагуудын ардчилалд үзүүлж буй эерэг нөлөөллийг товойлгосон бол, энэ бүлэгт иргэний нийгмийн байгууллагуудын өөрчлөлт хувьсалд шинжилгээ хийж, тэдний үзүүлж буй нөлөөллийн талаарх илүү гутранги дүр зургийг харуулжээ. Тус бүлэгт 1990-ээд оны үед харьцангуй тайван ТББ-ууд давамгайлж байсан бол, 2000-аад оны эхний 10 жилд нийгмийн хөдөлгөөний олон хэлбэр дэлгэрч эхэлсэн үйл явцыг танилцуулна. Зохиогч энэ үйл явцыг иргэдийн зүгээс Монгол дахь улс төрийн тогтолцоонд сэтгэл ханамжгүй байдал нэмэгдсэнээс үүдэн, эсэргүүцлийн хөдөлгөөн дахин сэргэсэн хэрэг хэмээн тайлбарлажээ. Эсэргүүцлийн хөдөлгөөн нь социализмыг эцэслэж, ардчилалд шилжихэд чухал үүргийг гүйцэтгэжээ. Гэвч нөөц эх үүсвэрийн дутагдалд орсон сөрөг хүчний улс төрийн намуудтай өрсөлдөх болсноор тэд олон нийтийг дайчлах чадамжгүй болж эрх баригч улс төрийн намуудад нөлөөлөх нөлөө нь багассан хэмээн үзжээ.

**Ойдовын Хатанболдын** бүлэгт Монгол дахь ардчиллын нөхцөл байдал, өөрчлөлт хөгжлийг иргэний нүдээр судлан үзжээ. Тэрбээр, олон эх үүсвэрээс авсан тодорхой судалгааны мэдээлэлд үндэслэн, сүүлийн жилүүд дэх улс төрийн тогтолцоог шинжилж, Монгол Улсын нөхцөл байдалд ардчилсан загваруудыг ашиглаж болох боломжтой эсэх талаарх экспертүүдийн үзэл бодлыг тандахын зэрэгцээ иргэдийн төсөөлөлд гарч буй энэ талаарх өөрчлөлтийг судалжээ. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монголын ардчилалд өгсөн экспертүүдийн үнэлгээ хурдацтай буурч буйг тогтоосон байна. Тухайлбал, экспертүүдийн үнэлгээ 1990-2008 оны хооронд өндөр байсан бол, 2012-2016 онд (судалгааг 2016 онд хийсэн) экспертүүдийн 69 хувь нь ардчиллын нөхцөл байдлыг буцаж ухарсан хэмээн үзсэнийг харуулжээ. Улмаар, Монголчууд үндсэндээ ардчиллыг дэмжиж буй ч, ардчилсан институциудад үзүүлэх ерөнхий сэтгэл ханамж буурч буй нь хувийн эрх ашгийг эрхэмлэгч улс төрчид, авлигаас үүдэлтэй болохыг судалгаанд тусгажээ. Ийнхүү Монгол дахь улс төрийн тогтолцоо ихээхэн эмзэг байдалд байна гэсэн дүр зургийг гаргажээ.

**Элизабет Фокс** (Elizabeth Fox) судалгааны бүлэгтээ, хот суурин газруудын анхан шатны түвшинд ардчилал хэрхэн хэрэгжиж буй талаар дүн шинжилгээ хийж, үр дүнг нь тусгасан байна. Нэгдүгээрт, тэрээр

Улаанбаатар хотын орлого багатай, хүн амын ядруу хэсэг оршин суух гэр хорооллын иргэдийн амьдралд хийсэн угсаатны зүйн судалгаанд үндэслэн, улс төрийн намуудын сонгогчдын саналыг худалдан авах оролдлого хийгээд чөлөөт ардчилсан сонголт хийхэд нь хөндлөнгөөс оролцож буй энэхүү үйлдлийг тэд хэрхэн эсэргүүцэж буйг шинжилжээ. Хоёрдугаарт, гэр хороолол дахь нийгмийн харилцаа болон орон нутгаас ирж суурьшсан иргэдийн дунд нийгмийн харилцан уялдаа хомс байгааг задлан шинжилжээ. Гуравдугаарт, ардчилсан төр улсад гэр хорооллын оршин суугчдын гүйцэтгэх үүрэгт үнэлгээ хийж, тэдний шинж чанарыг судлахдаа хоёр эсрэг байр суурийг судалгаандаа хамруулсан. Үүнд, нэг талаас тэднийг хөдөө орон нутгаас том хотуудад шилжиж ирснээрээ асуудал үүсгэгч хүмүүс, нөгөө талаас, тэднийг шилжин суурьшихаас өөр аргагүй байдалд оруулсан нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөхцөл байдлын золиос болох тухайд авч үзсэн. Харин өнөөгийн ардчилсан хуваарилалтын хүрээнд энгийн иргэд тулгарч буй асуудал, сорилтуудтай хамгийн боломжит байдлаар хэрхэн зохицож, шийдвэрлэж буй талаар олон өнгө аястайгаар, тодорхой зураглан гаргажээ.

Номын хоёрдугаар хэсэгт дэлхийн бусад оронд болж буй ардчиллын төлөөх тэмцэлд хийсэн ажиглалт шинжилгээг өргөжүүлэн, энэ чиглэлээрх судалгааг эдийн засаг нь олборлох үйлдвэрлэлийн салбараас бүрэн хамааралтай Монгол, өөр бусад орны хувьд голлох асуудал болоод буй засаглалтай холбон үзжээ. **Андреа Хэфнерийн** (Andrea Haefner) судалгааны бүлэгт Зүүн өмнөд Азийн байгалийн нөөцийн менежмент, байгаль хамгаалалд сөргөөр нөлөөлж буй дотоодын болон олон улсын бүс нутгийн хүчин зүйлсийн харилцан нөлөөллийг авч үзсэн байна. Лаос, Индонез зэрэг улс орны усны нөөц, агаарын чанарын асуудалд төвлөрсөн уг судалгаагаар АСЕАН (Зүүн өмнөд Азийн Улсуудын Холбоо)-ы гишүүн орнууд хэдий дэд бүтцийн төслүүд дээр хамтран ажиллаж байгаа ч, бүс нутгийн хэмжээнд тэдний гаргаж буй хүчин чармайлтыг хэрэгжүүлэх үндэстэн хоорондын байгууллагад эрх мэдэл олгох хүсэлгүй байгааг харуулжээ. Олон хүчин зүйлсийн дундаас авлига, сул хөгжсөн институциуд, эзэн-үйлчлүүлэгчийн (patron-client) харилцаа зэрэг нь засгийн газрууд улс орныхоо байгаль орчныг хамгаалах, өөрийн улсад хийгдэж буй үйл ажиллагаанаас хил дамнан үзүүлж буй нөлөөллийг бууруулах бодлогыг батлан хэрэгжүүлэхээс татгалзах шалтгаан болж байна. Бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь тухайн улсын тусгаар байдал гол саад бэрхшээлийг бий болгодог байна.

Дараагийн бүлэгт судлаач **Увшийн Дэлгэржаргал** байгалийн баялгийн гэнэтийн орлого нь ардчилалд хэрхэн нөлөөлдөг талаарх түгээмэл асуудлыг судлагдахуун болгож, баялгийн орлогын өсөлт, үнэ ханшийн гэнэтийн уналтаас үүдэн гарах нөлөөлөл ямар байх талаарх асуултад хариулт эрэлхийлжээ. Түүний хийсэн статистик шинжилгээ нь 500,000-

аас дээш хүн амтай бүхэл бүтэн улсын өнгөрсөн 55 жилийг хугацааг хамруулсан. Судалгааны гол олдвор нь, хэдийгээр үнийн уналтаас үүдэх цочрол эдийн засгийн хувьд хүндрэл үүсгэдэг ч, ардчилсан орнууд, тэр дундаа газрын тос, байгалийн хийнээс хамаарал бүхий улс орны хувьд ардчиллын индекс, оноог нэмэгдүүлдгийг харуулсан байна. Гэсэн ч уг нөлөөлөл нь нүүрс, металл зэрэг бусад төрлийн байгалийн баялаг, ашигт малтмалаас хамааралтай авторитари болон ардчилсан дэглэмүүдэд сул эсвэл огт байхгүй ажээ. Байгалийн нөөцөөс хамааралтай байдал ба дэглэмийн өөрчлөлт хоорондын харилцан хамаарлын талаарх судалгаагаар, дэглэмийн хэв шинж төдийгүй байгалийн нөөц баялгийн төрлийг нь мөн харгалзан үзэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлжээ.

**Самбуугийн Болдсайханы** судалгаанд мөн байгалийн баялгаас хамаарах хамаарлыг судалсан. Ингэхдээ баялгаас төвлөрсөн орлогыг сонгогчдын санал худалдан авахад зарцуулах явдлыг эдийн засгийн популизм болон клиентелизмийн арга замаар төвлөрөн судалжээ. Ботсвани, Гана, Монгол Улс судлалыг хослуулсан статистик тоон судалгаагаар үр дүн нь холимог гарчээ. Нэг талаар, байгалийн баялгаас хамааралтай байх нь улс төрийн намуудыг мөрийн хөтөлбөрөөрөө илүүтэй өрсөлдөхөд хүргэдэг ч, энэ нь улс төрийн намууд хоорондын өрсөлдөөн сул, ядуурлын түвшин доогуур байх нөхцөлд л хүчинтэй байна. Нөгөө талаар улс төрийн намуудын өрсөлдөөн өндөр, сонгогчид орлого багатай, ядуу байх тохиолдолд, улс төрийн намууд нь өөрийн нөөц эх үүсвэрийг клиентелизмд зарцуулдаг байна. Өмнөх бүлгүүдэд дурдсаны адилаар энэхүү үр дүн нь байгалийн баялаг хийгээд ардчилал хоорондын харилцаа хамаарал, тэр дундаа улс төрийн намуудын систем ба эдийн засгийн нөхцөл байдлын хувьсагчуудыг судлахад илүү тохиромжтой, нарийн ялгаа бүхий хандлагыг ашиглахыг санал болгожээ.

**Матиас Де Роек** (Mathias De Roek), **Ронан Ван Россем** (Ronan Van Rossem) нар ардчилах үйл явцыг судлахдаа макро хандлагыг баримталжээ. Бусад бүлэгт ардчиллыг ихэвчлэн улс орны дотоод хүчин зүйлсийн талаас авч үзсэн бол, энэ бүлэгт ардчиллыг хөхиүлэн дэмжих юм уу сааруулж буй олон улсын нөлөөллийг тоон судалгаа ашиглан шинжилжээ. Судлаачдын зүгээс, ардчилсан эсвэл авторитари дэглэмээс хамааралтай холбоо, сүлжээ нь түүхийн хувьд энэ төрлийн дэглэмийг судлах хамгийн сайн таамаглагч болохыг тогтоожээ. Гэвч Хүйтэн дайн төгсгөл болсны дараах он жилүүдэд энэхүү системт нөлөө суларчээ. Хятадын сэргэн мандалт болон бүс нутгийн хүчирхэг гүрнүүд нь бусад улс орнуудад хамааралтай байх олон тооны хэлхээ холбоог бий болгож, дэлхий хэмжээнд ардчилах үйл явцад үзүүлэх Барууны нөлөөг сулруулж байна. Энэхүү хэлхээ холбооны хувилбарт эх сурвалж, нөөц нь автократуудад 1990-ээд оны эхэн үеийг тодорхойлж байсан ардчиллын давалгааг зогсоох боломжоор хангасан юм.

Эцэст нь, **Нуриа Суеро Комеллас** (Núria Suero Comellas) “ахисан түвшний” либерал ардчилсан улс буюу Испани дахь нийтийн дайчилгаа (мобилизаци)-ны талаарх судалгааг чанарын аргад тулгуурлан хийжээ. Тэрээр Испанийн Засгийн газрын хоригийг үл хайхран 2017 онд болсон Каталоны тусгаар тогтнолын санал асуулгаас үзүүлсэн үр нөлөөнд дүн шинжилгээ хийсэн байна. Засгийн газрын зүгээс тухайн санал асуулгыг явуулах нь эрх зүйн хувьд боломжгүй болохыг мэдэгдэж, ардчилсан, чөлөөт сонгууль шаардсан, гар нүцгэн иргэдийн эсрэг хүч хэрэглэх замаар хариу барьсан юм. Испанийн Засгийн газрын энэхүү тулган шаардсан хариулт нь томоохон хэмжээний эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөхөд хүргэн, улмаар Каталоны тусгаар тогтнолын сэдвээс хальж, удаан үргэлжилж буй төрийн авторитари дэглэмийн эсрэг арга хэмжээ болон өргөжсөн түүхтэй. Түүний үзсэнээр суурь хөрснөөс буюу иргэдийн дундаас урган гарсан хөдөлгөөн нь Каталоны иргэдэд ардчиллыг гүнзгийрүүлэх, тэдний зүгээс хууль ёсны дагуу хүчирхийллээс ангид байдлаар эсэргүүцлээ илэрхийлэх шаардлагатайг сануулсан, өөрчлөгч үйл явдал болсныг тэрээр тэмдэглэсэн байна. Энэхүү санал асуулга нь ардчиллын зөвлөлдөх загварт суурилсан, оролцоот яриа хэлэлцүүлгийн орон зайг тусгаар тогтнолын төлөөх жагсагчдад нээн өгчээ.

## Ном зүй

- Bulag, Uradyn E. 2009. “Mongolia in 2008: From Mongolia to Mine-golia.” *Asian Survey*, 49(1): 129–134.
- Fish, M. Steven. 1998. “Mongolia: Democracy Without Prerequisites.” *Journal of Democracy*, 9(3): 127–141.
- Freedom House. 2019. *Freedom in the World 2019: Democracy in Retreat*. Washington and New York: Freedom House.
- Fritz, Verena. 2002. “Mongolia: Dependent Democratization.” *Journal of Communist Studies and Transition Politics*, 18(4): 75–100.
- Fritz, Verena. 2007. “Democratisation and Corruption in Mongolia.” *Public Administration and Development*, 27(3): 191–203.
- Lipset, Seymour Martin. 1959. “Some Social Requisites of Democracy: Economic Development and Political Legitimacy.” *American Political Science Review*, 53(1): 69–105.
- O'Donnell, Guillermo and Philippe C. Schmitter. 1986. *Transitions from Authoritarian Rule: Tentative Conclusions About Uncertain Democracies*. Baltimore and London: Johns Hopkins University Press.
- Sabloff, Paula L.W. 2002. “Why Mongolia? The Political Culture of an Emerging Democracy.” *Central Asian Survey*, 21(1): 19–36.

# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

---

Монгол дахь ардчилагдах үйл явц



## Монголын ардчиллыг тэтгэгч далд хүчин зүйлс

Стивен Фиш, Майкл Сийберг

Бүтцийн таатай бус олон нөхцөл, саад бэрхшээл байвч Монголд ардчилал оршин тогтносоор байна. Ингэж амжилттай үргэлжлэхэд нөлөөлсөн хүчин зүйлсээс хамгийн чухал нь хүчирхэг иргэний нийгэм байв. Нийгэмд гүнзгий үндэс суурь бүхий иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) засгийн газрын шийдвэр, үйл ажиллагааг нийтэд ил тод, нээлттэй болгох, улс төрийн хүрээнд уул уурхайн салбарынхны ашиг сонирхол давамгайлахыг эсэргүүцэх, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн далд асуудалд олны анхаарлыг хандуулахад чиглэж байв. Гэсэн хэдий ч, Монголын ардчилал албан тушаалтнуудын авлига, хүчирхэг улс төрчид, сонгуулийн өмнө дүрмээ өөрчлөх дадал зуршил, хүчирхэг хөршүүд нь хөндлөнгөөс саад учруулах зэрэг сорилттой тулгарсаар байна. Монголын иргэний нийгэм хүчирхэг байх эсэх нь энэ мэт бэрхшээлийг даван туулах, хөгжиж буй орнуудын хувьд ардчилсан засаглалын хамгийн гайхамшигт туршлагыг дахин голдиролд нь оруулахад шийдвэрлэх үүрэгтэй юм.

### Оршил

Глобал ардчиллын гурав дахь давалгаанд хамаарч буй бидний хувьд ардчилалд шилжих нь харьцангуй хялбар боловч олж авсан энэхүү ардчиллаа төлөвшүүлж, тогтвортой хадгалан үлдээх нь хэцүү гэдгийг ойлгодог болжээ. Оросоос Тайланд, Малигаас Турк хүртэлх олон орон нээлттэй улс төрд шилжиж байсан бол, одоо энэ бүхэн хэдийн түүх болон үлдэж, тухайн улсын удирдагч нар, батлан хамгаалах салбарынхан бүхий л эрх мэдлийг гартаа төвлөрүүлснээр иргэний эрх чөлөөг хязгаарласан, сонгуулийн хуурамч тогтолцоонд эргэн шилжээд буй билээ.

Бүтэлгүй ардчилал, хөдөлгөөнгүй хөшиж тогтсон автократ дэглэм бүхий пост коммунист Евроазийн бүс нутагт ардчилал тэсэж үлдсэн цорын ганц улс нь Монгол болж байна. Монгол Улс 1990 оны эхээр хуучин Зөвлөлтийг дагасан тогтолцоог эвдэж, авторитари дэглэмээс бүрэн ангижраад зогсохгүй, хуучин дэглэмдээ эргэн орохоос зайлсхийж чадсан юм.

Улсын Их Хурал (УИХ)-ын 2016 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит сонгууль Монгол Улсын ардчилсан статусыг баталгаажуулсан үйл явдал болов. Сонгуулийн үйл явц олон улсын стандартад бүрэн нийцсэн. Сонгогчдын санал тоолох автоматад машиныг нэвтрүүлсэн нь санал хураалтыг шуурхай зохион байгуулах, 6 дугаар сарын 29-ний шөнөдөө сонгуулийн дүнг зарлах боломжийг олгов. Энэхүү системийг ашигласнаар санал тоолоход гарч болзошгүй будилаанаас бүрэн сэргийлээд зогсохгүй, сонгуулийн үйл явцад итгэх иргэдийн итгэлийг ч бэхжүүлсэн юм.

Өмнөх сонгуулиудын нэгэн адил, гол өрсөлдөөн улс төрийн голлох хоёр нам болох хуучин коммунист намыг залгамжлагч Монгол Ардын Нам (МАН), 1989-90 онд эхэлсэн ардчилсан шилжилтийн дүнд үүссэн өөрчлөлтийг дэмжигч, харьцангуй либерал Ардчилсан Намын (АН) хооронд өрнөжээ. Энэ сонгуулиар МАН УИХ дахь нийт 76 суудлын 67-г авснаар үнэмлэхүй ялалт байгуулсан юм. Харин 2012-2016 оны УИХ-д АН ердийн олонхын суудлыг авч, эвслийн засгийн газар ажиллуулж байсан түүхтэй. Сонгуулийн үр дүнгээр эрх баригч нам солигдох нь Монгол Улсын хувьд хэвийн үзэгдэл бөгөөд ардчиллын үйл явц эхэлснээс хойш болсон 7 сонгуулийн 4-т нь эрх баригч нам солигдож ирсэн түүхтэй.

Гэсэн ч, 2016 оны сонгуулийн өмнөхөн системдээ өөрчлөлт хийсэн нь бас л тодорхой асуудал, маргааныг дэгдээсэн байна. Монгол Улсын сонгуулийн тухай хууль тогтоомж гайхалтай хувирамтгай байсаар иржээ. Жишээ нь 2012 оны сонгуулиас бусад сонгуульд мажоритар тогтолцоог ашигласан бол, 1992, 2008 оны сонгуульд пропорциональ системийг буюу 26 тойргийн сонгогчид тойргийн хэмжээнээс хамааран 2, 3 эсвэл 4 нэр дэвшигчийг сонгож байв. 1996, 2000 болон 2004 оны сонгууль цэвэр мажоритар буюу 76 тойрог тус бүр нэг нэр дэвшигчийг сонгох зарчмаар явагдсан. 2012 оны сонгуульд холимог систем ашиглаж, нийт 48 суудлыг тойрог бүрээс 1-3 нэр дэвшигчийг тойргийн сонгогчдын олонхын саналаар, үлдэх 28 суудлыг намын нэрсийн жагсаалтын дагуу пропорциональ байдлаар сонгож байв. Харин 2016 онд Сонгуулийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулснаар 76 тойрог тус бүрээс нэг нэр дэвшигчийг сонгохоор дахин хуульчилж, 1996, 2000 болон 2004 оны сонгуультай ижил зарчмыг ашиглажээ (Enkhbaatar, 2015).

Сонгуулийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь ардчилсан хэм хэмжээг зөрчсөн хэрэгт тооцогдохгүй ч, санал хураалтын өмнөхөн сонгуулийн тухай хууль тогтоомж байнга хэлбэлзэж өөрчлөгдөх нь хэм хэмжээний зөрчилд ойртсон явдал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2012 оны 3 дугаар сард мажоритар болон хувь тэнцүүлсэн холимог систем нь Үндсэн хуульд нийцсэн болохыг баталгаажуулсан ч, мөнөөх л Цэц 2016 оны 4 дүгээр сард тогтолцоог Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэнээр УИХ-ын сонгууль өмнө хэрэглэж байсан мажоритар буюу нэг тойргоос нэг нэр дэвшигч сонгогдох тогтолцоонд шилжжээ.

Хамгийн ноцтой асуудал нь УИХ-аас Сонгуулийн тухай хуульд 2015 оны 12 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулахдаа сонгууль болохоос зургаан сарын өмнө сонгуулийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг хориглосон зүйл заалтыг хассан явдал юм. Ийм өөрчлөлт нь 2016 оны 5 сард буюу сонгуулийн өмнөхөн хуульд өөрчлөлт хийх боломж нээсэн хуулийн цоорхойг үүсгэсэн. Монголын сонгуулийн үйл явцын том алдаа, сул тал нь тогтолцооны тогтворгүй байдал, дүрэм журамд гэнэтийн өөрчлөлт хийдэг юм. Сүүлийн мөчид өөрчлөлт хийхийг хориглож, тогтвортой байдлыг хангаснаар бусдаар өөлөх зүйлгүй сонгуулийн тогтолцоог бий болгож, эрүүлжүүлж сайжруулах нь гарцаагүй.



Сонгуулийн хууль тогтоомжид өөрчлөлт хийх нь ихэнх тохиолдолд улс төрийн зорилготой байдаг бөгөөд Монгол Улсын Сонгуулийн тухай хуульд 2016 онд хийсэн нэмэлт өөрчлөлт ч тийм байсан. Олон нийтийн санал асуулгаар сөрөг хүчин өндөр рейтингтэй байсан ч, эрх баригч АН-ын удирдлага мажоритар тогтолцоо нь тэдний болон бусад жижиг намын нэр дэвшигчдэд өндөр санал авч УИХ дахь олонхын суудлаа хадгалахад нөлөөлнө гэж тооцоолж мажоритар тогтолцоонд буцан орохыг сонгожээ. Харамсалтай нь, сонгуулийн инженерүүдийн энэхүү тооцоо буруу байж, өрсөлдөгч МАН хэдий нийт сонгогчдын 46 хувийн саналыг авсан ч, шинэ хуулийн дагуу УИХ-ын суудлын 86 хувийг авсан байна. Харин АН сонгогчдын 34 хувийн саналыг авсан хэдий ч, нийт суудлын 12 хувийг л эзэлсэн байна. Ийм утгагүй будилаан хийх явдал урьд өмнө ч тохиолдож байсан. Жишээ нь, Палестины 2006 оны сонгуулиар эрх баригч Фатах намын дэмжлэгтэйгээр сонгуулийн хуульд оруулсан өөрчлөлт нь өрсөлдөгч Хамас бүлэглэл Фатах намаас дөнгөж 3 хувийн саналын илүүтэй байсан ч хууль тогтоох суудлын үнэмлэхүй олонхыг эзлэхэд хүргэж байв.

Дээрх асуудлуудыг үл харгалзан, Монгол Улсын сонгууль өрсөлдөөнт байдлаар явагдаж, хэвлэл мэдээлэл нээлттэй ажиллаж, процедурын алдаа ч цөөн гарсан ажээ. Бүх томоохон улс төрийн намууд ч сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрчээ (OSCE, 2016). Энэхүү сонгууль нь тус улсад 25 жил тасралтгүй үргэлжилсэн ардчиллын бүрэн бүтэн байдлыг баталгаажуулжээ.

## Орших ёсгүй ардчилал

Монгол орны ардчиллын туршлага нь парадокс үзэгдлийн жишээ болж байна. Уламжлалт онолын үүднээс үзвэл, тус улсад ардчилал орших учиргүй мэт. Ардчилсан улс орнуудтай газар зүйн байршлын хувьд ойр байх нь давуу тал хэмээн эрдэмтэд үздэг ч, Монгол Улсын хамгийн ойрын хөршүүд болох БНХАУ, ОХУ болон Казахстан нь бүгд л авторитари дэглэм бүхий улсууд юм. Хэдий эдгээр улсын нөлөө сөрөг байх боломжтой ч, Монголын ардчилал эрүүл чийрэг хэвээр байна.

Монгол Улсыг хөрш орнуудтай нь харьцуулахад хамгийн ардчилсан байгаад зогсохгүй, ижил түвшний хөгжилтэй улсуудтай харьцуулсан ч сайн үзүүлэлттэй байна. Олон жилийн туршлагаас харахад, баялаг нэмэгдэх тусам улс төр илүү нээлттэй болдог бол үүний эсрэгээр Монгол нь баян орон биш юм. Худалдан авах чадварын индексээр нэг хүнд ногдох орлогын хэмжээ 12000 ам.доллар байгаа нь ОХУ-ын тухайн үзүүлэлтийн хагаст ч хүрэхгүй, харин Йордан, Египеттэй ойролцоо түвшинд байна. Фрийдом Хаусын жил болгон хийдэг судалгаагаар ардчиллын гурав дахь давалгаанд өртсөн, нэг хүнд ногдох орлого нь 15000 ам.доллараас доогуур байх орнууд дотроос Монгол, Бенин, Сан Томе, Принципи гэсэн

улс л өнгөрсөн хорин таван жилийн туршид “Чөлөөтэй” гэх ангилалд багтсаар иржээ (Freedom House, 2016). Монгол Улс хэдий орлого багатай ч, бат бөх ардчиллыг хөгжүүлж буй өвөрмөц жишээ болж байна.

Үнэмлэхүй ялагч байнга тодорч, сонгуулийн үр дүнд нэг намын засгийн газар дангаар бүрддэг Монгол орны хувьд, ардчиллыг хорин таван жилийн туршид тасралтгүй хадгалж явааг онцгойлон дурдах ёстой. Ардчилал шинээр үүсэж буй орнуудад нэг нам дангаар үнэмлэхүй олонхын суудал авах нь тухайн намд эрх мэдлээ цаашид хадгалахын тулд хууль тогтоомжийг өөрчлөхийг санаархах, тийм оролдлого хийх нь элбэг байдаг. Үүний тодорхой жишээ бол Ерөнхий Сайд Виктор Орбаны удирдаж буй Унгар, өмнө нь Ерөнхий Сайд, одоо Ерөнхийлөгч болсон Ресеп Тайип Эрдоганы удирдаж буй Турк зэрэг улс юм. Харин Монгол Улсын тухайд, улс төрийн хоёр гол нам өнгөрсөн хугацаанд парламентын олонхыг бүрдүүлсээр ирсэн ч, сонгуулийн тогтолцоог өөрсдөдөө нийцүүлэхийн тулд давуу талаа ашиглаж байсан түүх аль ч намд байхгүй байна. Үүнийүй байна. лд давуу талаа ашиглаж байсан түүх аль ч намд г бүрдүүлсээр ирсэн чбуй Турк тулд хууль тогтоомжийг өөрчлөхийг санаархах, тийм оролдлогод 25 жил тасралн санал шаардлагатай) Ерөнхийлөгчтэй ба үндсэндээ өнгөрсөн хугацаанд сөрөг хүчний нэр дэвшигч нь Ерөнхийлөгчөөр сонгогдож иржээ. Төрийн бүх эрх мэдлийг УИХ хэрэгжүүлж, Ерөнхий сайд хамгийн хүчирхэг улс төрч байдаг ч, аливаа асуудалд хориг тавих, шүүх эрх мэдлийн төлөөллийг томилох эрх нь Ерөнхийлөгчид эрх баригчдыг сөрөн зогсох хүчийг олгож байдаг. АН-аас нэр дэвшиж сонгогдсон өнөөгийн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нь шинээр үүссэн МАН-ын засгийн газрыг эсэргүүцэх гол хүч юм. Гэхдээ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 2017 оны дундуур дуусаж, түүний суудалд МАН-ын нэр дэвшигч сонгогдох тохиолдолд төрийн бүхий л эрх нэг намын хяналтад орох юм.

Өмнө нь ч Ерөнхийлөгч болон УИХ нэг намын хяналтад байх тохиолдол гарч байжээ. АН 1996-1997, 2012-2016 онд бүх эрх мэдлийг барьж байсан бол, МАН-ын бүрэн хяналтад 2000-2004, 2008-2009 онуудад ардчилал тэсэн үлдсэн түүхтэй. Улс төрчдийн зүгээс сонгуулийн дүрэм, журмыг өөрийн сонирхолд нийцүүлэн засах гэж оролдсоор ирсэн ч, нэг намын давамгайллыг үүрд тогтооход чиглээгүй, ялагдал хүлээсэн ч сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч иржээ. Тогтолцооны дотроос шахалт багатай байсан ч, элит хэсэг тогтсон журмыг хүндэтгэн, мөрдсөөр иржээ. Өнөөгийн МАН-ын бараг л монопол байдал нь санаа зовоох шалтгаан хэдий ч, нэг нам давамгайлж байсан ч ардчилал оршин тогтносоор ирсэн жишиг хэдийн бий болжээ.

Хэдийгээр нөхцөл байдал төдийлөн тааламжгүй байгаа боловч, олон ургалч үзлийг тогтвортой хадгалж буй нэг гол хүчин зүйл бол хүчирхэг иргэний нийгэм юм. Систем дотор түлхэх, шаардах хүч байх нь эрх баригчдыг тайван суулгадаггүй бөгөөд дороос ирж буй дарамтаас үүдэн эрх баригчид үүнтэй зууралдах, арга хэмжээ авах шаардлага

заавал үүсдэг юм. Шинжээчдийн зүгээс пост коммунист улс төрийн тогтолцоонд иргэний нийгэм харьцангуй сул байх хандлагатай хэмээн үздэг ч, Монгол Улс энэ дүгнэлтээс гадуур үлдэж байна (Pop-Eleches et al., 2013). 1989 оноос нээлттэй болох анхны шинж тэмдэг мэдэгдэж эхэлсэн үеэс хойш өнөөг хүртэл хараат бус сонирхлын бүлэг, нийгмийн хөдөлгөөнүүд (эдгээрийг нэгтгэн ИНБ-ууд гэж нэршиж заншсан) эрх баригчдыг шударга, үгүйдээ л байнгын сэтгэлийн дарамттай байх, улс төрийн системийг нээлттэй байлгахад хувь нэмрээ оруулж иржээ. ИНБ-уудын дуу хоолой, шургуу оролдлого нь Монголд ардчилал оршин тогтносоор байгаа явдлыг тайлбарлах түлхүүр юм.

## Иргэний нийгэм ба ардчилал

Өнгөрсөн хугацаанд олон төрөлт, баялаг иргэний нийгмийг ардчиллын өмөг түшиг хэмээн үзсээр иржээ. Алексис де Токвилл нь Ерөнхийлөгч Жексоны үеийн америкийн ардчилсан нийгэм эрүүл байсныг, нэг талаар америкчууд сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, тодорхой зорилго шалтгааны улмаас үүссэн байгууллагуудтай эвлэлдэн нэгдэж байсантай холбон тайлбарладаг. Токвиллийн үзлийг орчин үед баримтлагчид болох Роберт Путнам зэрэг судлаач үзэл бодлын үүднээс үүссэн төрийн бус эвсэл, холбоод нь ардчиллын хүчирхэг холбоотон гэж үздэг байна (Tocqueville, 2004).

Судлаач болгон иргэний нийгэм хүчирхэг байх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөөд байдаггүй. Учир нь эерэг нөлөөт ИНБ-уудтай зэрэгцэн экстремист, фанатик, эсвэл сөрөг нөлөө бүхий байгууллагууд үүсэх нь бий гэж зарим судлаач үздэг. Эдгээр тээнэгэлзэгчид ихэнх тохиолдолд Веймарын Германы засгийн газрыг<sup>1</sup> жишээ болгон авдаг бөгөөд Гитлер нэр нөлөөтэй болсон энэ үед төрийн бус эвсэл холбоод маш олон байжээ. Тэдний үзэж буйгаар үймсэн мөртлөө сайтар зохион байгуулалтад орсон олон нийт нь дээд түвшний элитүүдийн нэгэн адил ардчилалд эрсдэл учруулдаг байна (Berger, 1997; Armony, 2004).

Иргэний нийгмийн байгууллагуудын дунд “муудсан алим” байдгийн зэрэгцээ тэдгээр нь төрийн хүчирхэг институцийг орлохгүй нь ойлгомжтой. Гэвч иргэний нийгмийн хүчирхэг байгууллагуудыг эмпирик учир шалтгаанаар үгүйсгэх нь үндэслэл муутайгаас гадна “Веймарын сургамж”-ийг онцлох нь хоцрогдсон зүйл юм. Дэлхийн II дайны дараах ертөнцөдэхлэлтөдий, дүрэм журамд баригддаггүй иргэдийн хөдөлгөөнөөс илүүтэйгээр эрх баригч элит, гүйцэтгэх засаглалын удирдлага ардчиллыг хамгийн ихээр гажуудуулсан байдаг (Fish et al., 2009). Оросын удирдагч

---

1 1918–1933 онуудад Германд тогтсон төрийн байгууллын албан бус нэршил.

Путин, Беларусын Ерөнхийлөгч Лукашенко, Казахстаны Ерөнхийлөгч Назарбаев болон бусад автократ хүчирхэг ИНБ-ууд үүсэн бий болох боломжийг хаахаар хичээн зүтгэж байдаг нь цаанаа учиртай. Нийгмийг унтаа, идэвхгүй байлгах нь тэдний сонирхолд нийцэхийг мэддэг. Тэдний нүүр тулахаас айдаг зүйл нь зохион байгуулалттай, идэвхтэй иргэний нийгэм байдаг.

Эрх баригчид сонгогчдыг төөрөгдүүлж, эмзэг бүлгийнхнийг хувь тавилантай нь эвлэрүүлж, төрийн үйл ажиллагааг нийтийн хараа хяналтаас далдуур явуулахыг хүсдэг ба Монголд ардчиллын түүхэнд шийдэмгий, хүчирхэг ИНБ-ууд эрх баригчдад ямар сорилт бэрхшээлүүд учруулж болохыг харуулсаар байна. Үнэндээ шилжилт эхэлсэн цагаас Монголын иргэний нийгэм Оросын “цус багадалттай” иргэний нийгмээс эрс ялгаатай, хүчирхэг байж ирсэн нь Монголд ардчилал ийм амжилтад хүрсний гол тайлбар болох юм (Fish, 2005). Токвилл 19 дүгээр зууны эхээр Америкаар аялж явахдаа ардчиллыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн гүйцэтгэж буй үүргийг тодорхойлсон бөгөөд Монголын иргэний нийгэм тэдгээр бүхий л үүргийг гүйцэтгэсээр иржээ. Үүнээс бид дөрвөн чиг үүргийг гүнзгийрүүлэн судалж, идэвхтэй үйл ажиллагаатай байгууллагуудыг жишээ болгох бөгөөд ингэснээр бүтцийн хувьд тогтворгүй ч, иргэний нийгмийн идэвхтэй оролцооны үр дүнд ардчиллыг тогтвортой хадгалж болохыг энэхүү судалгаагаар харуулна.

Иргэний нийгмийн гүйцэтгэдэг олон чиг үүргээс хүн бүрийн мэддэг нь магадгүй төрд шахалт үзүүлэх явдал бөгөөд Монголын ардчилал нь хуучин Зөвлөлт маягийн дэглэмийг эсэргүүцэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зайг бий болгохын төлөө олон нийтийн бослого тэмцлээс үүдэлтэй юм. Тухайн үеийн дэглэмийг нураах үйл явцыг хурдасгасан жагсаал анх 1989 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Ховд хотод өрнөжээ. Хууль бус хэмээн тооцогдсон энэхүү цуглаан нь Монголын Ардчилсан Холбоо, Ардчилсан Социалист Хөдөлгөөн болон Шинэ Дэвшилт Холбоо үүсэн байгуулагдах үндэс болжээ. 1990 оны эхний хагаст болсон нийтийг хамарсан эсэргүүцэл, улс төрийн өлсгөлөнгийн дараа шинээр байгуулагдсан ардчиллын төлөөх намуудын төлөөлөл тухайн үеийн МАХН-ын удирдлагатай уулзаж, төрийн эрхийг дангаар барих монополыг буулган, иргэний эрх чөлөөг хангаж, хууль тогтоох байгууллагыг чөлөөт сонгуулиар бүрдүүлэх тохироонд хүрчээ. Хэдий дараахан 7 дугаар сард болсон сонгуулиар МАХН-ын нэр дэвшигчид ялалт байгуулсан ч, нийтийг хамарсан жагсаал цуглаан нь тухайн намыг хэдийн дангаар ноёлогч бус, харин улс төрийн жирийн л нэг намын хэмжээнд аваачсан байлаа. Монгол Улс анхны сонгуулиа иргэдийн шахалтаас үүдэн, зүүн Европын улс орнуудад болсон сонгуультай зэрэгцэн, ЗХУ задран унахаас жил гаруйн өмнө зохион байгуулсан билээ (International Republican Institute, 2015).

Эрх баригчдын хувьд, төрийн эрх мэдэл, үйл ажиллагаагаа иргэдийн хяналтаас гадуур байлгахыг үргэлж хүсэж байдаг ч, ардчилсан

тогтолцооны үед энэ нь хялбар биш юм. Эрх баригчид үеийн үед үндэсний аюулгүй байдлын нэрийг барьж төрийн үйл ажиллагааг нууцлах санаархалтай байдаг. Бүх ардчилсан оронд ил тод байдлыг дээд зэргээр хангаж, эрх баригчдыг тайван бус байлгах тэмцэл нь тасралтгүй явагдаж байдаг бөгөөд энэ нь улс төрийн нээлттэй дэглэмийг хадгалан үлдээхэд чухал үүрэгтэй.

Шинээр бойжиж буй ардчиллын нэгэн адил Монгол Улсад иргэдийн мэдээллийн хүртээмжийг хангасан хууль журам, хэм хэмжээг бий болгох шаардлага өндөр байгаа бөгөөд энэ чиглэлээр хэд хэдэн байгууллага ажиллаж, бодит үр дүнд хүрээд байна. Эдгээрийн нэг нь 1999 онд байгуулагдсан, гишүүнчлэлгүй ТББ болох “Глоб Интернейшнл” юм. Тус байгууллага Нээлттэй нийгэм хүрээлэн, Швейцарын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-ийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулж иржээ.

“Глоб Интернейшнл” нь “Мэдэх эрх: Мэдээллийн эрх чөлөө” хэмээх олон жилийн туршид үргэлжилсэн төслийг анхлан 2002 онд эхлүүлжээ. Тус төслийн хүрээнд сургалт, семинар зохион байгуулахын зэрэгцээ хууль тогтоогчидтой дугуй ширээний ярилцлагууд хийжээ. Төслийн хүрээнд, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлийн “хил хязгаараас үл хамааран мэдээлэл хайх, авах, хуваалцах эрхийг” тусгах заалтын хүрээнд Британийн хүний эрхийн байгууллагатай холбоо тогтоожээ. Тус байгууллага нь 2004-2005 онд мэдээллийн эрх чөлөөний чиглэлээр хэд хэдэн гарын авлага бэлтгэн гаргаж, улмаар хууль тогтоогчид болон Хууль зүй, дотоод хэргийн яамтай үйл ажиллагаагаа гүнзгийрүүлэн өргөжүүлжээ. Яамны зүгээс ч, “Глоб Интернейшнл”-ийн хуульчидтай хамтран олон улсын түншлэгч “19 дүгээр зүйл” байгууллагын боловсруулсан хуулийн төсөл дээр хамтран ажиллахаар зөвшөөрчээ.

Гэвч, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах энэхүү шинэлэг хууль тогтоомж эрх баригч элитүүдийн зүгээс төдийлөн дэмжлэг олохгүй байлаа. Засгийн газар 2005-2006 онд дээрх хуулийн төслийг УИХ-д өргөн барих талаар хэлэлцсэн ч, мэдээллийн аюулгүй байдлын асуудлыг дахин судлах шаардлагатай гэж үзээд хойшлуулжээ. УИХ-ын 5 гишүүн хамтран тус хуулийн төслийг хэлэлцүүлэхээр 2007 онд УИХ-д өргөн барьсан ч, ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна. Засгийн газар 2008-2012 онд хэрэгжүүлэх Мөрийн хөтөлбөртөө мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг батлуулахаар тусгаж байжээ. Мэдээллийн эрх чөлөө нь улс төрчдийн хувьд 4-5 жилийн төлөвлөгөө гэдэг шиг хэзээ ч бодитойгоор хэрэгжихгүй мөрөөдлийн жагсаалтын нэг зүйл болж хувирчээ.

Энэ чиглэлээр олон жил үргэлжлэх нөлөөллийн үйл ажиллагаа шаардлагатай болохыг ойлгосон “Глоб Интернейшнл” арван ТББ-аас бүрдсэн эвсэл байгуулж, “Мэдээлэл авах боломжийг сайжруулж, авлигатай тэмцэх нь” хэмээх төслийн хүрээнд лобби бүлэг байгуулсан байна. Глоб Интернейшнлийн Ерөнхийлөгч Нээлттэй нийгэм форумын захирлын хамтаар 2009 онд хоёр жилийн өмнө хуулийн төсөл өргөн

барьсан УИХ-ын гишүүдтэй уулзан ярилцаж, улмаар хуулийн төслийг шинээр боловсруулахаар зөвшилцжээ. Дахин нэг жилийн туршид дугуй ширээний уулзалт, олон нийтэд хандсан танилцуулга, эвслийн үйл ажиллагаа, хуулийн төслийн хэлэлцүүлэг, идэвхтэй лобби хийсний үр дүнд засгийн газар мэдээллийн ил тод байдлын тухай 143 тоот тогтоолыг баталж, боловсруулсан хуулийн төслөө УИХ-д өргөн барьжээ. “Глоб Интернейшнл” “Мэдэх эрх” компани ажил өрнүүлж эхэлснээс хойш бараг 10 жилийн дараа буюу 2011 оны дунд үеэс УИХ-аас “Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна (Globe International, n.d.).

Энэхүү хууль нь цохон тэмдэглэхүйц дорвитой амжилт болжээ. Хуульд төрийн байгууллагуудад төсөв, санхүү, худалдан авалтын үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй болгохыг үүрэг болгож, мэдээллээ олон нийтэд хэрхэн түгээх талаар заажээ. Мөн төрийн зүгээс хэвлэл мэдээллийн чиглэлээр хуваарилсан бүх санхүүжилт, үүнд зар сурталчилгаанд зарцуулсан хөрөнгийг олон нийтэд нээлттэй байхаар заажээ. Иргэд, хуулийн этгээдэд мэдээлэл авах хүсэлт гаргах эрхийг олгож, түүнд нь эрх бүхий төрийн байгууллага долоо хоногт багтаан хариу өгч байхаар зохицуулжээ. Мөн тус хуульд нууц мэдээллийг хамгаалах заалт оруулсан нь хамгийн нээлттэй, ардчилсан нийгэмд ч баримталдаг стандарт юм. Эрх баригчид энэхүү заалтыг хэтрүүлэн ашиглах нь авторитари дэглэмд түгээмэл байдаг бөгөөд ингэхийн тулд, иргэддээ эхлээд эдлэх төрөл бүрийн эрхийг нь өгч, улмаар дараа нь “аюулгүй байдал”, “олон нийтийн ашиг сонирхол” нэрийн доор хязгаарлаж байдаг (UNESCO, 2016). Албан ёсоор батлагдан хэрэгжиж эхэлсэн таван жилийн хугацаанд энэхүү хууль бодитоор “хазах шүдтэй” болохоо харуулаад байна. Энэ хууль төрийн үйл ажиллагаанд нөлөөлж эхэлсэн байна. Транспаренси Интернейшнлийн жил тутам гаргадаг Авлигын төсөөллийн талаарх судалгаагаар хууль батлагдан гарснаас хойш Монгол Улсын рейтинг 2011-2015 онд энэхүү дэлхийн хэмжээний рейтингээр 30-аас 57 оноо хүртэл дээшилжээ (Transparency International).

Эрх баригч элитүүд мэдээллийн эрх чөлөөг бүрэн хангах хүсэлгүй, энэ сэдэв олон нийтийн анхаарлыг тэр бүр татдаггүй учир “Глоб Интернейшнл” болон эвслийн түншүүдийн зүгээс үзүүлсэн шахалтын ачаар тус хууль батлагдан хэрэгжиж байна.

Төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгохоос өөр ардчиллыг тогтвортой хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл хуруу дарам цөөн байна. Сонгогчид өөрт байгаа мэдээлэл дээр л үндэслэн эцсийн шийдвэрээ гаргадаг бөгөөд энэхүү сонголтын чанар нь иргэд өөрийн удирдагчдын хийж буй ажлын талаар хэр их мэдээлэлтэй байгаагаас шалтгаална. Үүний зэрэгцээ хэр хэмжээний мэдээллийг ил тод түгээх нь улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээтэй уялдаатай байдаг. Тиймээс “Глоб Интернейшнл” зэрэг байгууллага иргэдийг мэдээлэлтэй, улс төрчдийг хяналттай байлгахад хүргэж, ардчиллыг бэхжүүлж байна.

## Төрд дэмжлэг үзүүлэх нь

Төрийн эрх мэдлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх нь иргэний нийгмийн чухал чиг үүргийн нэг байдаг хэдий ч, төр ба иргэний нийгэм нь хамтын ажиллагаатай, эсвэл харилцан нэгнээ үгүйсгэсэн харилцаатай байж болно. “Глоб Интернейшнл” Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл боловсруулсан нь хараат бус байгууллага өөрт буй мэдлэгийг ашиглан төрийн бодлогод хэрхэн дэмжлэг үзүүлж болохыг харуулсан жишээ юм. Өөр нэгэн жишээ нь Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо (МХҮХ) юм. Тус холбоо нь төрийн зүгээс үзүүлэх ёстой хэдий ч, тэр бүр үр дүнтэй байж чадахгүй байгаа үйлчилгээг үзүүлснээрээ нэг алхам урагшилж чаджээ.

Хуучин коммунист дэглэмийн үед, 1978 онд байгуулагдсан МХҮХ нь Зөвлөлт маягийн дэглэмд олон нийтийн байгууллага ямар байх ёстой тэр л маягаар үйл ажиллагаагаа явуулдаг байв. Олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалдаг нэртэй ч, бодит байдалд дээрээс ирсэн үүрэг даалгаврыг л биелүүлж байжээ. Бусад ижил төрлийн байгууллагын нэгэн адил тус холбоо нь нөлөөллийн ажил хийж буй мэт харагддаг ч, бодит байдалд тодорхой ажил хийдэггүй байв. Гэвч Зөвлөлт хэлбэрийн дэглэм задран унасны дараахан 1993 онд МХҮХ нь хараат бус байгууллага болж өөрчлөгджээ. Тэр цагаас хойш тус байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй, тэр дундаа хараагүй иргэдийн эрх ашгийг хамгаалагч идэвхтэй байгууллага болж хувирсан төдийгүй, тэдэнд зориулсан халамжийн үйлчилгээг бий болгоход төрд бодит дэмжлэг үзүүлдэг болжээ. Гаднаас ирсэн тусламж дэмжлэг тэдэнд чухал түлхэц болсон бөгөөд Данийн Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байна.

Улмаар, 2000 оны дундуур хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахыг шаардан, өлсгөлөн зарласнаар өөрийн нөлөөллийг бий болгож эхэлжээ. Монгол Улсын хувьд, хөгжиж буй бусад орны адил хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нуугдмал амьдарч, ажил хөдөлмөр эрхлэх боломж хомс, төрийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байсаар иржээ. Өлсгөлөн зарласнаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгардаг асуудал, бэрхшээлийн талаарх олон нийтийн ойлголт нэмэгдсэн төдийгүй, улмаар 2012 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал хариуцсан газрыг байгуулсан юм.

Мөн өлсгөлөнгийн ачаар УИХ-ын байнгын хороодод хууль тогтоомжийг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх төлөөллийг МХҮХ-ноос урьж байх санаачилгыг засгийн газраас гаргасан байна. МХҮХ ч энэ боломжийг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай харилцаа тогтоож, өөрсдийн асуудлыг эрх мэдэлтнүүдэд ойлгуулаад зогсохгүй, хуулийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж эхэлжээ. Шинэ хуулийн төсөл боловсруулах ажлыг 2013 онд эхлүүлэхдээ МХҮХ тухайн

үеийн УИХ-ын гишүүдээс С.Оюуныг гол түншээрээ сонгосон байна. Гишүүн С.Оюун хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж, эцсийн хувилбарыг УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлж байжээ.

УИХ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, нийгмийн амьдралд оролцуулах зорилготой “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль”-ийг 2016 оны 2 дугаар сард батлан гаргажээ. Энэ хууль нь төрийн албан тушаалтнууд, олон нийтийн дунд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтын нэмэгдүүлэхэд хөхиүлэн дэмжсэн юм. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрал, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээг зааж, барилга, дэд бүтцийн байгууламж болон нийтийн тээвэрт баримтлах хүртээмжийн стандартуудыг даган мөрдөхийг үүрэг болгожээ. Мөн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээ авах эрхийг тодорхойлон заажээ.

Хууль хүчин төгөлдөр хэрэгжих үеэс МХҮХ-ны тэргүүн Дондовын Гэрэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудал хариуцсан зөвлөхөөр ажиллах болжээ. Энэхүү албан тушаал нь түүнд УИХ, гишүүдтэй бүрэн хэмжээнд чөлөөтэй харилцах боломжийг нээснээс гадна, хууль боловсруулагчдын хувьд ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого боловсруулахад мэдээлэл, зөвлөгөө өгч чадах мэргэжилтэнтэй шууд холбоо тогтоох боломжтой болжээ. МХҮХ нь Улаанбаатар хотод нийслэлийн төр захиргааг төлөөлсөн арван тав, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөлөл долоон гишүүн бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл”-ийг байгуулснаар бодлого боловсруулахад дэмжих, шахалт үзүүлэх өөрийн хүчин чармайлтыг улам нэмэгдүүлжээ.

Төрийн албан ёсны бүтэц байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэх арга замаа өөрчлөх хүртэл үр дүнтэй харилцааг төртэй хөгжүүлж чадсаны зэрэгцээ МХҮХ нь хараагүй иргэдэд үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг хангах үндэсний хэмжээний тогтолцоог ч бий болгожээ. Тус холбоо нь 9500 гаруй гишүүнтэй бөгөөд холбоо болон 21 аймгийн салбаруудад нийт 52 хүн цалин хөлстэй ажиллаж байна. МХҮХ нь сургалтын төвөөрөө дамжуулан Брайл үсэг, компьютерийн хэрэглээг зааж, бэлтгэсэн хүмүүсээ Брайл ном хэвлэх үйлдвэрт ажиллуулж байна. Холбоо нь өөрийн радиотой бөгөөд хараагүй болон сул хараатай хүмүүсийг ажиллуулдаг. Түүнчлэн Монгол уламжлалт гэр үйлдвэрлэдэг үйлдвэрт хараагүй болон сул хараатай хүмүүсийг ажиллуулж байна (Young-Saver, 2013).

МХҮХ нь ИНБ-ууд хууль тогтоомжийн чанарыг сайжруулах, төрийн үйлчилгээг ард түмэнд үр дүнтэй хүргэхэд нөлөөлж чадахыг харуулсан тодорхой жишээ болж, төрд тулгардаг мэдээлэл, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал байдлыг хэрхэн даван туулж болохыг харуулж байна. Хэрвээ зөнд нь орхисон бол төрийн албан хаагчдад хөгжлийн



бэрхшээлтэй иргэдэд бодит тусламж болохуйц хууль тогтоомжийг боловсруулах мэдлэг, хүсэл эрмэлзэл дутах байсан нь лавтай. МХҮХ-ноос санаачилга гаргаж, хуулийн төслийг боловсруулалцсанаар хууль тогтоогчид Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хуулийг батлан гаргажээ.

Хөгжиж буй улс оронд тулгарч болох өөр нэгэн асуудал нь төрийн зүгээс хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй бусад иргэнд зориулсан ажлын байрыг хангалттай хэмжээнд бий болгох боломжгүй байдаг. Тиймээс МХҮХ нь өөрийн гэсэн үйлдвэрийг ажиллуулснаар, хөдөлмөр эрхлэх боломж бүхэн хаалттай ч байж болох олон хүнийг ажлын байраар хангаж байна. Эдгээр санаачилгыг гаргаснаар тус холбоо нь төрийн байгууллагын ачаанаас хөнгөлж, төрийн тогтолцооны хууль ёсны байдлыг хангахад хувь нэмрээ оруулж байна.

МХҮХ хүчин чармайлт гаргаагүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний гэр бүлийнхэн эрхээ эдэлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтээс гадуур үлдэх магадлалтай байв. Гэвч одоогийн байдлаар тус холбоо нь улс төрийн дэглэм дэх өөрийн эзлэх хувийг тогтвортой хангаж, бодит үр дүнг үзүүлжээ.

МХҮХ хуучин тогтолцооны үед суурь нь тавигдсан ч, ардчилсан тогтолцоонд шилжсэний дараа нийтийн эрх ашгийг хэрхэн бодитоор хамгаалагч байгууллага болж хөгжихийн жишээг харуулж байна. Пост коммунист олон оронд өмнөх тогтолцооны үед үүссэн олон нийтийн байгууллагуудын дийлэнх нь үгүй болсон, эсвэл төрийн гар хөл болсон хэвээр байна. Зөвлөлтийн өмнөх дэглэмийн үед нийтийн эрх ашгийг бодитойгоор төлөөлөхөөс илүүтэйгээр дүр үзүүлдэг байсан МХҮХ нь нээлттэй улс төрийн системд хэрхэн бие даасан байгууллага болж, үйл ажиллагаагаа итгэл төгс явуулахын зэрэгцээ, дэглэмийн хууль ёсны байдлыг сайжруулахад нь төрд дэмжлэг үзүүлж болдгийг харуулж байна.

## **Эдийн засгийн хүчирхэг ашиг сонирхлыг сөрөн зогсох нь**

Иргэний нийгэм хүчтэй байх нь нийгэм дэх ашиг сонирхлын тэнцвэргүй байдлыг сөрөн зогсож, төрийн хэт эрх мэдлийг тэнцвэржүүлж чаддаг. Үүний нэг жишээ нь “Онги голынхон” хөдөлгөөн, түүний суурин дээр Монголын нүүдэлчин ардыг төлөөлж байгуулагдсан, уул уурхайн хүчирхэг корпорацуудын эсрэг тэмцэж, ялалт байгуулсан “Монголын гол, нууруудын нэгдсэн хөдөлгөөн” (МГННХ) юм.

“Онги голынхон” хөдөлгөөн нь анх 2001 онд Онги гол дамжин урсдаг гурван аймагт үүсгэн байгуулагджээ. Хөдөлгөөний зорилго урсгал нь татарч ширгэсэн Онги гол болон Улаан нуурыг сэргээхэд оршиж байжээ. Тус гол 435 км урттай хэдий ч, ай сав газраар алтны уурхай идэвхтэй ажиллагаа явуулснаас урсгал нь тасалдан, дөнгөж 100 км-ын уртад урсах болсноос тус голын цутгадаг Улаан нуур ширгэжээ. Тус хөдөлгөөний үйл ажиллагаанд Германы Христийн ардчилсан намтай холбоотой “Конрад

Аденаурын Сан” ТББ анхны дэмжлэгийг олгосноос хойш Азийн Сан, АНУ-ын ОУХА, Мерси Кор болон Нээлттэй нийгэм форум зэрэг байгууллагаас санхүүжүүлж байжээ.

Тус хөдөлгөөн нь 2002 онд судалгаа хийж, уул уурхайн үйл ажиллагаанаас болж 10 гаруй голын урсгал хаагдаж, Онги голд цутгах горим өөрчлөгдсөн гэж дүгнэжээ. Хөдөлгөөнийхөн энэхүү дүгнэлтийг УИХ-ын нөлөө бүхий гишүүдэд танилцуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамыг бие даан шалгалт хийлгэхээр лоббидох үйл ажиллагааг явуулжээ. Дараа жил нь хөдөлгөөний удирдлагаас Монгол Улсын Ерөнхийлөгчид хандсан захидал, Ерөнхий сайдад хандсан голын урсгал сэргээх арга хэмжээ авахыг шаардсан хүсэлтийг тус тус илгээжээ. Захидалд энэ сөрөг үзэгдлийн нөлөөнд өртсөн бүс нутагт оршин суудаг 1200 гаруй хүн гарын үсэг зурсан байна.

Хөдөлгөөний үйл ажиллагаа 2004 онд дээд цэгтээ хүрч өргөжжээ. Тав, зургаадугаар сард 2000 гаруй идэвхтэн Онги голын дагуу 435 км газраар эсэргүүцлийн хөдөлгөөн зохион байгуулж, замдаа 12 удаагийн олон нийтэд хандсан арга хэмжээг зохион байгуулсны нэг нь алтны уурхайд болжээ. Уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хэмжээнд сурталчилснаар олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн байна. Арга хэмжээний дараа “Онги голынхон” хөдөлгөөн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) алт олборлож буй газар нутгуудаар хамтарсан аялал зохион байгуулжээ. Энэхүү арга хэмжээнд холбогдох гурван аймгийн засаг дарга, уул уурхайн компаниудын төлөөлөл оролцжээ. Улмаар АМГТГ нь гол, нууруудын ус багасаж байгаагийн шалтгааныг илрүүлэх зорилго бүхий иж бүрэн судалгаа хийлгэжээ. Тус хөдөлгөөн нь УИХ-ын гишүүдийг зөвлөхөөр ажиллуулах замаар лобби хийх ур чадвар болон төрийн байгууллагуудтай тогтоосон хэлхээ холбоогоо бэхжүүлж иржээ. “Онги голынхон” хөдөлгөөн нь өсөн хөгжиж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг ИНБ-уудтай эвлэлдэн нэгдэж, үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн байна (Beck et al., 2007). Тус хөдөлгөөн, хамтран ажиллагч байгууллагууд нэгдэн нийлж 2008-2009 онд МГННХ-ийг байгуулж, үүний хүрээнд идэвхтнүүдээ албаны хүмүүс, эрдэмтэн судлаачдын хамтаар Монгол Улсын бүхий л бүс нутагт илгээн ажиллуулж, байгаль орчныг хамгаалах бүсийн хил хязгаарыг тогтоох, уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн орон нутгийн хүн амтай шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэн зөвшилцөх ажлыг хийжээ.

Дараагийн шатанд, засгийн газраар шийдвэр гаргуулах байсан ч, уул уурхайн компаниудын эрх мэдлийг хязгаарлах нь амар хялбар ажил байсангүй. УИХ-аас холбогдох хуулийг батлахгүй хойшлуулахад хөдөлгөөнийхөн өлсгөлөн зарлажээ. Түүнчлэн, нэгдсэн хөдөлгөөний идэвхтнүүд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах чиглэлээр УИХ-ын гишүүдтэй хамтран ажиллаж эхэлсэн байна. Үүний үр дүнд “Урт нэртэй хууль” хэмээн нэрлэгдэх “Гол, мөрний урсац бүрэлдэх

эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль"-ийг батлан гаргажээ (Rivers Without Boundaries, n.d.).

Хэдийгээр хууль батлагдсан ч, түүний хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд олны анхаарал татсан дараагийн үйл ажиллагааг явуулах шаардлага урган гарчээ. Олон зуун малчин Улаанбаатар хотод 2011 оны 5 дугаар сард хүрэлцэн ирж, нийслэлийн төв-Чингисийн талбайд өлсгөлөн зарласан байна. Улмаар Монгол Улсын Дээд шүүх МГННХ-ний нэхэмжилсэн гомдлыг хэлэлцэж, гол усны эх, ойн сан бүхий газруудад уул уурхайн үйл ажиллагааг хориглох арга хэмжээ авахыг 10 дугаар сард засгийн газарт даалгасан байна. Ингэснээр засгийн газрын зүгээс урт нэртэй хуулийг нухацтайгаар хэрэгжүүлж эхэлжээ (Simonov, 2013).

Нэг талаас орон нутгийн иргэдийн байгууллага, тэднийг дэмжигчид, нөгөө талаас их хэмжээний санхүүжилт өгч чадах уул уурхайн компаниудын эрх ашгийг хамгаалах улс төрчид хоорондын тэмцэл өрнөсөөр байна. Энэ тэмцэл нь монголын төр дэх маргааны салшгүй хэсэг болсон байна. Засгийн газраас урт нэртэй хуульд 2015 оны 2 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулснаар дахин өлсгөлөн, жагсаал цуглааны шинэ давалгааг эхлүүлжээ. Эсэргүүцлээс үл хамааран цагаан сарын үеэр төрийн үйл ажиллагаанд тавигдах олон нийтийн хяналт суларсан мөчийг тааруулан, УИХ уул уурхайн компаниудад тавигдах зарим хязгаарлалтыг хөнгөвчилсөн хуулийн нэмэлт өөрчлөлтийг чимээгүйхэн баталжээ (Shourd et al., 2015).

МГННХ, түүний хамтран зүтгэгчид байнга ялалт байгуулж байгаагүйг 2015 онд урт нэртэй хуульд хийгдсэн өөрчлөлтөөс харж болно. Гэсэн ч тархан суурьшсан, эдийн засгийн хүчин чадал сул монгол малчдын хувьд асар баян, үндэстэн дамнасан компаниудын эсрэг бодит ялалт байгуулж чадсан нь цохон тэмдэглүүштэй амжилт билээ. Зарим нэг ухралт гарсныг үл тооцвол, МГННХ болон хамтрагч байгууллагууд нь Онги голын сав газарт аюул учруулж буй олон арван уул уурхайн компанийн үйл ажиллагааг зогсоож, нүүдэлчин малчдын нутаг бэлчээрийг хамгаалсан амжилттай байна (Goldman Environmental Prize, n.d.). Энэхүү хүч тэнцвэргүй тулаанд жижигхэн хөдөлгөөн ялалт байгуулах нь хөгжиж буй оронд төдийгүй хөгжингүй, аж үйлдвэржсэн орнуудад ч тэр бүр тохиодоггүй зүйл юм. Монгол Улсын суурин хүн амын ихэнх нь хөдөө орон нутгаас нүүдэллэн ирж суурьшаад, ердөө хоёр дахь үедээ явж байгаа бол, нийт монголчуудын гуравны нэгээс илүү хувь нь өнөөг хүртэл хөдөө орон нутагт амьдарсаар байна. Уул уурхайн компаниуд газар булаан авах явдлыг хянах нь олон сая жилийн туршид хэвшсэн амьдралын хэв маягийг хадгалах, орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэх хөдөлгөөнийг сааруулахад чухал үүрэгтэй юм.

МГННХ нь байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд үүсэж бий болоход сэдэл, урам зориг, дэмжлэг болоод зогсохгүй, тэд хамтдаа Монголын олон мянган нүүдэлчин малчдад

ардчиллын эерэг үр дүнг хүргэхээр ажиллаж байна. Уламжлалт малчны амьдралыг тэтгэгч байгаль орчин маш эмзэг атал, томоохон компаниуд үргэлжлүүлэн сүйтгэсээр байна. Тэгвэл нэгдсэн хөдөлгөөн монгол хүний мөн чанартай нягт уялдсан амьдралын хэв маягийг хадгалж үлдэхийн төлөө тэмцэж байна. Түүнчлэн тус хөдөлгөөн нь УИХ-ын 76 гишүүнийг цөмийг нь, цөөн тооны сайд нарт санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаад өөрийн ашиг сонирхлыг улсын ашиг сонирхол болгож чадахуйц уул уурхайн компаниудыг хянаж сэргийлж чадаж байна. Ардчилсан тогтолцоог ийнхүү шууд, хүчирхэг байдлаар дэмжиж буй хөдөлгөөнийг төсөөлөн бодоход ч хэцүү байдаг билээ.

## **Нийгмийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, шаардах нь**

Эмзэг хэмээн тооцогддог бүлгийн эрх ашгийг хүчирхэг бүлгээс хамгаалах, ахиц дэвшил гаргах нь иргэний нийгмийн байгууллагуудын үндсэн үүргийн нэг билээ. МГННХ нь энэ үүргийг нүүдлийн мал аж ахуйд аюул учруулж буй уул уурхайн компаниудыг сөрөх байдлаар гүйцэтгэж байна. Харин зарим байгууллага компани болон төрд шууд эсэргүүцэл үзүүлж тулалгүйгээр эмзэг бүлгийн иргэдэд тусалж байдаг. Заримдаа үл тоох, ичих, чимээгүй дарж өнгөрөөх нь хамгийн аюулт дайсан болж хувирдаг.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ) нь ийм л байгууллага юм. Тус төв эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, уг асуудлыг шийдэж ирсэн хууль зүйн орчныг шинэчилсэн нөлөөллийн үйл ажиллагааг эрхлэн явуулж иржээ. Тус төв нь улс даяар 18 салбар, 6 түр хоргодох байр ажиллуулж, 20 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. АНУ-ын Азийн Сан нь ХЭҮТ-ийн үйл ажиллагаанд зориулан санхүүжилт олгосон анхдагч байгууллагуудын нэг байв (Asia Network of Women's Shelters, n.d.).

ХЭҮТ-ийг анх 1995 онд Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо (МХЭХ) гэсэн эмэгтэйчүүдийн гурван байгууллага хамтран үүсгэн байгуулжээ. ХЭҮТ нь олон зууны туршид оршсоор ирсэн, ужгирсан гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг сүүдрээс гарган нийгэмд ил болгожээ. Тус төвийн эхний үйл ажиллагаа нь, нийт 5000 оролцогчийг хамруулсан судалгаа хийсэн бөгөөд цаашлан, томоохон хэмжээний давтан судалгааг хийсэн байна. Дараагаар нь тус төв 2001 онд хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа, 2003 онд өндөр настнуудын эсрэг хүчирхийллийн судалгааг тус тус хийжээ. ХЭҮТ-ийн судалгааны арга зүй нь шинэлэг, зоримог бөгөөд зөвхөн асуулга аваад зогсохгүй, олон тооны ярилцлага хийж, шүүх эмнэлгийн үзлэгийн тодорхойлолт зэргийг ашигласнаар судалгааны чанарыг бүрэн хангадаг байна.

Судалгаагаар цуглуулсан мэдээллээр зэвсэглэсэн ХЭҮТ нь гэр бүлийн хүчирхийллийн талаар олон нийтийн дундах яриа хэлэлцүүлгийн үндсэн

чиглэлд өөрчлөлт гаргаж чаджээ. Тус байгууллагын удирдлага нь сонин хэвлэл, цахим мэдээллээр олон нийттэй холбоо тогтоож, олон нийтийн семинарууд зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын захидлыг төрийн өндөр албан тушаалтнуудад хүргэж байв. Шинэ зууны эхээр тус төв сонгуулийн улс төрийн үйл ажиллагаанд оролцож эхэлжээ. УИХ-ын 2000 оны сонгуулийн компани ажлын үеэр тус төв нь МХЭХ-той баг болж, сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрт эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг хууль тогтоомжийг шинэ шатанд гаргах амлалт оруулахыг уриалан ажиллажээ. ХЭҮТ нь өмнө хийсэн бүхий л судалгааныхаа үр дүнг тоймлон 2003 онд хэвлэн нийтэлж, шинэ хуулийн орчин бүрдүүлэх үйл ажиллагааг мэдээллээр хангаж өгчээ.

Энэ бүхний дараа албан тушаалтнууд арга хэмжээ авч эхэлжээ. Дээр дурдсан баримт бичгүүдийг хэвлэн нийтэлсний дараахан УИХ-аас цагдаа, шүүх, прокурор, хэвлэл мэдээллийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулсан байна. ХЭҮТ-ийн захирал Д.Энхжаргал, МХЭХ-ны захирал Н.Чинчулуун нар ажлын хэсэгт тэргүүлэх гол үүрэг гүйцэтгэжээ. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2004 онд ХЭҮТ болон МХЭХ-ны захирлуудыг урин, УИХ-ын гишүүдэд хандан үг хэлүүлж, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр чанга хууль гаргах талаар яриулсан байна. Үүний үр дүнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн төслийг 19 гишүүн өргөн мэдүүлснээр 2004 оны 5 дугаар сард санал нэгтэй баталсан байна (Beck et al., 2007).

Тус хуулиар гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авч, хэрэг үүсгэн шалгах, хэргийн газарт үзлэг хийх, үйлдэгчийг байцаах, хохирогчийг түр хамгаалах байранд хүргэх зэрэг үүргийг ноогдуулжээ. Мөн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид ногдуулах хариуцлагыг тогтоосны дотор гэрээсээ хол байх, дундын эд хөрөнгийг ашиглахыг хориглох, хүүхдэд ойртохыг хориглох болон зан үйл өөрчлөх сургалтад хамруулах зэргийг заажээ (Department of State, 2015).

ХЭҮТ, МХЭХ зэрэг байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэх мэт дуу хоолойгоо нийгэмд тэр бүр хүргэж чаддаггүй хүмүүст өөрийгөө илэрхийлэх, оролцоог нь хангах боломжийг олгох замаар ардчиллыг дэмжин хөгжүүлж байна. Хэдийгээр, хүмүүс өөрийгөө эрх мэдэлгүй, улс төрөөс хаягдсан мэт санаж болох ч ХЭҮТ, МХЭХ зэрэг нөлөөллийн байгууллага тэдний дуу хоолой, холбох гүүр нь болсоор иржээ.

Монголчууд төр засгаа байнга шүүмжилдэг ч, ардчилсан тогтолцоог дэмжиж байдаг нь ИНБ-уудын эрч хүч, идэвх санаачилгын үр дүн юм. Монгол Улсад нэр хүндтэй, тэргүүлэх судалгааны байгууллагын хийсэн судалгаагаар сүүлийн жилүүдэд эдийн засаг болон төрийн үйлчилгээний чанарт итгэх иргэдийн итгэл буурсаар байна. 2016 оны хавар хийсэн судалгаагаар нийт оролцогчдын 67 хувь нь “Ардчилсан зарчмаар сонгогдсон төр засаг” “маш сайн” эсвэл “сайн” хэмээн үзсэн бол 21 хувь нь үүнийг “маш муу” эсвэл “муу” хэмээн үзжээ (Sant Maral Foundation, 2016). 2014 онд хийсэн Азийн барометрийн судалгаа ч энэ үр дүнг баталж байна.

Илүү баталгаажуулахын тулд эдгээр судалгааны дүн нь хатуу, тогтсон зүйлс бус болохыг харгалзан “Ардчилал байнгын хэрэгцээтэй зүйл” эсвэл “Авторитари дэглэм байнгын хэрэгцээтэй зүйл” мөн эсэхийг асуухад 44 хувь нь эхний хариултыг, 35 хувь нь сүүлийн хариултыг сонгож байжээ. Эндээс Монгол Улсын иргэдийн гуравны нэгээс илүү хувь нь авторитари дэглэм ардчилсан тогтолцооноос илүү сайн байж магад хэмээн үзэх боломжтойг харуулж байна. “Ардчилал нь өөрийн гэсэн асуудалтай байж болох ч, энэ нь төрийн хамгийн сайн хэлбэр мөн” эсэхийг асуухад 82 хувь нь үүнтэй санал нийлж, 16 хувь нь үгүйсгэж байжээ (Asian Barometer, 2014).

## Тулгарч буй сорилтууд

Монголын ардчилал нь хүчирхэг иргэний нийгэмтэй хэдий ч ихээхэн сорилттой нүүр тулсаар байна. Үүний нэг нь, нэг намын давамгайлал юм. Эрх баригч МАН-ын хувьд олон ургалч үзлийг дэмждэг хэдий ч, үүнд найдах боломжгүй юм. Тус нам 2016 оны сонгуулиар ялалтын тавцанд гарч ирснийхээ дараа бүх 16 сайдын суудлыг өөрийн гишүүдээр бүрдүүлжээ. Нэг намын ноёрхол нь хамгийн таатай, сайн нөхцөлд ч нээлттэй засаглалд сорилт учруулдаг. Нөгөө талаас Монгол Улсыг хамгийн таатай нөхцөл байдалтай байна гэж үзэх хэцүү. Зэргэлдээ хөрш орнууд дахь ардчиллыг эсэргүүцэх үзэл сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байна. Ялангуяа Оросын зүгээс олон улсын хэмжээнд ганц хүний ноёрхлыг хөхиүлэн дэмжиж сурталчлахад ихээхэн хөрөнгө хаях болоод байна (Diamond et al., 2016).

Монгол Улсад өнөөдөр тулгараад буй эдийн засгийн хямрал нь гаднаас ирэх дарамт, өдөөн хатгалгад өртөх магадлалыг нэмэгдүүлж байна. Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ сүүлийн үед огцом унасан нь Монгол Улсад санхүүгийн дэмжлэг туслалцаа авах хэрэгцээг үүсгэж, зарим удирдагч нь Хятадыг Олон улсын валютын сангийн оронд байж болох боломжит сонголт хэмээн харах болжээ (Bernard, 2016). Хэрвээ Монгол Улсыг ардчиллын тухай бүдэг ойлголтоос хэтэрдэггүй хоёр хөршийнхөө нөлөөнд автуулахгүй гэвэл барууны санхүүгийн байгууллагууд тус улсын дундарч буй санхүүг дэмжих шаардлагатай болж байна.

Алт, бусад үнэт металлын чиглэлийн уул уурхайн олборлолт их хэмжээгээр нэмэгдэж байгаа нь ч өөрөө олон тооны сорилтыг дагуулах болжээ. Байгалийн баялаг ихтэй улс орнуудад эрх баригч элитүүд өөрсдийгөө хянаж чаддаггүй нь ардчилалд сөрөг үр дагавар болдог. Орост гэхэд 1990-ээд онд байгалийн баялгийн “албан ёсны” авлига гаарсан нь энгийн иргэдийн ардчилалд итгэх итгэл алдрах, эрх баригчдын дээрмийг зогсоож чадахгүй юм байна гэж үзэхэд хүргэсэн түүхтэй. Энэ туршлага улмаар оросуудын ардчилалд үзүүлэх нөлөөлөл нь ямар байхаас үл хамааран авлигыг бууруулж, олигархуудын хяналтыг эвдэхээр амласан

удирдагчийг илүүд үзэхэд хүргэж байна. Түүнчлэн, Зөвлөлт засаг унасны дараа шинээр төрсөн улс төрчид газрын тосны орлогыг өөрсдийгөө баяжуулахад зарцуулж, хэт их нуух зүйлстэй болсноор засаглалыг нээлттэй байлгах сонирхолгүй болжээ (Fish, 2005).

Орос маягийн энэ түүх Монголд давтагдаж болох ч, иргэний нийгмийн хөгжил монголын ардчилалд давуу талуудыг бий болгож байна. Ил тод байдлыг сахиулагч “Глоб Интернейшнл”, түүний хамтрагчид мэдээж авлигыг арилгаж чадаагүй ч, улсын төсөв, санхүү, худалдан авалтыг ил тод болгож, Орос болон олон тооны хөгжиж буй оронд харж болох цөөн хэдэн хүн ямар ч хяналтгүйгээр бүхнийг захирдаг тогтолцооноос урьдчилан сэргийлэхэд түлхэц болж байна. “Онги голынхон”, МГННХ зэрэг идэвхтэй, байгаль орчны иргэний хөдөлгөөн нь хүчирхэг, үндэстэн дамнасан уул уурхайн компаниуд төрийн хяналтыг гартаа авахыг эсэргүүцэж байна. МХҮХ зэрэг байгууллага нь төрд бодлого боловсруулахад нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ, ашиг сонирхлыг нь уламжлал ёсоор үл хайхарч ирсэн нийгмийн бүлгүүдийн эрэлт хэрэгцээг ил болгож, хангаж байна. ХЭҮТ нийгэм дэх эмзэг асуудлыг сүүдрээс гаргаж, саяхныг хүртэл дуу хоолойгоо илэрхийлж чадахгүй байсан нийгмийн бүлэг болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын ашиг сонирхлыг алхам алхмаар урагшлуулж байна.

Монгол Улсын иргэний нийгмийн салбар тус улсын ардчилсан үйл явц нь цааш үргэлжилж, хөгжин цэцэглэлтийг баталгаажуулах хэмжээнд хүрээгүй ч, ардчиллын гаргаад буй амжилтын салшгүй нэгээхэн хэсэг болж чаджээ.

## Ном зүй

Asia Network of Women’s Shelters. n.d. “National Center Against Violence, Mongolia.” URL: <https://shelterasia.org/national-center-against-violence-mongolia/>.

Asian Barometer. 2014. *Wave 4 Survey*. URL: [www.asianbarometer.org/survey/wave4-mongolia](http://www.asianbarometer.org/survey/wave4-mongolia).

Beck, Linda, Toby Mendel and Jeff Thindwa. 2007. *The Enabling Environment for Social Accountability in Mongolia*. Washington D.C: World Bank.

Berman, Sheri. 1997. “Civil Society and the Collapse of the Weimar Republic.” *World Politics*, 49: 401–429.

Bernard, Andrew. 2016. “Why Chinese Money is Not the Answer to Mongolia’s Woes.” *The Diplomat*, October 20. URL: <https://thediplomat.com/2016/10/why-chinese-money-is-not-the-answer-to-mongolias-economic-woes>.

- Diamond, Larry, Marc F. Plattner and Christopher Walker (eds). 2016. *Authoritarianism Goes Global: The Challenge to Democracy*. Baltimore: John Hopkins University Press.
- Enkhbataar, Ch., D. Solongo, P. Amarjargal and Tom Ginsburg. 2015. *The Role of the Constitution of Mongolia in Consolidating Democracy: An Analysis*. Ulaanbaatar. Munkhiin Useg.
- Fish, M. Steven. 2005. *Democracy Derailed in Russia: The Failure of Open Politics*. New York: Cambridge University Press.
- Fish, M. Steven and Jason Wittenberg. 2009. "Failed Democratization." In Christian W. Haerpfer, Patrick Bernhagen, Ronald F. Inglehart and Christian Welzel (eds), *Democratization*. New York: Oxford University Press.
- Freedom House. 2016. *Individual Country Ratings and Status, 1973–2016*. URL:<https://freedomhouse.org/report-types/freedom-world>.
- Globe International. n.d. *Freedom of Information*. URL: <http://globeinter.org.mn/old/en/emech/index.php>.
- Goldman Environmental Prize. n.d. "The Goldman Environmental Prize: Ts. Munkhbayar." URL: <https://www.goldmanprize.org/recipient/tsetse-gee-munkhbayar/>.
- International Republican Institute and the Zorig Foundation. 2015. *How Democracy Was Born in Mongolia*. Ulaanbaatar. Munkhiin Useg.
- National Center Against Violence.n.d. "Who We Are." URL: <http://safefuture.mn/en/news.php?action=content&id=1#>.
- Organization for Security and Co-operation in Europe. 2016. *Mongolia, Parliamentary Elections, June 29, 2016: Final Report*. October 16.
- Pop-Eleches, Grigore and Joshua Tucker. 2013. "Associate with the Past? Communist Legacies and Civic Participation in Post-Communist Countries." *East European Politics and Societies*, 27: 45–68.
- Putnam, Robert D. 1994. *Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy*. Princeton: Princeton University Press.
- Rhoades, Hannibal and Odno Shourd. 2015. "Hunger Strike and Protest: Mongolian Government Gives Green Light to Hundreds of Mining Projects." *Yes to Life No to Mining*, March 4. URL: <http://www.yesto-lifenotomining.org/hunger-strike-protest-mongolian-government-gives-green-light-hundreds-mining-projects/>.
- Rivers Without Boundaries. n.d. "The Short History of the Law with Long Name." URL: <http://www.transrivers.org/documents/rivers-and-mining/the-short-history-of-the-law-with-long-name/>.



- Sant Maral Foundation and Konrad Adenauer Stiftung. 2016. *Politbarometer #15(49)*. URL: [www.santmaral.org/sites/default/files/SMPBE16.Mar%20\(updated\).pdf](http://www.santmaral.org/sites/default/files/SMPBE16.Mar%20(updated).pdf).
- Simonov, Eugene. 2013. "Protect Mongolian Rivers from Mining!" *International Rivers*, November 20. URL: <https://www.internationalrivers.org/blogs/227/protect-mongolian-rivers-from-mining>.
- Tocqueville, Alexis de. 2004. *Democracy in America*. New York: The Library of America.
- Transparency International. *Corruption Perceptions Index*. URL: <http://www.transparency.org/research/cpi/overview>.
- United Nations Educational, Scientific and Cultural Organization. 2016. *Assessment of Media Development in Mongolia: 27*. URL: <http://unesdoc.unesco.org/images/0024/002453/245364e.pdf>.
- U.S. Department of State. 2006. *2005 Human Rights Report: Mongolia*. URL: <https://2009-2017.state.gov/j/drl/rls/hrrpt/2005/>.
- Young-Saver, Dashiell. 2013. "Blind to the Blind: The Struggle for Opportunity in Mongolia." *The UB Post*, June 13. URL: <http://ubpost.mongolnews.mn/?p=4457>.



## Социализмын дараах үеийн Монголын иргэний нийгмийн хувирал өөрчлөлт

Далайбуяны Бямбажав

Монголын иргэний нийгмийг 1990-ээд онд ардчиллын төлөөх нийгмийн хөдөлгөөний саармагжилт болон “төрийн бус байгууллагажилт” тодорхойлж байсан бол, 2000-аад оноос хойших 10 жилийг иргэний хөдөлгөөнүүдийн дэлгэрэлт, нийгмийн оролцооны олон хэв шинжит байдал тодорхойлж байна. Монголын ардчиллын (хараахан бэхжээгүй) “содон” амжилт нь нийгмийн олон янзын асуудал, хэлбэр, арга зам хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлж өгчээ. Гэвч иргэний нийгмийн гол өөрчлөлт нь өмнөх коммунист намын үргэлжлэл МАХН (одоогийн МАН)-ын хүчтэй нөлөөн дэх улс төрийн орчны сөрөг хүчний намууд ямар үүрэгтэй байснаас ихээхэн хамаарч иржээ. Монголын иргэний нийгмийн орон зай улс төрийн намуудад эзлэгдсэн ба иргэний нийгмийн байгууллагууд нөөц маш хязгаарлагдмал орчинд үйл ажиллагаа явуулж иржээ. Иргэний нийгмийн байгууллагуудын хэлбэр, үйл ажиллагаа, үнэлэмжид нөөцийн хүртээмж, боломж маш их нөлөөтэй байна. Иргэний нийгмийн орон зай дахь улс төрийн намуудын нөлөө суларсан боловч иргэдийг зохион байгуулалтад оруулах хувилбар, арга, хэлбэрүүд бэхжиж амжаагүй байна.

### Оршил

Социализмын дараах шилжилтийн үеийн улс орнуудын хувьд иргэний нийгэм хэрхэн өөрчлөгдөн хувирав гэдэг асуудал нь онол, практикийн чухал ач холбогдолтой юм. Эдгээр улс оронд нам-төрийн байгууллагаас хараат бус аливаа үйл ажиллагаа, зохион байгуулалтын уг үндсийг таслах бодлого олон арван жил хэрэгжсэн түүхтэй. Бусад ардчилсан улс оронтой харьцуулахад, пост социалист социализмын дараах шилжилтийн улс орнуудын иргэний нийгэм сул дорой гэж үздэг (Howard, 2003; Lane, 2010; Uhlin, 2006). Социализмын дараах үеийн нийгмийн өөрчлөлтийн талаарх судалгаануудаас үзэхэд, 1990-ээд онд иргэдийн улс төрийн идэвх суларсан, ёс суртахууны үнэлэмж унасан, иргэний нийгмийн идэвх буурсан байна. Түүнчлэн, социализмын дараах улс орнуудад төрийн бус байгууллагууд (ТББ) тухайн нийгэм, орон нутагтаа суурь муутай, гадаадын санхүүжилтээс хамаарсан байх нь элбэг аж (Crotty, 2009; Mendelson and Glenn, 2002). Социализмын дараах зарим улс оронд авторитарианизм руу шилжих эрсдэл үүссэн үед ч иргэний нийгмийн хүчтэй эсэргүүцэл гарч байгаагүйг онцолсон байна (Carmin and Fagan, 2010).

1990 онд төрийн социализм нуран унасны дараа бусад “шилжилтийн” улс орны адилаар Монгол Улс асар их өөрчлөлтийг туулсан. Шилжилтийн

явцад хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан, мөн Зүүн Европын олон улс оронд “ардчиллын ухралт” явагдсан бол, Монгол Улсын хувьд олон нам бүхий улс төрийн тогтолцоо, чөлөөт сонгуулиа хадгалж ирсэн (Bertelsman Foundation, 2018). Олон улсын ажиглагчид Монгол Улсыг “ардчиллын шилжилтийн амжилт” хэмээн тогтмол үнэлж ирсэн. Гэвч улс төрийн намууд ба төрийн институцид авлига газар авсан нь ардчиллыг бэхжүүлэхэд ноцтой аюул учруулж байгааг мөн анхааруулсаар иржээ (Fritz, 2002; Dierkes, 2018).

Ардчилагдах үйл явцыг сонирхон судлагчдын хувьд Монголын ардчиллын ололт амжилт нь маш сонирхолтой хийгээд ээдрээтэй жишээ болдог (Fish, 1998, 2001; Fritz, 2002; Radchenko and Mendee, 2018). Стевен Фиш (Fish 1998, 129) “Ардчиллын ололт амжилтаар Туркменистан, Узбекистаны түвшинд л “очих ёстой” улс яаж Унгар, Польштой мөр зэрэгцэх болов?” гэж асуусан байдаг. Монгол Улс бол дэлхий дахинаа социалист нийгмийг тунхагласан хоёр дахь улс байсны зэрэгцээ, Өрнөдөөс олон арван жил тусгаарлагдсан байв. Социализмын өмнөх үед Монгол нь бурхны шашинт төрийн удирдлагатай байв. Социализмын дараах үед бурхны шашин, үндэсний үзэл, уламжлалт соёлын үнэлэмжүүд сэргэсэн. Монголын хүн амын гуравны нэг нь 1980-аад оны сүүлчээр хагас нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан. 1990-ээд оны эхэн үед Монгол Улсад нүүрлэсэн эдийн засгийн хямрал нь барууны улс орнууд дахь Их хямралын үеэс ч илүү ноцтой байсан гэж Петер Бууни (Boone 1994) үзсэн байдаг. Ардчиллын тухай нийтлэг онолд ардчилах үйл явц явагдахад модернизаци, хотжилт, дундаж давхарга (эдийн засгийн тогтвортой байдал), барууны соёл, шашны уламжлалд ойр байдал зэрэг нэжгээд урьдач нөхцөл байх шаардлагатай гэж үзсэн байдаг. Энэ талаас авч үзвэл, Монгол Улс нь ардчиллын “хэвийн бус” буюу нийтлэг хандлагаас зөрүүтэй “содон” тохиолдол юм.

Монголын ардчиллын үйл явцад чухал нөлөө үзүүлсэн хүчин зүйлсийн нэг нь иргэний нийгэм гэж судлаачид үздэг (Fish, 1998). Иргэний нийгэм гэдэг ойлголт нь Монгол дахь ардчиллын талаарх судалгаа, хэлэлцүүлгийн чухал хэсэг юм. Гэвч Монгол дахь иргэний нийгмийн талаарх эмпирик судалгаа дутагдалтай байдаг. Иргэдийн альянс төв ба CIVICUS (иргэний оролцоог хангах дэлхийн альянс) байгууллагаас хамтран 2004 онд гаргасан “Иргэний нийгмийн индекс” үнэлгээний тайланд монголын иргэний нийгмийн талаарх олон асуудлыг авч үзсэн байна (ССА, 2005). Гэвч уг судалгаанд иргэний нийгмийн чухал өөрчлөлт, хувиралтуудыг ойлгоход шаардагдах лонгитудинал болон үйл явцын дүн шинжилгээ хийгдээгүй байна.

Социализмын дараах иргэний нийгмийн талаарх судалгаа Зүүн Европ, Төв Ази, Оросын Холбооны Улс зэрэг томоохон бүс нутаг, улс оронд онцлон төвлөрсөн байдаг. Харин Монгол болон зарим улс орон анхаарлын гадна үлдэх нь элбэг аж. Монголын туршлага анхаарлын гадна ингэж үлдэх нэг шалтгаан нь улс орнуудыг бүсчлэн авч үздэг

арга зүйтэй холбоотой. Монгол Улс нь бүс нутаг судлал, нийгэм-улс төрийн харьцуулсан судалгаанд ашигладаг ангиллаас “сондгойрч” үлдэх тохиолдол олон жилийн угшилтай (Sabloff, 2011). Нөгөө талаас, судлаачдын байр сууринаас хамаарч Монгол Улс нь нэг бол Зүүн Хойд Ази эсвэл Дотоод Ази, Төв Еврази, Төв Азийн хэсэг болдог. Ингэж олон янзаар тодорхойлогдох байдал нь Монгол Улс бүс нутгийн харьцуулсан судалгаанаас орхигдох нэгэн шалтгаан болдог.

Социализмын дараах иргэний нийгмийн талаарх судалгаа нь эдгээр улс оронд өөрийн онцлог бүхий (онолын ба эмпирик түвшинд) иргэний нийгмийн хэв шинж илэрч буйг харуулдаг (Mendelson and Glenn, 2002; Uhlin, 2006). Жакобсон, Санович нар (Jakobson and Sanovich, 2010) ОХУ-ын хувьд иргэний нийгмийн хувьсал нь далд өсөлт, импортоос хамаарсан, нийгмийн суурьтай гэсэн залгамж бүхий гурван загварыг дамжсан гэж үзжээ. Нийгмийн суурьтай гэдэг нь, иргэний нийгэм тухайн улс үндэстний эдийн засаг, нийгэм, соёлын орчинд нийцсэн, “нутагшсан” хэв шинж юм. Төв Азийн бүс нутагт иргэний нийгмийн неолиберал ба хүй элгэний хэв шинж илэрч байна гэж зарим судлаач үздэг (Freizer, 2004; Suda, 2005). Түүнчлэн, социализмын дараах улс орнуудад иргэний нийгмийн дотор өөрийн “уугуул” буюу үндэстний онцлогтой үйл явц өрнөсөн гэж зарим эрдэмтэн үзжээ (Henry, 2010). Эдгээр судалгааны нэгэн адилаар бид, социализмын дараах “шилжилтийн” 20 жилийн турш Монгол дахь иргэний нийгэм хэрхэн өөрчлөгдөж хувирч ирснийг шинжлэхийг зорилоо.

Монголын иргэний нийгмийг 1990-ээд онд ардчиллын төлөөх нийгмийн хөдөлгөөний саармагжилт болон “төрийнллын төлөөх нийгмийн хөдөлгөөний саармагжилт, 2000-аад оны иргэний нийгмийг иргэний хөдөлгөөнүүдийн дэлгэрэлт ба нийгмийн активизмийн олон хэв шинжит байдал тодорхойлох болсон гэж энэ бүлэгт дүгнэв. Монголын ардчилсан үйл явцын (хараахан бэхжээгүй) “содон” амжилт нь олон төрлийн асуудлыг хөндөх, нийгмийн активизмын олон янзын хэлбэр, арга зам бий болох таатай нөхцөлийг бүрдүүлсэн боловч иргэний нийгмийн чухал өөрчлөлт нь хуучин коммунист нам болох МАХН (одоогийн МАН)-ын давамгайлж ирсэн улс төрийн орчин дахь сөрөг хүчний улс төрийн намуудын байр сууриас ихээхэн хамаарч иржээ. Иргэний нийгмийн орон зай дахь улс төрийн намуудын хүчтэй нөлөө суларсан боловч иргэдийг зохион байгуулалтад оруулах өөр арга хэлбэрүүд бэхжиж амжаагүй болохыг энэ бүлэгт авч үзлээ.

## Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн

Энэ бүлэгт монголын социализмийн дараах хорин жилийн туршид өрнөсөн өөрчлөлтийг зохиогчийн 2008-2012 онд Хоккайдогийн их сургуульд хийсэн докторын судалгааны ажлын хүрээнд цуглуулсан анхдагч мэдээлэлд үндэслэн шинжлэв. Энэхүү судалгаанд судалгааны холимог

арга зүй, хандлагыг баримталсан (Creswell, 2002) болно. Үүнд: нэгт, судалгааны мэдээлэлд ярилцлагын тэмдэглэлүүд, видео дүрс, сонины хайчилбар, олон улсын харьцуулсан судалгаа зэрэг чанарын болон тоон аргыг ашиглав. Хоёрт, зохиогч иргэний нийгмийн идэвхтнүүдтэй хийсэн ярилцлага, өдөрөхон а, гол сонины агуулгад хийсэн дүн шинжилгээ, иргэний нийгмийн байгууллагуудын дунд явуулсан асуулга судалгаагаар судалгааны мэдээллийг бүрдүүлэв. Гуравт, чанарын ба тоон мэдээллийг хослуулах, харилцан нөхөх замаар судалгааны үр дүнгийн баталгааг сайжруулахыг зорьсон болно (Small, 2011). Өөр өөр төрлийн мэдээллээс гарсан дүгнэлтийг харьцуулах, аль нэгэн арга зүй дутагдалтай үед өөр төрлийн арга зүйгээр нөхөх замаар судалгааны дүнг бататгасан болно.

## **Социализмын дараах “шилжилтийн” үеийн иргэний нийгэм**

Зарим судлаач хүйтэн дайны төгсгөлийг дэлхий дахинаа түгээмэл тогтох либерал ардчилсан үеийн эхлэл гэж үзсэн байдаг (Fukuyama, 1993). “Вашингтоны консенсус” буюу 1990-ээд оны эхэн үед хөгжиж буй, шилжилтийн үеийн улс орнуудын эдийн засгийн тогтолцоог либералчлах бодлогын чиглэлүүд нь тухайн үеийн иргэний нийгмийн тухай ойлголтод чухал нөлөө үзүүлсэн юм. Иргэний нийгэм гэдэг ойлголт либерал ардчилал, зах зээлийн капитализм зэрэг ойлголтын хүрээнд гарч ирсэн. Өрнөдийн донор байгууллагууд хөтөлбөртөө иргэний нийгмийн тухай нэлээд хялбаршуулсан хувилбарыг нэвтрүүлж, иргэний нийгмийг тодорхой байгууллага, ялангуяа ТББ-уудын нийлбэр гэж үзэж байв. Энэ хандлагын үүднээс өрнөдийн донорууд социализмын дараах үеийн улс орнуудад иргэний нийгмийг байгуулах, бүтээх, сайжруулах зорилт тавьсан байна. Либерал хандлагын талаарх гол шүүмжлэл нь донор байгууллагууд ба ТББ-уудын харилцаа, ялангуяа ТББ-уудын хууль ёсны, бие даасан байдал, тэдгээрийн иргэдийн эрх ашгийг төлөөлөх чадавхын тухай асуудал юм.

Социализмын дараах үеийн улс орнуудын иргэний нийгмийн тухай онолын ба эмпирик судалгаануудыг шинжилсний үндсэн дээр тэдгээрт ажиглагдаж буй нийтлэг асуудлыг социализмын ул мөр, иргэний нийгэмд зориулсан өрнөдийн туслалцаа, иргэдийн сул оролцоо гэж тодорхойлж болохоор байна.

### **Социализмын ул мөр**

Төрийн социализм нь дэлхийн зарим улс орон дахь авторитари дэглэмээс хол илүү түрэмгий тогтолцоо байсан юм. Эхэн үеийн авторитари дэглэмтэй харьцуулахад, төрийн социализм нь нам-төрийн байгууламжаас ангид аливаа нийгэм-эдийн засаг, улс төрийн бүлэглэл болон зах зээлжсэн эдийн засгийн харилцааг маш үр дүнтэйгээр хориглон хянаж байсан. Ийм хатуу хориг байгаагүй бол төрийн социализмыг нуран унасны дараа

нийгмийн дундаж анги ба хөрөнгөтөн хэсэг бүрэлдэн тогтох байв (Uhlir, 2006). Дэглэмийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хяналт ба патернализмын бодлого нь нийгэмд атомжилт, үл итгэлцлийг өдөөж байсан. Түүнчлэн, Лэйнийн үзсэнээр (Lane, 2010) төрийн социалист нийгмүүд нь “органик” эв нэгдэл гэхээс илүүтэй “механик” эв нэгдэлд суурилж байсан (Эмиль Дюркхаймын дэвшүүлсэн ойлголттой ижил утгаар). Социалист “хамтач үзэл” буюу механик эв нэгдэлд бүлэг эсвэл ангийн эрх ашиг гэж л байх бөгөөд түүнийг төр бататгадаг гэдэг ойлголтод үндэслэдэг. Төрийн социализм нь ийм хандлагыг хүмүүсийн оюун санаанд шингээж, “органик” эв нэгдэл үүсгэх аливаа хандлага, зан үйлийг хориглон хязгаарлаж байсан (Lane, 2010).

Түүнчлэн, коммунист засаг нуран унасан боловч шилжилтийн жилүүдэд олон элит өмнөх байр сууриа хадгалж үлдсэн байдаг. Коммунист нам, түүний харьяа байгууллагууд зэрэг улс төрийн чухал байгууллага шилжилтийн үед устаж алга болоогүйгээс гадна, зарим улс оронд улс төрийн голлох хүчин болсон байна (Ishiyama, 2001).

### ***Иргэний нийгэмд зориулсан өрнөдийн тусламж***

Гадаадын тусламжийн асуудлыг авч үзсэн судлаачид ТББ-ын хөгжилд гадаадын тусламж чухал үүрэгтэй байсныг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, ТББи ба донор байгууллагуудын хоорондын харилцаа ээдрээтэй, ТББ-уудад өгсөн гадаадын тусламж нь үндэстэн дамнасан үзэл санаа, санхүүжилтээс хамааралтай байгууллагуудыг үүсгэсэн гэж үзэх нь элбэг (Jones Luong and Weinthal, 1999; Spina and Raymond, 2013; Sundstrom, 2006). Гадаадын туслалцаа нь орон нутгийн, уугуул нийгмийн идэвхтэй хэсгийг тэтгэлэг, санхүүжилтийн төлөөх өрсөлдөөн рүү түлхэж, нийгмийн идэвх, оролцоонд саад учруулсан (Hann, 2003) Харин зарим судлаачийн үзсэнээр, ТББ-ууд донор байгууллагуудаас хамааралтай байсан ч олон гишүүнтэй байх, олонхын санаа бодлыг харгалзах зэрэг нийгмийн хязгаарлалтаас ангижрах боломжтой байсан нь бодлогын чухал асуудлаар үр дүнтэй ажиллах давуу талыг бий болгосон (Carmin and Fagan, 2010). Тиймээс донор байгууллагуудын ач холбогдол, өгч буй санхүүжилтийн бодлого, тэргүүлэх чиглэл нь ТББ-уудын үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг харгалзаж үзэх нь зүйтэй.

### ***Иргэдийн сул оролцоо***

Бусад улс оронтой харьцуулахад, социализмын дараах улс орнуудад иргэд сайн дурын байгууллагад гишүүнээр элсэх, оролцох түвшин маш сул байдаг (Howard, 2003; Lane, 2010). Судлаач Ховард 1995-1997 оны “Дэлхийн үнэлэмжийн судалгаа”-ны үр дүнг шинжлэхдээ зарим улсыг сонгон судалж үзэхэд, пост социалист улс орнуудад сайн дурын байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо сул байгаагийн гол шалтгааны нэг бол социализмын ул мөр, ялангуяа төрийн хяналттай

олон нийтийн байгууллагуудад үл итгэх хуучны хандлага хүчтэй хэвээр, албан бус нийгмийн хэлхээ холбоонд тулгуурлах явдал түгээмэл байдал гэж үзжээ (Howard, 2003).

## **Иргэний нийгмийн өөрчлөлт ба нийгмийн хөдөлгөөний онол**

Энэхүү судалгаанд иргэний нийгэм гэдгийг төрийн институциэс гадна оршдог, иргэд, байгууллагуудын явуулж буй янз бүрийн үйл ажиллагааны харилцан үйлчлэлийн хүрээ гэж тодорхойлсон. Иргэний нийгмийн гол институци нь нийгмийн янз бүрийн санаа бодол, эрх ашгийг илэрхийлдэг сайн дурын холбоо, ТББ, сүлжээ, нийгмийн хөдөлгөөнүүдийн тогтолцоо юм (Habermas, 1996). Иргэний нийгэмд хамтын үйлдэл болон нийгмийн өөрийн зохион байгуулалт маш чухал. Иргэний нийгмийн үйл ажиллагааны эрх зүйн ба улс төрийн орчныг төр бүрдүүлдэг ч, төрөөс хараат бус байх нь тэдэнд нэн чухал юм. Хэсэг байгууллагыг нийтэд нь иргэний нийгэм гэж нэрлэж байгаа хэрэг биш бөгөөд иргэний нийгэм нь заавал нэгдмэл, “сайн”, ардчилсан байдаггүй. Дотроо мөлжлөг, ноёрхол, хуваагдлыг агуулах боломжтой гэдгийг анхаарууштай (Burawoy and Behbehanian, 2011).

Социализмын дараах улс орнууд дахь иргэний нийгмийн өөрчлөлт хувирлыг судлан авч үзэх онолын бэлэн загвар байхгүй. Нийгмийн хөдөлгөөн судлал нь нийгэм, улс төрийн олон нийтийг хамарсан хөдөлгөөний үйл явц, үр дүнг ойлгох онолын загваруудыг дэвшүүлсэн байдаг. Эрдэмтэд нийгмийн хөдөлгөөний арга зүйн хандлагыг хувьсгал, зэвсэгт мөргөлдөөн, нийгмийн ерөнхий өөрчлөлт зэрэг нийгмийн хөдөлгөөнөөс өөр үйл явдал, үйл явцыг тайлбарлахад ашигласан байна (Tilly and Tarrow, 2007). Дээрх жишгээр энэ бүлэгт иргэний нийгмийн өөрчлөлт хувирлыг авч үзэхэд нийгмийн хөдөлгөөний арга зүйн хандлагыг ашиглав.

МакАдам нар (McAdam et al. 1996) нийгмийн хөдөлгөөний динамик өөрчлөлтийг тайлбарлахдаа улс төрийн боломж, үйл ажиллагааг дэмжих бүтэц, хамтын үйл ажиллагааны баримжаа гэсэн үндсэн гурван хүчин зүйлийг тодорхойлсон. Эдгээрийг “нийгмийн хөдөлгөөний арга зүйн сонгодог хандлага” гэж нэрлэдэг. Нийгмийн хөдөлгөөний хандлагаар иргэний нийгмийн өөрчлөлт хувирлыг судлах нь тодорхой нэгэн нийгмийн хөдөлгөөн эсвэл зөрчилдөөнийг судлахаас ялгаатай, учир юу гэвэл, иргэний нийгэм нь олон байгууллага, үйл ажиллагааны хүрээг хамардаг. Гэвч нийгмийн хөдөлгөөний хандлага нь иргэний нийгмийн өөрчлөлтийн гол онцлог шинжүүдийг тодорхойлоход ач холбогдолтой юм. Улс төрийн боломж, үйл ажиллагааг дэмжих бүтэц, хамтын үйл ажиллагааны баримжаа нь иргэний нийгмийн өөрчлөлтийг ойлгоход тустай. Улс төрийн боломж гэдэг нь үндсэндээ хуулийн зохицуулалтууд, үйл ажиллагаагаа явуулах орон зай, иргэд, олон нийт, байгууллагыг оролцуулсан үйл



ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай нөөцийг багтаасан ойлголт юм. Үйл ажиллагааг дэмжих бүтэц гэдэг нь “хүмүүсийн хамтын үйл ажиллагааг зохион байгуулах, түүнд оролцоход хэрэгтэй албан, албан бус арга замууд юм” (McAdam et al., 1996, 3). Албан ёсны арга замуудад сайн дурын байгууллага, орон нутгийн холбоод зэрэг албан ёсны байгууллага багтана. Албан бус арга зам буюу бүтэц нь хамтын үйл ажиллагааг дэмжиж болох албан бус хэлхээ холбоо, харилцаа юм. Хамтын үйл ажиллагааны баримжаа гэдэг нь “хүмүүс хамтын үйл ажиллагаагаа зөвтгөх зорилгоор ертөнц болон өөрсдийн тухай нэгдмэл ойлголт, үзэл санаагаа тодорхойлж буй ухамсартай оролдлого” (McAdam et al., 1996, 6).

Үйл ажиллагааг дэмжих бүтцийн (мобилизаци хийх бүтцүүд, тухайлбал байгууллага, сүлжээнүүд) онцлог нь олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулж буй иргэд, байгууллагууд өөрсдийн үйлдлийн хэлбэр, стратеги, эрх ашгийг тодорхойлоход нөлөөлдөг. Гэхдээ үүний эсрэг чиглэлд нөлөөлөл үүсэж болно гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь, улс төрийн орчинд гарсан өөрчлөлт нь иргэний нийгмийн бүлгүүд эрх ашиг, үйлдлийн стратегиа хэрхэн үнэлэхэд нөлөөлнө. Энэ хандлага нь иргэний нийгмийн байгууллага, сүлжээнүүдийн ажиллаж буй орчны онцлог шинж, өөрчлөлт болон иргэний нийгмийн дэвшүүлж хамгаалж буй гол асуудал, үнэлэмжид анхаарахын зэрэгцээ тэдний харилцан хамаарлыг судалдаг.

## **Монгол дахь ардчилсан шилжилт ба иргэний нийгмийн эхлэл**

### ***Улс төрийн хязгаарлагдмал боломж ба үйл ажиллагааг дэмжих (мобилизацийн) бүтэц***

1990-ээд оны эхэн үеийн социализмын дараах төр байгуулах үйл явцад МАХН давамгайлах байр суурьтай байсан нь олон нийтийн бие даасан үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн зохицуулалт, нөөцийг бий болгох боломжийг хязгаарлаж байв. Иргэдийн сайн дурын хамтын үйлдэлд зориулсан байгууллага, сүлжээг үүсгэж “дахин ашиглаж” байсан боловч түүгээр дамжуулж хүмүүсийг зохион байгуулах, нийгмийн эрх ашгийг илэрхийлэх чадавх маш хязгаарлагдмал байсан. Шинэчлэлийн төлөөх улс төрийн сөрөг намууд нь хамтын үйлдэл хийх гол бүтэц болж байсан бөгөөд энэ байдал 1996 оны сонгуульд тэднийг ялалт байгуулах хүртэл үргэлжилсэн юм.

1980-аад оны сүүл үед өрнөсөн улс төрийн үйл явц 1990-ээд оны Монгол дахь иргэний нийгмийн динамик өөрчлөлт, хэв шинжид чухлаар нөлөөлсөн. МАХН дахь шинэчлэлийн удаан үйл явц, улс орны эдийн засгийн хөгжлийн хоцрогдол нь Төв ба Зүүн Европын нийгмийн хөдөлгөөнөөс урам зориг авсан залуу сэхээтнүүдийг 1980-аад оны төгсгөл үед шинэчлэлийн төлөөх бүлгэм, хөдөлгөөн үүсгэхэд нөлөөлсөн. Шинэчлэлийн төлөөх хөдөлгөөнүүд олон намын тогтолцоо, чөлөөт сонгууль, хүний эрхийг шаардан, хэд хэдэн удаагийн тайван жагсаал,

өлсгөлөн зохион байгуулж, улмаар МАХН, засгийн газартай хэлэлцээ хийсний дараа 1990 оны 4 дүгээр сард МАХН тэдний шаардлагыг хүлээн авсан. Түүнээс 3 сарын дараа Монгол Улсад анх удаа олон намын оролцоотой улс төрийн сонгууль явагдсан юм.

Шинэчлэлийн төлөөх хөдөлгөөнүүдийн манлайлагчид нь гол төлөв хотын, залуу сэхээтнүүд (их сургуулийн багш, сэтгүүлч, зохиолч, оюутнууд) байсан. Тэдний дунд Зүүн Европ болон Орост боловсрол эзэмшсэн хүмүүс олон байсан. Ялангуяа, 1980-аад оны эхэн, дунд үед оюутан байсан, Польш дахь “Эв санааны нэгдэл” хөдөлгөөн, мөн Өрнөдийн улс төр, эдийн засгийн сэтгэлгээний талаар мэддэг залуучууд олон байжээ. Тэднийг тухайн үед эх орондоо буцаж ирэхэд, улс орны эдийн засгийн хөгжил хоцрогдсон хэвээр, улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөж байв. Шинэчлэлийн хөдөлгөөнүүдийн манлайлагчдаас олон хүн нийгмийн номенклатур хэсэгт багтаж байсан. Тэд төрийн захиргааны болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг байв. Тухайн үеийн социалист төрийн доорх идеал болон бодит амьдрал хоорондын зөрүүтэй нөхцөл байдлыг анхлан эргэцүүлж эхэлсэн хүмүүс юм.

Ардчиллын төлөөх дөрвөн хөдөлгөөн 1990 оны 2 сард хамтарсан арга хэмжээ зохион байгуулах шийдсэнээр, тэдний тэмцэл улс төрийн өргөн хүрээг хамарсан хөдөлгөөн болж хувирсан юм. 1990 оны 3 сард болсон нэгдсэн жагсаал нь монголын улс төрийн түүхэн дэх анхны өлсгөлөн болон үргэлжилсэн. Тэд улс төрийн товчоог огцрох, олон намын оролцоотой сонгууль зохион байгуулахыг шаардсан. Ардчиллын төлөөх хөдөлгөөнүүдийн үүсгэл санаачилгаар 1990 оны хавар улс төрийн шинэ намууд байгуулагдсан. Гэвч тэдний хажууд МАХН харьцуулшгүй давуу талтай байсан. Сөрөг хүчний намууд туршлагагүй, хуваагдмал, нөөц хомс байв. Түүнчлэн, тэд сонгуульд МАХН-тай өрсөлдөхийн хажуугаар өөр хоорондоо өрсөлдөж байв. Энэ үед хүн амын ихэнх нь хуучин коммунист намд бүрэн итгэл алдраагүй байсан юм.<sup>1</sup> Ийм байдалд МАХН сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулж, шинээр байгуулагдсан хоёр танхимт парламентад давамгайлах байр суурьтай болсон. МАХН нь Улсын Их Хурал буюу парламентын доод танхимын суудлын 85 хувийг, Улсын Бага Хурал буюу парламентын дээд танхимын суудлын

---

1 Каплонски (Kaplonski 2004, 1052) “Жагсаал цуглаанд хэчнээн олон хүн оролцсон байлаа ч МАХН нийгмээс бүрэн тусгаарлагдсан байгаагүй гэдгийг ойлгох нь чухал юм. Захидал, зурвас маш ихээр ирж байсан... Үүнд намаа дэмжсэн байр сууриа олон анзаар илэрхийлсэн байв. Гэхдээ бүгд намын удирдлагыг нэгэн дуугаар дэмжсэн байв” гэж тэмдэглэсэн байна. Лиштованы (Lishtovanny 2007, 79, 82) ардчиллын төлөөх анхны нэгдсэн жагсаалын үеэр оролцогчдын дунд явуулсан судалгааны сонирхолтой дүнг дурдсан байна. Нийт 335 хүн судалгаанд оролцсоны 67 хувь нь ардчилсан хөдөлгөөнийг дэмжихээр ирсэн, 4 хувь нь хөндлөнгөөс ажиглахаар ирсэн гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын дунд МАХН-ын гишүүд олон байсан бөгөөд тэдний 28 хувь нь намдаа итгэж буйг илэрхийлсэн бол, 23 хувь нь МАХН ба Ардчилсан эвслийн хамтын ажиллагааг дэмжинэ гэж үзжээ.

58,4 хувийг эзэлсэн. Хэдий олонх боловч МАХН-ын удирдлага сөрөг хүчний намуудтай хамтран ажиллах шийдвэр гаргасан юм. Сөрөг хүчний нэгжгээд манлайлагч засгийн газарт сайд, дэд сайдаар ажиллах болсон. Сөрөг хүчний намуудын төлөөлөл Монгол Улсын дэд ерөнхийлөгч, Улсын Бага Хурлын даргаар сонгогдсон.

Эдгээр намын удирдагчид 1990-1992 оны хооронд шинэ хуулиудыг боловсруулах үйл явц, засгийн газрын үйл ажиллагаанд чухал үүрэгтэй байсан. Харин ардчиллын төлөөх хөдөлгөөнүүдийн ихэнх гишүүд улс төрд төдийлөн албан ёсоор оролцолгүй үлдсэн. Сөрөг хүчний намууд 1992 оны парламентын сонгуульд нийт 76 суудлаас ердөө 6 суудал авч чадсан. Орон нутгийн сонгуульд ч МАХН бүх 18 аймагт дийлэнх олонх болсон нь хөдөлгөөний гишүүн, идэвхтнүүдийг улс төрийн амьдралаас улам холдуулсан аж. Ардчилсан хөдөлгөөнд гол үүрэгтэй байсан Монголын Ардчилсан Холбоо харьцангуй олон тооны гишүүн, дэмжигчидтэй байсан (орон нутгийн 60 орчим холбоодтой) боловч тэдний идэвх, оролцоо суларч эхэлсэн байна. Ийм байдалд сөрөг хүчний намууд нэгдэн Ардчилсан эвсэл байгуулж, улмаар 1996 оны сонгуулиар парламентын олонх болох хүртэл үргэлжилсэн юм.

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Монголын Ахмадын холбоо, Монголын Залуучуудын Холбоо зэрэг социализмын үеийн олон нийтийн байгууллага 1990 оноос, өмнөх үзэл суртал, алсын хараагаа орхиж, цаашид оршин тогтнох утга учраа тодорхойлох эхэлсэн. Олон нийтийн байгууллагууд өмнөх дэглэмийн үед байсан олон давуу эрхүүдээ 1990-1991 онд алдсан. Гэвч тэдний улс төрийн эрх баригч хүчин буюу МАХН-тай уламжлалт нягт холбоотой байдалд томоохон өөрчлөлт гараагүй. Харин, Монголын залуучуудын холбооны хувьд, ардчиллын төлөөх хөдөлгөөнүүдийн залуу манлайлагчид удирдаж байсан учраас МАХН-тай төдийлөн нягт холбоотой байгаагүй юм. Тухайлбал, Монголын эмэгтэйчүүдийн холбооны хувьд 1990 он хүртэл МАХН-ын эмэгтэйчүүдийн байгууллага байсан бөгөөд 1990 оноос хойш холбооны гишүүдийн ихэнх нь МАХН-ынхаа гишүүнчлэлийг хадгалсаар байсан. Бусад холбооны хувьд ч ийм байдал нийтлэг байв.

Өрнөдийн хэв маягтай, тодорхой асуудалд төвлөрсөн иргэдийн байгууллагууд 1990-ээд оны эхээр анхлан байгуулагдсан. Үүсгэн байгуулсан хүмүүсийн дунд сөрөг хүчний намуудын гишүүн, идэвхтнүүд олон байсан. Түүний зэрэгцээ, Малчдын холбоо, Бурхны шашинтнуудын холбоо, Ногоонтнуудын хөдөлгөөн зэрэг шинэ холбоо үүсэн бий болсон. Тухайн үед ийм, албан бус иргэдийн байгууллага хэр олон байсан нь тодорхойгүй байна. Албан бус мэдээллээр, 1992 онд иргэдийн сайн дурын 7 байгууллага байсан бол 1990 оны дунд үеэс огцом нэмэгдэж 400 гаруй болсон байна (UNDP, 2000). Гэвч эдгээр байгууллагын ихэнх нь зөвхөн цаасан дээр буюу үйл ажиллагаа нь идэвхгүй байсан бөгөөд албан бус тооцоогоор ердөө 50 орчим нь ТББ хэлбэрээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан байна (UNDP, 2000, 31).

Ардчиллын төлөө хөдөлгөөн болон олон улсын донор байгууллагуудын зорьж байсан институцийн өөрчлөлтийн нэг чухал хэсэг нь төрөөс хараат бус, иргэдийн сайн дурын байгууллага оршин тогтнох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх явдал байсан. Тухайлбал, нэгжгээд донор байгууллагаас Монгол Улсын Засгийн Газар болон иргэний нийгмийн бүлгүүдэд ТББ-ын хуулийг боловсруулахад дэмжлэг үзүүлж байв. Өмнө нь ТББ үүсгэн байгуулж, удирдаж байсан парламентын хэд хэдэн эмэгтэй гишүүний идэвхтэй оролцоотойгоор 1997 онд ТББ-ын тухай хууль батлагдсан бөгөөд энэ хуулийн үр дүн шууд гарч эхлэн, 1997 оноос хойш жил бүр дунджаар 500 орчим ТББ шинээр бүртгүүлэх болжээ (OSF, 2005).

Азийн сан, Соросын сан, Германы улс төрийн сангууд зэрэг олон улсын байгууллага, сангууд 1990-ээд оны эхэн үед засгийн газартай улс төр, эрх зүйн суурь шинэчлэлүүдийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахын зэрэгцээ, шийдвэр гаргагч болон шинэчлэлийн үйл явцад хяналт тавих чадвартай бие даасан байгууллагууд болоход нь ТББ-уудад туслалцаа үзүүлж байсан. Гэхдээ 1990-ээд оны сүүл үе рүү донор байгууллагууд иргэний нийгмийн улс төрийн шинж чанартай үйл ажиллагаанд анхаарах нь багасаж, ТББ-уудын нийгэм, эдийн засгийн дэмжлэг туслалцааны үүрэгт илүүтэй ач холбогдол өгч байсан нь ажиглагддаг. ТББ-уудын нийтийн ашиг сонирхлын өмгөөлөл, хяналт тавих үүргээс илүүтэй нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг донорууд ихээхэн онцолж байсан (ССА, 2005). Бусад хөгжиж буй орны адилаар, донор байгууллагын хувьд Монгол дахь ТББ-ууд нь нийгмийн янз бүрийн хэсэгт хүрч ажиллах үр дүнтэй суваг болсон. 2000 онд явуулсан нэгэн судалгаагаар ТББ-уудын хэрэгжүүлсэн 302 төслийн 93 хувь нь гадаад эх үүсвэрээс санхүүжиж байжээ (UNDP, 2000). Харьцангуй богино хугацаанд ТББ-уудын үйл ажиллагааны цар хүрээ ихээхэн өргөжиж тэлсэн. Боловсрол, эмэгтэйчүүдийн эрх, хэвлэлийн эрх чөлөө, эмзэг бүлгийнхэнд зориулсан туслалцаа, хүүхдийн хамгаалал зэрэг зарим асуудлаар үр дүнтэй ажиллаж байв. Донор байгууллагуудын дэмжлэг туслалцаа нь тогтмол үйл ажиллагаа явуулах боломж тааруу орчинд ажиллаж буй ТББ-уудад маш чухал нөөц болж байсан юм. Нэлээд ТББ-ын бүтэц, зохион байгуулалт харьцангуй тогтворжиж, санхүүгийн хувьд ч бэхэжсэн. Гэвч ихэнх ТББ-ын санхүү тогтворгүй, байгууллагын чадавх сул хэвээр байв.


Эрх баригчдын үйл ажиллагааг хянах, хариуцлага тооцох иргэний нийгмийн хүчтэй бүлгүүд байхгүй энэ үед сөрөг хүчний намууд олон нийтийн хэрэгцээ, эрх ашгийг нэгтгэн илэрхийлэх гол институци болж байжээ. 1994 оны 4 сард сөрөг хүчний намуудаас эрх баригчид хэвлэл мэдээлэлд хяналт тогтоох, иргэдийн хараат бус үйл ажиллагааг хориглохыг зорьж байна гэж үзээд, Улаанбаатар, бусад хотуудад жагсаал, өлсгөлөн зохион байгуулж байсан. Тэд засгийн газрыг огцрохыг шаардахын зэрэгцээ, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, жагсаал цуглаан хийх эрхийг хангах хууль зүйн баталгааг шаардаж байв.

1996 оны сонгуульд сөрөг хүчний намуудын эвсэл болох Ардчилсан эвсэл илт давуу ялалт байгуулахад олон нийт маш эерэгээр хүлээн авав.

Улс төрийн барууны үзэл баримтлалтай Ардчилсан эвсэл нь зах зээлийн эдийн засгийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх зорилго тавьж үнэ чөлөөлөх, төрийн өмчийг хувьчлах, санхүүгийн салбарыг шинэчлэх алхмууд хийсэн. Гэвч эдийн засгийн шинэчлэлийн бодлого хүмүүсийн амьжиргаанд шууд эерэг нөлөөлөл үзүүлээгүй юм. Ардчилсан эвсэл дотоод талцал, албан тушаалын төлөөх өрсөлдөөн, авлигын хэргүүдээс болж ганхаж эхэлсэн. МАХН парламентын маш хүчтэй сөрөг хүчин болж, хуралдаанд оролцохоос татгалзах замаар парламентын үйл ажиллагааг олон хоногоор гацааж байв. Дөрвөн жилийн хугацаанд гурван ерөнхий сайд огцорч, мөн 1998 онд Санжаасүрэнгийн Зориг алагдсан хэрэг гарсан нь энэ үеийн улс төрийн тогтворгүй байдлыг илтгэж байв.

Зураг 1-д харуулсанчлан 1996-2000 оны үеийн улс төрийн үйл явц, эдийн засгийн байдалд олон нийт маш таагүй хандаж, сэтгэл ханамжийн түвшин доогуур байсан нь эвслийн засгийн газрын төгсгөл болоход чухал нөлөөтэй байсан ба 2000 оны сонгууль Ардчилсан эвслийг сүйрлийн ирмэгт аваачсан. Эвсэл ердөө нэг л суудал авч чаджээ. Сөрөг хүчний намууд жирийн иргэдийг зохион байгуулалтад оруулж, тэдний дэмжлэгийг авч чадаж байсан нэр хүнд, алтан боломжоо алдсан юм. Зарим ажиглагч 2000 сонгуулийн дүнг 1990 оны ардчилсан хөдөлгөөний төгсгөл гэж үзэж байв (Murai, 2001). Сөрөг хүчний намуудын зарим удирдагч 2000-аад оны эхэн үед МАХН-ын засгийн газрыг эсэргүүцсэн жагсаал зохион байгуулж байсан боловч өмнөхийн адил олон нийтийн дэмжлэгийг авч чадаагүй юм.

**Зураг 1. 1995–2005 онд улс төрийн тогтолцоо, эдийн засгийн нөхцөл байдлын талаарх олон нийтийн санаа бодол**



Эх сурвалж: Prohl ба Sumati (2007); хувийг тухайн онуудын 6, 11 сард явуулсан судалгаанаас тооцсон.


## 2000-аад оны үеийн иргэний нийгмийн төрөлжилт

### Улс төрийн боломж ба үйл ажиллагааг дэмжих бүтцийн тэлэлт

Социализмын дараах шилжилтийн эхний арван жилээс ялгаатай нь 2000-аад онд иргэний хөдөлгөөнүүд үүсэж, иргэний нийгмийн дотоод төрөлжилт нэмэгдсэн нь иргэний нийгмийн дүр төрхийг тодорхойлж байв. 2005 оноос хойш олон янзын эсэргүүцлийн хөдөлгөөн үүссэн нь монголын иргэний нийгмийн олон хэв шинж, нийгмийн нөлөөлөлд чухал хувь нэмэр болсон. Зохиогч иргэний хөдөлгөөнүүдийн үүсэл, хувирал өөрчлөлтийг ойлгох зорилгоор 2002-2008 онд үндэсний хэмжээний өдөр тутмын хоёр сонинг шүүж энэ хугацаанд өрнөсөн эсэргүүцлийн үйл явдлын мэдээллийг цуглуулсан. Үүнийг судлаач Минеюки Мурайн нэгтгэсэн улс төрийн үйл явдлын мэдээлэлтэй харьцуулахад томоохон ялгаа байгаагүй (Murai, 2011). Зураг 2-т 2002-2008 онд болсон эсэргүүцлийн цуглаануудын (жагсаал, эсэргүүцлийн цуглаан, суулт, өлсгөлөн) тоог харуулав.

Эсэргүүцлийн үйл явдлууд нь олон янз байсан ба өөрсдийгөө “иргэний хөдөлгөөн” гэж нэрлэсэн эсэргүүцлийн хөдөлгөөнүүд эдгээр үйл явдлуудын төвд байсан юм. Үүнд засгийн газрыг эсэргүүцсэн олон нийтийг хамарсан жагсаалаас эхлээд таксины жолооч нарын машинтай жагсаал, хувийн компанийн дампуурлын улмаас хохирсон иргэд төрөөс нөхөн олговор шаардсан өлсгөлөн хүртэл орно. 2001-2008 онд ойролцоогоор 40 орчим өөр өөрийн онцлогтой “иргэний хөдөлгөөн” үүссэн ба эдгээр нь 2005-2007 оны хооронд хамгийн идэвхтэй байсан байна.

Зураг 2. 2002–2008 онд болсон эсэргүүцлийн цуглаанууд



Эх сурвалж: 2002-2008 оны “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сонины дугаарууд.

Тоогоор эсэргүүцлийн цуглаан (жагсаал, эсэргүүцлийн цуглаан, суулт, өлсгөлөн) болсон тохиолдлыг илэрхийлсэн. Нэгээс дээш өдөр үргэлжилсэн эсэргүүцлийн үйл явдлыг нэг тохиолдол болгон тооцсон.

Эдгээр хөдөлгөөний ихэнх нь 2004 оны сонгуулиар парламентын олонх бүрдэх боломжгүй болсны дараа үүссэн байна. Сонгуулийн дараа улс төрийн гол хүчнүүд Израйл улсын “зөвшилцлийн засгийн газрын” загварын дагуу хамтран ажиллах шийдэлд хүрсэн. Сөрөг хүчний намуудын эвсэл эхний хоёр жилд, МАХН дараагийн хоёр жилд буюу 2008 оныг хүртэл засаг барихаар тохиролцсон. Гэвч эвсэл бүрдүүлсэн сөрөг хүчний намуудын дунд дотоод зөрчил ихтэйн зэрэгцээ МАХН хэдийд ч гэрээгээ цуцлах боломжтой байсан нь гол сорилт болж байв. Эрх баригчдын ийм хэврэг нэгдлийн үед олон нийтийг хамарсан томоохон жагсаалууд гарч эхэлсэн. 2005 оны 2-5 дугаар сард “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” эхний томоохон жагсаалуудыг зохион байгуулсан. Түүний дараа “Эрс шинэчлэл хөдөлгөөн”, “Чөлөөт ахмадуудын холбоо”, “Миний Монголын газар шороо хөдөлгөөн” зэрэг томоохон байгууллага жагсаал зохион байгуулсан. Түүнчлэн энэ үед байгаль орчинд халтай уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцсэн орон нутгийн байгаль орчны хөдөлгөөнүүд байгуулагдсан. “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөн” нь анхандаа авлигатай тэмцэх, авлигач улс төрчдийг огцруулахаа илэрхийлж байсан бол бусад байгууллага, хөдөлгөөн жагсаал цуглаанд нэгдэн орсноор зорилго нь өргөжихийн зэрэгцээ бүдгэрсэн.

“Иргэний хөдөлгөөнүүд”-ийн Монголын засгийн газрын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл үүсгэх, дэмжих бодлогын эсрэг үйл ажиллагаа нь олон нийтийн анхаарлыг нэлээд татсан. Канадын Айвенхоу Майнз компани 2005 онд хөрөнгө оруулагчдад Монголын Өмнөговьд Оюу Толгой хэмээх дэлхийн хамгийн том зэс, алтны ордуудын нэгийг нээж, улмаар Монгол Улсын Засгийн газартай гэрээ байгуулсан гэж зарласан. Үүнийг олон нийт нууцаар гэрээ хэлэлцээ явагджээ гэж үзэн таагүй хүлээж авсан бөгөөд “иргэний хөдөлгөөнүүд” эсэргүүцлийн үйл ажиллагааг манлайлж байв.

### **Хамтын үйлдлийн шинэ баримжаа**

“Өнөөдөр” сонин энэ үеийн (2005-2007) улс төрийн үйл явдлуудыг “Яргуйн хувьсгал” гэж нэрлэж байв. Энэ нь эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг тухайн үед зарим пост социалист улсуудад өрнөсөн хувьсгал (Өнгөт хувьсгал)-ын үргэлжлэл, нэгэн хувилбар гэж үзэж байсны илрэл юм. Үнэхээр тэр үеийн “Эрүүл нийгэм иргэний хөдөлгөөний” эсэргүүцлийн арга хэмжээнүүдийн хэлбэр, зан үйл нь Өнгөт хувьсгалын эсэргүүцлийн байгууллагуудтай ижил төстэй байсан. Иргэний хөдөлгөөнийхөн шар бүч, гарын боолт зүүж ижилсэж байв. Тэд эсэргүүцлийн зөрчилдөөнт тактик баримталж, олон

нийтийн анхаарлыг татах, үндэсний хэмжээний сүлжээ үүсгэхийг хичээж байсан.<sup>2</sup> “Шинэчлэлийн төлөөх хөдөлгөөнүүдийн удирдагчид, сэтгүүлчид, эрдэмтэн судлаачид, ТББ-уудын оролцоотой 2007 онд байгуулагдсан “Иргэний эвсэл” нь Өнгөт хувьсгалын бас нэг хувилбар болох “сонгуулийн хувьсгал”-ын тухай хэлэлцүүлэг өрнүүлж байсан юм. 2005-2007 онд эсэргүүцлийн хөдөлгөөнүүд нь уул уурхайн хөрөнгө оруулалтын гэрээг дахин хэлэлцэх, тэтгэврийн тогтолцоог шинэчлэх зэрэг маргаантай зарим асуудалд засгийн газрыг буулт хийхэд хүргэж чадсан. Засгийн газар, эрх баригчид хөдөлгөөнүүдийн нөлөөг хүлээн зөвшөөрч эхэлсэн ба олон нийтэд хөдөлгөөнийхнийг сонсож, тэдэнтэй хамтран ажиллаж байгаа гэдгээ харуулахаас эхлээд бодлогын яриа хэлэлцүүлэгт оролцуулах болсон. Гэвч хөдөлгөөнүүдийн шаардаж байсан бодлогын томоохон шинэчлэл өөрчлөлт гараагүй юм. Томоохон үр дүнд хүрч чадаагүй учраас хөдөлгөөнүүд задралын байдалд орсон. Хөдөлгөөний зарим удирдагчид өөрсдийн улс төрийн намыг байгуулсан, зарим нь 2008 оны парламентын сонгуульд өрсөлдөхөөр намуудад элсэн орсон.<sup>3</sup> Гэвч тэднээс нэг ч хүн сонгуульд ялалт байгуулж парламентад сонгогдож чадаагүй юм.

Эсэргүүцлийн зарим хөдөлгөөн, ялангуяа уул уурхайн эсрэг бүлгүүд Улаанбаатар хот болон уул уурхайн бүс нутагт янз бүрийн эсэргүүцэл, нөлөөллийн арга хэмжээ тогтмол явуулсаар байсан. 2009 онд “Монголын гол, нууруудын нэгдсэн хөдөлгөөн” парламент дахь бүлэгтэй хамтран ажиллах, мөн эсэргүүцлийн арга хэмжээ явуулах замаар голын эх, усан сан, ойн сан бүхий газарт уул уурхайн үйл ажиллагааг хориглох тухай хууль буюу “Урт нэртэй хууль” хэмээх асар их маргаан дагуулсан хуулийг парламентаар батлуулж чадсан (Byambajav, 2015). Гэвч энэ хуулийн хэрэгжилт тун хангалтгүй байсан. Энэ нь хуулийн боловсруулалт хангалтгүй, засгийн газрын идэвх зүтгэл сул, уул уурхайн компаниудын эсэргүүцэлтэй холбоотой байв. Хөдөлгөөнийхөн энэ хуулийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхийг засгийн газраас байнга шаардаж нөлөөллийн болон эсэргүүцлийн арга хэмжээ явуулж байсан бөгөөд олон нийтийн анхаарлыг татах зорилгоор бэлгэдлийн шинжтэй олон арга хэмжээ авч байсан. Жишээ нь засгийн газрын ордны өмнөх төв талбайд гэр барих, морьд зогсоох, ордон руу нум сумаар харвах байдлаар эсэргүүцлээ илэрхийлж

---

2 Өнгөт хувьсгалын нэгэн адилаар Монголд өрнөж байсан эсэргүүцлийн жагсаалуудыг зохион байгуулагч хөдөлгөөнүүдийн удирдагч нарыг өрнөдийн донор байгууллагууд санхүүжүүлж байна гэсэн хардлага гарч байсан. Түүнчлэн иргэний хөдөлгөөнүүдийг албан тушаалтнууд болон бизнес эрхлэгчдийг жагсаал тэмцлээр айлган сүрдүүлэх замаар мөнгө хөрөнгө олж авдаг “шантаажчид” гэсэн хардлага хүчтэй байв. Ийм хандлагын эсрэг зарим хөдөлгөөн өөрсдийн санхүүгийн тайлангаа нийтэд танилцуулах арга хэмжээ авч байсан.

3 2007 онд нэжгээд хөдөлгөөн хоорондоо эвсэж, Иргэний Хөдөлгөөний Намыг байгуулсан.



байв. Гэвч 2013 оны 9 дүгээр сард хөдөлгөөний удирдагч болон нэжгээд гишүүн Засгийн газрын ордон руу буу барьж ирсэн хэрэг явдал болсон. Тэд дээрх хуулийг парламентаас цуцлах шийдвэр гаргах тухай бодлогыг эсэргүүцэж, олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор ийм үйлдэл хийсэн ч, олон нийт тэдний энэ алхмыг таагүй хүлээн авсан. Хуулийн дагуу тэд баривчлагдаж, олон нийтийн аюулгүй байдалд аюул занал учруулсан шалтгаанаар шүүхээс ял сонссон билээ.

### ***“Шаардагч иргэний нийгэм”***

Стивен Фиш 1990-ээд оны сүүл үеийн монголын иргэний нийгмийг “матриархал” шинжтэй буюу эмэгтэйчүүдийн манлайлал бүхий ТББ-ууд гол төлөөлөл нь байсан гэж тодорхойлсон байдаг (Fish, 1998). Харин шинэ зууны дараагийн арван жилд монголын иргэний нийгэм маш олон хэв шинжтэй болсон. Түүнчлэн иргэний нийгмийн “шаардагч” шинж нь нь Монгол Улсын Засгийн газраас иргэний нийгмийг төдийлөн анхаарч үздэггүй байсан хандлагаа өөрчилж илүү хамтран ажиллах бодлого руу шилжихэд чухал түлхэц болсон.<sup>4</sup> Шинэ засгийн газар, Ерөнхийлөгч бүр иргэний нийгэмтэй хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх талаар мөрийн хөтөлбөртөө тусгах болсон. Жишээ нь 2005 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн байгууллагуудын иргэний нийгмийн байгууллагын оролцоо, түншлэлийг хангаж буй эсэхт хяналт тавьж ажиллана гэж заасан байна. Бэлгэдлийн шинж чанартай ийм үйлдлүүдийн зэрэгцээ засгийн газраас иргэний нийгэмтэй ажиллах тодорхой алхмууд хийсэн байна. Жишээ нь засгийн газрын яам, агентлагууд “иргэний нийгмийн зөвлөл”-үүдийг дэргэдээ байгуулах болсон.

“Иргэний хөдөлгөөнүүд” Монгол дахь иргэний нийгмийн агуулга, хэлбэрийг өөрчилж иргэдийн улс төр, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлсэн. Хөдөлгөөнүүд нь иргэний нийгмийн неолиберал загвараас ялгаатай “шаардагч иргэний нийгмийн” хувилбарыг төлөөлж байсан. Зарим талаараа эдгээр хөдөлгөөн нь “иргэнлэг” биш (тэд олон нийтийг цочроосон, хууль бус арга хэрэглэх тохиолдол байсан), “сайн” биш (зарим хөдөлгөөн уул уурхайн компаниудаас мөнгө нэхсэн гэдэг хардлага байсан), нам, улс төрөөс хараат (голлох удирдагчид нь намд элссэн эсвэл намын гишүүд байсан) байсан. Гэвч эсэргүүцлийн үйл ажиллагааны давалгаа нь иргэний нийгмийн тухай ялгаатай төсөөллийг бий болгож, олон нийтийн хамтын үйлдэл хийх боломжийг харуулсан. “Иргэний хөдөлгөөнүүд” нь зохион байгуулалттай нийгмийн хамтын үйлдэл байсан ба ТББ-уудаас ялгаатай нь олон нийтийг зохион байгуулалтад оруулж төр, эрх баригчдад чиглэсэн шаардлага илэрхийлж байсан юм.

---

4 Тухайлбал Байгаль орчны яам зэрэг хэд хэдэн яам, төрийн байгууллага иргэний нийгмийн зөвлөл, зөвлөлдөх бүлэг байгуулсан.

### **Иргэний нийгмийн орон зай дахь улс төрийн намууд**

Монгол Улсад улс төрийн намууд иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгын байгууллагуудын дунд давамгайл байр суурьтай байдаг нь иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаанд нөлөөлсөн. Бусад пост социалист улс орны адилаар Монголд сайн дурын байгууллагын гишүүнчлэлийн хувь маш доогуур байдаг (Буамбажав, 2012). Гэвч бусад улсаас ялгарах чухал онцлог бол улс төрийн намын гишүүнчлэл өндөр хувьтай байдаг явдал юм. Азийн Барометр судалгааны дүнгээр 2006 онд Монгол Улсын насанд хүрсэн хүн амын 24.2 хувь нь өөрийгөө улс төрийн намын гишүүн гэж хариулсан байна. Энэ нь 2010 оны байдлаар 19.9 хувь болж буурсан.<sup>5</sup> “Шилжилтийн үеийн амьдрал” олон улсын судалгааны дүнгээр мөн адил улс төрийн намын гишүүнчлэл 24 хувьтай буюу бусад орноос өндөр гарсан байна.<sup>6</sup>

### **Хүснэгт 1. Баруун Европ, пост социалист бүс нутгууд, Монгол Улс дахь сайн дурын байгууллагын гишүүнчлэл (Тийм гэж хариулсан %)**

Сайн дурын байгууллагууд	Бүс нутаг, улсууд				
	Баруун Европ	Төв/ Зүүн/Балтик	Өмнөд Европ	ТУХН	Монгол
Шашин	27.9	20.5	21.5	12.4	4.7
Спорт	27.9	9.1	6.4	3.4	3.9
Соёл, боловсрол	15.4	5.2	4.1	2.8	3.8
Үйлдвэрчний эвлэл	17.0	5.9	6.6	8.9	10.9
Байгаль орчин	7.5	2.3	2.6	1.8	2.9
Мэргэжлийн	13.7	4.7	4.6	3.0	3.9
Хүмүүнлэгийн	19.1	4.5	4.1	2.2	5.6
Залуучууд	5.1	3.4	3.0	2.8	5.0
Улс төрийн нам	4.0	3.1	9.0	4.9	24.0
N	5504	10805	8844	12711	1000

Эх сурвалж: Life in Transition Survey 2010.

Нэг талаар, улс төрийн нам давамгайлсан иргэний нийгмийн орон зайд олон нийтийн өргөн хүрээтэй дэмжлэг авч, тууштай ажиллах нь

5 Азийн Барометр. Давалгаа 2 (2006) and Давалгаа 3 (2010) Монгол судалгааны дата. <http://www.asianbarometer.org/>.

6 ЕСБХБ. Шилжилтийн үеийн аж байдлын судалгаа. Дэлгэрэнгүйг: <https://www.ebrd.com/cs/Satellite?c=Content&cid=1395236498263&d=Mobile&pagename=EBRD%2FContent%2FContentLayout>.

иргэний хөдөлгөөнүүдийн хувьд маш хэцүү сорилт байсан. Тэдэнд гишүүдийн дэмжлэг, оролцоо, мөнгөн ба мөнгөн бус нөөц хомс байсан. Нөгөө талаар, улс төрийн намууд иргэний нийгмийн орон зайг эзлэхээр өрсөлдөж байсан. Улс төрийн голлох бүх нам дэргэдээ төрөл бүрийн ТББ байгуулж эмэгтэйчүүд, залуучууд, оюутнууд, өндөр настнууд зэрэг хүн амын янз бүрийн бүлэг, хэсгийг элсүүлэх, тэдэнд хүрч ажиллахыг зорьж байсан.<sup>7</sup> Ийм нөхцөл нь иргэний хөдөлгөөний удирдагчид улс төрийн нам байгуулсан, намд элсэх болсон чухал шалтгаан болжээ.

## Дүгнэлт

Өөрчлөгдөн буй улс төрийн орчинд өрнөсөн Монгол дахь ардчилсан хөдөлгөөний үр дүнд 1990 онд тайван шилжилт эхэлсэн. 1990 оноос хойш бүрэлдэн тогтсон иргэний нийгэм нь нийгэм-эдийн засаг, улс төрийн гүнзгий өөрчлөлт хувирлын нөлөөн дор өрнөв. Социализмын дараах шилжилтийн эхний болон дараах 10 жилд иргэний нийгмийн нэлээд ялгаатай хэв шинж зонхилж байжээ. Эхний арван жилд иргэний нийгэмд ардчилсан хөдөлгөөний үеийн иргэдийн идэвх, улс төрийн оролцоо буурах, ТББ олноор байгуулагдан иргэний нийгмийг төлөөлөх байдал гол тодорхойлогч хандлага байсан. Харин хоёр дахь арван жилд нийгмийн идэвхжил сэргэж, нийгмийн хамтын үйлдлийн олон хэв шинж илэрсэн. Энэ ялгаа нь хуучин коммунист нам болох МАХН ихэнх үед давамгайл байр суурьтай байсан монголын улс төрийн орчинд гарсан өөрчлөлтөөс хамаарч байжээ. 1990 оны ардчилсан хөдөлгөөнөөс угшилтай улс төрийн сөрөг хүчний намууд нь 1990-ээд онд иргэний нийгмийн байгууллагын үүрэг гүйцэтгэж байжээ. Учир нь тэд улс төрд байр суурь багатай байсны зэрэгцээ тухайн үед иргэдийн хүсэл зориг, сонирхлыг илэрхийлэх сайн дурын байгууллагууд бэхжээгүй байсан юм. Энэ үед иргэний нийгмийг шинээр үүссэн ТББ, өмнөх нийгмээс уламжилж ирсэн олон нийтийн байгууллагууд төлөөлж байсан боловч тэдгээр нь донор байгууллагууд, засгийн газартай сайн харилцаатай байхын тулд эсэргүүцлийн үйл ажиллагаанаас зайлсхийж байв.

2000-аад оны дунд үеэс улс төр, нийгмийн олон нийтийн хөдөлгөөнүүд идэвхжсэн нь улс төрийн голлох намуудын зөрчилдөөнөөс үүдэлтэй улс төрийн тогтворгүй байдалтай холбоотой байв. Улс төрийн институциудийн үр дүнгүй байдал, төрийн байгууллагууд дахь авлигын

---

7 Жишээлбэл, дөрвөн ТББ нь Монголын хоёр том намын нэг болох Монгол Ардын Намд албан ёсоор харьяалагддаг. Үүнд: Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбоо, Нийгмийн Ардчилал Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Нийгмийн Ардчилал Монголын Оюутны Холбоо болон Ахмадын Холбоо.

талаарх олон нийтийн дургүйцэл нь олон янзын “иргэний хөдөлгөөн”-ээр илрэн гарсан. Эдгээр хөдөлгөөний Улаанбаатар хот, орон нутагт зохион байгуулсан эсэргүүцлийн үйл ажиллагаа нь монголын иргэний нийгмийн голлох хэлбэр, үйл ажиллагааг өөрчилсөн. Улс төрийн бус сайн дурын байгууллагуудын гишүүнчлэл доогуур, харин улс төрийн намын гишүүнчлэл маш өндөр хувьтай байгаа нь иргэний нийгмийн орон зайд улс төрийн намууд давамгайл байр суурьтай байгааг илтгэж байна. Энэ нь шинээр үүсэн гарч буй иргэний нийгмийн байгууллагад томоохон сорилт болдог. Түүний зэрэгцээ, иргэний нийгмийн байгууллагууд үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөц маш хязгаарлагдмал орчинд оршин тогтнож, түүнээс тэдгээрийн хэлбэр, үйл ажиллагаа, үнэлэмж олон талаар хамаарч байжээ. Тухайлбал, иргэний оролцоо сул байдаг нь “иргэний хөдөлгөөнүүд” олон хүнийг хамруулсан үйл ажиллагаа зохион байгуулах гэхээс илүүтэй олны анхаарлыг татсан бэлгэдлийн шинжтэй арга хэмжээ зохион байгуулах чухал шалтгаан болж иржээ.

## Ном зүй

- Bertelsman Foundation. 2018. Bertelsman Transformation Index: Mongolia Country Report 2018. URL: <https://www.bti-project.org/en/reports/country-reports/detail/itc/MNG/>.
- Boone, Peter. 1994. “Grassroots Macroeconomic Reform in Mongolia.” *Journal of Comparative Economics*, 18(3): 329–356.
- Burawoy, Michael and Laleh Behbehanian. 2011. “Global Sociology: Reflections on an Experimental Course.” *Global Sociology Live*. URL: <http://globalsociologylive.blogspot.jp/> (accessed on January 12, 2012).
- Buyantogtokh, D. 2008. “Mongol Dahi HBNGU-yn Konrad Adenauer Sangyn Tuuhees” (From History of the Konrad Adenauer Foundation of the FRG). The Academy of Political Education. URL: [http://academy.org.mn/apem/index2.php?option=com\\_content&do\\_pdf=1&id=82](http://academy.org.mn/apem/index2.php?option=com_content&do_pdf=1&id=82) (accessed on January 22, 2012).
- Byambajav, Dalaibuyan. 2012. “Formal and Informal Networks in Post-socialist Mongolia: Access, Uses and Inequalities.” In Julian Dierkes (ed.), *Change in Democratic Mongolia: Social Relations, Health, Mobile Pastoralism and Mining*, 31–54. Leiden: Brill.
- Byambajav, Dalaibuyan. 2015. “The River Movements’ Struggle.” *Social Movement Studies*, 14(1): 92–97.
- Carmin, JoAnn and Adam Fagan. 2010. “Environmental Mobilization and Organizations in Post-socialist Europe and the Former Soviet Union.” *Environmental Politics*, 19(5): 689–707.

- CCA (Center for Citizens' Alliance). 2005. *State of Civil Society in Mongolia (2004–2005)*. Ulaanbaatar: CIVICUS Civil Society Index for Mongolia.
- Creswell, John W. 2002. *Research Design: Qualitative, Quantitative, and Mixed Methods Approaches*. 2nd ed. Thousand Oaks, Calif.: Sage Publications.
- Crotty, Jo. 2009. "Managing Civil Society: Democratization and the Environmental Movement in a Russian Region." *Communist and Post Communist Studies*, 36(4): 489–508.
- Dierkes, Julian. 2018. "Corruption is a Cancer that Mongolia Can't Cut Out." *East Asia Forum*. January 12, 2018. URL: <http://www.eastasiaforum.org/2018/01/12/corruption-is-a-cancer-that-mongolia-cant-cut-out/> (accessed March 6, 2018).
- Fish, M. Steven. 1998. "Mongolia: Democracy without Prerequisites." *Journal of Democracy*, 9(3): 127–141.
- Fish, M. Steven. 2001. "The Inner Asian Anomaly: Mongolia's Democratization in Comparative Perspective." *Communist and Post-Communist Studies*, 34 (3): 323–338.
- Freizer, Sabine. 2004. "Central Asian Fragmented Civil Society: Communal and Neo-liberal forms in Tajikistan and Uzbekistan." In Marlies Glasius, David Lewis and Hakan Seckinelgin (eds), *Exploring Civil Society: Political and Cultural Context*, 115–124. London: Routledge.
- Fritz, Verena. 2002. "Mongolia: Dependent Democratization." *The Journal of Communist Studies and Transition Politics*, 18(4): 75–100.
- Fukuyama, Francis. 1993. *The End of History and the Last Man*. London: Harper Perennial.
- Habermas, Jürgen. 1996. *Between Facts and Norms: Contributions to a Discourse Theory of Law and Democracy*. Translated by William Rehg. Cambridge: MIT Press.
- Hann, Chris. 2003. "Civil society: The sickness, not the cure?" *Social Evolution and History*, 2(2): 55–75.
- Henry, Laura A. 2010. *Red to Green: Environmental Activism in Post-Soviet Russia*. Ithaca, NY: Cornell University Press.
- Howard, Marc Morjé. 2003. *The Weakness of Civil Society in Post-Communist Europe*. Cambridge: Cambridge University Press.
- Ishiyama, John T. 2001. "Party Organization and the Political Success of the Communist Successor Parties." *Social Science Quarterly*, 82(4): 844–864.

- Jakobson, Lev and Sergey Sanovich. 2010. "The Changing Models of the Russian Third Sector: Import Substitution Phase." *Journal of Civil Society*, 6(3): 279–300.
- Jones Luong, Pauline and Erika Weinthal. 1999. "The NGO Paradox: Democratic Goals and Non-democratic Outcomes in Kazakhstan." *Europe-Asia Studies*, 51(7): 1267–1284.
- Kaplonski, Christopher. 2004. *Truth, History and Politics in Mongolia: The Memory of Heroes*. London: RoutledgeCurzon.
- Lane, David. 2010. "Civil Society in the Old and New Member States." *European Societies*, 12(3): 293–315.
- Lishtovannyi, Evgenii. 2007. *Ot Velikoi Imperii K Demokratii: Ocherki Politicheskoi Istorii Mongolii*. (From Great Empire to Democracy: Political History of Mongolia). Irkutsk: State University Press.
- McAdam, Doug, John D. McCarthy and Mayer M. Zald (eds). 1996. *Comparative Perspectives on Social Movements*. Cambridge: Cambridge University Press.
- Mendelson, Sarah Elizabeth and John K. Glenn. 2002. *The Power and Limits of NGOs: A Critical Look at Building Democracy in Eastern Europe and Eurasia*. New York: Columbia University Press.
- Murai, Muneyuki. 2001. "Minshuka Undou Wa Itsu Hajimari Itsu Owattaka" (When Did the Mongolian Democratization Movement Start and End?) *Mongoru Kenkyu* 19.
- Murai, Muneyuki. 2011. "Irgenii Hudulguunii Urnult ba Tugsgul: 2004–2008 on" (The Beginning and the End of Citizens' Movement: 2004–2008). URL: <http://www.aa.e-mansion.com/~mmurai/civilmovementstartandend20042008.pdf> (accessed on March 5, 2012).
- OSF (Open Society Forum). 2005. Mongol Dahi TBB-uudyn Suuri Medeelel. (Basic Information of NGOs in Mongolia). Ulaanbaatar.
- Prohl, Werner and Luvsandendeiin Sumati. 2007. *Voter's Voices: People's Perception of Mongolia's Political and Economic Transition as Reflected in Opinion Polls from 1995 to 2007*. Ulaanbaatar: Munkhiin Useg.
- Radchenko, Sergey and Jargalsaikhan Mendee. 2018. "Mongolia in the 2016–17 Electoral Cycle: The Blessings of Patronage." *Asian Survey*, 57(6): 1032–1057.
- Sabloff, Paula (ed). 2011. *Mapping Mongolia: Situating Mongolia in the World from Geologic Time to the Present*. Philadelphia: University of Pennsylvania Press.

- Small, Mario Luis. 2011. "How to Conduct a Mixed Methods Study: Recent Trends in a Rapidly Growing Literature." *Annual Review of Sociology*, 37(1): 57–86.
- Spina, Nicholas and Christopher Raymond, 2013. "Civil Society Aid to Post-communist Countries." *Political Studies*, 62(4): 878–894.
- Suda, Masaru. 2005. *The Politics of Civil Society, Mahalla and NGOs: Uzbekistan*. URL: [http://src-h.slav.hokudai.ac.jp/coe21/publish/no10\\_ses/12\\_suda.pdf](http://src-h.slav.hokudai.ac.jp/coe21/publish/no10_ses/12_suda.pdf). (accessed on February 18, 2012).
- Sundstrom, Lisa McIntosh. 2006. *Funding Civil Society: Foreign Assistance and NGO Development in Russia*. Stanford, CA: Stanford University Press.
- Tilly, Charles and Sidney Tarrow. 2007. *Contentious Politics*. Boulder: Paradigm Publishers.
- Uhlin, Anders. 2006. *Post-Soviet Civil Society: Democratization in Russia and the Baltic States*. London and New York: Routledge.
- UNDP. 2000. *Mongolyn TBB-uudyn Sanhuujiltyн Baidal. Sudalgaany Tailan*. URL: [www.forum.mnres\\_mat/Report\\_Sukhjargalmaa\\_mong.pdf](http://www.forum.mnres_mat/Report_Sukhjargalmaa_mong.pdf) (accessed on May 5, 2010).





## Монголын ардчилал: Үндсэн сорилт ба хэтийн боломж

Ойдовын Хатанболд

Өнгөрсөн гуч гаруй жилд монголын ардчилал нь хүсэл тэмүүлэл, итгэл найдвараас улс төр, эдийн засгийн хувьд алдаа дутагдал, бүтэлгүйтэл болж хувирсан гэх үзэл бодол газар авах боллоо. Энэхүү бүлэгт зохиогч өөрийн судалгааны хүрээнд экспертүүдийн дунд Монгол дахь ардчиллын сорилт бэрхшээлийг тодруулах зорилгоор зохион байгуулсан гүнзгийрүүлсэн ярилцлага болон ардчилсан үйл явцад гарсан өөрчлөлтийг тодорхойлох олон нийтийн санаа бодлын давтамжит судалгаануудын үр дүнд шинжилгээ хийсэн. Ингэхдээ Шведийн Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэнгийн (International IDEA)-ээс боловсруулсан арга зүй, хэрэглэгдэхүүнийг ашиглан монголын үндэсний өвөрмөц онцлог, нөхцөл байдалд хэрхэн тусгалаа олж буйг тодруулан судлахыг хичээсэн юм. Цаашлаад, эл бүлэг нь Монгол дахь ардчиллыг үнэлэхдээ монголын онцлог бүхий шинж чанаруудыг тусгасан нэмэлт шалгууруудыг боловсруулан хэрэглэх нь зүйтэй хэмээн үзсэний зэрэгцээ иргэдийн болон төрийн байгууллагуудад ардчилсан механизмыг сайжруулснаар хариуцлагыг нэмэгдүүлж, ардчиллыг бэхжүүлэх боломжийг эрэлхийлэхээр зорьсон болно.

### Оршил

Монгол Улсыг 1990 оноос хойших ардчиллын “дөрөв дэх давалгаа”-ны орнуудын нэг, Төв Азийн бүс нутагт ардчиллын “ер бусын содон” үйл явцын анхдагч жишээ гэж олон улсын хэмжээний судалгаануудад (ФСЭХ ба НҮБХХ, 2006, 2008, 2010, 2013, 2014) дүгнэсээр иржээ. “Ер бусын содон” хэмээн онцлохын гол үндэс нь ардчиллын уламжлалт “урьтал нөхцөл” өрнөдийн орнууд шиг байгаагүй ч, ардчилалд чухал гэгдэх соёл талын зарим хүчин зүйл болох уламжлалт нүүдлийн ахуй соёлоос улбаатай эрх чөлөөг эрхэмлэх үзэл, цаашлаад нэг нутаг усныхантайгаа ойр дотно харилцаатай байхыг илүүд үзэх хандлага нь соёлын хувьд өвөрмөц хэвээр байгаа явдал юм. Бас газар зүйн байрлалын хувьд ардчиллыг өрнөдийнхөөс өөрөөр хэрэгжүүлж буй хоёр их хөршийн дунд оршдог ба монголчуудын тусгаар тогтнолыг эрхэмлэх үзэл нь ардчилсан үнэлэмжээр дамжин илэрдэг байж болохыг ч энд дурдах нь зүйтэй (Sabloff, 2013).

Монгол Улсад ардчиллыг хөгжүүлэх явцад бүрэлдэн төлөвшиж буй улс төрийн тогтолцоо нь ардчиллын ерөнхий үзэл санаа, дэг жаяг, үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа гэж хэлэх үндэстэй. Үүний гол баталгаа нь Монгол Улсын шинэ ардчилсан Үндсэн хууль мөн. Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу ардчиллыг хэрэгжүүлсэн бодит үйл

явцын төвлөрсөн илэрхийлэл нь ардчиллын олон улсын жишигт нийцэж явагдсан найман удаагийн парламентын сонгууль, найман удаагийн ерөнхийлөгчийн сонгууль, мөн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын долоо удаагийн сонгууль, эдгээр сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан ардчилсан институцийн төлөвшил юм. 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд “ардчилал”-ыг хамгийн өргөн утгаар нь буюу ард түмэнд төрийн дээд эрх мэдлийг эдлүүлэх агуулгаар “хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” (Хууль зүйн үндэсний төв, 2007) эрхэм зорилгын хүрээнд тунхагласан байдаг. Шинэ Үндсэн хуулийн үзэл санааны онолын үндсийг авч үзвэл угтаа орчин үеийн ардчиллын хамгийн гол үнэт зүйлс (хүний эрхийн болон тэгш байдлын дэлхий нийтийн түгээмэл тунхаглалыг дээдлэх, хууль дээдлэх ёс, үндсэн хуульт улс төрийн байгуулал, олонхын зарчимд тулгуурласан хараат бус ард иргэдийн оролцоо, шударга ёс, эрх тэгш байдал, хувийн өмч, үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх суурь эрхийг хамгаалах, баталгаажуулах гэх мэт)-ийг багтаасан сонгодог хийгээд либерал онолын тулгуур зарчимд үндэслэсэн байдаг.

Монголын ардчилал нь эхэн үедээ эрчимтэй хөгжиж байсан боловч сүүлийн жилүүдэд, 2000 оноос аажмаар саарах, ухрах шинжтэй болсон байна. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж эхэлснээр эдийн засгийн шинэ боломжууд нээгдсэн боловч мөнгө дагасан улс төр үлэмж хүчтэй хөгжиж, улс төр-бизнесийн явцуу бүлэглэлд эрх мэдлийн далд төвлөрөл бий болох үйл явц улмаар ардчиллын хөгжилд өвөрмөц сорилт, бэрхшээлийг бий болгож байна (Улс төр судлалын салбар, ШУА 2017). Түүнчлэн хариуцан тайлагнах тогтолцоо сул хөгжсөн, эх оронч үзэл явцуурах болсон, улс төрийн намуудын чадавх сул байгаа зэрэг асуудал нь ардчилалд аюул учруулах болов. Энэ үеийн гол сорилт нь байгалийн баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах нэрийн дор үндэсний хэмжээнд улс төр-бизнесийн явцуу бүлэглэлийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхийг санаархах, эрх мэдэл ба баялгийг төвлөрүүлэх, үүндээ ардчиллыг арга хэрэгсэл болгон ашиглаж эхэлсэн явдал байв Түүнчлэн, 1990-ээд оны хоёрдугаар хагасаас эхлээд 2004 оны сонгууль хүртэлх хугацаанд улс төрийн намуудын төлөвшил удааширч, бүлэг фракцаараа хуваагдах, албан тушаалын наймаа, хуйвалдаан хийх, авлига, хээл хахуульд идэгдэх зэрэг сөрөг үзэгдэл идэвхжиж, ардчилалд шинэ сорилт бэрхшээлүүд үүсэж эхэлсэн байдаг. Сорилт бэрхшээлийн гол шинж нь улс төр, мөнгө хоёрыг нэг зоосны хоёр тал мэтээр ойлгож улс төр, сонгуулиар дамжин эрх мэдэлд хүрэх, эрх мэдэлд хүрч чадвал түүнийгээ ашиглан хувийн сонирхлоо хэрэгжүүлэх, чингэхдээ ардчиллын үнэт зүйлсийг баримталж байгаа мэт дүр эсгэх зэрэгтэй холбоотой болж ирсэн байна.

Энэхүү бүлгийн эхний хэсэгт ардчиллын хөгжлийг хязгаарлаж буй саад бэрхшээл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн үнэлгээ, ардчиллын улс орны хөгжилд үзүүлж байгаа нөлөөлөл, цаашлаад засаглалын чанарт

иргэд болон шинжээчдийн өгсөн үнэлгээний асуултуудын хариултыг харьцуулж үзсэн. Ингэхдээ, ардчиллын талаарх иргэдийн ойлголт, түүнчлэн ардчиллын бодит илэрхийлэл болох институци, тэдгээрийн харилцаа холбоо, шууд ардчиллын механизм зэрэг тогтсон олон судалгааны тойм шинжилгээ дээр үндэслэн судлав.

Бүлгийн хоёр дахь хэсэгт ардчиллын суурь зарчим нь монголын ардчилалд хэр тусаж байгаа, монголын ардчиллын загварыг тодорхойлсон шинж чанаруудын талаар онцолсон болно. Судалгааны явцад хийсэн шинжилгээгээр, ардчиллын эхний арван жилд монголчууд ардчиллыг голчлон “хүний эрх, эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө” хэмээн ойлгож ирсэн бол, аажимдаа энэ нь “иргэдийн оролцоонд тулгуурласан шударга ёс, үнэнч шударга байдлыг баталгаажуулах, хариуцан тайлагнах үр нөлөө бүхий үйл явцыг бий болгох явдал” хэмээн өөрчлөгдсөн байна. “Монголын ардчиллын үнэлгээ” шинжээчдийн судалгаагаар эл нөхцөл байдлыг тодруулахыг зорьсон буюу индукц ба дедукц, анализ ба синтез, аналог, харьцуулалт, түүхэн ба логик зэрэг судалгааны ерөнхий аргыг зохих хэмжээнд ашигласан болно. Түүнчлэн өөрийн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалахад зориулан судалгааны мэдээллийг дөч орчим экспертээс цуглуулж үнэлгээ, кейсийн шинжилгээний аргыг түлхүү хэрэглэсэн ба 2016 оны 3-4 дүгээр сард дээрх аргуудыг ашиглан судалгаагаа явуулсан болно. Эл шинжээчдийн судалгааг хийхдээ шалгуур үзүүлэлтүүдэд кластер ангилал үүсгэж, хүн амын нас, хот суурин, хөдөө орон нутгаар нь хоёр хувьсагч үүсгэн, улмаар оршин суугаа газрын байршил, боловсрол зэргээр харилцан хамаарлыг тооцож, дүн шинжилгээ хийхийг зорьсон юм. Харин шинжээчдийн хувьд, ардчилал, улс төрийн өргөн мэдлэг, туршлагаар сонгон авч улс орны нөхцөл байдалд уян хатан, дасан зохицох чадварыг хэрхэн үнэлж дүгнэж буй эсэхийг тодруулахыг эрэлхийлсэн болно.

Судалгаандаа Р.Даль, Л.Даймонд, Ф.Фукуяама нарын ардчиллын талаарх онолын үзэл баримтлалыг харьцуулан шинжилж, орчин үеийн суурь онолуудын хүрээнд дэвшигдэж судлаачдын анхаарлыг татаж байгаа “ард түмний засаглах дээд эрх мэдэл”-ийн тухай, Ролф Буэчийн (Buechi R, 2014) “бодитоор оршин ажиллаж буй ардчиллын хэлбэр”-ийн тухай үзэл баримтлалыг онолын ерөнхий үндэслэл, хүрээ болгосон. Түүнчлэн, ардчиллын үнэлгээний арга зүйн хувьд, сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын ардчилал, засаглалын төлөв байдалд үнэлгээ хийхэд өргөн хэрэглэж байгаа Шведийн Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн (International IDEA, 2002), АНУ-ын олон улсын хөгжлийн байгууллага, НҮБХХ (UNDP, 2011), Дэлхийн банк гэсэн дөрвөн байгууллагын хэрэглэж буй арга зүйг харьцуулсны үндсэн дээр “Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн”-гийн арга зүйг өөрийн боловсруулсан ардчиллын онолын логик матриксаар баяжуулан ашигласан. Уг аргачлалыг сонгох болсон шалтгаан нь дэлхийн олон оронд туршигдсан, чингэхдээ тухайн улс орны судлаач, эрдэмтэд өөрсдөө

үндэсний хэмжээний судалгааны арга зүй боловсруулж, түүгээрээ ардчиллын төлөв байдал, ардчилсан засаглалаа хэмжиж, үнэлгээ өгөхөд чиглэдэг гэдгээрээ онцлогтойн дээр, хөгжлийн төлөө үйл ажиллагаа явуулдаг голлох байгууллагууд уг судалгааны үр дүнг ашигладаг зэргийг харгалзаж үзсэн.

Дүгнэлт хэсэгт дурдсанчлан, монголын ардчилалд эерэг гэхээс илүү сөрөг хандлага давамгайлж байгаа нь ардчиллын гол бэрхшээл болж буйн дээр, улс төрийн намуудын дотоод ардчилал хэт удаашралтай явагдаж байгаа дүр зураг ажиглагдав. Улс төрчид болон иргэдийн ардчиллын талаарх мэдлэг сул, цаашлаад улс төрийн соёлын төвшин доогуур байгаа нь биднээс тал бүрийн хичээл зүтгэл, ур чадвар шаардаж байгааг онцлон тэмдэглэсэн болно.

## **Монгол дахь ардчиллын чанарыг үнэлэх нь**

Монголын ардчиллын хөгжил, төлөвшлийн үйл явцыг бүхэлд нь тоймлон үзвэл 1990-ээд оны хоёрдугаар хагас хүртэлх хөгжлийнхөө эхэн үед ардчиллын суурь үнэт зүйлс, тулгуур зарчмуудыг хамгийн тууштай хэрэгжүүлж байв. Энэ үеийн ардчиллын хөгжилд учирч байсан гол сорилт бэрхшээл нь өмнөх нийгмийн үеэс уламжилсан үнэт зүйлсийн инерцийг тусгасан сэтгэлгээ, арга барилын хоцрогдол, шинэ үзэл санаа, үнэлэмжийн “нялх” буюу сул хөгжилтэй холбоотой байв. Харин 1990-ээд оны хоёрдугаар хагасаас эхлээд 2004 оны сонгууль хүртэлх хугацаанд улс төрийн намуудын төлөвшил удааширч, бүлэг фракцаараа хуваагдах, албан тушаалын наймаа, хуйвалдаан хийх, авлига, хээл хахуульд идэгдэх зэрэг сөрөг үзэгдэл идэвхжиж, ардчилалд шинэ сорилт бэрхшээлүүд үүсэж эхэлсэн байдаг.

Шинжээчдийн үнэлгээгээр монголын ардчиллын хөгжлийн үйл явцыг парламентын ээлжит чуулганы үргэлжлэх хугацаагаар ангилж үзэхэд, шинжээчдийн 56 хувь нь 1990-1992 онд монголын ардчилал эрчимтэй хөгжсөн гэсэн бол, 2004-2008, 2012-2016 он хүртэлх хугацааг ардчилал эрчимтэй хөгжсөн гэж үзэх боломжгүй, харин ч дурдсан хугацаанд ардчилал зарим талаар (19 хувь), ерөнхийдөө ухарсан (47 хувь) гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхүл, улс орны хөгжлийн дор дурдсан зурвас үеүдэд ардчиллын хөгжил ухралтын байдалд орсныг харуулж байна. Шинжээчдийн үзсэнээр, монголын ардчилал нь эхэн үедээ эрчимтэй хөгжиж ирсэн боловч сүүлийн жилүүдэд буюу 2000 оноос аажмаар саарсаар, одоо (2008 оноос) ухралтын шинжтэй болсон байна (Хүснэгт 1).

### Хүснэгт 1: Монголын ардчилал хэрхэн хөгжиж буйд шинжээчдийн өгсөн үнэлгээ (хувиар)

Он	Эрчимтэй хөгжсөн	Ерөнхийдөө хөгжсөн	Зогсонги байдалд орсон	Зарим талаараа ухарсан	Ерөнхийдөө ухарсан
1990–1992	56.3	34.4	3.1	3.1	3.1
1992–1996	18.8	46.9	12.5	18.8	3.1
1996–2000	6.3	50.0	28.1	9.4	6.3
2000–2004	3.1	31.3	28.1	25.0	12.5
2004–2008	0.0	43.8	18.8	18.8	18.8
2008–2012	6.3	40.6	6.3	18.8	28.1
2012–2016	0.0	21.9	6.3	21.9	46.9

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Энэ байдал сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгааны дүнгээс нэлээд тодорхой харагдаж байна. Тухайлбал, 2006 онд хийгдсэн Азийн барометрийн судалгааны дүнгээс үзэхэд, монголчууд “ардчиллын идеалийг бүрэн дэмждэг, ардчиллын тухай ойлголт нимгэн, либерал ардчиллын тухай ойлголт бага, ардчиллын бодит дэмжигчид нь хүн амын цөөнх хэвээр, иргэдийн ардчиллыг хүсэмжлэх хэрэгцээ (эрэлт) бага”, бодит дэмжигчийн хувь нь зэргэлдээ бүсийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад арай бага буюу “ардчиллын бодит дэмжигчид Монгол Улсад 30 хувь, Зүүн Азийн дундаж 35 хувь, Зүүн Европын дундаж 38 хувьтай” байсан билээ (Д.Ганбат, 2006). Энэ бол иргэдийн хувьд ардчиллын талаарх анхны идеал шинжтэй мөрөөдөл, хүлээлт монголын ардчиллын хөгжлийн бодит үйл явцаас шалтгаалан эргэлзээнд орж эхэлсэн нь одоогоос 10-аад жилийн өмнөх ерөнхий дүр зураг юм.

Тэгвэл дөрвөн жилийн дараа 2010 онд хийгдсэн судалгааны дүнгээс үзэхэд энэ дүр зураг төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Гэхдээ ардчиллыг ил тод байдал, шударга ёс, эв нэгдэлтэй байх, зөвшилцөл гэж үзэх ойлголт бага зэрэг өссөн, бусад үзүүлэлтийн тухайд 1-2 хувиар буурсан байгаагаас үзэхэд (ФСЭХ ба НҮБХХ, 2010), ардчиллын уг мөн чанарыг илүү бодитой ойлгож бүтээлч хандах байдал бага ч гэсэн нэмэгдэх хандлага гарчээ. Угтаа шударга ёсыг хангах нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь, үндсэн зарчим бөгөөд монгол хүн бүрийн хүсэл юм (Г.Занданшатар, 2016). Энэ утгаараа, чанарын судалгааны мэдээллүүд иргэд улс орны хөгжилд тодорхой хэмжээний ахиц дэвшил гарч хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлд зарим нааштай зүйл байгаа боловч одоогийн төр, тэнд ажиллаж буй улс төрчдийн нэлээд нь олигархууд болон баян эрх мэдэлтэй

хүмүүсийн талд үйлчлэх болсноор, жирийн иргэдийн дунд нийгэмд эмх замбараагүй байдал бий болох, эрхээ хэтрүүлэх, дүрэм журамгүй байх явдал газар авч байгааг судалгаанд оролцогсад үндсэндээ хүлээн зөвшөөрч байсныг тэмдэглэе.

Монголчуудын ардчиллын талаарх төсөөлөл ямар учраас сөрөг болж ирснийг сэтгэл ханамж, дэмжлэг, итгэл гэсэн гурван суурь шалгуураар тодруулахыг зорьсон ба Хүснэгт 2-т үзүүлэлт тус бүрээр 2005 оноос хойш гарсан өөрчлөлтийг харуулав.

## Хүснэгт 2: Монголын ардчиллын хөгжилд саад болж буй зүйлс (2005–2013 оны судалгааны дүнд хийсэн харьцуулалт, хувиар)

	2013	2010	2008	2005
Үндсэн хуульт ёс, хүний эрхийн олон улсын үзэл санаа тулгуур зарчмыг үл тоомсорлож, хариуцлага тооцох тогтолцоо хангалтгүй байна.	13.9	16.4	14.0	16.2
Хүн болон улс орны асуудлыг хүний эрхэд суурилсан хандлагаар авч үздэггүй мөнгөөр бүхнийг шийддэг болсон.	9.6	7.3	16.4	17.8
Авлига, хээл хахууль буурахгүй байна.	9.3	16.0	15.0	18.8
Иргэдийн улс төрийн болон нийгмийн эрх хязгаарлагдмал.	7.2	10.3	10.3	13.6
Ардчиллын боловсрол дутмаг.	7.0	2.4	2.4	0.7
Нийгмийн алба улс төрөөс хараат бус байна.	12.4	10.6	22.8	14.2
Эрх зүйн шинэтгэлийг удаашруулсан.	21.8	25.1	20.6	20.4
Улс төрийн албан хаагчдын ур чадвар дутагдаж байна.	3.1	13.8	14.1	19.7
Нам төвтэй төрийн тогтолцоотой, хуучин коммунист үзэл хандлага	2.3	1.9	4.0	6.9
Шударга бус байдал гаарсан.	9.4	10.9	8.2	7.0
Улс төрийн намууд, улс төрчдийн хувийн амбиц их байна.	11.6	4.4	8.8	8.4
Улс төрийн соёл, боловсрол, мэдлэг төлөвшил дутмаг.	7.0	2.0	5.1	12.4
Танил талаараа талцах, эмх замбараагүй байдал	2.3	4.4	16.4	17.8
Ил тод байдал дутмаг.	2.3	3.1	3.8	6.2
Хуулийн хэрэгжилт хангалттай биш.	2.3	6.2	14.0	16.2
Хүнд суртал газар авсан.	7.0	8.1	6.0	8.3
Шүүх засаглалын хараат байдал	2.3	7.0	4.2	1.0
Мэдээллийн эрх чөлөө сул, мэдээлэл дутмаг.	2.3	1.1	0.9	2.4
Улс төрийн намуудын шударга бус өрсөлдөөн	16.0	11.8	22.5	5.2

Эх сурвалж: ФСЭХ ба НҮБХХ (2006, 2008, 2010, 2013, 2014).

Хүснэгтээс улс төрийн намууд, улс төрчдийн хувийн амбиц их (16 хувь), авлига, хээл хахууль буурахгүй байгаа (12.5 хувь) гэсэн хоёр үзүүлэлт хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа бол, ардчиллын боловсрол дутмаг, шударга ёс, шударга бус байдал, улс төрийн соёл, боловсрол, мэдлэг төлөвшил дутмаг, хүнд суртал гэсэн үзүүлэлтүүд удаалжээ. Мөн ардчиллын хөгжилд саад болж буй суурь шалтгааны тухай асуудлаар шинжээчдээс нэмэлт мэдээлэл авч үзэхэд, тэд хоёр гол суурь шалтгааныг онцолсон байна. Эдгээр нь, нэгт, иргэдийн улс төрийн боловсрол, соёл дутмаг байгаа явдал. Иргэд нь ардчиллын зохих боловсролтой, улс төрийн өндөр соёл төлөвшсөн нийгэмд улс төрчдийн дур зоргын үйлдлийг хязгаарладаг, ардчилсан үнэт зүйлсийн хамгаалалт сайн байдаг учраас энэ нь өөрөө ардчиллын суурь хүчин зүйл болдог байна. Хоёрт, нийгэмд баян, ядуугийн ялгаа хэт ихэссэн явдал. Аль ч нийгэмд ардчиллын суурь баталгааны нэг бол дундаж давхраа байдаг. Гэтэл манайд нийгмийн давхраажил хоёр туйл руу чиглэсэн ялгарал хүчтэй явагдаж байгаа нь ардчиллын хөгжилд саад учруулдаг олон хүчин зүйлийн суурь үндсийг бүрдүүлж байна.

### **Хүснэгт 3: Монголын ардчиллын хөгжилд саад болж буй зүйлс (2005–2013 оны судалгааны дүнд хийсэн харьцуулалт, хувиар)**

	2013
Эрх мэдлийн төлөөх тэмцэл	81.3
Авлига, хээл хахууль	75.0
Шударга бус байдал	65.6
Улс төрийн намуудын төлөвшил	46.9
Улс төрчдийн хувийн ашгаа илүүд үздэг байдал	37.5
Боловсролын нимгэн байдал	34.4
Хууль хэрэгждэггүй байдал	21.9
Нийгмийн эмх замбараагүй байдал	18.8
Төрийн албаны хүнд суртал, төрийн дарамт	15.6
Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаа	12.5
Иргэдийн улс төрийн соёл, ухамсар дутмаг	12.5
Хуучин коммунист үзэл суртал, хандлага	9.4
Ядуурал	9.4
Засаглалын одоогийн хэлбэр	6.3
Ажилгүйдэл	6.3
Мэдээллийн хомс байдал	3.1
Архидалт	3.1

Эх сурвалж: ФСЭХ ба НҮБХХ (2006, 2008, 2010, 2013, 2014).

Монголын хөгжилд саад болж буй хүчин зүйлсийн талаарх иргэдийн санал бодол ба шинжээчдын үнэлгээ хоорондоо давхцаж байгаа нь сонирхол татаж байна. Мөн иргэд, шинжээчдийн аль аль нь эдгээр хүчин зүйлийг нарийн түвэгтэй, төөр төрөл бүрийн үйл явц, үзэгдлээс хамаарна гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Тиймээс эдгээр хүчин зүйлийн нөлөөллийг тодруулах зорилгоор ардчилал улс орон, иргэдийн амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулсан юм. 2016 онд хийсэн “Монголын ардчиллын үнэлгээ” шинжээчдийн асуулгын дүнгээс харвал, ардчиллын нөлөө харьцангуй эерэг гэх хандлага давамгайлж байна. Энэ бол өмнө тэмдэглэсэн ардчиллын бодит дэмжлэг өсөж байгаагийн бас нэгэн илэрхийлэл юм. Мөн энэ үзүүлэлтийг дагаад сөрөг нөлөө үзүүлж байна гэсэн үнэлгээ нэлээд буурах хандлага ажиглагдаж байна (Хүснэгт 4). Хамгийн бага эерэг нөлөөтэй салбар бол төрийн албаны төлөвшил байна. Энд мэдээжээр цөөн биш шалтгаан буй. Гол нь төрийн албыг улс төржүүлж, сонгон шалгаруулалтыг хэлбэр төдий явуулдгаас төрийн алба тогтворгүй, чадваргүй болж байгаа явдал гэж үзэж болно. Гэсэн хэдий ч ерөнхийд нь авч үзэхэд ардчилал нь өөрийн гэсэн олон сорилттой тулгарч байгаа ч, улс орны хөгжилд шийдвэрлэх үр нөлөөтэй байсан гэдгийг шинжээчид хүлээн зөвшөөрчээ.

#### Хүснэгт 4: Монголын ардчиллын үр нөлөө улс орны хөгжилд үзүүлсэн үр нөлөөнд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувь, оноор)

Хүрээ	Он	Эерэг	Зарим талаар эерэг	Дундаж	Зарим талаар сөрөг	Сөрөг
Эдийн засгийн хөгжилд	2016	13.0	19.0	47.0	16.0	5.0
	2013	2.2	7.9	37.1	30.3	22.5
Улс төрийн хөгжилд	2016	9.0	19.0	38.0	28.0	6.0
	2013	4.5	15.9	29.5	28.4	21.6
Төрийн албаны төлөвшилд	2016	3.0	6.0	38.0	31.0	22.0
	2013	3.4	30.7	37.5	15.9	10.2
Хүний хөгжилд	2016	9.0	50	28.0	-	9.0
	2013	3.4	8.0	39.6	29.5	19.3
Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд	2016	22.0	25.0	34.0	9.0	9.0
	2013	4.5	16.9	30.3	27	20.2
Гадаад харилцаанд	2016	34.4	40.6	18.8	3.1	3.1
	2013	1.1	29.5	35.2	31.8	2.3

Эх сурвалж: О.Хатанболд, 2016; ФСЭХ ба НҮБХХ, 2013.



Монголд ардчилсан засаглалын шинжүүд хэрхэн төлөвшиж байгаа талаар шинжээчдийн 2016 оны асуулгын доорх дүнгээс харвал, хариуцлага хүлээх байдал (72 хувь), шударга үйл ажиллагаа (41 хувь), хариуцан тайлагнах байдал (47 хувь), хуулийн хэрэгжилт (37.5 хувь)-д 'муу', 'маш муу' гэсэн үнэлгээг өгсөн бол, нээлттэй, ил тод байдал (50 хувь), иргэдийн оролцоо (50 хувь)-ны хэрэгжилтэд 'дунд зэрэг' үнэлгээ өгсөн байна (Хүснэгт 5). Энэ нь шинжээчдийн дунд ардчилсан засаглалыг бүрдүүлдэг гол шинжүүд төдийлөн сайнаар хангагдаж, бэхжээгүй, зарим талаараа ухралт гарч буйг давхар нотолж байна (О.Хатанболд, 2016). Ардчилсан засаглалын дурдсан шинжүүд иргэдийн төсөөллийн судалгааны дүнгүүдтэй ойролцоо байгаа нь эндээс ажиглагдаж байна. Нийгмийн шударга ёс, хариуцлагатай байдал, шударга шүүхийн үйл ажиллагаа, хуулийн хэрэгжилт зэрэг ардчилсан нийгмийн тулгуур зарчим бүрэн үйлчлэхгүй байгаа нь өнөөгийн нийгмийн өмнө тулгарч буй томоохон сорилт болж буйг шинжээчдийн асуулгын дүн харуулж байна.

#### **Хүснэгт 5: Монгол дахь ардчилсан засаглалын шинжүүдэд шинжээчдийн өгсөн үнэлгээ, хувиар**

Шинжүүд	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Муу	Маш муу
Нээлттэй, ил тод байдал	8.9	12.5	37.9	31.3	9.4
Шударга үйл ажиллагаа	-	6.3	21.9	37.5	40.6
Хариуцлага хүлээх байдал	-	6.3	9.4	18.8	71.9
Иргэдийн оролцоо	6.3	6.3	50.0	37.5	6.3
Иргэдээ сонсож, үйлчлэх байдал	6.3	9.4	43.8	28.1	18.8
Хариуцан тайлагнах байдал	6.3	6.3	18.8	46.9	28.1
Хуулийн хэрэгжилт	6.3	3.1	28.1	37.5	28.1
Дундаж хувь	1.85	6.25	29.9	33.9	28.1

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Ардчилсан засаглалын шинжийг түүний гол институцидэд итгэх итгэл, үйл ажиллагааг нь иргэд хэрхэн үнэлж байгаагаар дамжуулан тодруулж болно. Ийм үнэлгээг манайд ардчиллын талаар хийгдэж буй бараг бүх судалгаа гаргадаг ба ерөнхий дүр зураг хандлага нь ойролцоо гардаг. Үндэсний Статистикийн Хорооны судалгаанд ерөнхийлөгчийн институци, парламент, засгийн газар, нутгийн удирдлагын байгууллагад ардчилал хэр хөгжиж буйг тогтмол давтамжтай, хамгийн өргөн, найдвартай түүврээр нэлээд цогц гаргадаг. 2018 оны дүнгээр ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай гэж судалгаанд оролцогч иргэдийн 44 хувь хариулсан бол, засгийн газарт 22 хувь, парламентын үйл ажиллагаанд 13 хувь л сэтгэл ханамжтай гэжээ (ҮСХ, 2012, 2013, 2014). Ерөнхийдөө засаглалын

харилцааны гол институциудийн талаарх иргэдийн үнэлгээний энэ дүр зураг олон жилийн турш тогтвортой хадгалагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

## Монголын ардчиллын зохистой хувилбарыг эрэлхийлэхүй

Монгол оронд өрнөсөн ардчилагдах үйл явцаар манай нийгэмд улс төрийн үзэл бодол, иргэний ашиг сонирхол, улс орноо хөгжүүлэхэд оролцох арга хэлбэр зэргээрээ ялгаа бүхий нийгмийн бүлгүүд үүсэн бий болсон. Ингэснээр монголчууд өөрсдийн үзэл баримтлал, итгэл үнэмшлээ дагасан улс төрийн үйл ажиллагаа явуулах, олон намын тогтолцоо цоо шинээр бүрэлдэн тогтох чухал үйл явцын эхлэлийг тавьсан юм. Энэ үйл явцын тусгал болж, түүнтэй нягт холбоотойгоор, монголын нийгмийн улс төрийн амьдралд олон ургалч ардчиллын хэлбэр хөгжиж, ардчилсан үйл явцын өрнөл, нийгмийн улс төрийн амьдралын шинэчлэл, өөрчлөлтийн агуулгыг тодорхойлох болсон. Тэгвэл, өнөөдрийн Монголд болж буй ардчиллын тухай яриа, судалгаа, сурталчилгааны ажлын ихэнх нь “Монголын ардчилал”-ын тухай үзэл санааны далбаан доор хийгдэж байгаа. Улс төрийн хүрээнийхэн, улс төр судлаачдын дотор ийм үзэл санааг талархан дэмжигчид үнэмлэхүй олонхыг бүрдүүлж байна. ХХ зуунд монголчууд ардчиллын тухай ярьдаг, бичдэг, бас ч судалдаг болсон. Ингэхдээ эхлээд марксист онолын “пролетарийн буюу социалист ардчиллын” тухай сургаалыг, дараа нь марксист биш онолын “либерал буюу чөлөөт ардчилал”-ын тухай үзлийг баримжаалсан. Социалист ардчиллыг хэрэгжүүлэх гэсэн оролдлого 1990-ээд онд мухардалд орж тасалдсан, либерал ардчиллыг хэрэгжүүлэх үйл явц хорь гаруй жил үргэлжилж байгаа хэдий ч, сүүлийн жилүүдэд хямрах, удаашрах, зарим талаар ухрах байдал ажиглагдах болсон (ФСЭХ ба НҮБХХ, 2006, 2008, 2010, 2013). Цаашид хэрхэх тухай асуудалд бүтээлч бодол санааны эрэл хайгуул хэрэгтэй байна. Ийм эрэл хайгуул нь эхлээд арга зүйн асуудалд төвлөрөх нь чухал байна (УТШУХ, 2008).

Ардчилал даяаршмал шинжтэй, олон улсын хэмжээний хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болсон өнөө үед ардчиллын чанар, хэлбэр, загвар, хөгжлийн түвшний ялгаа зэрэг асуудлыг судлах ажил эрчимжсэн байна. Роберт А.Даль, Габриел Алмонд, Сидней Верба, Давид Истон, Эмиль Дюркхейм, Талкот Парсонс, Рональд Инглхарт, Карл Поппер, Хуан Линц, Сеймур Мартин Липсет, Самуэль Хантингтон, Фрэнсис Фукуяама, Адам Прзиворский, Артур Шлесингер, Ларри Даймонд, Давид Колльер, Стив Левицкий, Арэнд Лийпхарт зэрэг олон эрдэмтэн судлаач ардчиллын онолыг хөгжүүлэх үйл хэрэгт хувь нэмрээ оруулсаар байна. Эдгээр судалгаа өөр чиглэлтэй, зохих үндэслэлтэй байгаа нь ойлгомжтой боловч ардчиллын томоохон судлаач Л.Даймондын хэлсэнчлэн ардчиллын чиглэлийн онол, судалгаанд өнөөдөр асар олон урсгал төрөн гарсан бөгөөд “онолын замбараагүй байдал” бий болжээ (Diamond, 1996). Даймондын

энэ дүгнэлтийг сөрөг үнэлгээ гэхээс илүү бие даасан төр улс бүрийн улс төрийн тогтолцоо, төрийн байгуулал, нийгмийн практик нь тухайн орны түүх, соёл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээр тодорхойлогдож олон хувилбар, загвартай болж байгаа учраас ардчилал чухам тийм байх ёстой гэсэн нийтлэг ухагдахуун гаргах боломж хязгаарлагдмал гэсэн байр суурийг судлаач хуваалцаж байгаа болно (Томмасоли, 2008).

Судалгааны хүрээнд хийсэн онолын логик матрицын арга зүйн ерөнхий загварчлалын үүднээс “Монголын ардчиллын үнэлгээ” шинжээчдийн асуулгаар ардчиллын онолын илэрхийллүүдээс монголын ардчилалд тохирох боломжит хувилбар бүхий илэрхийллийг тодруулах зорилгоор ардчиллын онолын илэрхийллүүдийг тус бүр долоон ангиллаар тодруулсан. Үүнд ардчиллын онолын пре-модерн, либерализм ба републиканизм, републиканизм ба коммунитари сэтгэлгээний хүрээ, ардчиллын орчин үеийн онолын хүрээ, плюралист ардчиллын үзэл санааны хүрээ, гүйцэтгэлийн ардчиллын үзэл санааны хүрээ, оролцоот ардчиллын үзэл санаа зэргээр тодруулсан болно.

Ардчиллын онолын пре-модерн хүрээ бол орчин үеийн ардчиллын онолуудын тогтолцоонд шинэчлэгдсэн, бидний сонгодог хэмээн нэрлэдэг үеийн сэтгэлгээний тодотголоор ардчиллыг ойлгох ойлголт, түүнд хандах хандлага, үзэл санаа, зарчмууд юм. Нөгөө талаар, энэ хүрээнд эрх, эрх чөлөө, тэгш байдлын зарчмыг хуулийн хүрээнд хууль ёсыг дээдэлж, ардын эрхт засгийг захирах, захирагдах журамтай хослуулах замаар нийгмийн шударга ёсны харилцан хамаарлыг чухалчлахыг шинжээчдийн асуулгаас гарсан хариулт харуулж байна (Хүснэгт 6). Шинжээчдийн үзэж байгаагаар хязгааргүй эрх чөлөө нь аливаа дарангуйллын суурийг бэлдэж ардчилсан зарчмыг туйлшруулж, эзэнгүйдүүлэхэд (81 хувь) хүргэхийн зэрэгцээ, нийгмийн дундаж давхаргын хамгийн өргөн оролцоог үл хангах аваас хууль бүхнээс дээгүүр үйлчлэх бодит үндэслэлийг үгүй (78 хувь) хийн, шударга ёсыг сааруулж (63 хувь) бүрхэгдүүлэхэд хүргэдэг байна. Өөрөөр хэлбэл, ардчиллын онолын сонгодог сэтгэлгээ, сэтгэгчид (Перикл, Сократ, Платон, Аристотель)-ийн дэвшүүлсэн үзэл санаа, загвар өнөөдрийг хүртэл чухал хэвээр байгааг шинжээчид үнэлж, монголын ардчиллын төлөвшилд бүрэн нийцэх (69.5 хувь) боломжтой гэж үзсэн байна.

## Хүснэгт 6: Ардчиллын онолын пре-модерн түүхэн сэтгэлгээний хүрээний илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Шударга ёсыг хүн өөрийн дур сонирхлын дагуу мөрддөггүй, харин хүн бүр шударга бус явдлыг шүүмжлэн хэлэлцэх замаар таслан зогсоох явдал мөн.	43.7	56.2
Хязгааргүй эрх чөлөө нь дарангуйллын суурийг бэлтгэж, улмаар ардчилсан зарчмыг туйлшруулж, эзэнгүйдүүлэх хандлага болно.	18.7	81.3
Нийгмийн харилцаа бол хөдөлмөрийн хуваарилалтын зарчим дээр тулгуурлах явдал мөн бөгөөд шударга ёстой байх нь хүний өөрөө хийвэл зохих зөв зүйл мөн.	37.4	62.6
Нийгмийн дундаж давхаргын хамгийн өргөн оролцоог хангасан тохиолдолд хууль бүхнээс дээгүүр үйлчлэх бодит үндэслэл болно .	21.9	78.1
Дундаж хувь	30.4	69.5

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Либерал үзлийн амин сүнс, түлхүүр ойлголт нь эрх чөлөөний үзэл санаа байдаг бөгөөд язгуур чанараараа нийт хүн төрөлхтний үнэт зүйл мөн бөгөөд түүний үзэл баримтлал, номлолуудыг барууны нийгмийн хөрс сууринд түшиглэж боловсруулсан учраас түүнийг зөвхөн барууны үзэгдэл гэж үзэх хандлага ихээхэн түгээмэл байдаг. Хүснэгт 7-д харуулсанчлан, монголчуудын хувьд либерал сэтгэлгээний хүрээнд “ардчиллын зарчим тэгш эрхийн үзэл санаа алдагдсанаас бус төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдаж, эрх мэдэл хэн нэг хүний гарт шилжиж хэтийдсэнээс завхардаг” (94 хувь), “иргэний эрүүл нийгмийг бүтээн байгуулах чадвар, нөхцөлийг бүрдүүлэх” (91 хувь), “ардчиллын үр дүнтэй үйлчлэх хэм хэмжээ нь соёл, боловсролын хөгжлөөр дамжин бүрддэг” (84 хувь) гэж шинжээчид үзсэн байна. Орчин үеийн ардчиллын онолыг үндэслэгчид Алекс Тукнесс (Tuckness, 2020), Ж.Медисон (Madison, 1787), Ш.Д.Монтескье (Ronald J.Terchek, Thomas C.Conte, 2000), А.Токвиль (Tocqueville, 1958), Ж.С.Милл (Mill, 1974), Жон Роулз (Rawls, 1971) нар төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдаж, эрх мэдэл нэг хүн эсвэл тодорхой бүлэглэлийн гарт шилжих нь дарангуйлал болох үндэслэл болохын зэрэгцээ, ардчилал бол үргэлж боловсронгуй болгож байхыг шаарддаг тасралтгүй өрнөх үйл явц болохыг сануулж байжээ.

Ардчиллын үр дүнтэй үйлчлэх хэм хэмжээ нь соёл, боловсролын хөгжлөөр дамжин бүрдэх боломжтой бөгөөд шударга ёс нь ардчиллын чухал баталгаа, ардчилсан нийгмийн институцийн оршин тогтнох гол хүчин зүйл болж чадна гэдэгтэй шинжээчид бүрэн (81 хувь) санал нийлсэн байна.

## Хүснэгт 7: Ардчиллын онолын либерализм ба республиканизмийн сэтгэлгээний хүрээний илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Хүн бүр амьд явах, өмч хөрөнгө өмчлөх, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх зэрэг хүний үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх боломжийг бүрэн хангадаг өөрсдийн удирдагчдадаа захирагддаг.	43.8	56.2
Ардчиллын зарчим тэгш эрхийн үзэл санаа алдагдсанаас бус, төрийн эрх мэдлийн хуваарилалт алдагдаж, эрх мэдэл хэн нэг хүний гарт шилжиж хэтийдсэнээс завхардаг.	6.3	93.7
Иргэний эрүүлнийг бүтээн байгуулах чадвар, нөхцөлийг бүрдүүлэх нь чухал.	9.3	90.7
Ардчиллын үр дүнтэй үйлчлэх хэм хэмжээ нь соёл, боловсролын хөгжлөөр дамжин бүрддэг.	15.7	84.3
<b>Дундаж хувь</b>	<b>18.7</b>	<b>81.2</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Республиканизм ба коммунитари сэтгэлгээний гол агуулга бол дарангуйлал анархизмаас зайлсхийж, ардчилсан бүгд найрамдах засаг төрийг тогтоох явдал мөн. Өөрөөр хэлбэл, хүн цаг хугацааны явцад өөрөө өөртөө бий болсон эдгээр шинэ хэрэгцээ хязгааргүй уян хатан бөгөөд үнэн хэрэгтээ бүрэн хангагдах боломжгүй байдгийг сэтгэгчид (Rousseau, 1762; Bentham, 2015; Durkheim, 1933) хэлсэн байдаг. Угтаа нийгмийн засаглах эрхийг хэрэгжүүлэх хамгийн чухал бүрэлдэхүүн бол иргэдийн оюун санаа, улмаар ард түмний амьдралын гүнд орж тэдний үйл хэрэгт илүү их анхаарал хандуулж ажиллах (84.5 хувь), мөн ардчилсан иргэний нийгмийн нөхцөл дэх хувь хүний үнэ цэн бол тэгш эрхийн гол хэмжүүр болсон нийтийн эрх ашгийн зарчимд нийцүүлж буй аливаа үйл ажиллагааг зөв зохистой, үнэ цэнтэй ханддаг үүргийг төр засаг нь иргэдийн өмнө хүлээх (72 хувь) чадвартай байхыг шаарддаг. Энэ нь нэг талаас хувь хүнээс үл хамааран орших ёс суртахууны нэгдэл нийгмийн оршин тогтнох үндэс нь эрх чөлөөний цогц орон зай болох үнэт зүйл бүхий дэг жаягаас (62.5 хувь) үүдэлтэй ажээ. Үүнийг нийгмийн бүх гишүүдийн эрхэмлэдэг ерөнхий үнэт зүйлс болгох шаардлага өнөөдөр бидний өмнө тулгарч буйг шинжээчдийн асуулгын үнэлгээ (68 хувь) тодотгож байна.

### Хүснэгт 8: Републиканизм ба коммунитари сэтгэлгээний хүрээний илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Нийгмийн засаглах эрхийг хэрэгжүүлэхэд иргэдийн оюун санаа, ард түмний гүнд орж, тэдний үйл хэрэгт илүү анхаарал хандуулж ажиллах явдал чухал.	15.5	84.5
Төр засаг нь иргэдийн орлогын тэгш хуваарилалтыг хариуцаж, зохистой бодлогоор хүмүүсийн ашиг сонирхол, үзэл бодолд адил тэгш, үнэ цэнтэй ханддаг байх үүрэгтэй.	28.1	71.9
Хүн бүр өөрийн эрх чөлөө, боломжийг урьд өмнө оршин байснаас үл хамааран өөрийн эрх, ашиг сонирхлыг хүндэтгэж, түүнийг хамгаалах чадвараа хэрхэн хэрэгжүүлж буйгаас хамаарна.	46.8	53.2
Хувь хүнээс үл хамааран орших ёс суртахууны нэгдэл нийгмийн оршин тогтнох үндэс нь эрх чөлөөний цогц орон зай болох үнэт зүйл бүхий дэг жаягаас үүдэлтэй.	34.3	62.5
<b>Дундаж хувь</b>	<b>31.2</b>	<b>68.8</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Шинжээчдийн үнэлгээнээс үзвэл, орчин үеийн ардчиллын онолуудад эдийн засгийн холбоо хамаарлын тухай асуудал хөндөгддөг ч, ардчилал нь аль нэгэн эдийн засгийн номлолтой шууд холбоогүй хэдий ч, эдийн засгийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн нэн чухал эд эс, гол баталгаа мөн гэсэн үзэл ихээхэн түгээмэл.

Протектив ардчиллын нэг чухал баталгаа бол иргэдийн улс төрийн соёл, идэвхтэй оролцоо байдаг. Ардчиллын хөгжил тогтвортой байх нь тухайн нийгэмд оролцооны улс төрийн соёлын орчныг бүрдүүлэх явдал юм. Тухайлбал, сонгууль нь ард иргэдэд баталгаатай амьдрал, хөрөнгө мөнгөтэй байх, боловсрол эзэмшихэд давуу эрх, шинэ боломжуудыг олгодог гэж үзэх нь хэт өрөөсгөл, монголын нийгэмд тохиромжгүй (84 хувь) зүйл болохыг шинжээчид үнэлсэн байна. Харин сонгох эрхээ шилжүүлсэн агентынхаа үйл ажиллагааг явцад болон үр дүнг нь хянах эрх иргэдэд олгогдсон байх нь монголын ардчиллын чухал шинж (75 хувь) гэдэгтэй шинжээчид санал нийлсэн байна. Түүнчлэн, иргэний сонголтын (Sen, 2009; Sydney Verba and Almond A.Gabriel, 1963; A.Friedrich, 1979) үнэ цэн ба эрх мэдлийг төлөөлөн хэрэгжүүлэх агентын үйл ажиллагаа, үр дүнг хянах ардчилсан механизмыг бүрдүүлэх боломж бүрдсэн гэж үзэх үндэслэл монголын ардчиллын үнэт зүйлст төдийлөн тусгалаа олоогүй байгаа нь шинжээчдийн үнэлгээний дүн (51 хувь)-ээс харагдаж байна.

### Хүснэгт 9: Ардчиллын талаарх орчин үеийн онолын хүрээ: Протектив ардчиллын үзэл санааны илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Ардчилал нь хувь хүний эрх чөлөө, нийгмийн ертөнцийг хамгаалахын тулд чөлөөт зах зээлийн тогтолцоог бүрдүүлэх суурь үндсийг бүрдүүлдэг.	31.2	68.8
Ард түмний өмнөөс сонгогдсон улс төрчдөөр дамжуулан иргэд шийдвэр гаргахад оролцох нь сонгодог утгаараа хангагдаж чаддаг.	53.2	43.8
Сонгууль ард иргэдэд баталгаатай амьдрал, хөрөнгө мөнгөтэй байх, боловсрол эзэмшихэд давуу эрх, шинэ боломжуудыг олгодог.	84.4	15.7
Сонгож эрхээ шилжүүлсэн агентынхаа үйл ажиллагааг явцад болон үр дүнг нь хянах эрх сонгосон иргэнд боломжтой байх орчин үеийн ардчиллын чухал шинж байдаг.	25.0	75.1
<b>Дундаж хувь</b>	<b>48.4</b>	<b>50.8</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Орчин үеийн нийгэмд хамгийн өргөн дэлгэрсэн ардчиллын хэлбэр бол плюралист ардчилал бөгөөд гол төлөөлөгч болох Роберт А.Даль, Давид Истон, С.М.Липсет, Хуан Линц, Рональд Инглхарт, С.Хантингтон, Давид Хелд (Dahl, 1982; Gunnell, 2013; Lipset, 1960; Linz, 1975; Inglehart, 1988; Huntington, 1997; Held, 2006) нар ардчиллыг хэмжих үнэт зүйлсийн тогтолцоог бий болгосон. Улмаар бидний өмнө тулгамдаж буй аливаа асуудал бидний ухамсарт үйлээс үүдэж, түүнээс шалтгаалан гарч буй хямрал нь соёл иргэншлийг сааруулж буйг тодорхой хэмжигдэхүүнээр дамжуулан судлахыг зорьсон байдаг. Тиймээс иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг эзэмшүүлэн өөриймшүүлэхэд болон хууль боловсруулахад иргэдийн бүтээлч сэтгэлгээтэй, идэвхтэй, шууд оролцох боломжийг хангах (72 хувь), бүх нийтийн сонгуулийн үйл ажиллагаа болон референдумд хараат бусаар оролцоход олон нийт өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлэх бодит боломжийг олгож чаддаг (72 хувь) гэж шинжээчид үнэлсэн байна. Угтаа плюралист ардчиллын үзэл санааны бодит байдал, үнэт зүйл өнөөгийн монголын ардчилалд тодорхой хэмжээгээр бүрэлдэн тогтож (60 хувь) байгааг шинжээчдийн үнэлгээ харууллаа.

### Хүснэгт 10: Ардчиллын талаарх орчин үеийн онолын хүрээ: Плюралист ардчиллын үзэл санааны илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Иргэдэд ардчиллын үнэт зүйлсийг эзэмшүүлж өөриймшүүлэхэд болон хууль боловсруулахад иргэдийн бүтээлч, идэвхтэй шууд оролцох боломжийг хангаж чадсан байх	28.0	72.0
Аливаа зүйлд тохиолдлын болон гэнэтийн байр сууринаас хандах	50.0	37.5
Бүх нийтийн сонгуулийн үйл ажиллагаа болон референдумд хараат бусаар оролцоход олон нийт өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлэх бодит боломжийг олгож чаддаг байх	28.0	72.0
Хүн амын дийлэнх нь өрсөлдөөнт сонгуулиар улс төрийн системийн гол удирдагчдаа сонгож чаддаг нөхцөлд л ардчилал зүй ёсоор оршин тогтноно.	18.7	59.4
<b>Дундаж хувь</b>	<b>31.1</b>	<b>60.2</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Шинэ, хуучин алин ч бай, ардчилал тогтсон улс орнуудын аль алинд нь “ардчиллын хямрал” хэмээх үзэгдэл түгээмэл ажиглагддаг. Үнэн чанартаа энэ бол эрх чөлөө, тэгш эрх нь хүмүүсийн зүгээс улс төрийн удирдагчдаа хянах, хууль дээдлэх ёсыг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд (84 хувь) гүйцэтгэлийн ардчиллын үзэл санааны шинж, хандлага чухлаар тавигдаж буйн илрэл мөн. Шинжээчдийн асуулгаар монголын ардчилалд гүйцэтгэлийн ардчиллын үзэл санаа бүрэн тохирох (72 хувь) боломжтойг харуулсан. Чингэхдээ иргэний нийгэм нь ардчиллыг бэхжүүлэх, шинэчлэл хийх тулгуур болохын хувьд засаглалын институцийн легитим чанарыг бэхжүүлж хамтран ажиллах (78 хувь) чадвар ихээхэн чухал гэдэгтэй шинжээчид санал нийлжээ. Нөгөө талаар иргэн бүр улс төрийн үйл явц, шийдвэр гаргахад оролцох (72 хувь) эрхтэй байх нь өнөөгийн нийгэм-улс төрийн нөхцөл байдал, иргэдийн улс төрийн соёлын бодит хандлагад ихээхэн тохирсон гэж үзэх үндэслэлтэй болохыг харуулж байна.



### Хүснэгт 11: Гүйцэтгэлийн ардчиллын үзэл санааны илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Мэдээллийн нээлттэй эх үүсвэр, чөлөөт урсгалыг өргөтгөснөөр ардчиллын суурь орчин, тэгш боломжийг бүрдүүлдэг.	21.9	56.2
Эрх чөлөө, тэгш эрх нь хүмүүсийн зүгээс улс төрийн удирдагчдаа хяналт тавих, хууль дээдлэх ёсыг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд ардчиллын чанар оршдог.	15.6	84.4
Иргэний нийгэм нь ардчиллыг бэхжүүлэх, шинэчлэл хийх тулгуур болохын хувьд, засаглалын институцийн легитим чанарыг бэхжүүлж хамтран ажиллах нь чухал.	21.9	78.1
Иргэн бүр улс төрийн үйл явц, шийдвэр гаргахад оролцох эрхтэй.	28.1	71.9
<b>Дундаж хувь</b>	<b>21.8</b>	<b>72.6</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

Ардчиллын онолын илэрхийллүүдээс монголд тохирох нэг чухал зүйл бол иргэдийн шууд болон төлөөлөн оролцох оролцооны ардчиллын үндсэн хэлбэрийг хослуулах (91 хувь), засаг төрийн болон олон нийтийн үйл хэрэгт эрх, ашиг сонирхлоо хамгаалан оролцох иргэдийн ухаалаг хэрэгцээг төлөвшүүлэх (87 хувь) шаардлага байгаа гэдгийг шинжээчид хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ жирийн иргэдийг эрх мэдэлжүүлэх замаар тэдний оролцоог бүрэн дүүрэн хангаж чадах идэвхтэй оролцооны боломжийг бүрдүүлэх (65 хувь), улс төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг шууд татан (75 хувь) оролцуулах боломжийг бүрдсэн гэдэгт шинжээчид бүрэн (80 хувь) санал нийлсэн эерэг дүн судалгааны үр дүнгээс харагдаж байна.

## Хүснэгт 12: Оролцоот ардчиллын үзэл санааны илэрхийллүүдэд өгсөн шинжээчдийн үнэлгээ (хувиар)

	Санал огт нийлэхгүй	Санал бүрэн нийлнэ
Улс төрийн бодлого хөтөлбөрийг боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг шууд татан оролцох боломжийг бүрдүүлэх нь чухал.	25.0	75.1
Жирийн иргэдийг эрх мэдэлжүүлэх замаар тэдний оролцоог бүрэн дүүрэн хангаж чадах идэвхтэй оролцооны боломжийг бүрдүүлэх нь чухал.	34.5	65.5
Иргэдийн шууд болон төлөөлөн оролцох оролцооны ардчиллын үндсэн хэлбэрийг хослуулах хэрэгтэй.	9.4	90.6
Төрийн болон олон нийтийн үйл хэрэгт эрх, ашиг сонирхлоо хамгаалан оролцох иргэдийн ухаалаг хэрэгцээг төлөвшүүлэх шаардлагатай.	12.5	87.5
<b>Дундаж хувь</b>	<b>20.3</b>	<b>79.6</b>

Эх сурвалж: О.Хатанболд, 2016.

## Дүгнэлт

Ардчиллын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлс, аливаа ард түмний амьдрал, үйл ажиллагаа, нийгэм-улс төрийн бодит байдалд биежиж хэрэгжсэн төлөв байдлыг тухайн улс үндэстний ардчиллын загвар гэж болзвол байдлаар нэрлэж болно. Энэ нь эгэл жирийн иргэний амьдралын хэвийн үйл ажиллагаанаас эхлээд улс төрийн засаглалын хэлбэр, бүтэц хүртэл өргөн хүрээтэй, нийгэм, улс төрийн үзэгдэл, үйл явцыг хамарна. Иргэдэд ээлтэй сайн, ардчилсан засаглал гэдэг нь иргэдэд тэгш боломж олгох, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй байдал бий болгох талаар нийгэм өөрийгөө зөв зохион байгуулах тухай асуудал юм (НҮБХХ, 2008).

Энэ үүднээс, уг бүлгийн эхний хэсэгт монголын ардчиллын загвар, засаглалын төлөвшлийг үнэлбэл, бие даасан загвар хувилбарын хэмжээнд цэгцэрч, судалгааны ном бүтээлүүдэд тодорхой дүгнэсэн зүйл одоогоор үгүй байна. Харин ийм загвар, хувилбар байх боломжтой гэсэн санаа, дүгнэлт нэлээд байдаг. Мөн олон улсын үнэлгээний арга зүй, аргачлалын хүрээнд ч “Монголын загвар” гэж тусгайлан яригдаж эхлээгүй байна. Бүтээлийн хүрээнд дэвшүүлж буй санаа дүгнэлтүүд энэ хүрээний хэлэлцүүлэгт зориулагдсан гэж үзэж болно (Хатанболд, 2016).

Монголын ардчиллын өнөөгийн төлөв байдлыг ерөнхийд нь, ардчиллын байгууллагдажсан бүтэц хэлбэр, зохион байгуулалтын хувьд бий болсон боловч энэ нь нийгэм ардчилсан болсныг илэрхийлэхгүй,

эдгээр байгууллагын оршин байх арга, явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь ардчилсан болж чадаагүй гэж дүгнэж болохоор байна. Ийм нөхцөлд ардчиллын чанарын шалгуурт үндэслэсэн арга зүйгээр манай ардчилсан хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшинд эерэг үнэлгээ өгөх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, өмнө хийсэн ихэнх судалгааны дүнгээс үзэхэд, дараах зүй тогтол түгээмэл ажиглагдаж байна. Тодруулбал, (i) Ардчилсан үнэт зүйлсэд хандах иргэдийн санаа бодолд эргэлзэж тээнэгэлзсэн, хийсвэрлэж дунджилсан үнэлгээнүүд давамгайлж байна. (ii) Монгол дахь ардчилал зарим талаараа хэврэгшиж байгаа юм биш биз гэсэн болгоомжлол олон нийтийн санаа бодолд төрөх болжээ. (iii) Монгол дахь ардчиллын хөгжил, төлөвшлийн цаашдын хандлага, ирээдүйн дүр зурагт ээдрээ түвэгтэй олон зөрчил, бэрхшээл сорилт тулгарч байгаад иргэд ихээхэн санаа зовних болсон байна. (iv) Ардчиллын хөгжилд нэгэнт бодитой болсон бэрхшээл, сорилтуудыг хэрхэн шийдвэрлэхээс монголын ардчиллын хөгжлийн цаашдын хувь заяа шууд хамаарах эгзэгтэй үед тулж ирсэн байна.

Цаашилбал, бидний судалгааны хоёр дахь хэсэгт, ардчиллын талаарх монголчуудын ойлголт, төсөөллийн өөрчлөлт нь дотоод гадаадын судлаачдын ардчиллын үнэлгээнд шууд нөлөөлж байгаа нь харагдлаа. Монголчууд ардчиллыг “хүний эрх, эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх явдал” гэх мэт ерөнхий үзэл санааг баримжаа болгож байснаа аажмаар “иргэдийн идэвхтэй оролцоонд үндэслэсэн хариуцлага, шударга ёсны төлөө бодит үйл явц” хэмээн ойлгох болсон нь ардчиллыг чанарын талаас нь илүү тодорхой үнэлэх боломжийг олгож байна (Хатанболд, 2016). Олон улсын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлж буй ардчиллын үнэлгээний арга зүйд монголын онцлогийг илэрхийлсэн нэмэлт шалгуур үзүүлэлтийг ашиглахын зэрэгцээ, зарим нэгд тодотгол, нарийвчлал хийх, заримыг хасах зэрэг бололцоо байгаа нь судалгааны явцад батлагдаж байна. Ардчиллын талаарх ойлголт хандлагын өөрчлөлтийг дагалдаж, Монголын өнөөгийн ардчилалд эерэгээсээ сөрөг хандлага нь давамгайлж буйг тодорхой харуулахын зэрэгцээ, гол бэрхшээл сорилтууд нь улс төрийн хүрээний сөрөг үзэгдлүүдтэй холбоотой болохыг баталж байна.

Өнөөгийн ардчилал, засаглалын тодорхой үнэлгээний тухайд Монгол дахь ардчилсан засаглал, ардчиллын төлөв байдлын талаарх сүүлийн жилүүдэд хийсэн томоохон судалгаануудын дүнг бүтээлд баримталж буй онолын матрицын арга зүйн үндсэн зарчмын дагуу харьцуулан шинжлэн, дор дурдсан үндсэн дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Бодит амьдралд буулгаж хэрэгжүүлэх засаглалын институтүүдийн ардчиллын чанарыг харуулах шинж сул, төрийн бодлого, үйл ажиллагаа иргэдийн сэтгэлгээний өөрчлөлтөөс илэрхий хоцрогдох хандлага бий болж байна.
- Парламентын судалгаа, мэдээллийн үйлчилгээний идэвх сул, хууль

тогтоогчдод судалгааны мэдээлэл ашиглах, судалгаанд түшиглэсэн үйл ажиллагаа явуулах хэрэгцээ төлөвшөөгүй, чадвар дадал эзэмшээгүй байдал нь хуулийн чанар, хэрэгжих боломжид сөргөөр нөлөөлж байна.

- Иргэд сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд тогтолцоо, хуулийн хүчин зүйлээс гадна улс төрийн намуудын үйл ажиллагаатай холбоотой бэрхшээл, хүндрэлүүд улам бүр нэмэгдсээр байна.
- Сонгогчдын бүртгэл, сонгуулийн үеийн сонгогчдын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой будилаан, саналын хуудасны зөрчил, санал давхардал, биелэгдэж хэрэгжихгүй амлалт, сонгогчдын санал худалдаж авах оролдлого зэрэг сонгуулийн дүн бодитой гарахад сөргөөр нөлөөлөх байдал нь хавтгайрч, сонгуулийн ардчилалд ноцтой бэрхшээл учирч байна.
- Олон намын тогтолцооны төлөвшил удааширч, ухралт гарсан гэхээр байдал бий боллоо. Намуудын улс төрийн институтийн хувьд шинэчлэгдэн төлөвших үйл явц удааширч, зогсонги байдалд орсноор тэдэнд итгэх иргэдийн итгэл ихээхэн багаслаа.
- Иргэдийн улс төрийн боловсрол, соёлын түвшин доогуур, ардчиллын үнэт зүйлс идеал буюу чин эрмэлзлийн хэмжээнд хэт ерөнхий байгаа учраас ардчилсан институт, ардчиллын механизмууд амьд, бүтээлчээр үйлчилж чадахгүй байна.
- Иргэдийн улс төрийн боловсрол, ардчиллын талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн тулд засаг төрөөс дорвитой, цэгцтэй бодлого, үйл ажиллагаа явуулахгүй байгаагаас ардчиллын хамгийн гол баталгаа сайн бүрдэхгүй байна. Төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх талаар тодорхой алхам хийж, энэ талаарх хуулийг дорвитой шинэчилсэн боловч үйлчлэл нь удаан, Төрийн албаны зөвлөлийн шинэчлэл хийгдэхгүй, үйл ажиллагаа нь идэвхгүй байгаагаас төрийн албаны чадавх сул, үйл ажиллагаа нь зүгшрэхгүй байна.
- Иргэний нийгмийн байгууллагууд ардчиллын хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч төлөвшил хөгжлийнхөө эхний шатнаас тэр бүр гарч чадаагүй, хууль эрх зүйн бодит зохицуулалт бүхий дүн шинжилгээ үгүйлэгдэж байна.

## Ном зүй

Beetham, David, Iain Kearton, Nalini Vittal, Sarah Bracking, and Stuart Weir. 2002. *The State of Democracy: Democracy Assessments in Eight Nations Around the World*. The Hague, Netherlands: The Kluwer Law International. URL: <https://brill.com/view/title/10951>.

Bowring, John. 1838. *The Works of Jeremy Bentham*. (J. Bowring, Ed.) Edinburgh: William Tait, reprinted New York, 1962.

- Buechi, Rolf. *Direct Democracy What It Means How It Works*. URL: [https://www.academia.edu/40167707/Direct\\_Democracy\\_What\\_It\\_Means\\_How\\_It\\_Works](https://www.academia.edu/40167707/Direct_Democracy_What_It_Means_How_It_Works).
- Dahl, Robert A. 1982. *Dilemmas of Pluralist Democracy*. New Haven: Yale University Press.
- Department of State. 2005. *Human Rights Report: Mongolia*. URL: <http://www.state.gov/j/drl/rls/hrrpt/2005/62653.htm>.
- Diamond, Larry. 1996. "Is the third wave over?." *Journal of Democracy*, 7(3): 20–37.
- Durkheim, Emile. 1933. *The Division of Labor in Society*. New York: Macmillan Publishing.
- Ginsburg, Thomas. 2005. *Strengthening Legislation Research and Analysis Capacity*. Ulaanbaatar: USAID.
- Gunnell, John G. 2013. "The Reconstitution of Political Theory: David Easton Behavioralism, and the Long Road to System." *Journal of the History of the Behavioral Sciences*, 49(2): 190–210.
- Hayek, Friedrich A. 1979. *The Political Order of a Free People*. Chicago: University of Chicago Press.
- Held, David. 2006. *Models of Democracy*. Stanford: Stanford University Press.
- Huntington, Samuel. 1997. "After twenty years: The Future of the Third Wave." *Journal of Democracy*, 8(4): 3–12.
- Inglehart, Ronald. 1988. "The Renaissance of Political Culture." *American Political Science Review*, 82(4): 1203–1230.
- Lieber, Hans-Joachim. 1993. *Politische Theorien von der Antike bis zur Gegenwart*. Bonn: Bundeszentrale fuer politische Bildung.
- Linz, Juan J. 1975. *Totalitarian and Authoritarian Regimes*. Boulder: Addison-Wesley.
- Lipset, Martin. 1960. *Political Man: The Social Bases of Politics*. Garden City, New York: Doubleday & Company.
- Madison, James. 1787. *Federalist No. 10*. URL: [https://liberalarts.utexas.edu/coretexts/\\_files/resources/texts/c/1787%20Federalist%20No%2010.pdf](https://liberalarts.utexas.edu/coretexts/_files/resources/texts/c/1787%20Federalist%20No%2010.pdf).
- Mill, John Stuart. 1974. *On Liberty*. London: Penguin Books.
- Rawls, John. 1971. *A Theory of Justice*. Cambridge, MA: Harvard University Press.
- Rousseau, Jean-Jacques. 1762. *Du contrat social ou principes du droit politique*. Amsterdam: Marc Michel Rey.
- Sabloff, Paula L. 2013. *Does Everyone Want Democracy? Insights from Mongolia*. New York: Routledge.

- Sen, Amartya. 2009. *The Idea of Justice*. Cambridge, Massachusetts: The Belknap Press of Harvard University Press.
- Terchek, Ronald and Thomas C. Conte. 2000. *Theories of Democracy: A Reader*. Lanham, MD: Rowman and Littlefield.
- Tocqueville, Alexis. 1958. *Democracy in America*. Chicago: University of Chicago Press.
- Tuckness, Alex. 2020. "Locke's Political Philosophy." In Edward N. Zalta (ed.) *The Stanford Encyclopedia of Philosophy* (Winter 2020 Edition). Stanford: Metaphysics Research Lab, Stanford University. URL: <https://plato.stanford.edu/archives/win2020/entries/lockepolitical/>.
- UNDP. 2011. *Democratic Governance Reader. A Reference for UNDP Practitioners*. New York: Oslo Governance Centre.
- Ганбат Д. 2006. *Азийн барометрын судалгаа–2006. Ардчилал ба Монголчуудын үнэлэмж*. Улаанбаатар: УТБА.
- Занданшатар Г. 2016. *Авлигыг өршөөхгүй, ардчиллыг өмөөрөхүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Засаглалын судалгааны баг, ШУА. 2006, 2008, 2010, 2013, 2014. *Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт*. Улаанбаатар: ФСЭХ, ТБШХ.
- Томмасоли, М. 2008. Төлөөллийн ардчилал ба хариуцлагатай улс төр бий болгох чадавхийг хөгжүүлэх нь. ЕЭХАХАБ. *Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг засгийн газар*. Улаанбаатар: Орч Даваадулам Ц. Сансудай ХХК, НҮБХХ. ФСЭХ.
- ШУА. ФСЭХ. 2017. *Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- УТШУХ. 2008. *Үндэсний өвөрмөц соёлын орчин дахь ардчиллын зарчмын үйлчлэл*. Улаанбаатар: ЭШ-ний грант-төслийн тайлан.
- ҮСХ. 2012, 2013, 2014. *Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа: Ардчилсан засаглал модуль*. Улаанбаатар: Үндэсний статистикийн хороо.
- ФСЭХ ба НҮБХХ. 2006, 2008, 2010, 2013. *Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт*. Улаанбаатар: ФСЭХ. ШУА.
- Хатанболд Ойдов. 2016. Монголын ардчиллын үнэлгээ. Шинжээчдийн үнэлгээний дүнгээс. Улаанбаатар: Тод бичиг ХХК.
- ХЗДХЯ. ХЗҮТ. 2007. 1992 оны *Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн оршил хэсэг*. Улаанбаатар: ХЗҮХ-ийн хэвлэх цех.

## Монголын ардчиллын өдөр тутмын дүр зураг: Улаанбаатар хотын гэр хороололд амьдрах хугацаандаа ардчиллын явцыг антропологийн үүднээс судалсан нь

Элизабет Фокс

Өнгөрсөн хорин таван жилийн хугацаанд монголчуудын аж амьдрал хурдацтай өөрчлөгджээ. Үүний нэг нь нийслэл хот Улаанбаатар, ялангуяа барилга байгууламж сүндэрлэсэн хотын төвийг тойрон орших “гэр хороолол” руу чиглэсэн хүмүүсийн шилжилт хөдөлгөөн байв. Энэхүү судалгааны бүлэгт “зах зээлийн” үе дэх гэр хорооллыг антропологийн үүднээс буюу гэр хорооллын оршин суугчдын дуу хоолой, амьдралын туршлагад нь тулгуурлан зураглан харуулах ерөнхий зорилгыг дэвшүүллээ. Ингэхдээ монголын орчин үеийн ардчиллын гурван асуудлыг авч үзсэн болно. Нэгдүгээрт, гэр хороолол дахь ардчиллын үйл явцын эрүүл, төлөв байдлыг авч үзсэн. Энэ хүрээнд сонгуулийн санал худалдан авахыг санаархсан улс төрийн намуудын оролдлыг тайлбарлаж, эдгээр нь хэрхэн явагдаж, оршин суугчид үүнд хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгаа талаар судлав. Хоёрдугаарт, гэр хороолол дахь ардчилал хийгээд нийгмийн нийцэл (эсвэл нийцэлгүй байдал) хоорондын холбоог тандан судалаа. Эцэст нь гэр хорооллын оршин суугчид ардчилсан Монгол Улсын иргэнийхээ хувьд хэрхэн өөрсдийнхөө байр суурийг ойлгож байгаа талаар авч үзлээ. Энэхүү судалгааны бүлэгт гэр хороолол, тэнд оршин суугчдыг хохирогч эсвэл буруутан мэтээр хэт хялбарчлан дүрслэх бус, харин Монгол Улсад тулгамдаад буй сорилт бэрхшээлийг тэд өдөр тутамдаа хэрхэн даван туулж буйд анхаарал хандуулж, тэднийг илүүтэйгээр сонсож судалсан шинэ ойлголтыг оруулсан болно. Хэрвээ, эдгээр сорилт бэрхшээлийн нэгийг орон нутгаас суурин газарт шилжин ирэгсэд нэмэгдэж буйтай холбоотой нийгэм эдийн засгийн ялгарал гэж үзвэл, гэр хорооллын оршин суугчдаар дамжуулан энэхүү ялгарал нь яагаад, ямар хэлбэрээр бий болж байгааг тодруулах нь чухал гэдгийг уг бүлэгт онцолсон болно.

### Оршил

Ардчилал, зах зээлийн капитализмд шилжсэнээс хойш монголчуудын аж амьдрал өнгөрсөн хорин таван жилийн хугацаанд хурдацтай өөрчлөгдсөн байна. Сүүлийн жилүүдэд гарсан гол өөрчлөлт бол нийслэл хот Улаанбаатар луу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн ихээр нэмэгдсэн явдал байлаа (IOM, 2018).<sup>1</sup> Монголын хүн амын бараг тал хувь

1 Монгол дахь Олон улсын Шилжих хөдөлгөөний байгууллагын мэдээлснээр Улаанбаатар хот 2000 оноос хойш жилд 21,000 хүний шилжих хөдөлгөөний үрсгалтай байсан (IOM, 2018, 1). Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хүрээлэн (ТЧНОСХ)-гийн мэдээлснээр “Монгол Улсын хүн амын хагас гаруй хувь нь Монголын 0.3 хувийн нутаг дэвсгэр болох Улаанбаатар хотод амьдарч байна” (ТЧНОСХ, 2014, 5). Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) цахим хуудсанд 2017 он гэхэд 1,46 сая хүн ам (нийт улсын хүн амын 46%) Улаанбаатар хотод оршин сууж байна (<http://www.nso.mn/> accessed November 30, 2018). ҮСХ-ны 2018 оны мэдээллийн самбараас харна уу.

нь Улаанбаатарт амьдардаг бөгөөд тэдний ихэнх хэсэг буюу 83 хувь нь хотын төвийг тойрон хүрээлэх “гэр хороолол”-д амьдардаг (Дэлхийн Банк, 2015, 1).<sup>2</sup> Гэр хороолол нь голдуу доод тал нь нэг монгол гэр юм уу тусдаа байшингаас бүрдсэн, хашаалсан газартай, архитектурын хувьд онцгой хэлбэр дүрстэй байдаг. Ихэнх гэр хорооллын айл гэрэл цахилгаантай боловч төвлөрсөн ус, халаалт, бохирын шугам зэрэг хотын бусад дэд бүтэцтэй холбогдоогүй. Харин тэндэхийн зам нь хатуу хучилтгүй, оршин суугчид нь ойролцоох худгаас мөнгө төлж ус авдаг, хоол ундаа бэлтгэх, гэрээ халаахад зориулан мод, нүүрс түлдэг бөгөөд гаднаа ил задгай жорлонтой.

Гэр хорооллын дэд бүтэц (эсвэл дэд бүтэцгүй байх нь) оршин суугчдын эрүүл мэнд, боловсрол, боломж бололцоонд хэрхэн нөлөөлж буй талаар судлаачид хэд хэдэн өнцгөөс харж бичсэн байдаг (Алтантуяа нар., 2012; Баасандорж ба Алтанзагас, 2007; Батхуяг нар., 2016; Hasenkopf, 2012; Janes et al., 2006; UNICEF, 2016). Мөн нэлээд хэдэн судалгаанд Монголын хотжилт, шилжилт хөдөлгөөний татах-түлхэх хүчин зүйлийн загварчлалыг голчлон бичжээ. (Батбаатар нар., 2006; IOM, 2018). Арга зүйн хувьд санал асуулга, бүтэцжсэн ярилцлагын үр дүнд найдах хандлагатай байдаг өнөөгийн судалгааны ажлаас эрс ялгаатай уг шинжилгээ нь Улаанбаатар хотын гэр хорооллын амьдралыг өөр өнцгөөс харуулахыг хичээсэн болно.

Нийгмийн антропологичийн хувьд миний баримталсан арга зүй бол судалгаанд оролцогчдыг ажиглах явдал байсан. Энэ нь урт хугацааны судалгаа бөгөөд “судалж буй хүмүүсийнхээ нийтлэг болон ердийн бус үйл ажиллагаануудыг ажиглаж юм уу оролцох замаар угсаатны зүй судлаачид энгийн орчинд мэдээллийг цуглуулах арга юм” (DeWalt ба DeWalt, 2002, 2).

Улаанбаатарын гэр хороололд, талбарт нь 20 гаруй сарын хугацаанд идэвхтэй судалгаа хийж, тэндэхийн айлд амьдарч, Монголын хотжилтын бодит байдлыг биеэр туршин үзсэн хүний хувьд би, голдуу хөндлөнгөөс дүгнэсэн судалгааг бодвол гэр хороолол дахь өдөр тутмын амьдралыг угсаатны зүйн талаас нь танилцуулах болно.<sup>3</sup> Ийнхүү уг бүлэгт Монголын

---

2 2015 онд Дэлхийн Банкнаас Улаанбаатар хотын иргэдийн 60 хувь нь гэр хороололд амьдардаг гэж мэдээлсэн (IEG, 2015, 67). 2000-2010 оны хооронд гэр хорооллын хэмжээ 73 км<sup>2</sup>-аар буюу 39 хувиар нэмэгдсэн (Дэлхийн Банк, 2015, 5) ба гэр хороололд амьдарч буй өрхийн тоо 149 хувиар өссөн байна. “Энэ нь Улаанбаатар хотод шинээр шилжин ирж буй өрхийн 68 хувийг эзэлж байна” (Дэлхийн банк, 2015, 2; мөн АНУ, 2014-ийг үзнэ үү).

3 Антропологийн стандарт ба практикийн дагуу уг судалгаанд оролцогчдын хувь хүний болон нэрийн нүүцлалыг хангаж, оролцогчдын нэрийг өөрчилсний зэрэгцээ, мэдээлэл цуглуулсан гэр хорооллын дүүргийн нэрийг дурдаагүй болно.



хотын захын хороололд өрнөж буй ардчиллын талаарх амьдралын туршлагаас танилцуулах болно.

Юуны түрүүнд, Улаанбаатарын гэр хороолол нь монголын ардчиллын өнөөгийн байдлыг судлах баялаг талбар болохыг тайлбарлана. Учир нь, миний үзэж байгаагаар гэр хороолол нь одоо байгаа дүр төрхийн хувьд зөвхөн ардчиллын цаг үед үүссэний хувьд монголын ардчиллын чухал илэрхийлэл юм. Тодруулбал, гэр хорооллыг бүрдүүлж буй “хашаа ба гэр (байшин)” гэх архитектурын хэлбэр нь урт хугацааны түүхтэй бөгөөд үүнийг бүхий л аймаг, сум (дүүрэг)-ын төвөөс харж болно. Энэ нь Улаанбаатар хот үүсэхээс өмнө Монгол Улсын нийслэл байсан Өргөө хотын анхны дүр төрх болж байжээ (Campi, 2006; Rupen, 1957). Иймд социализмаас өмнө, хот нь гэр хороололоос бүрдэж байсан. Өөрөөр хэлбэл гэр хороолол гэсэн нэршилгүйгээр, хэлбэрийн хувьд оршин тогтнож байжээ. Социализмын үед, орчин үеийн Улаанбаатар хотыг төлөвлөн бүтээн байгуулахтай зэрэгцээд орон сууцны барилга, архитектурын бусад загвар бүхий барилга байгууламжууд өмнө нь бүтээн байгуулсан орчныг орлох болсноор, гэр хороолол улам ихээр хотын зах руу шахагдах болсон байна (Duurenbayar, 2016, 35). Эсгий гэр давамгайлж үлдсэн энэ хэсэг газар нь түр зуурын бөгөөд орчин үеийн хотын үзэл баримтлалд нийцсэн бүтэц тогтолцоонд аажмаар шилжих учиртай юм хэмээн үздэг байжээ (Sneath, 2006). Түүнчлэн, газрын өмчлөл болон дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх төрийн хязгаарлалтууд нь хотын хүн амын өсөлтийг хатуу зохицуулж байжээ. Үнэхээр зөвхөн ардчилал үүсэн хөгжиж эхэлсэн үеэс л шилжилт хөдөлгөөн болон эрх зүйн зохицуулалтын нөхцөлүүд нь гэр хорооллыг өөрийн гэсэн онцлогтой, бусдад хүлээн зөвшөөрөгдсөн, түр зуурын бус хотын нэг хэсэг болон оршин тогтноход хүргэсэн байна. Энэхүү шилжилтийн гол зангилаа түлхүүр нь хувьсгалын дараа батлагдсан үндсэн хуулийн хоёр суурь болох иргэдийн чөлөөтэй зорчих эрх болон газрыг хувийн хэрэгцээнд ашиглах эрх байлаа. Хожим нь Монголын иргэн бүр 700м<sup>2</sup> хүртэлх газартай болох эрх олгосон хууль батлагдан хэрэгжүүлсэн нь гэр хороолол өсөн нэмэгдсэн өнөөгийн чиг хандлагыг улам эрчимжүүлжээ.

Монгол дахь ардчиллын өнөөгийн туршлагын талаар судалгаа хийхэд гэр хороолол нь онцгой үнэ цэнтэй хэсэг болох ба энэхүү судалгааны бүлэгт тэндэхийн оршин суугчид ардчиллыг хэрхэн үнэлж, энэ талаар ямар туршлага хуримтлуулсан болохыг судлахдаа дараах гурван асуудлыг авч үзнэ. Үүнд: нэгдүгээрт, микро түвшинд гэр хороололд ардчиллын эрүүл тогтолцоо бий эсэхийг ажигласан. Улс төрийн намуудын санал худалдаж авах оролдлогыг газар дээр нь ажигласнаар, тэнд санал худалдан авах үйл ажиллагаа хэрхэн өрнөж байгаа, тэдгээрт оршин суугчид хэрхэн хандаж хариу үйлдэл үзүүлж байгаа талаар өгүүлнэ. Ингэхдээ хууль бусаар бэлэг тараах нь ардчиллын үнэт зүйлст илт аюул занал учруулдаг хэдий ч, оршин суугчид өөрсдийнх нь чөлөөтэй саналаа өгөх эрхийг үгүй хийх гэж буй улс төрчдийн оролдлогыг эсэргүүцэн, ардчиллын зарчмуудад үнэнч

хэвээр гэдгээ нотлон харуулж байгааг авч үзнэ. Онолын дунд түвшинд, гэр хороолол дахь ардчилал болон нийгмийн нийцэл (social cohesion) хоорондын холбоосыг тандан судалсан. Ардчилсан хувьсгалын үед нэвтрүүлсэн газар хувьчлал, өмчлөлийн хууль мөн ардчилсан цаг үеийг тодорхойлох чөлөөт шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн хүмүүс томоохон хотыг буй болгон зэрэгцэн амьдрах атлаа, тэдний нийгмийн гол харилцаа нь өнөөг хүртэл хувь хүмүүс ба нутгийн хэлхээ холбоонд тулгуурласан хэвээр байгаа талаар судлах болно. Ингэснээр энэхүү нийгмийн бодит байдал нь монголын ардчиллын одоо, ирээдүйд хэрхэн нөлөөлөх талаар авч үзнэ. Уг бүлгийн гуравдугаар хэсэгт илүү өргөн хүрээний асуудлыг хөндөх бөгөөд гэр хорооллын оршин суугчид ардчилсан Монгол Улсын иргэний хувьд өөрсдийнхөө байр суурийг хэрхэн дүгнэж үзэж буй талаар судална. Энэ сэдвээр судлагдсан бүтээлүүдийг ерөнхийд нь хоёр үндсэн төрөлд хуваадаг. Үүнд: нэг хэсэг нь гэр хорооллын оршин суугчдыг байгалийн гамшиг болон улс төр, эдийн засгийн хямралын улмаас хот суурин газар луу татагдах болсон идэвхгүй хохирогч гэж тайлбарладаг. Хоёр дахь нийтлэг тайлбар нь оршин суугчдыг нүүрс түлж агаар бохирдуулагч, гүний усны нөөцийг бохирдуулагч, орон сууцанд шилжин нүүхийг эсэргүүцэгч буруутнууд, мөн тэдний боловсрол муутай, ажилгүйдэл их байдал нь Монголын хөгжлийг хойш татаж буй гол асуудал хэмээн томъёолсон байдаг. Улмаар гэр хороолол, тэнд оршин суугчид бол энгийн утгаараа ямар нэгэн хохирогч бус, буруутан бус гэсэн шинэ санааг илэрхийлж буй бодит амьдрал дээр хийсэн судалгааны үр дүнг харуулсан болно. Судлаачийн хувьд Монголд тулгамдаад буй сорилт бэрхшээлийг гэр хорооллын оршин суугчид өдөр тутамдаа хэрхэн даван туулж, нөхцөл байдалд зохицон амьдарч буйд анхаарал хандуулж, тэднийг илүү сонсох замаар маш их зүйлийг ойлгож судлах боломжтой гэж үзэж байна. Энэ нь нийгмийн тодорхойгүй байдал болон төр засагтаа итгэл алдарсан үе дэх ардчиллын бодит дүр зураг юм.

## **Гэр хороолол дахь ардчиллын үйл явц**

Монголд судалгаагаа 2012 онд эхлүүлснээс хойш би УИХ-ын хоёр, ерөнхийлөгчийн хоёр удаагийн сонгуулийн үеэр тус улсад байлаа. 2008 онд болсон хууль тогтоогчдыг сонгох сонгуулийн дараа хүчирхийлэл үүссэнийг ч бид мэднэ. Энэ үеэр таван иргэн амь үрэгдэж, хэдэн зуун хүн гэмтэж бэртсэн. Азаар, хотод судалгаа хийж байх үед буюу 2012 оноос хойших гурван удаагийн сонгууль ямар нэг хүчирхийлэлгүй болж өнгөрсөн юм. Сонгогчдын оролцооны хувьд, хотын сонгогчид голдуу идэвхтэй оролцдог; тэд нэр дэвшигчид болон зурагтаар гарч буй кампанит ажлуудыг цаг алдалгүй үзэж саналаа өгөх ардчилсан эрхээ баталгаажуулан, санал хураах байранд идэвхтэй ирцгээдэг. Газар зүйн

хувьд өргөн уудам нутагтай, хүн ам нь тархай бутархай суурьшсан байдаг ч, өнгөрсөн дөрвөн удаагийн сонгуулиар санал өгөх эрхтэй нийт иргэдийн бараг 70 орчим хувь нь сонгуульд оролцсон байдгийг статистикийн мэдээллээс харж болно (IFES, 2019). Гаднаас нь өнгөц харвал бүх зүйл хэвийн мэт. Төр барих эрхийг сонгуульд оролцсон иргэдийн өгсөн саналын дагуу тайван журмаар шилжүүлнэ. Гэвч өнгөн хэсгийг бага зэрэг сөхөөд харвал, бодит байдалд өөр дүр зураг буух болно.

Одоо Улаанбаатар хотын гэр хороололд<sup>4</sup> өрнөж буй ардчиллын үйл явцын талаар ярихын тулд 2017 онд болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үед болсон бодит явдлын талаар мэдээлэл хуваалцъя. Энэ сонгуульд улс орон, тус хот “бүхэлдээ” хэрхэн оролцсон талаар авч үзсэн товч дүгнэлт хийхээс илүү, гэр хорооллын оршин суугчдын хувьд нэг хүүрнэл ярианы сэдвийн хүрээнд өрнөж буй хэд хэдэн арга туршлагыг угсаатны зүйн хувьд хооронд нь холбож сүвэгчлэх замаар нягт харуулахыг хичээлээ. Гэр хороололд сонгууль хэрхэн өрнөж буй талаар уялдаа холбоо бүхий бүрэн зураглалыг харуулахын тулд судалгаанд оролцсон хүмүүсийн нэрийг нууцалсан болно.<sup>5</sup>

Сонгууль хүртэлх замнал урт, урам хугалам байсан ба гэр хорооллынхны үзэж байгаагаар, энэ сонгууль нь ардчиллын 26 жилийн турш тус улсад болж буй хамгийн бохир сонгууль ажээ. Эхнээсээ л монголчуудын хэлдгээр өрсөлдөгчдийнхөө нэр хүндийг хорлонтой, гутамшигтайгаар гутаасан мэдэгдлүүд буюу “хар PR” хөвөрч эхэлжээ. Ерөнхийлөгчид өрсөлдөж буй гурван нэр дэвшигч тус бүр бие биеэ ямар нэгэн ичгүүртэй явдалд холбогдсон мэтээр харагдуулж байлаа. Үнэндээ, нэр дэвшигчдийн нэрийг зарлах үед олон хүн нэг нь нөгөөгөөсөө ялгаагүй муу, иймд хэнийг нь ч сонгох аргагүй тул ямар ч “сонголтгүй сонгууль” болно гэгцгээж байлаа.

Ардчиллын 26 жилийн түүхийг туулсан хүмүүсийн хувьд өнгөрсөн хугацаанд тэгш бус байдал, эдийн засгийн хямрал хэрхэн өсөн нэмэгдэж ирсэн, байгалийн баялгийн үр ашгийг нууцаар хурааж хуримтлуулсан улс төрчид гарч суучаад сайхан үг хэлж, элдэв амлалт өгөх нь утгагүй хэрэг гэж үзэж байлаа. Хүмүүс байн байн “тэд бүгд л адилхан” гэгцгээж, “тэд юм юм хэлж л байдаг, тэгээд сонгогдсоныхоо дараа юу ч хийдэггүй, харин мөнгө идэж эхэлдэг” гэж байв.

---

4 2017 оны ерөнхийлөгчийн сонгуульд Монгол Улсын улс төрийн гурван үндсэн намаас нэр дэвшигчид өрсөлдсөн: Монгол Ардын Нам (МАН) [нэр дэвшигч: М.Энхболд], Ардчилсан Нам (АН) [нэр дэвшигч: Х.Баттулга] ба Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН) [нэр дэвшигч: С.Ганбаатар]. 2016-2017 оны Монголын парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийн тойргийн тодорхой тоймыг Радченко ба Жаргалсайхан 2017-с уншина уу.

5 Энэ бүлэгт сонгуулийн “бодитой” буюу “тэнцвэртэй” улс төрийн дүн шинжилгээ хийхийг эрэлхийлээгүй бөгөөд хувийн улс төрийн үзэл бодлыг агуулаагүй болохыг ойлгоно уу. Гол нь ярилцагчдын санал бодлыг танилцуулах зорилготой юм.

Өнгөрсөн жилийн парламентын сонгуулийн үеэр нэр дэвшигчид бэлэн мөнгө тараасан гэх цуу яриа гарсан ч улс төрчид сонгогчдыг татахын тулд шинэ зам барих эсвэл Таван Толгойн уурхайн<sup>6</sup> хувьцааг тараах гэх мэт харьцангуй “цэвэрхэн” арга мөн хэрэглэсэн байна. Харин энэ жил бэлэн мөнгө баруун солгойгүй урсаж байлаа. Утасны дуудлага ар өвөргүй хангинаж, хөршүүдийн маань хажууд хэдэн зуун машин ирж байгаа мэт санагдаж байлаа. Гэнэт “Машин энд байна!” гэх дуу хадна. Тухайн хүмүүсийн иргэний үнэмлэхийг яаран сандран шалгаж, машинаар ирсэн хүмүүстэй уулзахаар гэрээс нэг удаад дөрөв таван хүн цуван гарч байлаа. [Машины] хаалга хаагдсаны дараа хүн бүрт 20,000 төгрөгийн дэвсгэрт (8.50 ам.доллар) өгч байсан бөгөөд нэр дэвшигчийн төлөө саналаа өгөөрэй гэж байжээ. Цагдаа нарт илчлэгдэхээс зайлсхийж, сонгуулийн санал хураах байр болж ажиллаж байсан, дүүргийн сургуулиас холгүй өнөөх зорчигчдоо буулгаж байлаа. 20 хоногийн ажлын хөлсөнд 300,000 төгрөг (127.50 ам.доллар) авч байсан намын албаныхан, цагийн ажилчид сонгогчдоос цуглуулсан “сонгуулийн хуудас”-уудын (санал өгсөн баримт) тоогоор мөн төлбөр хүлээн авах болно. Зарим газар, намууд 30 хуудагт 100,000 төгрөг (42.50 ам.доллар), заримд нь бүр таван хуудагт 100,000 төгрөг өгөх санал тавьж байжээ. Ийнхүү сонгуулийн хуудасны бизнес хурдан газар авлаа: Хүмүүс тэднийг бараагаар арилжин, нэг нь нөгөөдөө борлуулж, бие биеэрээ дамжуулан хүргүүлэх зэргээр үргэлжилсэн байна. Асуудал газар дээр нь тодорхой болж эхлэх үед хүмүүс нүүр хуудаснаасаа салахгүй (Facebook) шинэ мэдээ үзнэ. Баруун аймгууд руу 120 сая төгрөг (51,000 ам.доллар) ачсан машин сонгогчдод мөнгө тараахаар явж байна гэсэн яриа гарав. Ялахын тулд намууд юу ч хийхээс буцахгүй нь илт тодорхой байв.

Намын энэ мэт үйл ажиллагааг гэр хорооллынхон овжин ашиглаж байлаа. Жишээлбэл, хөдөө орон нутагт амьдардаг ч, хотод хамаатныдаа айлчилж буй иргэдийн хувьд, тэд саналаа хаана ч өгч болно гэж сонсжээ. Улаанбаатар хотод саналаа өгч болно гэдэгт итгэсэн тэд сонгуулиас урьтаж орон нутаг руугаа буцаагүй байна. Өнөөх мөнгө тарааж буй машинд орж, саналаа тухайн нэр дэвшигчид өгөхөөр амласныхаа төлөө 20,000 төгрөг авахаас цааргалсангүй. Санал өгөх эрхийн [хуулиар заасан] 18 нас хүрээгүй хэд хэдэн оршин суугч бас бэлэн мөнгө цуглуулж амжсан байна.

Санал хураалт дуусаж сонгуулийн тойргийн ойролцоох автобусны буудал хүнгүй болж эхлэв. Хүмүүс [сонгуулийн] урьдчилсан үр дүнг зарлах 10 цагийн мэдээг сонсохоор гэртээ харьжээ. Монгол Ардын намын (МАН)

---

6 Монгол Улсын 2016 оны парламентын сонгуульд нэр дэвших эрхийн талаарх мэдээллийг Бонилла ба Шагдар (2018)-с харна уу.

нэр дэвшигч Энхболдын оноо тааруу гарсан нь тодорхой болоход хүмүүс ихээр баярлаж байлаа. Ардчилсан намын (АН) нэр дэвшигч Баттулга [сонгуулийн] сунгааг хошуучилж байх явцад, олон хүн Монгол Ардын хувьсгалт намын (МАХН) нэр дэвшигч Ганбаатарыг илүүд үзэж байгаа нь харагдаж байсан ба тэдний аль нь ч саналын доод босго 50 хувьд хүрэхээргүй байсан тул хоёр дахь шатны сонгууль явуулах шаардлагатай болж магадгүй байлаа. Тэрхүү нөхцөл байдал маш сонирхолтой байв, учир нь хоёр дахь шатны сунгаанд хөтөлгөө морьтой Ганбаатар ялах болно гэдэгт хүмүүс маш итгэлтэй байлаа. Шөнө болох үед [сонгуулийн] дүнгүүд цувран гарч эхэлсэн ба ойролцоогоор [шөнийн] хоёр цаг хүртэл хүмүүс зурагтаасаа салахгүй үзсээр байлаа. Энэ цаг мөчид ерөнхий дүр зураг ойлгомжтой болсон мэт санагдаж, улмаар гэр бүлийн олон гишүүн гэр гэртээ амарч эхлэв.

Энхболд, Ганбаатарыг ямар нэг байдлаар ялсан гэх цочирдом мэдээлэл сонсогдов. Гэр хорооллынхны хувьд үүнийг луйвар гэж үзэж байлаа. Хүмүүс Ганбаатарыг мэхлэгдсэн хэмээж: тэд түүнийг бусад хоёр нэр дэвшигчид шиг баруун солгойгүй цацан тараах хэмжээний бэлэн мөнгөгүй, хөрөнгө босгох боломжгүй байсан учраас цэвэр өрсөлдсөн хэмээн мэтгэлцэж байлаа. Ийм шалтгаантай байсан ч тэр ялагдсан. Үүний дараа төөрөгдөл, үл ойлголцол дүүрэн хэдэн өдрийг араасаа дагуулав. Хоёр дахь шатны сонгуулийг хэрхэн зохион байгуулах талаар маргаан мэтгэлцээн өрнөсөн боловч эцэст нь Ганбаатарыг сунгаанаас хассан болох нь тодорхой болжээ. Хоёр дахь шатны сонгуульд өрсөлдөгчид аль нь ч нэр цэвэр биш байв.

Эхний болон хоёр дахь шатны сонгуулийн хоорондох өдрүүдэд өөдрөг хэвээр байсан хүмүүс бол хоёр дахь шатны сонгуулиар илүү их бэлэн мөнгө тараахыг хүлээгчэд байв. Оршин суугчид хөдөө орон нутгаас ирсэн хамаатан саднаасаа өмнөх сонгуулиар нэг саналд 50,000 төгрөг (21.25 ам.доллар) тарааж байсан тухай сонсоод, дахин мөнгөн шагнал ирэх нь хэмээн баярлаж суулаа. Ялалтаа баталгаажуулахын төлөө томоохон нэр дэвшигчдийн ашигладаг бохир аргуудын талаарх цуу яриа үргэлжилсээр байв. Тэдний таамагласнаар, аль нэг нэр дэвшигчийн намын ажилтнууд хүмүүсийн иргэний үнэмлэхийн дугаарыг цуглуулж, дараа нь тэр саналууд нэр дэвшигчийнх нь төлөө орсон байх нөхцөлийг хангахын тулд санал хураах цахим машинуудыг “хакердсан” байж таарах нь. Үнэндээ сонгууль болохоос хоёр өдрийн өмнө тухайн гэр бүлийн нэг хамаатан, тэднийг иргэний үнэмлэхийн дугаараа бичихийг хүсэж, 20,000 төгрөг өгөхөө амлаж байв.

Сонгуулийн өглөө ямар нэгэн арга хэмжээ болсонгүй. Өмнөх өдөр нь эрх барьж буй намын зүгээс, 2 дугаар сараас хойш нэн ядуу өрхүүдээс бусад бүх гэр бүлд өгөхөө зогсоогоод байсан нийгмийн халамж болох “хүүхдийн мөнгө”-ийг (20,000 төгрөг/сар бүр/хүүхэд бүрт) гэнэт дахин сэргээж, бүтэн дүнгээр нь хүмүүсийн данс руу автоматаар шилжүүлэхээр зарлав. Банкинд дугаарлан зогсож буй хүмүүсийн тоо хэдэн зуу болж

өсөв. Гэр хорооллынхны хувьд, энэ арга хэмжээнд сэтгэл дундуур байлаа. Ядуу гэр бүлийн хувьд тэдний сар бүрийн орлогын амин чухал эх үүсвэр болсон хүүхдийн мөнгөө тэд сар бүр авдаг байсан тул тэдний хувьд энэ нь гэнэтийн ашиг болохооргүй байв. Цаашилбал, энэхүү үйл явц нь эрх барьж буй нам нэн ядуу иргэдээ хайхарсангүй гэдгийг харуулсан нотолгоо боллоо гэж тэд үзэж байв.

Эцэст нь орой болохын хэрд хүмүүс бэлэн мөнгө тараах тухай сонсжээ. Энэ удаад ямар нэгэн машин байсангүй, сонгогчид санал хураах байр луу явцгаав. Хуучин хувцас зардаг жижиг дэлгүүрийн ард хүлээж байгаарай хэмээн хэн нэгэн тэдэнд утсаар хэлсэн байжээ. Бас нэгэн дуудлага ирсэн нь, тэднийг сургуулийн ард хүлээж бай гэсэн байжээ. Гурав дахь дуудлага нь харин тэднийг эхлээд санал өгөөд, дараа нь мөнгөө аваарай гэсэн аж. Гэр бүлээрээ ирэгсэд саналын хуудсаа бүрэн уншуулж, дараа нь санал хураах байрны гадаа хөрш айл, хамаатан саднаараа цугларч эхлэв. Цуу яриа элбэгшиж байсан ч ямар нэг мөнгө төгрөг харагдсангүй. Автобусны буудал дээр хүлээж залхсан тэд удалгүй гэр лүүгээ харьцгаав. Тэр орой нь хүн бүр дахиад 20,000 төгрөгтэй болжээ.

Олон янзаар чармайн хичээсэн боловч Энхболд сонгуульд ялсангүй. Баттулга ялжээ. Сонгууль болсны маргааш нь л гэр хорооллын оршин суугчдын хувьд улс төрийн сонирхол нь буурсан мэт харагдав. Зарим нь бүр “Энхболд ялсан бол арай илүү байх байсан юм: МАН парламентад олонх болсон үед АН-ын ерөнхийлөгч юу хийж чадах вэ дээ?” гэлцэж, хоосон саналын хуудас өгсөн хүмүүс түүгээрээ бахархаж: Ойролцоогоор 100,000 ийм саналын хуудас улсын хэмжээнд бүртгэгдсэн боловч энэ нь дахин сонгууль эхлүүлэхэд хүргэх хэмжээний биш байсан тухай ярилцана. Гэхдээ ихэнх газар байдал урьдын хэвдээ орж: улс төрчид гэр хорооллыг хайхрахаа больж, оршин суугчдын хувьд, сонгуулийн үеэр л хааяа сонсдог нялуун үгтэй харьцуулахад ор тас алга болчихдог байдал нь илүү тодорхой харагдана. Гэр хорооллын оршин суугчид богинохон хугацаанд үл ялиг хөрөнгөлөг болж, аж амьдралаа эргээд үргэлжлүүлсэн боловч алсын ирээдүйд эерэг өөрчлөлт ирнэ гэсэн ямар ч итгэлгүй болсон байлаа.

## **Ардчилал ба нийгмийн нийцэл**

Энэ хэсэгт гэр хороолол дахь ардчиллын онцгой шинж чанар бүхий орон зайд ардчилал болон нийгмийн уялдаа хоорондын харилцан холбоо хэрхэн бүрэлдэн тогтож байгааг задлан шинжилсэн болно. Миний үзэж буйгаар гэр хороололд нийгмийн нийцэл сул байгааг хараад гайхах зүйлгүй юм. Монголын улс төрийн өнгөрсөн үеийн тогтолцоо ялангуяа төрөөс удирдан чиглүүлдэг социализмтай харьцуулахад ардчилал нь “ард түмэн” гэсэн ойлголтыг бий болгоход харьцангуй бага анхаарал тавьдаг (Sneath, 2003).

Үнэндээ, өнөөдөр монголын ардчиллыг өмнөх, социалист эрин үетэй нь холбон тайлбарлалгүйгээр авч үзэх аргагүй. Учир нь тойргийн олон сонгогч улс төрийн огт өөр системд өсөж өндийсөн байдаг ба тэд өөрсдөө ч ардчиллыг харьцангуй үзэгдэл болохыг нь туулж мэдсэн байдаг. Ардчилсан хувьсгалаас өмнө ямаршуу байсан бэ? гэдэгтэй уялдуулан, ардчилсан зах зээлийн үеийн амьдрал ямаршуу байгаа талаар асуусан асуултын хариултууд нь гуйвалтгүй нэгэн янз байх нь бий. Социалист эрин үеийн төгсгөл үед өсөж торнисон хүмүүсийн хувьд (жишээ нь, 35 ба түүнээс дээш насны) ялангуяа иргэдийн зорчих эрх, газар өмчлөх эрх гэх мэт социализмын үед боломжгүй байсан хувь хүний эрх чөлөөг баяртайгаар хүлээн авсан байдаг. Харин өнгөрсөн 25 жилийн хугацаанд тийм ч гойд үйлчилгээ хүртэж чадаагүй гэр хорооллын оршин суугч зэрэг яахын аргагүй өнгөрснөө дурсан санагалзаж буй хүмүүсийн нүдээр харвал, тэрхүү эрх чөлөөний ач тус нь нийгмийн дэг алдарсан хохирлын үнээр олдсон гэж үзэх нь бий (cf. Buyandelgeriy, 2007; Højer and Pedersen, 2019; Pedersen, 2017; Pedersen and Højer, 2008; Sneath, 2003). Тэдний хувьд, социализмын дараах эрин үеийг уралдахад бэлэн бус уралдаан байсан төдийгүй, үнэндээ ташуурдуулах хүртлээ ийм уралдаан эхэлсэн байсныг ч мэдээгүй байсан гэж ярьдаг. Нийгэм “бүхэллэг” байх, хүн бүрийн үүрэг оролцоо, үйл ажиллагаа нь бусадтай харилцан уялдаатай оршиж байдаг нийгмийн нийцэл аль хэдийн алдагдсан мэт санагдана (хэрэв энэ нь хэзээ нэгэн цагт байсан гэж үзвэл). Социализмаас ардчилал руу шилжсэн томоохон өөрчлөлтөд бэлэн байсан нэгнийх нь хувьд, өөрөөр хэлбэл нийцэл, эв нэгдлээс нийгмийн өрсөлдөөнт, автоматчилсан хэлбэр лүү шилжсэн энэ шилжилтийг урьдчилан таамаглаж, бэлэн байсан нэгний хувьд бол, социализмын дараах шилжилтийн шуургад харьцангуй тэсэж үлдсэн юм. Ингэж тэсэж үлдсэн хэсгийнхэн ч шилжилтийн үед хэн ч бэлэн байгаагүй гэж үздэг байна.

Социализмын төгсгөлийн дараа нийгэм “бүхэллэг” хэмээх төсөөлөл үгүй болж, оронд нь хуваагдаж бутарсан нийгмийн харилцаа холбоо бүхий бүтэц бий болжээ. Энэ нийгмийн холбоос нь ураг төрөл ба нутаг<sup>7</sup> гэсэн ойлголтоор илэрч байна. Эдгээр нийгмийн харилцаа, сүлжээ нь хүмүүс орон нутагт байгаа цагт их бага ямар нэг хэмжээгээр үүргээ гүйцэтгэж байдаг бол, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн хот хөдөөгийн хуваагдмал байдлыг буй болгож, тэднийг тусгаарлаж буй энэ орон зай нь уг хэлхээсийг үгүй хийдэг ажээ.

Хүмүүс өөр өөр нутгаас хот руу шилжин ирэхдээ шинээр оршин буй газраараа өөрийгөө тодорхойлох бус харин өөрийн “гарал үүсэл”, нутагтайгаа уяатай хэвээр байгаа нь нийгмийн хуваагдлыг бий болгож байна. Гэр хорооллын оршин суугчид ураг төрөл болон нутгийн ойлголтдоо

---

7 Нутаг хэмээх монгол нэр томъёо, түүний нэгдмэл байдал, улс төрийн үйл ажиллагааны ойлголтод ач холбогдол өгдөг талаар Sneath (2010) болон Шагдар (2015)-аас харна уу.

түшиглэсэн хэвээр байна. Энэ үзэгдлийг “орчин үеийн амьдралын хэв маяг”-ийн хурдыг “уламжлалт” үзэл санаа гүйцэхгүй байгаа мэтээр тайлбарлаж болохгүй бөгөөд харин дараах хүндрэлтэй бодит байдлын улмаас буй болж байна гэж ойлгож болно. Үүнд, гэр хорооллынхны хэлснээр, тэдний одоо амьдарч буй газрыг төрсөн нутагтай нь харьцуулахад “бахархал төрүүлэх” зүйл огт үгүй тул, шинэ адилсал (identity) бий болгох боломжгүй аж<sup>8</sup>. Мөн нийгмийн төр, хувийн хэвшил дэх элитүүд улс орны талаар ярихдаа неолиберал ардчилсан бодлогыг хэрэгжүүлсний шууд үр дагаварт бий болсон хотын ядуусыг дурддаггүй нь гэр хорооллын иргэд өөрсдийгөө төрсөн нутгаараа төлөөлүүлэхээс аргагүй болдог байна.

## Гэр хороолол дахь ардчилал

Судалгааны бүлгийнхээ энэ хүртэл монголын ардчиллыг бага, дунд гэсэн хоёр түвшинд авч үзсэн байгаа. Үүнд тулгуурлан, гэр хорооллын оршин суугчид хэрхэн өөрсдийн байр суурийг ардчилсан Монгол Улсын иргэд хэмээн ойлгож байгаа, тэднийг гаднаас нь харж дүгнэсэн бусад судалгаатай хэрхэн огтлолцож байгаа талаар авч үзнэ. Гэр хорооллын талаар хөндлөнгөөс тайлбарласан хоёр үндсэн чиглэл байгаа нь: нэгт, тэднийг хохирогч, удаах нь буруутан гэж үзэх тайлбарууд байдаг.

### ***Гэр хорооллын оршин суугчид экологи болон нийгмийн өөрчлөлтүүдийн “хохирогчид” болох нь***

Эрдэм шинжилгээний болон хөгжлийн чиглэлээр хийсэн судалгааны материалууд нь дүүргийн гэр хорооллын оршин суугчдыг хохирогч мэтээр авч үзэх хандлагатай байдаг. Өнгөрсөн арваад жилийн хугацаанд хэд хэдэн хүнд өвлийн улмаас улсын мал сүрэг сүйрсэн тул, тэднийг нутгаа орхиход хүргэсэн гэж үздэг. Эдгээр судалгааны тогтсон тайлбарыг хураангуйлвал: “Дэлхийн зах зээлийн өөрчлөлтийн улмаас улсын эдийн засагт тогтворгүй байдал үүссэн. Энэ нь байнга тохиолдох болсон зудын гамшигтай хавсран ядуурлын түвшинг ихэсгэж, олон сая мал хорогдов. Ийм ядуурал нь хөдөө орон нутагт илүү хурц илэрдэг ба улмаар хөдөөгөөс хот руу чиглэсэн асар их хэмжээний шилжилт хөдөлгөөн бий болоход хүргэсэн” (Diener and Hagan, 2013, 637). Гэр хороололд шилжиж ирснээс хойших амьдрал хүнд, хэцүү, байнга өргөжин тэлж байдаг дэд бүтэцгүй сунаж тогтсон газар гэж тодорхойлсон байна. (Bolchover, 2016, 22). Олон судалгаанд гэр хороолол дахь материаллаг бэрхшээл, тулгамдаж буй асуудлын талаар дурдсан байдаг. Хөрс, ус, ялангуяа агаарын бохирдлын асуудлыг эдгээр судалгаанд онцлон тэмдэглэсэн байдаг (Altantuya et

---

8 Гэвч үүнээс эсрэг жишээг харах боломжтой, жишээ нь реппер Жий, энэ талаар Dovchin (2017)-с харна уу.



al., 2012; Baris et al., 2006; Batkhuyag et al., 2016; Hasenkopf, 2012; Ishihara et al., 2016; Uddin, 2016; UNICEF, 2016). Гэр хороололд халаалт болон хоол хүнсээ бэлтгэхэд голлон ашигладаг мод, нүүрс түлэхийн аюулын талаарх ойлголт тэлсээр байна. Андерсон нарын судлаачийн тэмдэглэснээр, “Улаанбаатар хотод тэмдэглэгдсэн зүрх судасны өвчний 29 хувь, уушгины хавдрын 40 хувийг гаднах агаарын бохирдолтой холбоотой гэж үзэж болно” гэжээ (Anderson et al., 2017, 218). 2013 оны нэгэн судалгаагаар, Улаанбаатар хотод тохиолдож буй 10 нас баралт тутмын нэг нь агаарын бохирдолтой холбоотой байна (Allen et al., 2013)<sup>9</sup>. Сүүлийн үеийн судалгаануудад үүнээс ч дутахгүй гамшгийг тэмдэглэсэн нь улирлын чанартай агаарын бохирдол, эрс нэмэгдсэн үр зулбалт хоорондын хамаарал юм. Судалгаанаас үзвэл, 12 дугаар сард хийгдсэн зайлшгүй үр хөндөлтийн тоо 1,000 амьд төрөлт тутамд 73 хүрч байгаа нь 5 дугаар сард хийгдсэн 1,000 амьд төрөлт тутамд 23 хүрдэг хэмжээнээс эрс өссөн дүн юм (Allen et al., 2013; Aghajanian, 2015).

Гэр хорооллын сууц нь усан хангамжийн төвлөрсөн системд холбогдож чадаагүй байдаг тул оршин суугчид нь цэвэр, аюулгүй, боломжийн үнэ бүхий усан хангамжийг хүртэхэд тун бэрхшээлтэй. Худгаас ус авахаар дараалалд хүмүүсийн зарцуулж буй цаг, ялангуяа өвөл хүүхдүүдийн сургуульдаа явах цагт үзүүлж буй сөрөг нөлөөлөл, эрүүл мэндэд үзүүлж буй хохирлын талаар баримтжуулсан судалгаанууд бий (Basandorj and Altanzagas, 2007; see also Hawkins and Seager, 2011). Түүнчлэн, оршин суугчид орон сууцныхны хэрэглэдэг устай харьцуулахад өчүүхэн хэмжээний ус хэрэглэдэг (өдөрт 8-10 литр, гэтэл орон сууцны иргэдийн дундаж хэрэглээ өдөрт 240-450 литр хэрэглэдэг!) ба ус ашигласны төлөө аж үйлдвэр болон уул уурхайн компаниудын төлдөг хэмжээнээс 84 дахин их төлбөр төлдөг байна. Нийслэлийн засаг даргын тамгын газар, ялангуяа байгаль орчны бодлого төлөвлөлт ба агаарын чанарыг хамгаалах асуудал хариуцсан газруудын хүний нөөцийн дутагдал зэрэг хүнд суртлын шинжтэй бэрхшээлийн талаар мөн дурдсан байдаг (Altantuya et al., 2012). Эдгээр нь гэр хорооллын оршин суугчдын эрүүл мэнд, боловсролын хүртээмжид асар сөргөөр нөлөөлж байдаг (Batbaatar et al., 2006; Dovchin, 2017; Enkhtuya et al., 2009; Janes and Chuluundorj, 2004; Janes et al., 2006; Lhamsuren et al., 2012).

---

9 Хот бүхэлдээ агаарын бохирдолд өртөж байна. Гэсэн ч гэр, байшинд гаднаас их хэмжээний тоосонцор нэвтэрдэг тул гэр хороололд амьдардаг иргэд илүү ихээр өртөж байна (Очир ба Смит, 2014; UNICEF, 2016).

### **Гэр хорооллын оршин суугчдын “гол буруутнууд”**

Гэр хорооллын оршин суугчдыг хохирогч мэтээр үзэхийн зэрэгцээ, тэднийг санаатай, санамсаргүй аль нь ч бай гол буруутан хэмээн үзэх санал сэтгэгдлүүд нийтлэг юм. Олон хүмүүсийн хувьд, Улаанбаатар хотын өсөлт нь хүсүүштэй зүйл биш бөгөөд гэр хорооллын оршин суугчид, сүүлийн үед ирсээр байгаа шилжин суурьшигчид лав сайн зүйл авчрахгүй, харин ч нэгэнт тогтсон (элит) хотын нийгмийг заналхийлэх болно гэж үздэг. Тэднийг гутаан доромжилсон үг хэллэг, уг судалгааг хийж байсан 2016 онд орк гэх доромж үг элбэг байв. Судалгаа шинжилгээний ажлууд ч мөн ийм үг хэллэг рүү халтирах боломжтой байв. Жишээ нь, Диенер, Хаган нарын (Diener and Hagan 2013, 639) дурдсанаар бол, “Сүхбаатарын талбай орчим, хотын төвд цэцэглэж буй, дэлхийтэй хөл нийлүүлэн алхаж буйг илэрхийлэх гялалзсан барилгуудыг тойрон үүний эсрэг, тааламжгүй дүр зураг болох гэр хороолол оршиж байдаг.” Экологийн нөхцөл байдал хот руу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлж байгаа ч, үүнд шилжигсэд өөрсдөө тодорхой хэмжээнд буруутай. Тухайлбал, тэд ашиг олз ихтэй ноолуурын үйлдвэрлэлд ач холбогдол өгч, сүргийн бүтцэд ямааны эзлэх хувийг нэмэгдүүлж, бэлчээрийн даацыг хэтрүүлэн мал маллаж байгаа зэргээр тайлбарладаг (cf. Lkhagvadorj et al., 2013; Sneath, 2003; Upton et al., 2013).

Хотын байгаль орчны бохирдол, доройтлын асуудал нь гэр хорооллын оршин суугчдын хогоо хэрхэн хаях талаарх мэдлэг сул байгаатай холбоотой (Altantuya et al., 2012; Sugimoto et al., 2007). Хэдийгээр гэр хорооллын оршин суугчид бага хэмжээний ус хэрэглэдэг ч, тэдний бохир усаа “зүй бусаар” асгадаг байдал нь хөрсний бохирдол үүсгэдэг. Цаашлаад тэдний бие махбод нь бохирдол, нийтийн эрүүл мэндтэй холбоотой өвчний асуудал болж хувирдаг: “Цусан суулга, хижиг өвчин, гепатит А зэрэг гэдэс гүйлгэх өвчин нь таваас доош насныхны дунд тохиолддог, нас баралтын нэг томоохон шалтгаан болдог” (Basandorj and Altanzagas, 2007, 168). Мөн гэр хорооллын оршин суугчдыг засгийн газрийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй цахилгааны шөнийн тарифын хөтөлбөрийн “давуу талыг ашигладаггүй”-гээс гадна цахилгаанынхаа төлбөрийг ч төлж чаддаггүй гэж тайлбарлажээ. Бассайхан зэрэг судлаачийн (2003) үзэж буйгаар цахилгаан түгээх сүлжээ хувьцаат компани 2003 онд гэр хорооллын дүүргүүдээс 4.5 тэрбум төгрөгийг (нийт өрийн 84.6 хувь) төлбөрт хүлээн авч цуглуулах ёстой байсан бөгөөд жилээс жилд төлж буй төлбөрийн хувь хэмжээ буурсаар байна гэжээ (мөн Нансалмаа 2011 материалыг үзнэ үү). Тэрбишийн Баярцэцэг, Маргот Раустөун нарын тодорхойлсноор, гэр хорооллын оршин суугчдын нөхцөл байдал бол “нийгмээс гадуурхах хандлагатай сүүлийн үеийн үзэгдэл”-ийн нэг бөгөөд уг нөхцөл байдал нь тэд “нийгмийн амьдралд үр бүтээлтэй оролцож чадахгүй байх, оролцох боломж хомс” байгаагийн улмаас үүдсэн үр дагавар юм (Terbish and Rawsthorne, 2016, 11). Эдгээр судлаач нийгмийн гадуурхлыг буй болгож

буй нарийн түвэгтэй хүчин зүйлсийг хүлээн зөвшөөрч байгаа бол бусад судлаач, гэр хорооллын оршин суугчдыг нийгмийн хүрээ, улс төрийн тавцанд илүү идэвхтэй байж чадахгүй байна хэмээн буруутгадаг байна (Duurenbayar, 2017, 52). Бусад нь энэ санааг ахиулан энэ хэсэг хүн амын хувьд олны дунд амьдрах өмнө хуримтлуулсан туршлага байхгүй, мөн 'community' гэдгийг орчуулах монгол үг, ойлголт ч байдаггүй" (Bolchover, 2016, 22) хэмээн дүгнэсэн байдаг.

## Гэр хорооллын өнцгөөс харах нь

Социализмын далбаан дор бодлогоор зохицуулж, төрөөс чиглүүлэн хөгжүүлсэн хот төлөвлөлттэй харьцуулвал ардчилсан Улаанбаатар хот үндсэнээ удирдлагагүй байна. Хотын олон удирдлага өөр хоорондоо зөрчилдсөн байр суурьтай ажилласан байдаг (Anderson et al., 2017). Бямбадорж нарын (2011) судалгаа нь Монголд хэрэгжсэн газрын шинэчлэлийн түүх болон мастер төлөвлөлт хоорондоо асар зөрүүтэй байгааг онцлон тэмдэглэсэн байдаг. Нэг талаас газрын шинэчлэлийн асуудал нь гэр хорооллыг албан ёсны болгоход чиглэж байсан бол, нөгөө талаас мастер төлөвлөлт нь гэр хорооллыг хууль бус, түр зуурын үзэгдэл гэж гадуурхаж иржээ. Нэр дэвшигчдийн зүгээс газар хувьчлалыг орон нутгийн сонгогчдын санал авахын тулд санал болгодог улс төрийн хэлэлцээрийн хэрэгсэл болгон ашигладаг (Byambadorj et al., 2011, 173). Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хувьд, хүнд суртлын аппарат нь байгаа хэдий ч, энэ нь үйлчилгээний хүртээмжийг дэмжих бус, харин хязгаарлаж ирсэн байдаг. Орон нутгийн бүртгэлтэй холбоотой баримт бичиг зэргийг олж авахад тулгарч буй албан, албан бус (хээл хахууль гэх мэт) саад бэрхшээл нь Улаанбаатар хот руу чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөнийг бууруулах засгийн газрын сонирхлыг ил, далд илэрхийлж байдаг (Lindskog, 2014).

Эдгээр удирдлагын зүгээс явуулж буй хоорондоо зөрчилдөөнтэй үйл ажиллагаанууд нь гэр хорооллын оршин суугчдыг гол буруутан эсвэл хохирогч гэсэн хоёр туйлын дунд хавчуулан орхидог байна. Хэдийнээ тулгамдаад эхэлсэн байгаль орчны нөхцөл байдалтай зэрэгцэн, социализмын дараа хөдөө орон нутагт улсын хөрөнгө оруулалтыг зогсоосон нь мал маллагааг түшиглэсэн амьдралын хэв маяг хэвийн үргэлжлэх нөхцөлийг улам дордуулахад хүргэсэн аж (Lindskog, 2014). Улаанбаатарын гэр хороололд амьдарч байгаа олон нийтэд ардчиллын он жилүүд амар цаг үе байсангүй. Ээлж дараалсан улс төрийн скандал, улс төрийн эс үйлдэл нь хувь хүмүүст тулгамдаж буй зовлон бэрхшээлийг улам даамжруулж байлаа. Ардчиллын дараах цаг үед иргэдийн ардчилалд итгэх итгэл алдарч буй эсэхийг судлаачид олон жилийн турш ажигласаар иржээ. Үнэндээ, улс оронд нь эзэнт гүрний яруу алдар хүндийг эргүүлэн авчрах, эсвэл бохир улс төрөөс улс орныг нь цэвэрлэх чадалтай Чингис

Хаан шиг хүчтэй манлайлагч төрөн гарна гэж ярьж буй олон монголчууд байдаг. Гэвч хүчтэй үр дүнтэй манлайлагчийг хүсэн хүлээнэ гэдэг нь заавал ардчилсан үйл явцад авсан үүрэг амлалтын төгсгөл ирж байна гэсэн үг биш юм. Энэ асуудлыг зураглан илэрхийлэхийн тулд би 2017 оны сонгуулийн талаар эргэж ярья.

Хоёр гол намын зүгээс олгож байсан бэлэн мөнгийг авсан гэр хороололд амьдарч буй, миний мэдэх бүх хүн хэрэг дээрээ Ганбаатарт саналаа өгсөн байдаг. Саналыг нь худалдан авахыг хичээсэн “луйварчдыг” давуулан тонгорсондоо тэд ихээхэн сэтгэл хангалуун байлаа. Хэдийгээр бэлэн мөнгө тараагдаж, хүн бүр түүний араас хошуурцгаасан боловч зарим нь үүнийг зөвтгөх үйлдэл байсан эсэхт эргэлзэж байв. “Тэд ядуу хүмүүс бидний саналыг хямдхан худалдаж авсан гэж хэлэх байх” хэмээн зангидсан нударгандаа 20,000 төгрөг нуусан нэгэн эмэгтэй дуугаа өндөрсгөж, “Гэвч тэд буруу бодож байна! Юу ч худалдаж авч чадаагүй. Бид тэдний нэр дэвшигчдэд саналаа өгөө ч үгүй. Ямар ч байсан, бид яагаад бэлэн мөнгө авч болохгүй гэж?” Тэд тэнд суучхаад, энд байгаа биднийг огт хайхралгүй бүхнийг идэж ууж байна. Биднээс хулгайлсан зүйлээс нь өчүүхэн хэсгийг буцаан авахад юу нь буруу байхав!” хэмээн сэтгэл нь хөдлөн ярьж байв. Сонгуулийн үйл явцад бүрэн сэтгэл ханамжтай байгаагүй ч, сонгуулийг хуурамч болсон гэж эргэлзэж байсан хүн цөөн байв. Хэдийгээр том намуудын зүгээс баруун солгойгүй мөнгө цацаж байсан ч, хүмүүс хөндлөнгийн нэр дэвшигч Ганбаатарт боломж олдохгүй байх вий хэмээн санаа зовниж, сэтгэл зүрхээрээ дэмжин, түүнд саналаа өгч байлаа.

Урьдчилан таамаглаагүй хоёр дахь шатны сонгууль болох нь тодорхой болоход хүмүүс анхан шатны сонгуулийн орой болсон бохир арга хэмжээнүүдийн талаар сэтгэл гонсгор байгаагаа илэрхийлэхийн тулд ардчиллын арга хэрэгслийг ашиглахыг эрэлхийлж байлаа. Тэд хоёр дахь шатны сонгуулийн үеэр мөн адил багахан хэмжээний санхүүгийн үр ашиг хүртэх байх гэж найдаж байсан боловч энэ нь талаар болсон юм. Улс төрийн үүднээс ярихад, тэд хасагдсан нэр дэвшигч Ганбаатарт үнэнч хэвээр, эсвэл ядаж л үлдсэн хоёр нэр дэвшигчдийн эсрэг байр суурьтай хэвээр үлдсэн байв. Ганбаатарын “хулгайлагдсан сонгуулийн” эсрэг тэмцэл нь хоосон саналын хуудас өгөх, магадгүй бүр гурав шинэ нэр дэвшигч бүхий гурав дахь шатны сонгууль явуулахыг шаардаж ч болох төлөвлөгөө боловсруулж эхлэв. Анхан шатны сонгуулийн үеэр бэлэн мөнгө тараасан талаар дээр тайлбарласанчлан улс төр нь иргэд, удирдагчдын аль алиных нь муу муухайг ил болгосон гэж үзэж, гэр хорооллын иргэд эцсийн дүнд сэтгэл дундуур үлдэв. Автобусны буудал дээр бэлэн мөнгө тараахыг удаан хүлээж залхсан дунд эргэм насны нэгэн эр “Монголчууд бид 20,000-хан төгрөгийн төлөө гүйхийг харах маш харамсалтай байгаа биз дээ. Гэхдээ бид юу ч хийж чадах билээ дээ? Бидэнд мөнгө хэрэгтэй, хэрэв тэд үүнийг зүгээр л цацаж байгаа бол бид яагаад заримыг нь авч болохгүй гэж?” хэмээн хэлсэн юм”

## Дүгнэлт

Олон хүчин зүйл дотроос Монголын ардчилсан эрин үе, нэгдүгээрт: орон нутгаас хот руу чиглэсэн их хэмжээний шилжилт нүүдэл, мөн хоёрдугаарт: Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн тэлж байгаа байдлаар тодорхойлогдоно. Уг бүлэгт эдгээр сэдвээр эрдэм шинжилгээний судалгаа хийх нь Монголд өрнөж буй ардчиллын өнөө, ирээдүйн талаар ойлголт авах суурь болно хэмээн үзсэн болно. Эдгээр асуудлаар дээрээс доош чиглэсэн судалгаанаас гадна, монголчуудын өдөр тутмын амьдрал, гарч буй өөрчлөлтүүд, эдгээр өөрчлөлтүүдэд ороогдож буй байдал зэргийг угсаатны зүйн гүнзгийрүүлсэн шинжилгээ хийх замаар судлах нь ач холбогдолтой гэдгийг харуулав. Мөн оролцоот ажиглалтын аргаар илүү нарийвчлалтай, антропологийн судалгаа хийсэн нь уг судалгааг сэдвийн хүрээнд хязгаарлах, дүн шинжилгээнд хязгаарлалт учруулахгүй болохыг харуулсан болно. Харин ч өдөр тутмын амьдралын нарийн үйл явдлыг дүрслэн харуулах нь томоохон хүрээний асуултууд, тухайлбал, Монголын ардчиллын өвөрмөц шинж чанарыг ойлгож тайлбарлахад чухал суурь болж байна.

Уг судалгаанд ардчилсан үйл явц, зарчмууд нь иргэд, тэр дундаа Улаанбаатарын гэр хорооллын иргэдийн дунд чухал хэвээр байгааг харууллаа. Гэр хорооллын иргэд хээл хахууль, бэлэг сэлт нь ардчиллыг доройтуулж чадна гэж үзэхгүй байгаа бөгөөд ялахын тулд нэр дэвшигчдийн хэрэглэж байгаа аргуудыг ичгүүртэй зүйл гэж үзэж байв. Нэг талаар, улс төрийн дэд бүтэц ерөнхийдөө ажиллаж байгаа бөгөөд улс төрийн намуудын зарим далд үйлдэл, тактикийг иргэд өөрсдийн чөлөөт, нууц санал өгөх боломжоо ашигласнаар эсэргүүцэж чадаж байна. Сонгогчдын ирц өндөр байснаас гадна, хоёр дахь шатны сонгуульд хоосон саналын хуудас өгөх компанит ажил явагдсан нь нийгмийн эмзэг бүлгийн иргэд хүртэл өөрсдийн эрхээ сайн ойлгож, ардчиллын үйл явцад оролцож буйг илтгэж байна.

Улс төрөөс үүдэн гарах аюулыг үл тоомсорлодог, хотын захад орших гэр хорооллынхныг маш хүчирхэг санал өгөх хэсэг хэмээн хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, ядуурал нь тэдний саналыг хямдхан худалдан авах нөхцөлийг бүрдүүлж байна хэмээн томоохон хэвлэл мэдээллийн байгууллага хийгээд иргэд харамсан өгүүлдэг. Бусдад хохирогч эсвэл гол буруутан хэмээн цоллуулдаг гэр хорооллын оршин суугчдын эрхэмлэж буй улс төрийн үзэл баримтлалыг дорд үзэн тохуурхаж хүлээн авах нь бий. Парламентын сонгуульд өрсөлдөх үеэр гэр хорооллын сонгуулийн дүүрэгтээ цагаан морьтойгоо давхин ирж эсэргүүцлээ илэрхийлсэн дуучин Жавхлангийн хувьд сурталчилгааны залуучуудтай зэрэгцэн уламжлалт монгол дээлээ өмссөн байсан нь маш олон онигооны эх сурвалж болсон байдаг. Үүний нэгэн адил хотын төвийн оршин суугчдын маш цөөн хэсэг нь Ганбаатарын тухай егөөдөлгүйгээр ярьж чадна. Зах

зээлийн үеийн хамгийн сөрөг үр дагаврыг туулж өнгөрүүлсэн, зөвхөн сонгуулийн үед л эрх баригчдын хувьд чухалд тооцогддог, бусад үед хэрэггүй болдог эмзэг амьдралаар амьдарч буй гэр хорооллын оршин суугчдыг социалист нийгмийн зохион байгуулалтын талаарх “хуучин өдрүүд”-ийг санагалзах, эсвэл Монголын эзэнт гүрний түүх домгийг дурдсаных нь төлөө хэн буруутгаж чадах билээ.

Уг судалгаагаараа гэр хорооллын оршин суугчдыг зүгээр л энгийн байдлаар нэг бол гол буруутан, эсвэл хохирогч мэтээр тодорхойлж болохгүй гэдэг санааг илэрхийлсэн юм. Удирдагчид нь ядрагхан тактик хэрэглэхийг харж байгаа ч, гэр хорооллын оршин суугчид ардчилсан Монголын ирээдүйн талаар бүх итгэл найдвараа алдчихаагүй байна. Хүмүүс улс төрчдийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлэхдээ ардчилсан үйл явцыг ашигласаар байгаа бөгөөд эрээ цээргүй болж буй үйл явдалд нэг их цочирдсон шинжгүй байна. Нэг гараараа саналаа өгөөд нөгөө гараараа 20,000 төгрөг авч байгаа энэ хоёр өөр үйлдэл нь бие биеэ заавал бүрэн үгүйсгэж байгаа хэрэг биш болж таарч байна. Харин нэг үйлдэл нь нөгөө үйлдлийнхээ тавьсан мөрийг эрсдэлээс хамгаалах үүднээс хийсэн болж байгаа бөгөөд тэр нь нөгөөтэйгөө яг адилхан байж магад гэж гэнэн байдлаар үл ойшоохын оронд, бүх зүйл сайхан болж болно гэсэн итгэлийг давхар тээж явааг илэрхийлж байна.

## Ном зүй

- Aghajanian, Liana. 2015. “Fighting to Breathe in Mongolia: As Air Pollution Gets Worse, Maternal Health Suffers.” *Al Jazeera America*, December 20. URL: <http://projects.aljazeera.com/2015/12/mongolia-maternal-health/> (accessed February 12, 2019).
- AHI. 2014. *Affordable Housing Strategy for Ulaanbaatar*. Boston: Affordable Housing Institute.
- Allen, Ryan W., Enkhjargal Gombojav, Baldorj Barkhasragchaa, Tsogtbaatar Byambaa, Oyuntogos Lkhasuren, Ofer Amram, Tim K. Takaro and Craig R. Janes. 2013. “An Assessment of Air Pollution and its Attributable Mortality in Ulaanbaatar, Mongolia.” *Air Quality, Atmosphere and Health*, 6(1): 137–150.
- Altantuya, Dashnyam, Zhongrui Zhang and Haomiao Li. 2012. “Municipal Solid Waste Management of Mongolia: Analysis on the Solid Waste Treatment of Ulaanbaatar City.” *Advances in Asian Social Sciences*, 3(3): 695–697.
- Anderson, Raven, Michael Hooper and Aldarsaikhan Tuvshinbat. 2017. “Towers on the Steppe: Compact City Plans and Local Perceptions of Urban Densification in Ulaanbaatar, Mongolia.” *Journal of Urbanism: International Research on Placemaking and Urban Sustainability*, 10(2): 217–230.

- Baris, Enis, Salvador Rivera, Zuzana Boehmova and Samantha Constant. 2006. "Indoor Air Pollution in Cold Climates: The Cases of Mongolia and China." *ESMAP, Knowledge Exchange Series 8*.
- Basandorj, D. and B. Altanzagas. 2007. "Current Situation and Key Problems on Water Supply and Sanitation in Mongolia." *International Forum on Strategic Technology* (pp. 166–168). IEEE.
- Bassaikhan, D., D. Sodnomdori, K. Enklargal, M. Narantuya, and L. Dolgorsuren. 2003. "Commercial Losses of UB Electric Distribution Network Shareholding Company (CO., SH) and Their Reducing." *Proceedings of the 7th Korea International Symposium* (pp. 38–44). KORUS.
- Batbaatar, M., T. Bold, J. Marshall, D. Oyuntsetseg, C. Tamir, and G. Tumennast. 2006. *Children on the Move: Rural-Urban Migration and Access to Education in Mongolia*. Report 17, Save the Children UK, Childhood Poverty Research and Policy Centre.
- Batkhuuyag, Enkh Uchral, Tomoo Sekito, Enkhdul Tuuguu and Yukata Dote. 2016. "Characteristics of Household Waste and Coal Ash in Ulaanbaatar, Mongolia." *The 27th Annual Conference of JSMCWM* (pp. 561–562).
- Bolchover, Joshua. 2016. "Settling the Nomads: Rural Urban Framework, an Incremental Urban Strategy for Ulaanbaatar, Mongolia." *Architectural Design*, 86(4): 20–27.
- Bonilla, Lauren and Tuya Shagdar. 2018. "Electoral Gifting and Personal Politics in Mongolia's Parliamentary Election Season." *Central Asian Survey*, 37(3): 457–474.
- Buyandelgeriyn, Manduhai. 2007. "Dealing with Uncertainty: Shamans, Marginal Capitalism, and the Remaking of History in Postsocialist Mongolia." *American Ethnologist*, 34(1): 127–147.
- Byambadorj, Tseregmaa, Marco Amati and Kristian J. Ruming. 2011. "Twenty-First Century Nomadic City: Ger Districts and Barriers to the Implementation of the Ulaanbaatar City Master Plan." *Asia Pacific Viewpoint*, 52(2): 165–177.
- Campi, Alicia. 2006. "The Rise of Cities in Nomadic Mongolia". In Ole Bruun and Li Narangoa (eds), *Mongols from Country to City: Floating Boundaries, Pastoralism and City Life in the Mongol Lands*, 141–143. Copenhagen: NIAS Press.
- Diener, Alexander C. and Joshua Hagen. 2013. "City of Felt and Concrete: Negotiating Cultural Hybridity in Mongolia's Capital of Ulaanbaatar." *Nationalities Papers: The Journal of Nationalism and Ethnicity*, 41(4): 622–650.
- DeWalt, Kathleen Musante and Billie R. DeWalt. 2002. *Participant Observation: A Guide for Fieldworkers*. Lanham, MD: Altamira Press.

- Dovchin, Sender. 2017. "Uneven Distribution of Resources in the Youth Linguascapes of Mongolia." *Multilingua*, 36(2): 147–179.
- Duurenbayar, Buyandalai. 2017. Informal Settlement and Its Upgrading Ulaanbaatar's Ger District. Master's Degree thesis, School of Architecture Urban Planning and Construction Engineering, Politecnico Di Milano, Italy.
- Enkhtuya, B., T. Badamusuren, N. Dondog, L. Khandsuren, N. Elbegtuya, G. Jargal, V. Surenchimeg and J. Grundy. 2009. "Reaching Every District—Development and Testing of a Health Micro-Planning Strategy for Reaching Difficult to Reach Populations in Mongolia." *Rural and Remote Health*, 9(2): 1–12.
- Hasenkopf, Christa. 2012. "Clearing the Air." *World Policy Journal*, 29(1): 83–90.
- Hawkins, Roberta and Joni Seager. 2010. "Gender and Water in Mongolia." *The Professional Geographer*, 62(1): 16–31.
- Højer, Lars and Morten Axel. 2019. *Urban Hunters: Dealing and Dreaming in Times of Transition*. New Haven: Yale University Press.
- IEG. 2015. *Mongolia Country Program Evaluation*. Independent Evaluation Group, The World Bank.
- IFES. 2019. "Election Guide: Mongolia." International Foundation for Electoral Systems. URL: <http://www.electionguide.org/countries/id/144/> (accessed February 12, 2019).
- IOM. 2018. *Mongolia: Internal Migration Study*. UN Migration. Ulaanbaatar: International Organization for Migration.
- Ishihara, Yoko, Motoyuki Nakao, Keiko Yamauchi, Hisamitsu Oomori, Dashtseren Ichinnorov and Bandi Solongo. 2016. "Effect Of Particulate Matter Air Pollution On The Health Status, Respiratory Symptoms, And Lung Function Of Mongolian Living In Ger District And Urban Area Of Ulaanbaatar." *American Journal of Respiratory and Critical Care Medicine*, 193: A5415.
- Janes, Craig R. and Oyuntsetseg Chuluunjorj. 2004. "Free Markets and Dead Mothers: The Social Ecology of Maternal Mortality in Post-Socialist Mongolia." *Medical Anthropology Quarterly*, 18(2): 230–257.
- Janes, Craig R., Oyuntsetseg Chuluundorj, Christopher E. Hilliard, Kimberly S. Rak and K. Janchiv. 2006. "Poor Medicine for Poor People? Assessing the Impact of Neoliberal Reform on Health Care Equity in a Post-Socialist Context." *Global Public Health*, 1(1): 5–30.
- Lhamsuren, Khandsuren, Tserendolgor Chojiljav, Enkhtuya Budbazar, Surenchimeg Vachinkhuu, Diana Chang Blanc and John Grundy. 2012. "Taking Action on the Social Determinants of Health: Improving Health



- Access for the Urban Poor in Mongolia." *International Journal for Equity in Health*, 11(15): 1–13.
- Lindskog, Benedikte V. 2014. "Natural calamities and 'the Big Migration': Challenges to the Mongolian Health System in 'the Age of the Market'." *Global Public Health*, 9(8): 880–893.
- Lkhagvadorj, D., Hauck, M., Dulamsuren, C., & Tsogbaatar, J. 2013. "Pastoral Nomadism in the Forest-Steppe of the Mongolian Altai Under a Changing Economy and a Warming Climate." *Journal of Arid Environments*, 88: 82–89.
- Nansalma, Erdenekhuu. 2011. Evaluation on Health Impact of Government Support for GER (Traditional Dwelling) District's Electricity Night Rates in Ulaanbaatar City. Master's thesis, School of Public Health, Georgia State University, USA.
- NSO. 2018. *Socio-Economic Situation of Mongolia*. Ulaanbaatar: National Statistics Office of Mongolia.
- Ochir, Chimedsuren and Kirk R. Smith. 2014. *Air Pollution and Health in Ulaanbaatar*. Ulaanbaatar: Ministry of the Environment and Green Development.
- Pedersen, Morten Axel. 2017. "Debt as an Urban Chronotope in Mongolia." *Ethnos*, 82(3): 475–491.
- Pedersen, Morten Axel and Lars Højer. 2008. "Lost in Transition: Fuzzy Property and Leaky Selves in Ulaanbaatar." *Ethnos*, 73(1): 73–96.
- Radchenko, Sergey and Mendee Jargalsaikhan. 2017. "Mongolia in the 2016–17 Electoral Cycle: The Blessings of Patronage." *Asian Survey*, 57(6): 1032–1057.
- Rupen, Robert Arthur. 1957. "The City of Urga in the Manchu Period." *Studia Altaica, Festschrift für Nikolaus Poppe*. Wiesbaden: O. Harrassowitz.
- Shagdar, Tuya. 2015. "Homeland Associations and the Production of Informal Power in Mongolia." Emerging Subjects Blog (blog). May 11. URL: <https://blogs.ucl.ac.uk/mongolian-economy/2015/11/05/homeland-associations-and-the-production-of-informal-power-in-mongolia/>.
- Sneath, David. 2003. "Land Use, the Environment and Development in Post-Socialist Mongolia." *Oxford Development Studies*, 31(4): 441–459.
- Sneath, David (ed.). 2006. *Imperial Statecraft: Political Forms and Techniques of Governance in Inner Asia, Sixth-Twentieth Centuries*. Cambridge: Mongolia and Inner Asia Studies Unit.
- Sneath, David. 2010. "Political Mobilization and the Construction of Collective Identity in Mongolia." *Central Asian Survey*, 29(3): 251–267.

- Sugimoto, Hirofumi, Umekazu Kawagishi, Koki Kitano, Ishjamts Gonchigbat and Naoyuki Hirota. 2007. "Living Environment of Nomads Residing on the Outskirts of Ulaanbaatar, Mongolia: Dispositional Characteristics from the Perspective of a Comparison of Nomads and People Living in Ger Fixed Residences in the City." *Journal of Asian Architecture and Building Engineering*, 6(2): 283–290.
- Terbish, Bayartsetseg and Margot Rawsthorne. 2016. "Social Exclusion in Ulaanbaatar City Mongolia." *Asia Pacific Journal of Social Work and Development*, 26(2): 77–87.
- Uddin, Sayed Mohammad Nazim, Zifu Li, Jan Franklin Adamowski, Tobias Ulbrich, Heinz-Peter Mang, Roman Ryndin, Javzansuren Norvanchig, Jean Lapegue, Alexander Wriege-Bechtold and Shikun Cheng. 2016. "Feasibility of a 'Greenhouse System' for Household Greywater Treatment in Nomadic-Cultured Communities in Peri-Urban Ger Areas of Ulaanbaatar, Mongolia: An Approach to Reduce Greywater-Borne Hazards and Vulnerability." *Journal of Cleaner Production*, 114: 431–442.
- UNICEF Mongolia. 2016. *Understanding and Addressing the Impact of Air Pollution on Children's Health in Mongolia*. Ulaanbaatar: UNICEF Mongolia.
- Upton, Caroline, Kate Moore, Nyamaa Nyamsuren and Erdenebaatar Batjargal. 2013. *Community, Place and Pastoralism: Nature and Society in Post-Soviet Central Asia*. Mongolia Country Report, The Leverhulme Trust, University of Leicester.
- World Bank. 2015. *Review of Program Design and Beneficiary Profiles of Social Welfare Programs in Mongolia*. Ulaanbaatar: World Bank Group, Ministry of Population Development and Social Protection.

# ХОЁРДУГААР ХЭСЭГ

Ардчилсан тэмцэл ба байгалийн баялгийн үүргийн  
талаарх харьцуулсан судалгаа



## **Зүүн Өмнөд Азийн байгалийн нөөцийн менежмент: Авлигатай тэмцэх, хууль сахиулах болон ашигт ажиллагаанд тулгарч буй сорилтууд**

**Андреа Хэфнер**

Энэхүү бүлгийг утаанаас үүдэлтэй агаарын бохирдол, усны менежментийг хамарсан бөгөөд хил дамнасан асуудлыг шийдвэрлэхэд байгаль орчны удирдлага, АСЕАН-ны гүйцэтгэх үүргийг анхлан Зүүн Өмнөд Азид судалсан материалд тулгуурлан бичсэн болно. Лаос, Индонез улсын жишээнээс харахад, Доод Меконгийн эрэг орчмын бүсэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгаль орчны асуудлын талаар харилцан зөвлөлдөж, шийдвэрлэхийн оронд Лаос болон бусад орон эдийн засгийн ашиг сонирхлоо илүүд үзэж, дэд бүтцийн хөгжлийн асуудалд түлхүү анхаарч байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Хэдийгээр утааны бохирдол бүс нутгийн шинжтэй, бохирдлыг бууруулах санаачилга, үйл ажиллагаа АСЕАН-ны түвшинд төвлөрсөн байгаа ч, төдийлөн үр дүнтэй биш байна. Хамгийн бэрхшээлтэй асуудал нь АСЕАН-ы түвшинд гарсан санаачилгыг үндэсний бодлогод тусгаж хэрэгжүүлэх механизм байхгүй, үүнийг бий болгоход сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс нь гишүүн улс орнууд байгаль орчныг эрүүл байлгах зардлыг тооцдоггүй, эзэн үйлчлүүлэгчийн таагүй харилцаа, авлига, төрийн агентлагуудын тэнцвэргүй байдал зэрэг байна. Байгаль орчны зорилтуудад хүрэх, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хангахын тулд гишүүн улс орнуудын институци ба улс төрийн асуудлуудыг шийдвэрлэх чиглэлд зоригтой алхам хийх хэрэгтэй байна. Тулгарсан асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээ аваагүй тохиолдолд байгалийн нөөцийн хомсдол, байгаль орчны доройтлоос ирээдүйд урьдчилан сэргийлэх боломжгүйн зэрэгцээ авлига, эзэн үйлчлүүлэгчийн таагүй харилцаа газар авч болзошгүй юм.

### **Оршил**

Зүүн өмнөд Азийн Орнуудын Холбоо (АСЕАН) нь Индонез, Лаос гэх мэт Зүүн өмнөд Азийн арван улс<sup>1</sup>-ыг нэгтгэсэн байгууллага юм. Засгийн газар хоорондын хамын ажиллагааг хөгжүүлэх зорилготойгоос гадна, гишүүн орнууд Азийн бусад улстай эдийн засаг, улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, боловсрол, нийгэм-соёлын интеграцийг дэмжихэд анхаарлаа хандуулдаг. Тус бүсийн байгаль орчны асуудал, ер нь Зүүн өмнөд Азийн байгаль орчны доройтол дэлхийн эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж буй үйлдвэржилтээс шалтгаалан үүсэж байгаа юм. Үйлдвэржилтэд нөлөөлж буй хүчин зүйлс нь улс төр, эдийн засгийн нөхцөл, хотжилт, хүн амын өсөлт,

---

1 Бруней, Малайз, Сингапур, Филиппин, Тайланд, Вьетнам, Индонез, Мянмар, Камбож, Лаос.

амьдралын хэв маягийн өөрчлөлт билээ (Nazeer and Furuoka, 2017, 74). Байгаль орчинд тулгарч буй сорилт гэдэгтээ устгал, мод бэлтгэл, агаарын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний нуруулт, загасны тоо толгой бууралт, халдварт өвчний тархалт, зэрлэг амьтдын хууль бус худалдаа, хууль бус ангуучлал, аюултай хог хаягдлыг задгай хаях зэрэг орж байна (Nazeer and Furuoka, 2017, 75; Chang and Rajan, 2001, 62; Koh, 2012). Энэ бүс нутаг “илүү бохир, экологийн төрөл зүйлийн тоог бууруулсан, байгаль орчныг илүү эмзэг болгох” үйл ажиллагаанд шилжжээ (ADB 1997, 199). Уур амьсгалын өөрчлөлт Зүүн өмнөд Азид эрчимтэй явагдаж, үер, ган гачиг тохиолдох нь ихэссэн байна.

Бүсийн хамтын ажиллагааны байгууллагууд бүсийн болон дэлхийг хамарсан байгаль орчны асуудалтай тулгарч, хариу арга хэмжээ авах шаардлагатай болоод байна. Эхлээд нэг улсын асуудал мэт байсан байгаль орчны сорилт удалгүй бүсийн хэмжээний асуудал болж хувирах нь түгээмэл үзэгдэл болжээ. Ялангуяа, усны асуудалд анхаарал тавих шаардлагатай бөгөөд энэ нь усыг орлох зүйл байхгүй; тив дамнасан худалдааны хэлэлцээр гэх мэт аргаар усыг хангалттай хэмжээгээр нөөцөлж хадгалах боломжгүй; эцэст нь гидрологийн тогтолцоо нь харилцан уялдаатай байдаг тул нэг улс орны усны менежментийн үйл ажиллагаа нь хөрш орнуудын ашиг сонирхолд шууд нөлөөлж байдаг (Hsing, 2011, 299). Цэнгэг ус нь эрчим хүч ба хүнсний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн хөгжил, тээвэр, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг байгаль орчин болон нийгмийн үйл ажиллагааны тулгуур хүчин зүйл боловч цэнгэг усны нөөц бүс нутаг, тэр ч байтугай нэг улс дотор ч тэгш бус байдаг (Gleick, 1993; Frey, 1993). Тухайлбал, хил дамнасан усны харилцаа ярвигтай бөгөөд сав газар бүрт өөр өөр байна. Учир нь усны нөөцийн байршил, газар нутаг, байгууллагуудын дэд бүтэц газар бүр ялгаатай билээ (Zeitoun and Allan, 2008, 11).

Ус эзэмших өрсөлдөөн, улс дамнасан голуудаас болж зөрчигддөг нутаг дэвсгэрийн бүрэн эрхт байдлын үзэл баримтлалаас үүдэн цэвэр усны нөөцийн төлөө улс хоорондын болон улс доторх зөрчилдөөн нь эрдэмтэд, улс төрчдийн хувьд сонирхолтой сорилт үүсгэдэг. Агаар, агаарын бохирдол нь устай адилхан бас улсын уламжлалт хилийг давдаг бөгөөд тухайн үндэстний хүн ам, ашиг сонирхолд төдийгүй түүнтэй хөрш орнуудад нөлөөлж, хил дамнасан адил төстэй бэрхшээл сорилтыг буй болгоно.

Хүйтэн дайны дараа аюулгүй байдлын үзэл баримтлал илүү явцуу хүрээтэй, бүс нутагт төвлөрсөн шинжтэй болсон тул хил залгаа үндэстнүүдэд тулгарах аюул заналхийлэл, тэдгээр улсын хамтын ажиллагаанд түлхүү анхаарч байна. Бүс нутагт төвлөрөх энэхүү хандлага 1990-ээд оноос эхэлсэн бөгөөд дэлхийн даяарчлагдах үйл явц, улс орнуудын хамтын ажиллагаа бүсийн түвшинд илүү нягт явагдах болсон зэргээс шалтгаалсан гэж Йенс-Уве Вүндерлих (Jens-Uwe Wunderlich, 2007, 2) үзжээ. Энэ санааг Барри Бузан (Barry Buzan, 1994, 94–95)

дэмжсэн бөгөөд тэрээр Хүйтэн дайны буюу хоёр туйлт систем задран унаснаар төвлөрөл саарч, олон улсын аюулгүй байдлын тогтолцоо бүс нутгийн түвшинд шилжсэн хэмээн үзсэн байна. Тийм учраас, дэлхий даяарчлагдах үйл явцын нөлөөгөөр бүс нутгийн аюулгүй байдлын үзэл баримтлал хүчээ авч, эдүгээ ус, агаарын нөөцийн менежментийн онол, бодлогод чухал үүрэг гүйцэтгэж байна (Beeson and Berger, 2003, 40).

Түүнчлэн, ардчиллын талаар судалгаа хийдэг эрдэмтэд дэлхий даяар, түүний дотор Зүүн өмнөд Азид ардчилал буурч байгаад сэтгэл зовниж байна. Родриго Дутерте Филиппиний ерөнхийлөгчөөр сонгогдсоноос авхуулаад Камбож, Вьетнам, Ардын Ардчилсан Лаосын<sup>2</sup> Бүгд Найрамдах Улс мэт зэргэлдээ улсад сөрөг хүчнийг нухчин дарсан олон жишээнээс харахад, Зүүн өмнөд Азийн бүс нутагт авторитари эрх баригчид улс орнуудыг удирдаж байна. Бүсэд тулгарч буй байгаль орчны асуудлыг энэхүү шинэ нөхцөл байдалтай уялдуулахын тулд, энэ бүлэгт судалгааны хоёр асуудлыг дэвшүүлж байна. Үүнд: Байгалийн нөөцийн менежментийн чиглэлээр Зүүн өмнөд Азид тулгарч буй томоохон сорилт, бэрхшээл юу вэ? Эдгээр сорилт, бэрхшээл улс үндэстний болон бүс нутгийн түвшинд ямар үр нөлөө үзүүлэх вэ?

Судалгааны гол үр дүнгээс харахад Зүүн өмнөд Азийн байгалийн нөөцийн менежментэд олон саад бэрхшээл тулгарч байгаагаас, ялангуяа, улс орнуудын түвшинд тухайн орны улс төрийн дэглэмтэй холбоотойгоор эзэн-үйлчлүүлэгчийн харилцаа, авлига, төрийн агентлагуудын хүч тэнцвэргүй байдал, байгаль орчныг эрүүл хадгалахад гарах зардлыг хуваарилдаггүй зэрэг нь хамгийн том бэрхшээл болж байна. Цаашлаад, АСЕАН-ы түвшинд гарсан санал, санаачилгыг гишүүн улсын үндэстний бодлогод тусгагдах байдал хангалтгүй, хэрэгжилт тааруу байгаа нь Зүүн өмнөд Азийн байгаль орчин, байгалийн нөөцийн доройтолд хүргэж байна. Энэ байдал бидний авч үзсэн Лаос, Индонез улсын жишээнээс ил харагдаж байгаа бөгөөд улс үндэстний болон бүсийн гэсэн засаглалын хоёр түвшин хоёулаа адил чухал бөгөөд энэ хоёр түвшний хамтын ажиллагаа, зохицуулалтад анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Улс төрийн эрх мэдэл, авлига, институцийн чадавх гэх мэт дутагдлуудыг авч үзэхийн өмнө бүс нутгийн байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэхэд АСЕАН-ы гүйцэтгэх үүргийг тодорхойлох шаардлагатай. Индонез, Лаосыг жишээ болгон сонгож ногоон ойн сүйтгэл гэх мэт Индонезид авч буй арга хэмжээ зөвхөн энэ улсад төдийгүй бүс нутгийн хэмжээнд утааны бохирдлыг үүсгэж буй жишээг авч үзлээ. Лаос улсын хувьд, Доод Меконг дэх анхны том далан болох Заябуриг судалсан ба тухайн улсын улс төрийн дэглэм хил залгаа улсуудад усны нөөцийн менежментэд зарим бэрхшээл учруулж байгаа асуудлыг авч үзнэ.

---

2 Цаашид Лаос гэнэ.

## Судалгааны арга хандлага, арга зүй

Энэ судалгааны зорилго нь Зүүн өмнөд Азийн байгалийн нөөцийн менежментийг ардчилал ба авлигын асуудалтай уялдуулж судлах бөгөөд Индонез, Лаос улсыг жишээ болгон авлаа. Судалгаанд улс төрийн шинжлэх ухааны арга зүйг ашигласан бөгөөд засаглалын янз бүрийн түвшинд эрх мэдэл, нөлөөлөл хэрхэн хуваарилагдсан, эрх мэдэлд хүрч буй хувь хүн, бүлгүүдийн ашиг сонирхлыг тодорхойлоход анхаарлаа.

Энэ судалгаа нь Меконг мужид өмнө хийгдсэн судалгаанд тулгуурласан бөгөөд ашигласан арга зүйд хагас бүтэцлэгдсэн ярилцлага, кейс судалгаа, харьцуулсан дүн шинжилгээ гэх мэт олон аргыг ашигласан. Судалгаанд ашигласан ярилцлагын дийлэнхийг 2013 оны 1-6 дугаар сарын хооронд ААБНЛаос Улсын нийслэл Вентиан гэх мэт газрыг оролцуулан Меконг мужид хийсэн бөгөөд засгийн газрын агентлаг, бус, олон улсын байгууллага, мөн олон улсын ТББ, орон нутгийн сүлжээнд харьяалагдах 20 гаруй хүнийг хамруулсан ярилцлагыг 2017 оны сүүлээр хийсэн. Индонезийн кейс судалгаа нь баримт бичгийн судалгаанд суурилсан бөгөөд Сингапур, Пномпеньд зохиогдсон бүсийн төрөл бүрийн зөвлөгөөнд оролцсон Индонезийн мэргэжилтэн, эрдэмтэдтэй фокус бүлгийн ярилцлага хийж дийлэнх мэдээллийг цуглуулсан болно. Бичиг баримтын судалгаа, ярилцлагын сийрүүлж бичсэн мэдээллийг нэгтгэхэд NVIVO программ хангамжийг ашиглав. Ингэснээр бүх эх, ярилцлагыг урган гарч буй сэдвийн дагуу кодлох, задлан шинжилж багцлах замаар дүгнэлтүүдийн ижил төстэй байдал, ялгаа, хоорондын харилцаа хамаарлыг харуулах боломжтой болсон юм.

## Бүс нутгийн байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд АСЕАН-ы гүйцэтгэх үүрэг

Зүүн өмнөд Азийн орнууд олон жилийн турш байгаль орчны янз бүрийн асуудалтай тулгарч байгаагийн дотор ногоон ойн устгал, мод бэлтгэл, уур амьсгалын өөрчлөлт, хөрсний гулсалт, хэт их загасчилснаар загасны төрөл зүйл, тоо толгой багасах, халдварт өвчний тархалтын аюул, зэрлэг ан амьтны хууль бус худалдаа, аюултай хог хаягдлыг ил задгай хаях зэрэг томоохон бэрхшээлийг дурдаж болно. Гишүүн орнуудын байгаль орчны хамтын ажиллагааг дэмжих зорилгоор 1978 онд АСЕАН-ы шинжээчдийн бүлгийг байгуулсан байна (Sunchindah, 2002). АСЕАН-ы байгаль орчны хамтын ажиллагааг гурван ерөнхий үе шатад хувааж болно. Эхний үе шатад, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, гэрээ хэлэлцээр байгуулах гэх мэт албан бус, тунхгийн шинж чанартай олон мэдэгдэл гаргаж байсан бол дараагийн шатад байгаль орчныг хамгаалах үйлс, хамтын хариу үйлдэл, олон нийтийн эрх ашигт төвлөрөх болжээ. Байгаль орчны сайд нарын бага хурал, АСЕАН-ы Ажлын алба



гэх мэт байгууллагыг байгуулж үйл ажиллагааг нь дэмжих болсон байна (Elliott, 2003). Эхэн үед биологийн төрөл зүйлийн тоо ширхгийг олноор хадгалах, газар тариалан эрхлэх зорилгоор ногоон ойг шатааж газрыг нь чөлөөлснөөр агаарын бохирдол нэмэгдэж утаа униарыг хянах шаардлагатай болсон гэх мэт байгаль орчны хамтын нөөцийн менежментийн асуудал анхаарал татаж байжээ (Koh and Robinson, 2002).

Энэ бүлэгт бүс нутгийн байгаль орчны хоёр асуудлыг авч үзэх бөгөөд эдгээр нь усны менежмент, агаарын бохирдол юм. Усны менежмент, агаарын бохирдлын аль аль нь, нэг тал хэмжээгүй ихээр ашигласнаар нөгөө талынхаа ашиглах боломжийг бууруулдаг нийтийн эзэмшлийн асуудалд багтах юм. Мөн нэг улсын нутаг дэвсгэрээс нөгөө улс руу хил хязгаар харгалзахгүй урсах гол мөрөн, салхинд туугдах агаарын бохирдол тухайн улс орны нутаг дэвсгэрийн бие даасан байдал ямар ч хамаагүй бөгөөд хил залгаа улс орнуудын нийтлэг сорилт бэрхшээл болж байна.

Зүүн өмнөд Азид утаанаас үүдэлтэй агаарын бохирдол жил бүр тохиолдож, 1997-1998 онд хамгийн дээд түвшинд хүрч байжээ. Энэ бүсэд, ялангуяа Индонезид томоохон хэмжээний ой, газрын түймэр байнга гардаг бөгөөд энэ нь АСЕАН-ы бүсийн улс орнууд, түүний дотор Индонез, Малайз, Сингапурт утаа, агаарын бохирдлыг үүсгэдэг байна. Аянга цахилгаан гэх мэт байгалийн үзэгдлийн улмаас түймэр гарах тохиолдол бий боловч, Индонезийн түймэр ихэнхдээ хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэдгийг баталсан хөдөлшгүй нотолгоо байдаг (Tan, 2005; Chang and Rajan, 2001, 662). Эдүгээ Индонез улс дэлхийн дал модны тосны хамгийн том үйлдвэрлэгч (Workman, 2017) бөгөөд энэхүү үнэ цэнтэй модыг бэлтгэсний дараа талбайг нь газар тариалан эрхлэх зорилгоор цэвэрлэж чөлөөлөх хамгийн хялбар бөгөөд хямд арга нь өсөлт муутай давжаа мод, үртэс хог хаягдлыг шатаах явдал юм.

Бүсийн хэмжээний утааны бохирдлын асуудлыг шийдвэрлэхийн тулд, АСЕАН-ы гишүүн орнууд 2002 онд Куала Лумпурт “Хил залгаа улс орнуудын утааны бохирдлын тухай АСЕАН-ы гэрээ” хэмээх бүс нутгийн түүхэн баримт бичигт гарын үсэг зуржээ. Бүсийн улс орнууд хамтарч ажилласнаар бохирдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилготой энэ санал зөвхөн бүсэд төдийгүй, дэлхийн хэмжээнд анхдагч байсан юм. Мөн АСЕАН-ы төлөөлөгчдийн үзэж байгаагаар утааны бохирдлын тухай яриа хэлэлцээр нь гишүүн орнуудын үзэл бодлын зөрүүтэй байдлыг анх удаагаа даван туулж шийдвэрлэж чаджээ (Singh, 2008). Гэхдээ хэлэлцээрийн баримт бичигт хоёр үндсэн дутагдал бий. Нэгт, утааны бохирдлыг үүсгэгч гол орон Индонез 2015 он хүртэл гэрээнд нэгдэж ороогүй. Хоёрт, гэрээ маргааныг шийдвэрлэх, гэрээг зөрчсөнөөр ямар торгууль шийтгэл оногдуулах тал дээр сул, тодорхойгүй зүйл заалттай байна (Nazeer and Furuoka, 2017, 76).

Усны хэрэглээний асуудлыг судлахын тулд Меконг голыг жишээ болгон ашиглах нь түгээмэл байна. Энэ гол зургаан улсыг (Хятад, Мянмар, Лаос, Тайланд, Камбож, Вьетнам) дамжин урсдаг бөгөөд эдгээрийн тав

нь АСЕАН-ы гишүүн орон юм. АСЕАН-ы бүс нутаг ерөнхийдөө хангалттай их усны нөөцтэй боловч зарим улс оронд улирлын чанартай хомсдол үүсдэг ба хүн амын өсөлт, аж үйлдвэрлэл, газар тариалангийн эрчимтэй хөгжил зэргээс шалтгаалан цэнгэг усны хэрэгцээ ихээхэн нэмэгдэж байна. Меконг мөрөн нь Төвөдийн өндөрлөгөөс эх авч Өмнөд Хятадын тэнгист цутгахаас өмнө нийт 4900 км орчим урсдаг, дэлхийд наймдугаарт бичигддэг,<sup>3</sup> Зүүн өмнөд Азийн хамгийн том мөрөн юм. Тэр ч утгаараа ихээхэн эдийн засаг, экологийн нөөцийг агуулж байдаг, эргийн дагуу орших зургаан улсын хувьд улс төрийн томоохон ач холбогдолтой мөрөн юм (Osborne, 2000; Goh, 2006). Ази-Номхон далайн бүсэд Меконгийн дэд бүс чухал байрыг эзэлдэг бөгөөд энэ нь тус мөрний ай сав газарт 70 сая гаруй хүн амьдарч байгаа, чухал ач холбогдол бүхий экологийн тогтолцоонд өргөн цар хүрээтэй, өвөрмөц экологийн төрөл зүйлийг агуулж байгаатай холбоотой юм). Одоо АСЕАН-ы усны менежментийн асуудлыг АСЕАН-ы Байгаль орчны хамтын ажиллагааны баримт бичгийн дагуу зохицуулж байна. Цэнгэг усыг эрх тэгш хуваарилах, чанарын шаардлага хангасан усыг хүртээмжтэй байлгах зорилгоор, усны нөөцийн нэгдсэн менежментийг хангах чиглэлээр АСЕАН-ы Нийгэм-соёлын хамтын нийгэмлэгийн төлөвлөгөөний дагуу хамтын ажиллагааг явуулж байна. АСЕАН цэнгэг усны нөөцийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч “Усны нөөцийн асуудлаарх АСЕАН-ы ажлын хэсэг”-ийг 2002 онд байгуулжээ. АСЕАН-ы гишүүн орнуудын байгаль орчны сайд нар 2003 онд АСЕАН-ы “Усны нөөцийн менежментийн урт хугацааны стратегийн төлөвлөгөө”-г баталсны дараагаар усны нөөцийн тогтвортой байдлыг хангах, эрх тэгш хүртээмжтэй, баталгаат чанартай, хангалттай хэмжээний усан хангамжийг баталгаажуулах зорилготой “АСЕАН-ы Усны нөөцийн менежментийн стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г АСЕАН-аас 2005 онд баталсан юм (ASEAN, 2005)

### **Бүс нутгийн байгаль орчны засаглалыг хэрэгжүүлэхэд тулгарч буй гол сорилт: Улс төрийн эрх мэдэл, авлига, институцийн сул хөгжил**

АСЕАН-ы бүсэд тулгарч буй байгаль орчны асуудал гишүүн орнуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй, гарсан шийдвэрийг тулгахгүй гэсэн тус байгууллагын зарчим, соёлтой ихээхэн хамаатай. Мөн АСЕАН-ы түвшинд гарсан санал санаачилгыг үндэсний бодлого, хөтөлбөрүүдэд оруулах, хэрэгжилтийг хангах арга механизм бүсийн хэмжээнд байхгүй

---

3 Энэ асуудал маргаантай бөгөөд голыг ямар аргаар хэмжсэнээс хамаарна. Уг аргуудад голын жилийн дундаж урсац, голын уртыг хэмжих орно. Арга, асуудлыг Кампбел (2009)–ээс нарийвчлан үзнэ үү.

байгаа нь асуудлыг хүндрүүлж байна (Koh and Robinson, 2002). Хэдийгээр АСЕАН нь Меконгийн дэд бүсийн дээвэр байгууллага боловч, байгаль орчны чиглэлээрх журам, удирдамжийн хэрэгжилт удаан, хяналт мониторинг хангалтгүй зэргээс шалтгаалан дэд бүсийн нөхцөл байдалд хүчтэй нөлөө үзүүлж чадахгүй байна. Үүнээс гадна, АСЕАН-ыг үүсгэн байгуулсан шалтгаан нь бүсийн худалдааны асуудал бөгөөд үүнтэй холбоотой улс орнуудын эрх ашиг, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын маргаан давамгайлсан хэвээр байна. Тийм ч учраас, АСЕАН асуудалд төвлөрөх боломжгүй сул байгууллага болоод байгаа бөгөөд энэ байдлаа ч засах сонирхолгүй байна. Байгаль орчны стандарт, удирдамжид онцгой анхаарч, түүний дотор Усны суурь удирдамжийн хэрэгжилтийг гишүүн орнууддаа үүрэг болгодог Европын Холбоо зэрэг байгууллагатай харьцуулахад энэ байдал нь өдөр шөнө шиг ялгаатай байна (Haefner, 2016).

Гэхдээ байгаль орчны тулгамдсан хоёр асуудлыг ойлгохын тулд гол тоглогч нар хэн бэ, бүсийн түвшин төдийгүй, үндэсний түвшинд тэдний шийдвэрт нөлөөлөх ямар хүчин зүйлс байна вэ гэдгийг ойлгох нь чухал. Учир нь эдгээр хүчин зүйлс бүсийн болон үндэсний түвшинд бодлого, үйлдэл, хэрэгжилтийг тодорхойлно. Утааны бохирдлын тухайд ихээхэн хэмжээний газар ба ойн түймрийн голомт болж агаарын бохирдлын дийлэнх хувийг үүсгэж байгаагаараа Индонез голлох үүрэгтэй. Меконг мөрний усны хуваарилалт ба менежментийн тухайд, Лаос чухал үүргийг гүйцэтгэж байна. Далайд гарцгүй энэ орон усан цахилгаан станц, далан барих үйл ажиллагааг баталж хэрэгжүүлж байгаа төдийгүй Доод Меконгийн орнуудаас Меконг мөрөн дээр далан босгосон анхны орон болох юм.

### **Эзэн-үйлчлүүлэгчийн харилцаа**

Зүүн өмнөд Азид улс төр, эдийн засгийн хувьд хүчирхэг эзэд, тэднээс хараат үйлчлүүлэгч хоорондын харилцаа чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ бүсийн соёлын харилцааны амин сүнс нь болж байдаг. Ялангуяа, байгалийн нөөцийн менежментийн хувьд, энэ асуудал үнэхээр чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал, Индонезийн түймрийн утааны тухайд, 2013 онд утааны бохирдол ил гарч байх үед хиймэл дагуулын авсан зургаас харахад, Суматра арлын Риану захиргааны нэгжийн харьяа нутагт тариалангийн томоохон үйл ажиллагаа эрхэлдэг компанийн газар дээр түймэр асаж байсныг тогтоожээ. Гэвч тариалангийн компаниуд энэ дүгнэлтийг эрс үгүйсгэж, ойролцоох, жижиг хэмжээний газартай нутгийн тариаланчдыг буруутгасан байна (Tan, 2015). Мөн 1997-1998 онд Индонезид гарсан түймрийн дараагаар засгийн газар тариалан, мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг 176 компани, газар дахин олгох хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийг хууль бус түймэр тавьж байгаа эсэхийг шалгасан боловч институцийн чадавх муу, хээл хахуульд

автсанаас нэг ч хүн, байгууллагыг шийтгэж чадалгүй өнгөрчээ (Nazeer and Furuoka, 2017, 78). Ерөнхийдөө, Индонез гэх мэт оронд засгийн газрын ажилтнуудыг тариалан эрхэлдэг баян корпорациуд хахуульданд, үйлдсэн аливаа гэмт хэргээ нуун дарагдуулах боломжтой байдаг (Tan, 1999). Түүнчлэн, доройтсон газрыг авч дараа нь мөнгө олох, ашигтай тариалангийн талбай болгон хувиргадаг компаниуд нь цаана нэг ижил, эсвэл голдуу салбар буюу дэд компани байдаг (Tan, 2005, 654).

Ерөнхийдөө, Индонезийн газар, ойн газрыг ашиглахтай холбоотой бодлого нь байгаль орчны тогтвортой байдлыг хангахад бага анхаардаг бөгөөд улс төрийн хүчнээр хамгаалуулсан арилжааны сонирхлын бүлгүүд байгалийн нөөцийг их хэмжээгээр сүйтгэх явдлыг дэмжсэн байдалтай байна. Хэдийгээр үнэлгээний арга нь янз бүр, бодитой хэмжихэд хэцүү ч, судалгааны дүнгээс харахад, Ерөнхийлөгч Сухартогийн эрх барьсан 32 жилийн туршид Индонезийн ойн нөөцийн алдагдал дор хаяж 40 сая га-д хүрсэн ажээ (Tan, 2005). Газрын эзэн-үйлчлүүлэгчийн харилцаа өргөн дэлгэрсэн бөгөөд байгаль орчны салбар газар тариалангийн эзэд, тэдний ашиг сонирхлыг хамгаалагч улс төрчдөд шууд ашигтай олон тооны үйл ажиллагааг дэмжиж байх нь түгээмэл тохиолддог. Заримдаа тэтгэвэрт гарсан ахмад албан тушаалтнууд төрийн байгууллагад зуучлагчаар ажиллаж, компанийн нэрийн өмнөөс зөвлөгөө өгөх, зуучлах үйл ажиллагаа эрхэлж байна (Varkkey, 2013). Нөхцөл байдал ийм байгаа нь улс төрийн элитүүдийг бүс нутгийн болон дотоодын улс төр, эдийн засгийн хөгжил, үүнд байгалийн баялгийг борлуулах зах зээлийг хамгаалах арга хэмжээ авахаас өөр аргагүйд хүргэж байна (Nazeer and Furuoka, 2017, 81–82). Түүнчлэн эрх мэдэл бүхий улс төрийн олон нам эдгээр газар тариалангийн ашиг сонирхлын бүлгүүдтэй шууд холбоотой гэсэн үг юм. Варккигийн (Varkkey, 2014, 66) үзэж буйгаар, “АСЕАН маягийн хамтын ажиллагаанд оролцсоноор улс төрийн элитүүдэд АСЕАН-ы гаргасан санаачилгыг үйлчлүүлэгчийнхээ сонирхлыг хамгаалахад ашиглах боломжийг бүрдүүлсэн боловч олон нийт утааны хор уршгийг жилээс жилд амссаар байна” гэжээ.

Үүний зэрэгцээ Лаост одоо баригдаж буй Доод Меконгийн анхны далан, Заябури далангийн талаар мөн адилхан зүйлийг хэлж болно<sup>4</sup>. Далангийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг (БОНУ) Финляндын инженерингийн Пойри компани хийснийхээ дараа төслийн гол инженер болжээ. Бүсийн хэмжээнд баригдаж буй бусад усан цахилгаан станцын нэгэн адил, энэ жишээ нь “ашиг сонирхлын зөрчил”-ийг бий болгож байгаа бөгөөд энэ нь аль нэг компани тодорхой мэдэгдэл гаргаж төсөл баталснаар нийгэм, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс үл хамаарсан давуу талтай болно гэсэн үг юм. Цаашлаад, энэ нь ашиг сонирхлын харилцаан дээр үндэслэн хувийн компаниуд, шийдвэр гаргагч нарын хоорондын уялдаа холбоо, тэдэнд ирэх шууд ашиг хонжоог харуулж байна.

---

4 Заябури далангийн тухай (Haefner 2017a, Haefner 2017b)–аас илүү тодорхой мэдэж болно.

**Засгийн газар дахь тэнцвэргүй байдал, улс төрийн хүсэл зоригийн хомсдол**

Байгаль орчны засаглалд хамаарах өөр нэг томоохон сорилт нь засгийн газрын бүтэц, бие даасан яамдын эрх мэдлийн тэнцвэргүй байдал бөгөөд энэ асуудал салбар, захиргааны түвшин харгалзахгүй түгээмэл байна. Засгийн газрын байгууллагууд ижил байр суурьтай байдаггүй, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх олон хүчин зүйл байдаг байна. 2015 он хүртэл Индонезийг төлөөлж утааны эсрэг хэлэлцээрт Байгаль орчны яам, Ойн аж ахуйн яам хоёр оролцож байсан бөгөөд энэ хоёр яамны чиг үүрэг өөр өөр байсан юм. Байгаль орчны яам гэрээ хэлэлцээрт байгаль орчныг хамгаалах байр суурьтай оролцож, гэрээг парламентаар батлуулахыг оролдож байв. Харамсалтай нь, парламентад шилжсэний дараагаар гэрээг батлах асуудал гацаж, хэлэлцэгдэхгүй олон жил дарагдсан байна. Ингэж гацаахад Ойн аж ахуйн яам томоохон үүргийг гүйцэтгэсэн бөгөөд энэ нь тус яам ойн салбарын томоохон тоглогчидтой нягт холбоотой байж, тэдний “ашиг сонирхлыг хамгаалахыг” оролдсонтой холбоотой юм. Бусад яамтай харьцуулахад энэ яам дээд зэргийн боловсон хүчин, эрх мэдэл, төсвийн хөрөнгөтэй бөгөөд хувийн аж ахуйн нэгжүүдэд ойн бизнесийн лицензийг олгохдоо ихээхэн нугалаа гаргахад үүрэг гүйцэтгэдэг ажээ (Tan, 2005). Нитрагуул (Nguntrago, 2011), Сяриф (Syarif, 2010) нарын үзэж байгаагаар, Байгаль орчны яам нь Индонезийн засгийн газрын жижиг яамны нэг бөгөөд бусад яамд, төрийн байгууллагад хууль хэрэгжүүлэх шаардлага тавих, удирдамжийн биелэлтийг шаардах эрхгүй ажээ. Хоёр яам 2015 онд нэгдэн, байгаль орчин, ойн яам болсон байна. Хөдөө аж ахуй судлалын эрдэмтэн Ноер Фаузи Рачман [өмнөх захиргаанаас ажилтан шилжүүлэх тухай ярихдаа] “энэ бол өөрчлөлтийн шинж биш” гэжээ (Saturti, 2015). Гэсэн хэдий ч ингэж нэгтгэснээр тулгарч буй асуудлуудыг эергээр шийдвэрлэх үү, үгүй юу гэдгийг хэлэхэд эрт байна.

Салбарт тулгарч буй бэрхшээлээс гадна үндэстний, дүүргийн, орон нутгийн зэрэг засаглалын бүх түвшинд институцийн чадавх сул байгаа нь хамгийн том саад тотгор болж байгаа юм. Назир, Фүруока нарын үзэж байгаагаар (Nazeer and Furuoka, 2017, 77) “орон нутгийн болон үндэсний түвшний аль алинд нь төрийн захиргаа, засаглалын стандартыг хангалттай хэрэгжүүлдэггүй байсан, одоо ч тэр хэвээр байгаа нь Индонезид хамгийн том саад бэрхшээл болж байна” гэжээ. Байгаль орчны засаглал, газар эзэмшил, ойн менежмент, гал түймэр, утааны бохирдолтой тэмцэхийн тулд төвлөрлийг сааруулж, институцийн чадавхыг нэмэгдүүлэх зэрэгт ахиц гарахгүй байгаа нь үүнтэй холбоотой (Tan, 2005). Төрийн янз бүрийн байгууллагаас гадна лобби бүлгүүд гэрээ хэлэлцэх асуудалд саад учруулж байна. Ялангуяа Индонезийн Дал модны тосны холбоо, Индонезийн Дал модны тосыг тогтвортой аргаар гаргах комисс нь өөрсдийн хувийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд парламентын гишүүдэд байнга нөлөөлдөг (Nazeer and Furuoka, 2017).

Үндэсний хууль тогтоомжууд байгаа боловч хэрэгжилт, дагаж мөрдөх байдал хангалтгүй байгаа нь эргээд институцийн чадавх сул байгаатай холбоотой (Nazeer and Furuoka, 2017, 77). Үндэсний түвшинд

ийм байлаа гэхэд АСЕАН-ий түвшинд ч Утааны бохирдлын эсрэг гэрээг дагаж мөрдөх, гэрээг зөрчсөн гишүүдийг торгох, шийтгэх тогтолцоо сул байгаа нь АСЕАН-ы гишүүн орнуудын дотоод хэрэгт оролцохгүй байх, зөвшилцөх зарчимтай холбоотой юм. Гэсэн хэдий ч, гэрээг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл байгаагүй нь тодорхой бөгөөд үүнийг Индонези улс 12 жилийн турш Утааны бохирдлын эсрэг гэрээнд нэгдэж ороогүй жишээнээс харж болно. Нэмж хэлэхэд, орон нутгийн түвшинд түймрээс сэргийлэх, тэмцэх чадавх, арга хэрэгсэл байдаггүй тул хуулийг хэрэгжүүлэх, сахиулах ажиллагаа хүндрэлтэй.

Лаосын усан цахилгаан станцын хөгжлийн тухайд бол төрийн яамдын эрх мэдлийн тэнцвэргүй байдал бас л тодорхой харагдаж байна. Тухайлбал, харьцангуй шинээр байгуулагдсан Байгалийн нөөц, орчны яаманд үндэстний, дүүргийн болон орон нутгийн түвшинд ажиллах чадавх дутмаг байна. Гэтэл Эрчим хүч, уул уурхайн яам нь усан цахилгаан станц барих асуудлаар Лаосын засгийн газрыг үндэсний болон олон улсын түвшинд төлөөлөн удирдах чадвартай маш хүчирхэг яам юм<sup>5</sup>. Усан цахилгаан станцын төслийн хувьд, саяхан хүртэл уг салбарыг Лаосын Эрчим хүч, уул уурхайн дэд сайд Вирапонг Виравонг ахалж байсан бөгөөд тэрээр усан цахилгаан станцыг цэвэр, хямд, сэргээгдэх эрчим хүчний нөөц гэж үздэг. Цааш нь дурдахдаа, “Усан цахилгаан станц Лаосын байгалийн нөөц баялгийн 33 хувийг бүрдүүлдэг. Хэрэв Лаос 2020 он гэхэд буурай хөгжилтэй улсын ангиллаас гарахыг хүсэж байгаа бол, энэ бол бидний цорын ганц сонголт юм” гэжээ (Varchol, 2012).

## **Байгаль орчныг хамгаалахад гарах зардлыг тооцохгүй байх нь**

Байгаль орчны асуудал, үр нөлөөг хэлэлцэх үед гарах чухал асуудал бол экосистемийг эрүүл хадгалж үлдэхэд гарах зардал өртгийг тооцохгүй байх явдал юм. Жишээлбэл, зардал-үр ашгийн тооцоо, эсвэл дэд бүтцийн шинэ төслийн нөлөөллийн үнэлгээ хийхэд агаарыг цэвэр, эрүүл байлгахад гарах зардлыг оруулах ёстой. Утаа униар аль хэдийн эдийн засгийн хохирол учруулаад эхэлсэн бөгөөд ирээдүйд бүр ч их учруулах болно. Индонезийн гал түймэр ойролцоогоор 10 сая га ой, ногоон бүсийг сүйтгэж АСЕАН-ы орнуудад ойролцоогоор 300 сая хүн амд нөлөөлсөн байна (Abberger, 2003). Гал түймрээс гарсан хохирлыг хэзээ ч бүрэн тооцож чадахгүй ч, “зөвхөн” 1997 оны гал түймрийн улмаас олон улсын хэмжээнд 4.5–9.3 тэрбум ам.долларын хохирол учирсан гэдэг (Tan, 2005). Эдийн

---

5      Хувийн ярилцлага, 2013 оны 5 дугаар сар, Вьентиан, Лаос.

засгийн хохирлыг тооцохдоо авч үзсэн хүчин зүйлс нь гол төлөв сүйдсэн ургац, мод, аялал жуулчлал, гадаадын хөрөнгө оруулалт буурсан, эрүүл мэндийн үйлчилгээний зардал нэмэгдсэн бөгөөд зөвхөн эрүүл мэндийн зардал 164 сая ам.долларт хүрсэн гэж тооцож байна (Nazeer and Furuoka, 2017, 79)<sup>6</sup>. Цаашилбал, Индонезийн ойн түймрийг хянахад ойролцоогоор 1.2 тэрбум ам.долларын зардал гарахаар байна (Nazeer and Furuoka, 2017, 79). Ерөнхийдөө, Эллиотын хэлснээр (Elliot, 2003) “Индонезийн хамгийн гол асуудал бол байгаль орчныг хамгаалахаас байгалийн баялаг (газар, ой) -аас олох эдийн засгийн ашиг илүү чухал байгаад оршино.”

Үүнтэй төстэй Меконг бүс нутагт эдийн засгийн ашиг сонирхол тэргүүн байранд орох бөгөөд үндэсний эдийн засгийн өсөлтийг хангахын тулд голын сав газрын нөөцийг ашиглах хэрэгтэй гэж мөрний дагуу орших улс орнууд үздэг нь түгээмэл байна (Goh, 2004, 7). Лаосын Эрчим хүч, уул уурхайн хуучин дэд сайдын олонтоо хэлснээр, усан цахилгаан станц нь цэвэр, хямд, сэргээгдэх эрчим хүч учраас чухал ажээ. Лаосын засгийн газрын үзэж байгаагаар, Заябури даланг ашигласны төлбөр, татвараас жилдээ нийт 130 сая ам.долларын ашиг авчрах төлөвтэй ажээ<sup>7</sup>. Тэглээ ч байгаль орчин, нийгмийн үр нөлөөллийн зардал байхгүй, эсвэл засгийн газрын зүгээс түүнийг зардал-үр ашгийн дүн шинжилгээнд ашигладаггүй байна.

Заябури далан ашиглалтад орсноор ойр хавийн орчны биологийн олон төрөлт байдлын алдагдал, экосистемийн өөрчлөлт, загасны тоо төрлийн хорогдол гарна гэсэн тооцоолол байна. Ихээхэн маргаантай асуудал бол Заябури Далангийн анхны төслөөр санал болгож тавьсан загасны урхи ашиглах явдал юм. Меконгийн загас төрөл зүйлээр баялаг, янз бүрийн урттай, олон тооны загастай, мөн далангийн өндөр зэргээс шалтгаалан загасны урхийг ашиглах боломжгүй хэмээн мэргэжилтнүүд үзсэн байна (Orr et al., 2012). Төслийн дагуу 2100 орчим хүнийг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд голын эрэг орчим далангийн ойролцоо амьдардаг 202,000 гаруй хүн хөдөө аж ахуйн газраас гадна алт угаах, ойн бүтээгдэхүүнд хүрэлцэх боломжоо алдахад ашиг орлого болон хүнсний аюулгүй байдал нь хөндөгдөх төлөвтэй байна (International Rivers, 2011). Загасны аж ахуйд оруулж буй хувь нэмрээс гадна, голоос хамааралтай хөдөө аж ахуйн салбар, тухайлбал, цагаан будаа тариалангийн өсөлтөд 4.6 тэрбум ам.доллар, голын эрэг дэх цэцэрлэгт жил бүр 574 сая ам.долларыг тус тус зарцуулж байна (International Rivers, 2011). Биологийн төрөл зүйл, загасны нөөц, хүнсний аюулгүй байдалд

---

6 1997 онд Индонез, Малайз, Сингапурт гарсан ойн түймрийн өртөг зардлын талаар Чанг, Ражан (2001, 663.) нараас нарийвчлан үзнэ үү.

7 Хувийн ярилцлага, 2013 оны 6 дугаар сар, Вьентиан, Лаос.

үзүүлэх нөлөөллөөс гадна, санал болгож буй далангийн өөр нэг асуудал нь “эрүүл” Меконг голын одоо байгаа орлогын бодит зардлыг тооцоогүй, нийгэм, байгаль орчны хохирол, мөн нөлөөллийг бууруулах, нөхөн төлбөр хийхэд шаардагдах мөнгө ямар ч тооцоонд ороогүй байна. Энэ нь бодит зардал тодорхойгүй бөгөөд түүнийг далангийн хөрөнгө оруулалтаар бий болсон орлоготой харьцуулан үнэлж болохгүй гэсэн үг юм. Өөр нэг гол асуудал гэвэл, зардал ба үр өгөөж нь зөвхөн Лаосын хүмүүсийн хооронд төдийгүй, Доод Меконгийн эрэг орчмын орнуудын дунд тэгш бус хуваарилагддаг ажээ (Kuenzer et al., 2012). Тийнхүү Лаосын гол ашиг хүртэгч нь элит, улс төрчид, хувийн компаниуд байна. Харин загасны нөөц дундрах, хөдөө аж ахуйн бүтээмж буурах, нүүлгэн шилжүүлэлтийн хүндрэл зэргээс болж орон нутгийн түвшинд орлого багассанаар тэнд дарамт ачаалал үүсдэг ажээ.

## Дүгнэлт

Бүс нутгийн байгууллагууд улам илүү бэрхшээлтэй тулгарч, хил дамнасан болон дэлхий нийтийн байгаль орчны асуудалд хариулт өгөх шаардлагатай болж байна. Үндэсний хэмжээний мэтээр эхэлдэг хүрээлэн буй орчны асуудал нь төдөлгүй хил дамнасан шинжтэй болдог байна. Тухайлбал, Меконг гол дээр усан цахилгаан станц барих одоогийн томоохон төслүүдийн давалгаа нь үндэсний хил дамжин усан хангамж, хүнсний аюулгүй байдалд нөлөөлж байна. Тийнхүү, хил дамнасан агаарын бохирдол Зүүн өмнөд Азид бараг жил бүр тохиолддог. Индонезид хүлэр ба ойн түймрээс голдуу утаа үүсэж, түүний уршгаас Малайз, Сингапур улсууд хамгийн их хохирол амсдаг байна.

Засаглалын янз бүрийн түвшин, мөн эрх мэдлийг эрхэмлэгч хувь хүн, бүлгүүдийн хүрээнд эрх мэдэл, нөлөөг хэрхэн хуваарилж хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулан, хэдийгээр хил дамнасан усны менежментийн хэлэлцээргүй АСЕАН-ны түвшинд манантай утаанаас үүдэлтэй агаарын бохирдлыг зохицуулах бүс нутгийн хэлэлцээр байгаа боловч энэ хоёр асуудлын гол бэрхшээл нь Индонез, Лаос хоёр оронд хийсэн түүвэр судалгааны үр дүнтэй адил шинжтэй байгааг энэ бүлэгт өгүүлсэн. Энэ хоёр тохиолдолд дараах бэрхшээлүүд байна. Үүнд: эзэн-үйлчлүүлэгчийн таагүй харилцаа; төрийн байгууллагуудын тэнцвэргүй байдал; улс төрийн хүсэл зориг дутагдах; эрүүл орчныг бүрдүүлэх зардлыг харгалзан үздэггүй зэрэг байна. Судалгааны гол үр дүнг дурдвал, Доод Меконгийн эрэг хавийн улсуудад эдийн засгийн ашиг сонирхол давамгайлж байхад Лаос болон бусад орнууд хамтын ажиллагаагаа голын урсгал дагасан хөгжлийн хил дамнасан сөрөг нөлөөллийг зөвлөлдөн зохицуулахаас илүүтэйгээр дэд бүтцийн хөгжлөөр хязгаарлах хандлагатай ажээ. Түүнчлэн, утаа манангийн бүс нутгийн шинж чанараас шалтгаалан, утаа манан сааруулах үйл ажиллагааг АСЕАН-ы түвшинд



төвлөрүүлсэн хэдий ч, эдгээр санаачилга нь утааг үр дүнтэй багасгаж чадахгүй байна.

Ерөнхийдөө, энэ бүлэгт өгүүлснээр эдгээр бүтэлгүйтэл нь үндэстний тусгаар тогтнолын бүрэн бүтэн байдлыг бүс нутгийн хамтын сонирхлоос илүүд үздэг АСЕАН-ы бүсийн оролцооны хэв маягаас шалтгаалдаг байна. АСЕАН-д тулгарч буй байгаль орчны зарим сорилт нь түүний соёл, хөндлөнгөөс оролцож шийдвэр гаргахгүй байх зарчимтай холбоотой. Бүс нутгийн амлалт санаачилгыг үндэсний бодлого, түүний хэрэгжилт болгон хувиргах тодорхой арга хэрэгсэл АСЕАН-ы түвшинд байхгүй байгаа нь бас нэг асуудал мөн. АСЕАН нь тухайн бүсийн дээвэр хэдий ч хүрээлэн буй орчны арга хэмжээ, удирдамж нь гишүүн орнуудад хүчтэй нөлөөлдөггүй байна. Учир нь эдгээр журам, удирдамж нь урт хугацаанд хэрэгжихдээ хяналт муутай байдаг байна.

Хэрэв тухайн улс орны засаглалыг сайжруулах, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, институцийн болон улс төрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд шуурхай арга хэмжээ авч чадвал, байгаль орчны зорилго, байгалийн нөөцийн тогтвортой менежментийг чухамхүү хэрэгжүүлэх болно. Бодлогыг газар дээр нь хэрэгжүүлэх, мөрдүүлэхэд үргэлж гол төв нь болдог авч, ихэвчлэн зохих хүн хүч, ур чадвар, өөрчлөлтийг авчрах хөрөнгөгүй байдаг үндэсний болон дэд салбарын гэх засгийн газрын бүх түвшин, агентлагуудад анхаарах хэрэгтэй байна.

Лаос, Индонезийн хоёр кейс судалгаанд үндэслэн үндэстний болон бүс нутгийн гэсэн засаглалын хоёр түвшинд анхаарлаа төвлөрүүлэх нь ижил ач холбогдолтой боловч энэ хоёрын заагийг анхааралдаа авах нь чухал. Энэ чиглэлээр цаашид хийх судалгаа нь засаглалын хоёр түшингийн уулзвар, бие биедээ үзүүлэх харилцан нөлөөллийг илүү нарийвчлан ойлгох боломж олгоно. Засгийн газрын агентлаг, бодлого, хэрэгжүүлэх механизм гол үүрэгтэй байдаг ч бусад оролцогч тал болон хөтлөгч нар чадавхыг бэхжүүлэх, мэдлэг дээшлүүлэх замаар хөгжилд эерэг нөлөө үзүүлж чадна. Гэсэн ч эдгээр асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол ирээдүйд нөөцийн хомсдол, байгаль орчны доройтлоос сэргийлэх боломжгүй болж, цаашид авлига, эзэн-үйлчлүүлэгчийн таагүй харилцааг хөхиүлэн дэмжих нөхцөл бүрдэж болзошгүй билээ.

## Ном зүй

Abberger, Hartmut. 2003. *Staff of the Integrated Forest Fire Management Program*. Jakarta: FAO.

ADB. 1997. *Emerging Asia: Changes and Challenges*. Manila: Asian Development Bank.

ASEAN. 2005. "Strategic Plan of Action on Water Resources Management." URL: <http://environment.asean.org/files/ASEAN%20Strategic%20Plan%20of%20Action%20on%20Water%20Resources%20Management.pdf> (accessed April 1, 2018).

- Beeson, Mark and Mark T. Berger. 2003. "The Paradoxes of Paramountcy: Regional Rivalries and the Dynamics of American Hegemony in East Asia." *Global Change, Peace and Security*, 15(1): 27–42.
- Buzan, Barry. 1994. "The Interdependence of Security and Economic Issues in the New World Order." In Richard Stubbs and Geoffrey Underhill (eds), *Political Economy and the Changing Global Order*, 92–112. New York: St Martin's Press.
- Campbell, Ian. 2009. "Introduction." In Ian C. Campbell (ed), *The Mekong—Biophysical Environment of an International River Basin*, 1–11. New York: Elsevier.
- Chang, Li L. and Ramkishen S. Rajan. 2001. "Regional versus Multilateral Solutions to Transboundary Environmental Problems: Insights from the Southeast Asian Haze." *The World Economy*, 24(5): 655–671.
- Elliott, Lorraine. 2003. "ASEAN and Environmental Cooperation: Norms, Interests and Identity." *The Pacific Review*, 16(1): 29–52.
- Frey, Frederick W. 1993. "The Political Context of Conflict and Cooperation Over International River Basins." *Water International*, 18(1): 54–68.
- Gleick, Peter H. 1993. "Water and Conflict: Fresh Water Resources and International Security." *International Security*, 18(1): 79–12.
- Goh, Evelyn. 2004. "China in the Mekong River Basin: The Regional Security Implications of Resource Development on the Lancang Jiang." Singapore: Institute of Defence and Strategic Studies Singapore.
- Goh, Evelyn. 2006. "China in the Mekong River Basin: The Regional Security Implications of Resource Development on the Lancang Jiang." In Mely Caballero-Anthony, Ralf Emmers and Amitav Acharya (eds), *Non-Traditional Security in Asia*, 237–258. Hampshire and Burlington: Ashgate.
- Haefner, Andrea. 2016. *Negotiating for Water Resources: Bridging Transboundary River Basins*. New York: Routledge.
- Haefner, Andrea. 2017a. "Environmental Disasters in the Mekong Subregion: Looking Beyond State Boundaries." In Michelle A. Miller, Michael Douglass and Michael Garschagen (eds), *Crossing Borders: Governing Environmental Disasters in a Global Urban Age in Asia and the Pacific*, 117–132. Singapore: Springer.
- Haefner, Andrea. 2017b. "Pak Beng Consultation Process Improved, But To What End?" *Mekong Eye*, May 9, 2017.
- Hsing, Loh Su. 2011. "China Holds the Key to Asia's 'Blue Gold'." *Jakarta Globe*, December 15, 2011.

- International Rivers. 2011. *The Xayaburi Dam: A Looming Threat to the Mekong River*. Berkeley: International Rivers.
- Koh, Keng L. 2012. "Transboundary and Global Environmental Issues: The Role of ASEAN." *Transnational Environmental Law*, 1(1): 67–82.
- Koh, Kheng L., and Nicholas A. Robinson. 2002. "Regional Environmental Governance: Examining the Association of Southeast Asian Nations (ASEAN) Model." In Daniel C. Esty and Maria H. Ivanova (eds.), *Global Environmental Governance*, 101-120. Yale: Yale School of Forestry and Environmental Studies.
- Kuenzer, Claudia, Ian C. Campbell, Marthe Roch, Patrick Leinenkugel, Vo Quoc Tuan and Stefan Dech. 2012. "Understanding the Impact of Hydropower Developments in the Context of Upstream-Downstream Relations in the Mekong River Basin." *Sustainable Science*, 8(4): 565–584.
- Nazeer, Nazia and Fumitaka Furuoka. 2017. "Overview of ASEAN Environment, Transboundary Haze Pollution Agreement and Public Health." *International Journal of Asia-Pacific Studies*, 13(1): 73–94.
- Nguitragool, Paruedee. 2011. "Negotiating the Haze Treaty: Rationality and Institutions in the Negotiations for the ASEAN Agreement on Transboundary Haze Pollution." *Asian Survey*, 51(2): 356–378.
- Orr, Stuart, Jamie Pittock, Ashok Chapagain and David Dumaresq. 2012. "Dams on the Mekong River: Lost Fish Protein and the Implications for Land and Water Resources." *Global Environmental Change*, 22(4): 925–32.
- Osborne, Milton. 2000. "The Strategic Significance of the Mekong." *Contemporary Southeast Asia*, 22(3): 429–444.
- Saturi, Sapariah. 2015. "Merging Of Indonesia's Forestry and Environment Ministries Continues with Inauguration Event." Ecosystem Marketplace. URL: <http://www.ecosystemmarketplace.com/chapters/merging-of-in-donesia-s-forestry-and-environment-ministries-continues-with-inauguration-event/> (accessed April 15, 2018).
- Singh, Bilveer. 2008. "Singapore: Success at Home, Challenges from Abroad." *Southeast Asian Affairs, 2008*: 315–330.
- Sunchindah, Apichai. 2002. *The ASEAN Approach to Regional Environmental Management*. Jakarta: ASEAN Secretariat.
- Syarif, Laode M. 2010. "The Source of Indonesian Environmental Law." *IUCN Academy of Environmental Law*, 1: 1–18.
- Tan, Alan K-J. 1999. "Forest Fires of Indonesia: State Responsibility and International Liability." *International and Comparative Law Quarterly*, 48(4): 826–885.

- Tan, Alan K-J. 2005. "The ASEAN Agreement on Transboundary Haze Pollution: Prospects for Compliance and Effectiveness in Post-Suharto Indonesia." *N.Y.U. Environmental Law Journal*, 13(3): 647–722.
- Tan, Alan K-J. 2015. The "HAZE" Crisis in Southeast Asia: Assessing Singapore's Transboundary Haze Pollution Act. NUS working paper 2015/002, National University of Singapore.
- Varchol, Douglas. 2012. Movie: The Mekong; CGIAR, IUCN's Mekong Water Dialogue and the Swedish International Development Agency.
- Varkkey, Helena. 2013. "Patronage Politics, Plantation Fires and Transboundary Haze." *Environmental Hazards*, 12(3–4): 200–217.
- Varkkey, Helena. 2014. "Regional Cooperation, Patronage and the ASEAN Agreement on Transboundary Haze Pollution." *International Environmental Agreements*, 14(1): 65–81.
- Workman, Jan. 2017. "Palm Oil Exports by Country." World's Top Exports, URL: <http://www.worldstopexports.com/palm-oil-exports-by-country/> (accessed April 15, 2018).
- Wunderlich, Jens-Uwe. 2007. "Regionalism and Integration Theory. The First Wave: Traditional Approaches." In Jens-Uwe Wunderlich (ed), *Regionalism, Globalisation and International Order*, 22–24. Farnham: Ashgate.
- Zeitoun, Mark and Tony Allan. 2008. "Applying Hegemony and Power Theory to Transboundary Water Analysis." *Water Policy*, 10(2): 3–12.

## Өөрчлөлтийн мөч үү? Орлогын сөрөг цочрол ба дэлхийн улс орнуудын улс төрийн дэглэмийн өөрчлөлт

### Увшийн Дэлгэржаргал

Улс төрийн шинжлэх ухааны судалгаанууд нь байгалийн нөөцийн хараат байдал ба улс төрийн дэглэм хоорондын харилцаа, хамаарлыг нарийвчлан судалсан байдаг. Гэсэн хэдий ч, ихэнх судалгаа зөвхөн нөөцийн хамаарлын нэг хэсэг болох байгалийн нөөцийн орлого гэнэт нэмэгдэх буюу улс орнууд орлогын эерэг цочролд өртсөнөөр юу болдог талаар судалсан байдаг. Харин түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэлтэй орлогын сөрөг цочролыг улс төр, эдийн засгийн тоглогчид хэрхэн зохицуулдаг талаар бид маш бага мэдээлэлтэй. Сөрөг цочролыг судлах шалтгаан олон байгаагийн нэг нь байгалийн баялгийн орлого багасахад “баялгийн хараал”-ын урвуу нөхцөл байдалтай тулгарч магадгүй юм. Өөрөөр хэлбэл нөөцийн орлогын түвшин буурснаар ардчиллын боломж нэмэгдэж, авторитари дэглэм тогтвортой байдлаа алдах нөхцөл байдал үүсэж болзошгүй. Нөгөөтэйгүүр, улс төр, эдийн засгийн тоглогчид байгалийн баялгийн орлого багасаад ирэхээр, алдсан орлогоо нөхөхийн тулд хууль бус арга ашиглаж, “баялгийн хараал”-д улам гүн нэвтэрч болзошгүй юм. Энэ нь эргээд авторитари чиг хандлагыг тогтоож, ардчиллыг доройтуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Энэ судалгаагаар байгалийн нөөцийн орлогын сөрөг цочролын улс төрийн дэглэмд үзүүлэх төрөл бүрийн үр дагавар, нөлөөллийг 1961-2016 оны хоорондох өгөгдлийг ашиглан туршиж үзнэ. Эконометрикийн эхний ялгааны загвараас<sup>1</sup> гарсан шинжилгээний үр дүнгээс харахад ардчилалд үзүүлэх орлогын сөрөг цочролын богино хугацааны дундаж үр нөлөө<sup>2</sup> нь эерэг боловч ач холбогдлын хувьд тийм ч их биш гэдгийг харуулав. Ерөнхийдөө газрын тос, байгалийн хийн орлого буурахад үйлдвэрлэгч орнуудын ардчиллын оноо сайжрах хандлагатай байв. Эдгээр туршилтад нөөцийн хамаарлын динамикийг авч үзэх нь чухал, мөн нөөцийн орлогын хэлбэлзэл, тогтворгүй байдал зэрэг нь эдийн засгийн хувьд хохирол учруулж болох боловч тухайн улс орны ардчиллын хэтийн төлөвт ашигтай байж болох юм гэдгийг харуулж байна.

### Оршил

Байгалийн баялгийн нөөц болон улс төрийн дэглэмийн харилцан хамаарал нь улс төр судлаачдын сонирхлыг ихээхэн татсаар ирсэн. Тиймээс ч байгалийн баялаг нь ардчиллын түвшин доогуур (Tsui, 2011), ардчилалд шилжих магадлал багатай (Wright et al., 2015), мөн авторитари дэглэмийн удирдагчид мэдрэмжтэй, уян хатан (De Mesquita and Smith, 2010) байх зэрэгтэй харилцан хамааралтай байгааг олон

1 Анхны ялгаатай загвар.

2 Орлогын сөрөг цочролын дундаж богино хугацааны нөлөө.

тооны судалгаанд тайлбарласан байдаг. Нөөцийн баялаг нь авторитари дэглэмтэй удирдагчдыг хэвлэл, мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах (Egorov et al., 2009) болон цэрэг армид илүү ихээр зардал гаргах (Wright et al., 2015) зэргээр улам дарангуй болгох магадлалтай. Байгалийн баялгийн орлого нь ардчилалд мөн сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Тухайлбал улс төрд нэр дэвшигчдийн чанарт сөргөөр нөлөөлөх (Brollo et al., 2013) болон засгийн газраас хариуцлага нэхэх хэрэгцээг бууруулах (Ross, 2004) магадлалтай байдаг.

Улс төр дэх “баялгийн хараал”-ын талаарх ихэнх судалгааны ажил нь байгалийн нөөцийн хамаарлын нэг хэсэг болох нөөц ашиглалтаас бий болсон гэнэтийн “орлогын эерэг цочрол” нь улс төр, эдийн засгийн бодлогод хэрхэн нөлөөлдгийг харуулсан. Үүний үр дүнд судлаачид үйл ажиллагааны бус орлогын (unearned revenue) өсөлт нь хэрхэн, ямар нөхцөлд улс төрийн дэглэмд нөлөөлж болох талаар онол, практикийн хувьд анхаарлаа хандуулсаар иржээ. Нөгөө талаар, “орлогын сөрөг цочрол” буюу байгалийн нөөцийн орлогын бууралт нь улс төрийн идэвхжилд хэрхэн нөлөөлдөг талаар бид маш бага мэдээлэлтэй байна. Түүнчлэн хэд хэдэн улс орныг дамнан хэрэгжүүлсэн тоон судалгааны математик загварын таамаглал нь нөөцийн хамаарал, улс төрийн дэглэм хоорондын холбоо, хамаарлын динамик нь нөөцийн орлогын эерэг болон сөрөг аль ч цочролын хувьд ижил байдаг. Харин гэнэтийн орлогын бууралт нь орлогын эерэг цочролоос үүдэлтэй хүсээгүй үр нөлөөг буцаах магадлалтай гэсэн санааг агуулсан байдаг. Энэ таамаглалын үнэн зөв нь эрдэм шинжилгээний судалгааны хувьд сонирхолтой бөгөөд нөөцийн хараат байдлаас гарах бодлогыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Энэхүү бүлэгт 1961-2016 оны хооронд улс төрийн дэглэмийн өөрчлөлтөд орлогын сөрөг цочрол хэрхэн нөлөөлж байгааг улс орны түвшинд тогтмол нөлөө үзүүлэх хувилбар бүхий эхний ялгааны загвар<sup>3</sup> статистик аргаар тооцож харууллаа. Үүнээс гадна, олон судалгаанд таамагласанчлан, уг судалгаанд орлогын эерэг, сөрөг цочрол нь улс төрийн дэглэмийн өөрчлөлтөд ижил төрлийн (symmetric) нөлөө үзүүлдэг эсэхийг шалгасан. Энэхүү бүлэгт орлогын цочрол нь байгалийн нөөцийн ямар төрлөөс шалтгаалж ялгаатай байгаа эсэхт анхаарал хандуулсан. Ингэхдээ байгаагийн нөөцийн төрөл нь ардчилсан ба авторитари дэглэмд үзүүлэх ялгаатай нөлөөллийг судалж, эдгээрийн холбоо, хамаарлыг илүү тодорхой болгохыг зорьсон.

Орлогын сөрөг цочрол нь ардчиллын системд шилжихэд эерэг нөлөөлөл үзүүлж байгаа статистик тооцоолол гарсан ч, энэхүү нөлөөлөл нь цар хүрээний хувьд ерөнхийдөө тийм ч их биш гэдгийг уг судалгаа

---

3 Урт хугацааны цуврал нь Никеллийн хазайлтаас үүсэх үр дагаврыг багасгах боломжтой.

харуулсан. Өөрөөр хэлбэл тухайн улс орны байгалийн баялгийн орлого багасахад тус орны ардчиллын оноо сайжирдаг буюу илүү ардчилсан нээлттэй болдог гэсэн дүр зураг харагдаж байгаа юм. Гэхдээ ардчиллын оноо ихээр бус, бага зэрэг сайжирдаг байна. Газрын тос, байгалийн хийтэй, зарим тохиолдолд үнэт металл үйлдвэрлэдэг орнуудын байгалийн баялгийн орлого буурахад ардчилал сайжирдаг бол нүүрстэй орнуудын хувьд энэ хамаарал байдаггүй гэсэн үр дүн гарсан. Газрын тосны орлого нь ардчилсан засаглалтай орнуудын хувьд, ардчиллын оноотой ихээхэн эерэг хамааралтай байсан бол, авторитари, захиргаадалтын засаглалтай улсын хувьд холбоо хамааралгүй байна. Зөвхөн металлын орлогын бууралт л авторитари дэглэмийн ардчиллын оноонд бага зэрэг эерэг нөлөөлөл үзүүлжээ.

Үр дүнгээс харахад эерэг, сөрөг цочролын нөлөөллийн аль аль нь ерөнхийдөө эерэг, цар хүрээний хувьд ижил түвшинд байна. Өөрөөр хэлбэл, тухайн орон тухайн жилд хэр их нөөцийн орлоготой байсан бэ гэдгээс илүү, орлого нь хэр их нэмэгдэж буурч байгаа нь чухал юм. Тухайн жилийн байгалийн баялгаас орж ирсэн орлого нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад багассан байвал ардчиллын чанар сайжирдаг. Нэмэгдсэн тохиолдолд ч гэсэн сайжирдаг гэсэн сонирхолтой үр дүн энэхүү судалгаанаас гарсан.

Ерөнхийдөө, уг судалгааны гол ач холбогдол нь баялгийн хамаарал өөрчлөгдөх нь зөвхөн “баялгийн хараал” бус, “баялгийн хишиг” байж болох ба ардчилсан дэглэмийг сайжруулах, ардчилагдах үйл явцыг эрчимжүүлэх нөлөөтэй байх боломжтой гэдгийг судалсанд оршино. Судалгааны олдворууд нь баялгийн хамаарлын талаарх улс төр эдийн засгийн онол, судалгаа, баялгийн хамаарлын динамик үр нөлөөг судлах судалгаанд хувь нэмэр оруулсан гэж үзэж байна. Улмаар, уг судалгаа нь баялгийн хамаарлын улс төрийн үр дагаврыг бууруулах, удирдахад хэрэгтэй бодлогын асуудлуудыг хөндсөн болно.

Дараагийн хэсэгт байгалийн нөөцийн орлогын сөрөг цочрол нь улс төрийн системд хэрхэн нөлөөлөх талаарх онолын үндэслэл болон таамаглалыг багтаав. Гурав дахь хэсэгт эмпирик судалгааны стратеги, дөрөвдүгээр хэсэгт судалгааны үр дүнг тайлбарласан. Харин сүүлийн хэсэгт дүгнэлт, тэдгээрийн үр нөлөөг авч үзлээ.

## **Онолын тайлбар**

Байгалийн баялгийн орлогын бууралт нь улс төрийн дэглэмд хэрхэн нөлөөлж болох вэ? Хэдийгээр энэ асуултын хариулт бусад эрдэм шинжилгээний ажлаас шууд, тодорхой харагдахгүй ч, бидэнд хэд хэдэн байдлаар дүгнэлт гаргах боломж байна. Нэг талаас, байгалийн баялгийн орлогын сөрөг цочрол тохиолдоход ардчилсан болон авторитари

дэглэмтэй орнуудын ардчилал сайжирч болзошгүй. Эдийн засгийн цочролын үр нөлөөний талаарх өргөн хүрээтэй судалгаанд, төсвийн цочрол нь авторитари дэглэмийн удирдагчдын тохиролцоо хийх эрх мэдлийг үгүйсгэж, засгийн газрын сөрөг хүчний байр суурийг бэхжүүлж, улс төрийн дэглэмд өөрчлөлт оруулахад хувь нэмэр оруулдаг болохыг харуулсан (Haggard and Kaufman, 1997). Хүнд хэцүү цаг үе нь бодлогын чиг баримжааны өөрчлөлтөд хүргэж болзошгүй, учир нь одоогийн эрх баригчдын дунд, тэдний эргэн тойронд мөнгө хөрөнгө багассанаас тухайн үеийн эрх баригчдад улс төрийн эрсдэл үүсэж болно (Gourevitch, 1986). Эдийн засгийн хүндрэлүүд нь эдийн засгийн бодлогын өөрчлөлтөд хүргэдэг, учир нь тухайн цаг үед өөрчлөлт шинэчлэл хийх ёстой гэж үздэг удирдагчдад бодлогын шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай зүйлүүдийн хамт нэг хөтөлбөрт багцлах, шинэчлэлийн эсрэг хүчинд санал болгох боломж олгодог (Rodrik, 1996). Тиймээс томоохон сөрөг цочролууд нь удирдагчдыг өөрчлөлтийн тал дээр илүү нээлттэй болгосноор дэглэмд эерэг өөрчлөлтүүдийг бий болгох боломжийг бүрдүүлдэг.

Нөөцөөс ихээхэн хамааралтай улс орнуудад тулгарч буй нөөцийн цочрол нь эдийн засгийн өөрчлөлттэй шууд холбоотой ба энэ нь ардчиллын хувьд ч чухал ач холбогдолтой байж болно. Байгалийн баялгийн үнэ буурахад Голланд өвчний урвуу нөхцөл байдал үүсэж болно. Баялгийн үнэ өсөж, экспортын хэмжээ нэмэгдсэнээр дотоодын валют илүү эрэлттэй болж, ханш өсөж худалдааны салбар дахь дотоодын үйлдвэрлэлийн гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бууруулдаг (Friedman, 2006). Нөгөө талаас, хэрэв орлогын сөрөг цочрол нь байгалийн баялгийн үнэ буурснаас үүдэлтэй бол, дотоодын валютын ханш суларч, худалдааны салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж болно. Цаашид, нөөцийн салбарт үзүүлж буй томоохон орлогын сөрөг цочрол нь чанартай ажиллах хүчнийг байгалийн нөөцийн бус салбарт шилжүүлэн байршуулах магадлалтай. Ингэснээрээ улс төрийн мэдэгдэхүйц нөлөөлөл үзүүлж болох юм. Энэ нь дотоодын бизнес эрхлэгч элитүүдийн бүтцийг өөрчилж, худалдааны, нөөцийн бус салбарын тэргүүлэх тоглогчдыг нэг эвсэл, эрх баригчдын эсрэг боломжит өрсөлдөгчид бий болгох боломжийг өргөжүүлдэг. Удирдагчдыг илүү нээлттэй байхыг урамшуулж юм уу шаардсанаар эдгээр шинэ элит нь улс төрийн дэглэмийг сайжруулж болох юм.

Байгалийн нөөцийн орлогын сөрөг цочрол нь улс төрийн өөрчлөлт, нээлттэй байдлын түгээмэл эрэлтийг нэмэгдүүлдэг. Байгалийн баялгийн экспортын орлогоос ихээхэн хамааралтай улс орнуудын хувьд, байгалийн баялгийн үнэ буурахад үйлчилгээний болон бусад салбарууд, мөн улсын секторын хөрөнгө оруулалт нь ерөнхийдөө орлогын цочролыг мэдэрдэг. Нөлөөлөлд өртсөн салбар дахь хувь хүн, оролцогч талууд засгийн газраас орлогын цочролын хохирлыг нөхөх юм уу өөр зүйлээр орлуулж олгохыг шаардаж болно. Түүнчлэн, орлогын цочрол үргэлжилснээр засгийн газрууд алдагдсан орлогоо нөхөх зорилгоор татвар нэмэх арга хэмжээ авахад хүргэж болзошгүй (Bornhorst et al., 2009). Татварын



хэмжээ нэмэгдэх нь засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлдэг болохыг туршилтаар нотолсон (Paler, 2013).

Эцэст нь, орлогын сөрөг цочрол одоогийн албан тушаалтнуудын баялгийг бууруулснаар өрсөлдөгчдөө дарах, нийгмийн дэмжлэгийг худалдан авах чадварыг багасгаж, улс төрийн дэглэмийг өөрчлөх магадлалыг нэмэгдүүлнэ. Хэрэв орлогын эерэг цочрол буюу байгалийн баялгийн орлого нэмэгдэх нь тухайн албан тушаалд байх үнэ цэнг нэмэгдүүлдэг бол (Robinson et al., 2006), орлогын сөрөг цочрол нь эрх мэдэлтэй байснаар ашиг хүртэх хэмжээг багасгах боломжтой гэж үзэж болох юм. Ингэснээр тухайн албан тушаалтан буулт хийх хүсэл эрмэлзлийг бий болгох болно.

Гэсэн ч орлогын сөрөг цочрол нь “баялгийн хараал”-ыг үргэлжлүүлж, авторитари, ардчилсан дэглэмийн аль алинд нь эрх баригч засгийн газрыг бэхжүүлж болох юм. Нийгмийн баялгийг дахин хуваарилах, улс төрийн нээлттэй байдлыг шаардах нийгмийн хэрэгцээ, түүнчлэн боломжит сорилтууд бий болсноор албан тушаалтан, цэргийнхэн дарангуйллыг үргэлжлүүлж, баялгийн дахин хуваарилалтыг зогсоох оролдлого хийж (Wright et al., 2015), улс төрийн эрх мэдлийг төвлөрүүлж болно.<sup>4</sup> Түүнээс гадна авлига гэх мэт нөөцийн орлого ихэссэнтэй холбоотой бий болсон улс төрийн болон институтийн эмгэгийн улмаас орлогын сөрөг цочролд орох үед, одоогийн эрх барьж буй удирдагчдад алдагдсан орлогоо хууль бусаар нөхөн олох, холбоотнуудаа үр дүнтэй ажиллуулах зэрэг боломжийг олгох боломжтой. Авлига нь албан бус институтийн хувьд ярвигтай, өөрчлөхөд хэцүү байж болно. Төрийн байгууллагын (удирдлагын тогтолцоо) хувьд, авлига өндөр түвшинд хүрсэн тохиолдолд, авлигад автах зан төлөвийн орчин нь давтамжаас хамааралтай тэнцвэрт байдал (equilibrium) болдог. Учир нь улс төр, эдийн засгийн тоглогчид бие дааж, авлигад автахгүй байх замаар өөрсдийн ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжгүй болно (Mansion, 2004). Өөрөөр хэлбэл, бусад бүх албан тушаалтан авлигад автсан тохиолдолд, бие даасан хувь хүн авлигад автахгүй байх магадлал бага. Авлига нь авторитари дэглэмтэй улс орнуудад нэлээд өргөн тархсан байдаг (Montinola and Jackman, 2002). Энэ нь тухайн орны чанга дэглэмийн тогтвортой байдлыг дэмжих үүрэг гүйцэтгэдэг байх боломжтой. Иймд орлогын сөрөг цочролын үр дүнд нөөцийн шууд хамаарал буурсан ч, нөөцийн хамааралтай улс орнуудад ардчилал оршин тогтнох магадлал, боломж буурах онолын шалтгаан байдаг.

Онолын эдгээр асуудал орлогын сөрөг цочрол нь улс орнуудын удирдлагын дэглэмийн өөрчлөлтөд эергээр ч, сөргөөр ч нөлөөлж болно гэдгийг харуулж байна. Дүрсэлсэн өгөгдлөөс харахад, байгалийн баялгийн орлого буурах, улс төрийн дэглэм өөрчлөгдөх хоёрын уялдаа


---

4 Орос дахь улс төрийн төвлөрөл нь энэхүү логикийг харуулж байгаа болно. Зарим эрдэмтний үзэж байгаагаар, 2015 оноос хойших газрын тосны үнийн уналт, барууны хориг арга хэмжээний үр дүнгээс үүдэлтэй орлогын сөрөг цочролын улмаас олон тооны орон нутгийн удирдагчийг баривчлах, солих арга хэмжээ авч байгаа юм.

холбоо нэг чигт биш, тодорхойгүй байна. Зураг 1 нь дэлхийн улс орнуудад гарсан улс төрийн дэглэмийн томоохон өөрчлөлтүүд хэзээ бий болсныг харуулж байна. Томоохон өөрчлөлт гэдэгт тухайн улсын ардчиллын төрийн байгууламжийн буюу Полити IV оноо түрүү жилийнхээсээ 30 хувиар багассан, ихэссэн тохиолдлуудыг хамруулсан. Улаанаар дэлхийн газрын тосны үнийг харуулав. 1980-аад онд газрын тосны үнэ буурсантай холбоотойгоор ардчилсан байдал, түүний чанар багассан орнуудын тоо буурч, харин ардчилсан байдал, чанар нь сайжирсан орнуудын тоо ихэссэн. Үүнийг нэг талаас, газрын тосны үнийг даган орлого буурах нь дэлхийн ардчилалд сайнаар нөлөөлсөн байна гэж тайлбарлаж болох юм. 2000-аад оноос хойш газрын тосны үнэ буцаж өссөн хэдий ч, дэлхий дахины ардчиллын нөхцөл байдал эргэж муудаагүй нь харагдаж байна.

Зураг 2-т V-DEM төслийн ангилалд суурилан (Mechkova et al., 2017)<sup>5</sup> улс орнуудын төрийн дэглэмийг дөрвөн ерөнхий бүлэг болгон ангилж, дэлхийн газрын тосны үнэтэй харьцуулан харуулсан. Эдгээр ангилал дундаас хамгийн авторитар хэлбэр болох авторитари хаалттай дэглэмийн тоо 1980-аад онд газрын тосны үнэ буурсантай нэг үед зэрэг буурсан нь харагдаж байна. Гэвч 1980-аад оны газрын тосны уналтын үед сонгуулийн эрх мэдэл бүхий авторитари дэглэмийн тоо өсөж, энэ чиг хандлага 2000-аад онд ч (газрын тосны үнэ хүчтэй нэмэгдсэн үед) үргэлжилжээ. Үүний нэгэн адилаар, сонгуулийн болон либерал ардчиллын тоо газрын тосны үнийн хэлбэлзлийг үл харгалзан 1970-аад оны сүүлээс хойш өссөөр байна.


**зураг 1. Дэлхийн улс орнуудад гарсан улс төрийн дэглэмийн томоохон өөрчлөлтүүд (тухайн улсын ардчиллын оноо түрүү жилийнхээсээ >30 хувиар буурсан эсвэл өссөн тохиолдлууд) ба дэлхийн газрын тосны үнэ**



Эх сурвалж: V-DEM өгөгдөлд хийсэн зохиогчийн тооцоолол.

5 Сонгуулийн ардчилал нь наанадаж нэг сөрөг хүчний нам сонгуульд оролцож, институцийн баталгааны өндөр түвшинд сонгууль явагддаг боловч зөрчил ихтэй байдаг. Либерал ардчилал нь сонгуулийн ардчиллын шалгуураас гадна, либерал үзэл бодлын зарчмуудын биелэлтийг хангах ёстой. Сонгуулийн авторитар дэглэм нь сонгуулийн ардчиллын нэг, түүнээс дээш шалгуурыг хангадаггүй боловчсүя удирдагчийг олон намын сонгуулийн зарчмаар сонгоно. Хаалттай авторитар нь сүүлчийн шалгуурыг хангаж чадахгүй Tungsten, and Zinc.

**Зураг 2. V-DEM төслийн ангилалд тулгуурлан засаглалын өргөн хүрээний хэлбэрүүдийг цаг хугацааны хүрээнд дэлхийн газрын тосны үнийн хэлбэлзлийн мэдээлэлтэй харьцуулан хуваарилж харуулсан байдал**



Эх сурвалж: V-DEM өгөгдөлд хийсэн зохиогчийн тооцоолол.

Байгалийн баялгийн нөөц ба улс төрийн дэглэм хоорондын харилцаа хамаарлын талаарх судалгаануудад хоёр асуудал нийтлэг байна. Нэгдүгээрт, нөөцийн хамаарлын динамик, ялангуяа байгалийн баялгийн сөрөг өөрчлөлтүүд нь хангалттай судлагдаагүй байна. Олон тооны эмпирик судалгаанд байгалийн нөөцийн хараат байдлын түвшин нь улс төрийн дэглэм ба дэглэмийн өөрчлөлттэй хэрхэн уялдаж байгааг харуулдаг (Ross, 2015). Тиймээс энэ асуудалд эмпирик дүн шинжилгээ хийх шаардлага гарч ирж байна. Хоёрдугаарт, байгалийн нөөцийн орлого ба улс төрийн дэглэм хоорондын харилцаа, хамаарлын талаарх эконометрик судалгааны таамаглал нь орлогын эерэг, сөрөг цочрол нь дэглэмийн өөрчлөлтөд ижил нөлөөтэй байдаг талаар дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл, байгалийн баялгийн үнийн хэт өсөлтийн үед үүссэн нөхцөл байдал нөөцийн уналтын үед эргэн хэвэндээ очдог гэсэн ойлголт байдаг. Дараах бүлэгт орлогын эерэг цочролын хэмжигдэхүүнийг загварт оруулж тооцооноор энэ таамаглалын үнэн эсэхийг эмпирик аргаар судалж үзнэ.

## Судалгааны стратеги

Энэ судалгааны гол зорилго нь улс орнуудын төрийн байгууламжийн (удирдлагын тогтолцоо) онооны өөрчлөлтөд үйл ажиллагааны бус (байгалийн баялгаас орж ирсэн) орлогын сөрөг цочролын дундаж нөлөөг тодорхойлох юм. Судалгааны дараагийн зорилго нь эерэг, сөрөг хоёр төрлийн цочрол нь ардчиллын байдалд адил тэгшээр нөлөөлж байгаа эсэхийг тайлбарлах явдал байв. Улс орны байгалийн баялгийн орлого өсөж, буурах нь дэлхийн түүхий эдийн үнээс ихээхэн хамааралтай байдаг тул, судлаачид уг орлогын өөрчлөлтийг улс орны дотоод нөхцөл байдлаас бус, гадаад зах зээлээс хамааралтай гэж үздэг (e.g. Ahmed, 2012). Энэ нь ч судалгаа хийхэд тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ бүлэгт 1961-2016 оны хоорондох дэлхийн улс орнуудын статистик өгөгдлийг ашиглан “first-differences with country fixed effects” буюу улс орнуудын цаг хугацааны урсгалд өөрчлөгддөггүй онцлогийг тусгасан анхны ялгааны загварыг тооцоолох юм.<sup>6</sup>

$$Y_{i,t} - Y_{i,t-1} = \beta(R_{i,t} - R_{i,t-1}) + \theta(X_{i,t}) + \lambda_i + E_{i,t} \quad (1)$$

$Y$  нь судлагдахуун буюу тухайн улсын болон жилийн ардчиллын оноо юм.  $R$  нь байгалийн баялгийн орлогыг илэрхийлэх ба үндсэн бие даасан хувьсагч юм.  $X$  нь хяналтын хувьсагчдын багц юм,  $i$  - тухайн улс,  $t$  - тухайн оныг тэмдэглэсэн тэмдэглэл.  $E_{i,t}$  - нь улсын түвшинд хуримтлагдсан статистикийн алдааны нийлбэр.  $\lambda$  тухайн улсын түвшний тогтмол нөлөөг тэмдэглэсэн хувьсагч.

Эерэг болон сөрөг цочролууд ардчилалд ижил нөлөөтэй эсэхийг тодруулахын тулд уг загварт аль алиныг нь оруулж өгсөн. Үр дүнд нь тэгшитгэл 1-ийг дахин бичвэл:

$$Y_{i,t} - Y_{i,t-1} = \beta_1 (R_{i,t}^+) + \beta_2 (R_{i,t}^-) + \theta(X_{i,t}) + \lambda_i + E_{i,t} \quad (2)$$

$(R_{i,t}^+)$  байгалийн баялгийн орлогын эерэг цочролын хэмжээг хэмжих ба  $R_{i,t} - R_{i,t-1}$  if  $R_{i,t} - R_{i,t-1} > 0$ -ээс их байх үед түүнтэй тэнцүү байна. Үүний нэгэн адилаар,  $(R_{i,t}^-)$  - нь орлогын сөрөг цочролын хэмжээг хэмжих бөгөөд хэрэв,  $|R_{i,t} - R_{i,t-1}|$  if  $R_{i,t} - R_{i,t-1} < 0$  нь 0-ээс бага эсвэл 0-тэй тэнцүү байх үед, энэ нь  $R_{i,t} - R_{i,t-1}$  -тэй тэнцүү байна.

Эхний ялгааны загвар (first-differences model)-ыг тогтмол нөлөө үзүүлэх (fixed effects) хувилбартай хамт ашигласнаар, үл хамаарах хувьсагчийн өөрчлөлт нь бусад хамаарах хувьсагчийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж

6 Судалгаанд олон оны өгөгдөл оруулах нь Nickell bias гэх мэт статистикийн асуудлаас зайлсхийхэд нэмэр болдог.

байгааг харж болно (бусад хувьсагчдыг тогтгмол гэж үзвэл). Ингэснээр тухайн улс орнуудын Полити (ардчиллын төрийн байгууламжийн) онооны өөрчлөлтөд орлогын сөрөг цочрол богино хугацаанд хэрхэн нөлөөлөхийг мэдэх боломжтой болно.

Судалгааны үндсэн хамаарах хувьсагч, судлагдахуун нь Полити IV онооны жил бүрийн өөрчлөлтүүдийг багтаана. Полити IV оноо нь улс төрийн шинжлэх ухаан дахь улс төрийн дэглэмийн өөрчлөлтийг хэмждэг стандарт хэмжигдэхүүн юм. Энэ нь улс төрийн өрсөлдөөн, нээлттэй байдал, албан тушаалын өрсөлдөөн, эрх мэдэл гэх мэт олон төрлийн хэмжигдэхүүнээс бүрдэнэ (Marshall et al., 2017). Харбер ба Меналдо (2011) нарын аргачлалаар Полити ардчиллын төрийн байгууламжийн оноог 0-100-ын хооронд байхаар болгож өөрчилсөн.

Үл хамаарах хувьсагчдын нэг нь байгалийн нөөцөөс орж ирж буй нэг хүнд ногдох орлогын сөрөг өөрчлөлт буюу бууралт юм. Байгалийн нөөцийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар биш, нэг хүнд ногдох хэмжээгээр илэрхийлсэн. Байгалийн баялгийн орлогын ДНБ-д эзлэх хувийг үл хамаарах хувьсагчаар сонгож харьцуулах нь тохиромжгүй бөгөөд аль нэг талд давуу байдал үүсгэх магадлалтай. Тухайлбал, тодорхой t-1 хугацаанд адил хэмжээний байгалийн нөөцийн орлогын цочролтой хоёр улсыг авч үзье. Нэг нь чинээлэг, эдийн засаг нь төрөлжсөн, харин нөгөө нь ядуу ба байгалийн нөөцөөс хараат улс. Энэ тохиолдолд ядуу, байгалийн нөөцөөс хараат улсын хувьд, ДНБ-ий хэмжээ нь цочролоос болж буурах боловч ДНБ-д тийм ч ихээр нөлөөлөхөөргүй чинээлэг оронтой харьцуулахад нөлөөлөл нь бага байх болно. Тиймээс байгалийн нөөцийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар нь авч үзсэнээр Type II алдааг үүсгэж болзошгүй юм.

Байгалийн нөөцийн орлогын талаарх тоо, мэдээллийг олон төрлийн эх сурвалжаас, үүнээс нэг хүнд ногдох байгалийн нөөцийн ерөнхий орлогын талаарх тоог Дэлхийн банкны 2016 оны статистикаас авсан. Дэлхийн банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн мэдээллийн сан дахь тоо, мэдээлэл нь ДНБ-д эзлэх нийт байгалийн нөөцийн орлогын хувийг харуулдаг бөгөөд үүнд ойн аж ахуйн орлогыг мөн багтаасан байдаг. Голлох нөөц болох газрын тос, байгалийн хий болон эрдэс бүтээгдэхүүний улс төр, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл мөн дагалдах нөөцүүд, түүн дотроо хөдөө аж ахуй, загасны болон ойн аж ахуй зэргийн нөлөөлөл нь харилцан адилгүй байх магадлалтай (Leite and Weidmann, 1999). Тиймээс дээрх нийт байгалийн нөөцийн ДНБ-д эзлэх хувийн тоо, мэдээллээс ойн аж ахуйн хэсгийг хасаад, нийт ДНБ болон нийт хүн амын тоог ашиглан ам.доллороор тоон мэдээллийг гаргасан.<sup>7</sup>

---

7 Энэ тооцоололтын дүнд нийт 120 ажиглалт хасах утгатай гарсан. Судалгааны үр дүн нь эдгээр ажиглалтыг хассан ч өөрчлөгдөөгүй.

Энэ хэмжээ нь байгалийн нөөцийн орлогыг нийт дүнгээр нь гаргаж байгаа юм. Иймд илүү нарийвчилсан тоо, мэдээлэл авахын тулд голлох нөөцүүдийг ангилж, тусдаа улс төрийн дэглэмд хэрхэн нөлөөлж байгааг судлахаар нэг хүнд ногдох орлогын хэмжээг авсан. Росс ба Махдави (2014) нар газрын тос, байгалийн хийн орлогын нэг хүнд ногдох хэмжээг гаргасан ба нүүрс, металл зэргээс орох орлогын өгөгдлийг Харбер ба Меналдо (2011)-аас авсан.<sup>8</sup>

Эдгээр байгалийн баялгийн орлогын талаарх хэмжигдэхүүн нь хэдийгээр өргөн хүрээг хамрах давуу талтай ч, онолын хувьд энэ бүлгийн гол судлах хувьсагч бол засгийн газрын татварын бус, орлого байх ёстой. Энэ талаарх өгөгдөл маш ховор байдаг. Энэ асуудлыг шийдэхийн тулд Олон улсын татвар, хөгжлийн төв (International Centre for Taxation and Development) байгалийн нөөцийн орлоготой холбоотой шинэ мэдээллийн санг бий болгосон. Энэ мэдээллийн сан нь 148 орныг хамруулсан буюу харьцангуй өргөн цар хүрээтэй байгаа хэдий ч, гол дутагдалтай тал нь 1980 оноос хойших цөөхөн оныг хамарч байгаа юм. Гэсэн хэдий ч, шинжилгээндээ тухайн мэдээллийн сангийн тоо, мэдээллээс авч ашигласан. Мөн ДНБ-д эзлэх татварын орлогын хувь болон татварын бус орлогын хэмжээ энэхүү мэдээллийн санд байдаг. Нийт ДНБ-ний хэмжээ, нийт хүн амын тоог ашиглан нэг хүнд ногдох татварын бус орлогын хэмжээг гаргаж ирсэн.

Үл хамаарах хувьсагчийг тодорхойлохын тулд, янз бүрийн баялгийн орлогын нэг хүнд ногдох хэмжээний нэг жилээс нөгөөд шилжих өөрчлөлтийг авсан. Хэрвээ, тухайн улсын нэг хүнд ногдох орлогын жилийн өөрчлөлт эерэг байвал эерэг цочролтой байна гэж үзнэ. Эсрэгээрээ нэг хүнд ногдох орлогын өөрчлөлт сөрөг байвал сөрөг цочрол гэж үзнэ. Бүх хувьсагчийг логарифмаар хувиргасан бөгөөд сөрөг цочролыг логарифмаар хувиргахын тулд харьцангуй утгыг нь аваад, нэгийг нэмж тооцсон.

Улс төрийн дэглэмд нөлөөлж болзошгүй хэд хэдэн хүчин зүйлсийг хяналтын хувьсагч загварт оруулсан. Нэгдүгээрт, улс төрийн дэглэмийн янз бүрийн түвшинд дэглэм тогтворжих маягтай байдаг байдал, дэглэмийн дундаж руугаа буцах хандлагыг хянахын тулд тухайн улсын t-1 буюу өмнөх жилийн Полити оноог загварт оруулсан.<sup>9</sup> Нийт баялгийг мөн адил хувьсагч болгон загварт оруулсан. Учир нь цочролоос өмнөх үеийн их хэмжээний баялгийн орлого нь засгийн газар сөрөг цочролын үед ч эрх мэдэл, хүчээ хадгалж байх боломжийг олгох магадлалтай. Үүнтэй харьцуулахад, нөөцийн баялаг багатай улсын улс төрийн дэглэм нь багахан хэмжээний цочролд ч мэдэрэмтгий байх боломжтой. Тиймээс t-1 хугацаанд өмнөх жилийн баялгийн

---

8 Энэ хувьсагч нь аж үйлдвэрлэл, үнэт металлын ихэнхийг агуулдаг. Тухайлбал, Антимони, Боксит, хром, зэс, алт, төмрийн хүдэр, хар тугалга, манган, мөнгөн ус молибден, никель, мөнгө, цагаан тугалга, вольфрам, цайр.

9 Ардчиллын оноо нь улс орны хувьд тэнцвэрийн үтгэд эргэж орох хандлагатай байж болно (Acemoglu et al., 2008).

хамаарал (Total Resource Dependence)-ыг загварт тусгасан. Үүнээс гадна, орлогын тодорхой түвшинд улс төрийн дэглэм, ардчилалд өөрчлөлт орно гэсэн санааг авч үзэхийн тулд t-1 хугацаанд өмнөх жилд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг оруулав (Lipset, 1959). Энэ загварт иргэний дайныг мөн нэг хувьсагч болгон авсан. Одоо болж буй иргэний дайн улс төрийн дэглэмийг өөрчлөхөд ихээр нөлөөлж болзошгүй тул уг үзүүлэлтийг авч үзэх хэрэгтэй. Иргэний дайн мөн орлогын цочролоос бий болох магадлалтай учир тухайн жилд бус өмнөх жилд 1000-аас дээш хүн амь эрсэдсэн, дайн, мөргөлдөөн болсон эсэхийг тодорхойлогч хувьсагчаар (indicator variable) илэрхийлэн орууллаа.

Улс төрийн авлига нь эрх баригчдын ардчилалд шилжих, сайжрах үйл явцад саад болохуйц эрх мэдлийг нэмэгдүүлдэг. Улс төрийн авлигын хэмжээг улс төрийн авлигын индексийн дата (Political Corruption Index of Variables of Democracy)-аас авч загвартаа оруулсан. Өөр нэг улс төрийн дэглэмийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйл бол тэгш бус байдлын хэмжээ юм. Тэгш бус байдал их байх тусмаа нийгэмд ардчиллыг хүсэх явдал их байх боловч ангид, тусгай байх хүслээс болоод дээд, элит хэсгүүд ардчилсан дэглэмтэй болохыг дэмжихгүй байх магадлалтай (Dunning, 2008). Тэгш бус байдлыг хэмжихдээ “Egalitarian Democracy Index of the V-Dem” мэдээллийн санг ашигласан ба энэ индекс нь тухайн улсад эрх тэгш ардчиллын зорилгын хэрэгжилтийг хэмждэг. Эцэст нь улс төрийн дэглэмийн өөрчлөлт нь зөвхөн бие даасан, ганц улсын хувьд өрнөдөггүй бөгөөд хөрш орнуудад харилцан тархаж байдаг (Gleditsch and Ward, 2006). Тиймээс тухайн улсын газар зүйн болон соёлын бүсийн ардчиллын хувийг бас тооцсон.<sup>10</sup> Бүх хувьсагчдын мэдээллийн эх сурвалж болон нэгдсэн статистикийг Хүснэгт 1-т оруулав.

Улсын түвшинд тогтмол нөлөө үзүүлэх хувилбар бүхий эхний ялгааны загварын (country fixed effects in first-difference) тэнцэтгэл нь цаг хугацаанаас хамааралгүй тухайн оронд болсон өөрчлөлтийг тооцож байгаа юм. Энэ хувилбар нь улс орон бүрт оногдох статистикийн алдааны өөр хоорондын корреляцийг бас багтааж тооцсон байгаа. Судалгаанд 2010 оны байдлаар 500,000-аас дээш хүн амтай байсан дэлхийн бүх улс орны 1961-2016 оны хоорондох хугацааны өгөгдлийг оруулсан. Судалгааны явцад тусгаар тогтносон улсууд, тусгаар тогтнолоо тогтоосон жилээс эхэлж тооцогдож явсан байгаа. Тоон мэдээллүүд нь мэдээллийн олдоц зэргээс хамаарч тэнцвэргүй байна.

---

10 Тухайн орон Ойрх Дорнод эсвэл Сахарын орчмын Африкт оршдог эсэхийг заасан үзүүлэлтийн хувьсагч нь (indicator variable) дэглэмийн өөрчлөлт, бат бөх байдлын талаарх судалгаанд түгээмэл байдаг. Миний шинжилгээний хувьд эдгээр үзүүлэлтийн 11 хувьсагч нь улс орны тогтмол нөлөөллийн хувьсагчтай country fixed effects) хамааралтай байгаа юм.

**Хүснэгт 1. Статистикийн хураангуй**

Хувьсагч	Дундаж	Std. хэлбэлзэл	Хамгийн бага	Хамгийн их	Эх сурвалж
Төрийн байгууламжийн Полити IV оноо	54.601	36.940	0.000	100.000	Marshall et al. (2017)
Уг төрийн байгууламжийн IV оноон дахь Δ	0.401	8.260	-90.000	80.000	Зохиогчийн тооцоолол
Нийт баялгийн орлого (ам долл, хожуу)	46024.384	182372.741	-1408.893	2837570.750	Computed from World Bank (2016)
Log (нийт баялгийн орлого дахь эерэг Δ)	2.986	3.799	0.000	14.347	Зохиогчийн тооцоолол
Log (нийт баялгийн орлого дахь сөрөг Δ)	1.654	3.198	0.000	13.870	Зохиогчийн тооцоолол
Газрын тос, хийн орлого (нэг хүнд оногдох, хожуу)	716.690	3413.909	0.000	70179.969	Ross and Mahdavi (2014)
Log (Газрын тос, хийн орлого дахь эерэг Δ)	0.858	1.796	0.000	10.511	Зохиогчийн тооцоолол
Log (Газрын тос, хийн орлого дахь сөрөг Δ)	0.594	1.559	0.000	9.941	Зохиогчийн тооцоолол
Газрын тосны орлого (нэг хүнд оногдох, хожуу)	583.663	2984.165	0.000	67454.211	Ross and Mahdavi (2014)
Log (Газрын тосны орлого дахь эерэг Δ)	0.754	1.692	0.000	10.427	Зохиогчийн тооцоолол
Log (Газрын тосны орлого дахь сөрөг Δ)	0.511	1.456	0.000	9.856	Зохиогчийн тооцоолол
Нүүрсний орлого (нэг хүнд оногдох, хожуу)	22493.316	69602.254	0.000	819789.625	Haber and Menaldo (2011)
Log (нүүрсний орлого дахь эерэг Δ)	1.228	2.760	0.000	12.250	Зохиогчийн тооцоолол
Log (нүүрсний орлого дахь сөрөг Δ)	0.925	2.417	0.000	11.979	Зохиогчийн тооцоолол
Төмөрлөгийн орлого (нэг хүнд оногдох, хожуу)	61742.246	160479.248	0.000	2592402.000	Haber and Menaldo (2011)
Log (Төмөрлөгийн орлого дахь эерэг Δ)	2.566	3.830	0.000	14.098	Зохиогчийн тооцоолол
Log (Төмөрлөгийн орлого дахь сөрөг Δ)	1.656	3.273	0.000	13.029	Зохиогчийн тооцоолол
Татварын бус нийт орлого (нэг хүнд оногдох, хожуу)	874.130	2431.731	-88.483	32548.613	Prichard et al., 2018
Log (Татварын бус орлого дахь эерэг Δ)	1.666	1.987	0.000	9.247	Зохиогчийн тооцоолол
Log (Татварын бус орлого дахь сөрөг Δ)	0.458	1.261	0.000	9.277	Зохиогчийн тооцоолол
Log (нэг хүнд оногдох ДНБ, хожуу)	8.076	1.533	4.752	11.641	Дэлхийн Банк (2016)
Иргэний дайны үзүүлэлтийн хувьсагч (хожуу)	0.083	0.275	0.000	1.000	Haber and Menaldo (2011)
Улс төрийн авлигын индекс (хожуу)	0.507	0.346	0.000	1.000	Coppedge et al. (2017)
Эгалитар ардчиллын индекс (хожуу)	0.340	0.245	0.032	0.891	Coppedge et al. (2017)
Бус нутгийн ардчиллын тархалт (хожуу)	0.401	8.261	-90.000	80.000	Haber and Menaldo (2011)

Тайлбар: Баялгийн нийт орлогыг тооцож үзэхэд, 120 ажиглалт эерэг бус баялгийн орлоготой гарав. Эдгээр ажиглалтыг хасахад, регрессийн шинжилгээний үр дүнд мөнөөрчлөлт гараагүй болно. Мэдээллийн сангийн эх хувилбарт зарим орны тодорхой жилүүдэд ДНБ-д эзлэх татварын бус орлого бага зэрэг сөрөг утгатай байв. Эдгээр ажиглалт нь Бенин улс 1981 он, Эл Салвадор улс 1996 он, Гуатемала улс 1998-2000 он, Того 1999 он, Туниз 2000-2007 зэрэг байв. Уг бүлгийг бичиж байх үед эдгээр зөрүүний шалтгааныг тодруулах боломжгүй байв. Ажиглалтуудыг үр дүнгээс хассан ч, судалаганы үр дүн төлөөлөх чадвартай хэвээр байв.



## Үр дүн

Хүснэгт 2-т орлогын эерэг, сөрөг цочрол болон төрийн байгууламжийн буюу ардчиллын онооны өөрчлөлт хоорондын харилцан хамаарлыг тооцоолов. Эдгээр загварт тухайн улс орон бүрийн өнгөрсөн оны улс төрийн дэглэмийн оноо, байгалийн нөөцийн ерөнхий хамаарлыг хянах хэлбэрээр оруулсан. Багана бүр өөр өөр бие даасан хувьсагчаас бүрдсэнээрээ ялгаатай. Өөрөөр хэлбэл, цочролд хүргэсэн байгалийн нөөцийн орлогын төрөл нь багана бүрт өөр. Засгийн газрын татварын бус нийт ашгийг хэмжиж үзсэн тохиолдлыг эс тооцвол, орлогын сөрөг цочролын ардчилалд үзүүлэх үр нөлөө эерэг байсан бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой байв. Газрын тосны орлогын болон газрын тос, байгалийн хийн хавсарсан цочролын нөлөөллийн цар хүрээ нь хамгийн өргөн байна. Үүний адилаар, газрын тос болон газрын тос, байгалийн хийн хосолсон орлогын цочрол нь статистикийн хувьд хамгийн ач холбогдолтой байгаа юм. Нүүрс болон металлын орлогоос үүдэх сөрөг цочрол нь ардчилалд мөн адил эергээр нөлөөлдөг боловч нөлөөллийн хэмжээ бага, статистик ач холбогдлын түвшин доогуур байна.

### Хүснэгт 2. Суурь үр дүн: Полити IV онооны өөрчлөлтөд орлогын сөрөг цочролын үзүүлэх нөлөө

Хамаарах хувьсагч	Полити IV онооны $\Delta$					
	Нийт баялаг	Газрын тос ба хий	Газрын тос	Нүүрс	Төмөрлөг	Татварын бус орлого
Сөрөг цочрол	0.248*** (0.056)	0.484*** (0.117)	0.501*** (0.122)	0.237** (0.108)	0.143* (0.084)	0.210 (0.144)
Эерэг цочрол	0.234*** (0.056)	0.447*** (0.097)	0.482*** (0.105)	0.089 (0.101)	0.076 (0.079)	0.182 (0.133)
Полити IV <sub>t-1</sub>	-0.089*** (0.008)	-0.070*** (0.007)	-0.071*** (0.007)	-0.080*** (0.008)	-0.080*** (0.008)	-0.121*** (0.012)
Баялгийн хамаарал <sub>t-1</sub>	-0.000 (0.000)	-0.000** (0.000)	-0.000** (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)
Тогтмол	4.584*** (0.507)	3.513*** (0.349)	3.649*** (0.362)	4.097*** (0.555)	4.057*** (0.605)	7.893*** (0.785)
N	5771	7530	7393	6149	6145	3712
Улс орнууд	157	166	162	160	160	145
Тухайн орны тогтмол нөлөөллүүд	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes
Бүлэглэсэн алдаанууд (орноор)	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes

Тайлбар: Хашилтад Гетероскедастис-робаст стандарт алдаа. \* p < 0.10, \*\* p < 0.05, \*\*\* p < 0.01.

Сонирхолтой нь байгалийн баялгийн бүх төрлийн орлогын эерэг цочрол нь [ардчиллын] удирдлагын тогтолцооны онооны өсөлтийг авчирдаг. Дээрхтэй адил, газрын тос болон газрын тос, байгалийн хий хосолсон

орлогын цочрол нөлөөллийн хувьд ч статистикийн үүднээс хамгийн их нөлөө үзүүлсэн байна. Нийт байгалийн баялаг, нөөцийн ашгийн өсөлтийн ардчилалд үзүүлэх үр нөлөөний хэмжээ бага боловч статистик ач холбогдол их байв. Энэ үр дүн нь байгалийн нөөцийн гэнэтийн ашгийн орлого ардчиллыг доройтуулдаг гэсэн судалгааны үр дүнгээс ялгаатай байгаа юм. Байгалийн баялгийн нийтлэг орлогын өсөлт ардчилалд бараг нөлөөлдөггүй дүр зураг эдгээр загвараас харагдаж байна.

Хүснэгт 3-т бүх хяналтын хувьсагчийг бүрэн багтаасан загварын үр дүнг харуулав. Эдгээр загварт байгалийн баялгийн орлогын сөрөг цочролын нөлөөлөл нь мөн адил ихэнх тохиолдолд эерэг байсан хэдий ч, коэффициентын цар хүрээ нь дээрх тайлбарласан загваруудаас бага байна. Хяналтын хувьсагчтай загварууд статистик ач холбогдлын хувьд ч бага байна. Нүүрсний орлогын сөрөг цочролын коэффициент нь бүхэлдээ ач холбогдлоо алдав. Дахин хэлэхэд, орлогын эерэг цочрол нь Полити IV онооны өсөлттэй хамааралтай байсан боловч энэ нь зөвхөн газрын тос, газрын тос ба байгалийн хий хосолсон байгалийн нөөцийн нийт орлогын өсөлтийн хувьд л хамааралтай байна.

### Хүснэгт 3. Бүрэн загвар: Полити IV онооны өөрчлөлтөд орлогын сөрөг цочролын үзүүлэх нөлөө

Хамаарах хувьсагч	Полити IV онооны $\Delta$					
	Нийт баялаг	Газрын тос ба хий	Газрын тос	Нүүрс	Төмөрлөг	Татварын бус орлого
Орлогын эх үүсвэр						
Сөрөг цочрол	0.172** (0.070)	0.335** (0.169)	0.384** (0.168)	0.134 (0.101)	0.132* (0.078)	0.167 (0.199)
Эерэг цочрол	0.157** (0.066)	0.350** (0.135)	0.364** (0.137)	0.068 (0.099)	0.094 (0.071)	0.185 (0.179)
Төрийн байгууламж (удирдлагын тогтолцоо) $Y_{t-1}$	-0.171*** (0.020)	-0.174*** (0.017)	-0.173*** (0.017)	-0.176*** (0.017)	-0.175*** (0.017)	-0.205*** (0.022)
Нийт баялгийн хамаарал $t_{-1}$	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)
Нэг хүнд ногдох ДНБ $t_{-1}$	-0.056 (0.640)	-0.416 (0.533)	-0.404 (0.513)	-0.144 (0.508)	-0.138 (0.498)	-1.414* (0.753)
Иргэний дайны илтгэгч $t_{-1}$	0.465 (0.673)	0.514 (0.673)	0.479 (0.677)	0.514 (0.679)	0.504 (0.678)	-1.248 (0.820)
Улс төрийн авлигын индекс $t_{-1}$	4.561*** (1.353)	4.081** (1.320)	4.082** (1.324)	4.452** (1.344)	4.283** (1.344)	2.990 (1.950)
Эгалитар ардчиллын индекс $t_{-1}$	17.158*** (3.966)	20.313*** (3.199)	20.298*** (3.210)	20.775*** (3.260)	20.419*** (3.204)	18.720*** (4.295)
Ардчиллын бүсийн тархалт $t_{-1}$	0.136*** (0.020)	0.127*** (0.022)	0.126*** (0.023)	0.131*** (0.022)	0.131*** (0.022)	0.109*** (0.028)
Тогтмол	1.462 (4.952)	3.878 (3.971)	3.779 (3.829)	1.723 (3.869)	1.525 (3.813)	15.577** (5.842)
N	4466	5198	5196	5056	5056	2696
Улс орнууд	152	154	154	154	154	140
Тухайн орны тогтмол нөлөөлүүд Бүлэглэсэн алдаанууд (орноор)	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes
	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes

Тайлбар: Хашилтад Гетероскедассити-робаст стандарт алдаа. \*  $p < 0.10$ , \*\*  $p < 0.05$ , \*\*\*  $p < 0.01$ .

Хяналтын хувьсагчдын коэффициентүүд мөн анхаарал татаж байна. Суурь болон бүрэн загваруудын аль алиных нь хувьд Полити онооны өндөр түвшин нь дараах үеийн өөрчлөлтийн бууралттай уялдаатай байна. Улс төрийн авлига нь дараагийн үе шатанд бүх загвар дээр Полити онооны өөрчлөлтөд томоохон, эерэг, статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлдэг.

Тэгш бус байдал, ардчиллын бүсийн тархалт нь дэглэмийн өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлдэг боловч нөлөөллийн хэмжээ нь өмнөх хувилбарынхаас хамаагүй их байдаг.

Судалгааны гол зорилго нь орлогын сөрөг, эерэг цочролын богино хугацааны дундаж үр нөлөөг тодорхойлоход оршиж байсан тул бүх дэглэмийн төрлийг судалгаанд хамруулсан. Нэмэлт дүн шинжилгээ хийхдээ: Байгалийн баялгаас хамааралтай байдал нь ардчилсан болон автократ буюу захиргаадалтын дэглэмийн хувьд өөр өөр байдаг уу? гэсэн түлхүүр асуултыг асуусан. Судалгаанд оруулсан улс орнуудыг ардчилсан болон авторитари засаглалтай гэж хоёр хуваагаад, дээрхтэй ижил загварыг ашиглах замаар ялгаатай үр нөлөөнүүдийг авч үзсэн (Хүснэгт 4, 5). Нийт нөөцийн болон газрын тосны орлогын бууралт нь автократ захиргаадалтын дэглэмтэй улсуудтай харьцуулахад ардчилсан улс орнуудын төрийн байгууламжийн оноонд эерэг өөрчлөлтүүдийг авчрах магадлал илүү байна. Тэгш эрхийн индекс өндөртэй, эргэн тойрных нь орнон ардчиллыг эрхэмлэдэг орнуудад (ардчилсан, захиргаадалтын ялгаагүй) ардчиллын оноо өсөх хандлагатай байдаг. Гайхалтай нь, улс төрийн авлига нь ардчилсан орнуудад ардчилал сайжрахад нөлөөлдөггүй хэдий ч, авторитари буюу захиргаадалтын дэглэм ардчилсан болоход нөлөөлдөг байна.<sup>11</sup>

---

11 Хоёр төрлийн дэглэмийн суурь өгөгдлийн загварын үр дүнг зохиогчоос хүсэлтээр авах боломжтой.

#### Хүснэгт 4. Бүрэн загвар: Ардчилсан орнуудын хувьд Полити IV онооны өөрчлөлтөд орлогын сөрөг цочролын үзүүлэх нөлөө (стандартчилсан Полити оноо $\geq 50$ )

Хамаарах хувьсагч	Полити IV онооны $\Delta$					
	Орлогын эх үүсвэр	Нийт баялаг	Газрын тос ба хий	Газрын тос	Нүүрс	Төмөрлөг
Сөрөг цочрол	0.239** (0.098)	0.274 (0.192)	0.434** (0.211)	0.099 (0.096)	0.059 (0.121)	0.130 (0.194)
Эерэг цочрол	0.219** (0.090)	0.255 (0.159)	0.302* (0.179)	0.055 (0.103)	0.083 (0.112)	0.170 (0.175)
Полити <sub>t-1</sub>	-0.267*** (0.056)	-0.244*** (0.053)	-0.244*** (0.053)	-0.251*** (0.055)	-0.254*** (0.056)	-0.304*** (0.064)
Нийт баялгийн хамаарал	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)
Нэг хүнд ногдох ДНБ <sub>t-1</sub>	1.452 (1.178)	0.017 (0.831)	0.024 (0.815)	0.262 (0.821)	0.232 (0.837)	0.866 (1.082)
Иргэний дайны илтгэгч <sub>t-1</sub>	-1.007 (1.217)	-0.914 (1.103)	-0.943 (1.108)	-0.987 (1.117)	-0.960 (1.119)	-2.058 (1.327)
Улс төрийн авлигын индекс <sub>t-1</sub>	3.040 (2.646)	2.800 (2.434)	2.776 (2.426)	3.022 (2.543)	2.988 (2.551)	0.234 (2.507)
Эгалитар ардчиллын индекс <sub>t-1</sub>	17.347** (6.772)	22.516*** (5.845)	22.293*** (5.844)	23.054*** (6.052)	23.264*** (6.138)	7.810 (4.812)
Ардчиллын бүсийн тархалт <sub>t-1</sub>	0.160*** (0.031)	0.169*** (0.030)	0.168*** (0.030)	0.172*** (0.031)	0.173*** (0.031)	0.101** (0.033)
Тогтмол	-1.100 (10.531)	7.526 (7.203)	7.504 (7.098)	5.736 (7.440)	6.003 (7.324)	14.419 (9.289)
N	2512	2848	2848	2742	2742	1632
Улс орнууд	121	123	123	123	123	109
Тухайн орны тогтмол нөлөөлүүд Бүлэглэсэн алдаанууд (орноор)	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes

Тайлбар: Хашилтад Гетероскедассити-робаст стандарт алдаанууд. \*  $p < 0.10$ , \*\*  $p < 0.05$ , \*\*\*  $p < 0.01$ .

**Хүснэгт 5. Бүтэн загвар: Авторитари буюу захиргаадалтын засаглалтай орнуудын хувьд, Полити IV дэх онооны өөрчлөлтөд, орлогын сөрөг цочролын үзүүлэх нөлөө (стандартчилсан Полити оноо <50)**

Хамаарах хувьсагч	Полити IV онооны Δ					
Орлогын эх үүсвэр	Нийт баялаг	Газрын тос ба хий	Газрын тос	Нүүрс	Төмөрлөг	Татварын бус орлого
Сөрөг цочрол	0.190* (0.109)	0.403 (0.302)	0.460 (0.280)	0.396 (0.296)	0.197* (0.112)	0.422 (0.420)
Эерэг цочрол	0.156 (0.097)	0.408 (0.253)	0.364** (0.137)	0.189 (0.235)	0.067 (0.104)	0.333 (0.369)
Полити <sub>t-1</sub>	-0.140** (0.044)	-0.107** (0.040)	-0.105** (0.040)	-0.108** (0.042)	-0.106** (0.042)	-0.197** (0.064)
Нийт баялгийн хамаарал	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)
Нэг хүнд ногдох ДНБ <sub>t-1</sub>	0.413 (0.664)	0.370 (0.869)	0.343 (0.846)	0.941 (0.773)	0.693 (0.764)	-1.420 (0.942)
Иргэний дайны илтгэгч <sub>t-1</sub>	1.955 (1.184)	1.778* (1.016)	1.734* (1.014)	1.759* (1.028)	1.819* (1.032)	0.106 (1.341)
Улс төрийн авлигын индекс <sub>t-1</sub>	5.182** (2.176)	3.625* (2.090)	3.612* (2.091)	3.937* (2.156)	3.690* (2.106)	2.092 (3.825)
Эгалитар ардчиллын индекс <sub>t-1</sub>	48.250*** (12.263)	32.980** (12.327)	33.281** (12.254)	33.634** (12.625)	32.314** (12.607)	65.787** (20.835)
Ардчиллын бүсийн тархалт <sub>t-1</sub>	0.198*** (0.033)	0.139*** (0.037)	0.139*** (0.037)	0.141*** (0.037)	0.138*** (0.037)	0.249*** (0.056)
Тогтмол	-10.224** (4.965)	-6.863 (6.072)	-6.753 (5.860)	-10.583** (5.311)	-9.188* (5.336)	3.510 (6.340)
N						
Улс орнууд	1954	2350	2348	2314	2314	1064
Тухайн орны тогтмол нөлөөллүүд	104	105	105	105	105	81
Бүлэглэсэн алдаанууд (орноор)	Yes	Yes	Yes	Yes	Yes	Yes

Тайлбар: Хашилтад Гетероскедастити-робаст стандарт алдаа. \* p < 0.10, \*\* p < 0.05, \*\*\* p < 0.01.

Туршилтын хугацаанд, судалгааны дээжээс загварчлал тухай бүрт нь нэг орныг хасах замаар (a jackknife test) үр дүнгийн найдвартай байдлыг шалгасан. Суурь болон бүтэн загварын үр дүнгийн аль аль нь үндсэн шинжилгээний үр дүнгээс ялгаагүй байна. Нэг ялгаа байгаа нь суурь загвар дахь нийт баялгийн орлогод үзүүлэх цочролын хувьд Полити t-1 коэффициент нь сөргөөс эерэг болж өөрчлөгдсөн байв.

**Дүгнэлт**

“Баялгийн хараал”-ын тухай судалгааны ном зохиол нь гол төлөв уг “хараал” үнэхээр байдаг эсэхийг тодорхойлоход анхаарал хандуулж бусад сонирхолтой бөгөөд чухал асуудлуудыг орхисон байдаг. Чухамдаа, баялгаас хамаарах асуудалд чиглэсэн олон судалгаа нь байгалийн

нөөцийн орлогын эерэг, ач холбогдол бүхий цочролууд нь байгалийн баялаг бага орнуудтай харьцуулахад нөөцийг олборлон үйлдвэрлэгч орнуудыг хэрхэн илүү доройтуулдаг тухай асуудалд анхаардаг. Ингэснээр ойлгомжгүй олон асуудлыг орхигдуулдаг. Үүний нэг нь орлогын сөрөг цочрол нь улс төрийн дэглэмийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөх тухай асуудал юм.

Энэ бүлгийн гол зорилго нь байгалийн баялгийн зөрөг цочрол, улс төрийн дэглэмүүдийн хоорондын уялдаа холбоог тодруулахад оршсон билээ. Түүнээс гадна орлогын гэнэтийн эерэг болоод сөрөг цочролуудын улс төрийн дэглэмд үзээлэх нөлөө нь тэгш хэмтэй байдаг эсэхийг судалж үзэхээр зорьсон билээ. 1961-2016 онд байгалийн баялгийн орлогуудаас, тэр дундаа газрын тос, газрын тос ба байгалийн хий хосолсон орлогоос үүдсэн сөрөг цочролууд нь төрийн байгууламжийн (удирдлагын тогтолцоо) оноонд [ардчилалд] үнэмлэхүй бөгөөд богино хугацааны эерэг нөлөө үзүүлжээ. Гэхдээ энэ нөлөө нь үндсэндээ ардчилсан дэглэмийн өсөлт сайжруулалтаас үүдэн гарч ирсэн. Газрын тосны орлогын бууралт нь ардчилсан засаглалтай орнуудын Полити IV оноог өсгөдөг бол авторитари буюу захиргаадалтын засаглалтай орнуудад нөлөө үзүүлдэггүй. Авторитар засаглалтай орнуудад зөвхөн төмөрлөгийн орлогын бууралт ардчиллын сайжирсан оноотой сулхан бөгөөд эергээр холбогдож байлаа.

Энэхүү бүлэгт судалсан байгалийн баялгийн орлого болон улс төрийн дэглэмийн үнэлгээний уялдаа холбоо нь зөвхөн корреляцийн хамааралтай биш учир шалтгааны хамааралтай байж болзошгүй юм. Өөрөөр хэлбэл энэ судалгаан дээр үндэслэн байгалийн баялгийн орлогын өөрчлөлт нь улс төрийн дэглэмд шууд нөлөөлдөг гэж аргумент гаргаж ирж болно. Анхны ялгааны загварын давуу тал нь судалгаанд оруулсан улс орон бүрт жилээс жилд гарч буй өөрчлөлт дээр үндэслэн дүгнэлт гаргадаг учир судалгаанд харгалзаж үзээгүй улс орны түвшний хүчин зүйлс байгалийн баялаг болон улс төрийн дэглэмийн харилцан холбоог булингартуулах магадлал багатай. Баялгаас орж ирж буй орлого, улс төрийн дэглэм хоёр зэрэг өөрчлөгдөж байгааг харин үгүйсгэх аргагүй. Гэхдээ онолын хувьд нэг жилд гарч буй улс төрийн дэглэмийн онооны өөрчлөлт тухайн жилд байгалийн баялгаас орж ирж буй орлогод шууд нөлөөлөх магадлал бага. Иймд судлагдсан хоёр хувьсагчийн учир шалтгааны холбогдлыг дараа дараагийн судалгаанд нарийвчлан үзэх шаардлагатай.

Уг судалгааны ажлын өөр нэг тэмдэглүүштэй ололт бол байгалийн баялгийн орлогын эерэг ба сөрөг цочрол нь эсрэгцсэн нөлөө үзүүлдэггүй гэдгийг харуулсан. Тэдгээрийн Полити IV онооны өөрчлөлтүүдэд үзүүлэх нөлөө нь хэмжээ болон чиглэлийн хувьд адилхан эерэг ажээ. Судалгааны ажлуудад харуулснаар байгалийн баялгаас орох орлогын түвшин нь ардчиллын үйл явцыг саатуулж болзошгүй гэж үздэг, гэвч энэ судалгааны үр дүнгээс харахад орлогын түвшний бус өөрчлөлтүүд ардчиллын үйл явцад хувь нэмэр оруулж болох юм.

Судалгааны илүү өргөн хүрээнд илэрхийлж буй утга нь хоёр талтай юм. Нэгдүгээрт, байгалийн баялгийн хамаарлын динамик өөрчлөлтийг авч үзэх нь баялгийн хамаарлын судалгаанд чухал. Дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэлтэй харьцуулж үзвэл байгалийн баялгийн орлогууд нь богино хугацаанд ихээхэн хэмжээгээр өөрчлөгддөг. Иймэрхүү тогтворгүй, хувирамтгай байдал нь байгалийн баялгаар баян орнуудад эдийн засаг, санхүүгийн хүндрэл үүсгэдэг гэж үздэг. Мэргэжилтнүүдийн зөвлөж байгаагаар, улс орнууд баялгаас олох орлогын гэнэтийн бууралтаас үүдэх сөрөг үр дагавраас зайлсхийхийн тулд нөөц баялгийн салбаруудаас холдож, эдийн засгаа төрөлжүүлэх хэрэгтэй. Гэхдээ байгалийн баялгийн орлогын бууралт нь улс төрийн нээлттэй байдалд хор холбогдолгүй байж магадгүй бөгөөд үнэндээ энэ нь зарим тодорхой орнуудын хувьд өөрчлөлт шинэчлэлт хийх торгон мөч болж болох юм.

Хоёрдугаарт, энэ судалгааны ажлын үр дүн, ололт амжилт нь байгалийн “баялгийн хараал”-ыг засаж залруулах бодлогын маш сонирхолтой хэлбэрийг олж хэрэгжүүлэхийг дэмжиж байна. Нэг талаас, байгалийн баялгийн хараат байдал (гэнэтийн ашгийн орлого) буурах нь дэлхийн түвшинд ардчилсан засаглалуудад үр өгөөжтэй байж болохыг харууллаа. Нөгөө талаас, сөрөг цочролууд нь зөвхөн аль хэдийн ардчилсан засаглалтай болчихсон улс орнуудад л эерэг өөрчлөлт авчрах магадлалтай юм. Ирээдүйд эдгээрийн цаана оршиж буй механизмуудыг туршин судлах замаар энэ судалгааны ажлын хүрээнд олж мэдсэн дундаж үр нөлөөллүүдийг задлан шинжилж түүнчлэн эдгээр дүн шинжилгээний далд утга санааг нээн илрүүлэх боломжтой.

## Ном зүй

- Acemoglu, Daron, Simon Johnson, James A. Robinson and Pierre Yared. 2008. “Income and Democracy.” *American Economic Review*, 98(3): 808–842.
- Ahmed, Faisal Z. 2012. “The Perils of Unearned Foreign Income: Aid, Remittances, and Government Survival.” *American Political Science Review*, 106(1): 146–165.
- Andersen, Jørgen J. and Michael L. Ross. 2014. “The Big Oil Change: A Closer Look at the Haber-Menaldo Analysis.” *Comparative Political Studies*, 47(7): 993–1021.
- Bornhorst, Fabian, Sanjeev Gupta and John Thornton. 2009. “Natural Resource Endowments and the Domestic Revenue Effort.” *European Journal of Political Economy*, 25(4): 439–446.
- Brollo, Fernanda, Tommaso Nannicini, Roberto Perotti and Guido Tabellini. 2013. “The Political Resource Curse.” *American Economic Review*, 103(5): 1759–1796.

- Coppedge, Michael, John Gerring, Staffan I. Lindberg, Svend-Erik Skaaning, Jan Teorell, David Altman, Frida Andersson, Michael Bernhard, M. Steven Fish, Adam Glynn, Allen Hicken, Carl Henrik Knutsen, Kyle L. Marquardt, Kelly McMann, Valeriya Mechkova, Pamela Paxton, Daniel Pemstein, Laura Saxer, Brigitte Seim, Rachel Sigman and Jeffrey Staton. 2017. "V-Dem Codebook v7." Varieties of Democracy (V-Dem) Project. University of Gothenburg and University of Notre Dame. Accessed July 1, 2018. URL: <https://www.v-dem.net/en/>.
- De Mesquita, Bruce Bueno and Alastair Smith. 2010. "Leader Survival, Revolutions, and the Nature of Government Finance." *American Journal of Political Science*, 54(4): 936–950.
- Dunning, Thad. 2008. *Crude Democracy: Natural Resource Wealth and Political Regimes*. New York: Cambridge University Press.
- Egorov, Georgy, Sergei Guriev and Konstantin Sonin. 2009. "Why Resource-Poor Dictators Allow Freer Media: A Theory and Evidence from Panel Data." *American Political Science Review*, 103(4): 645–668.
- Friedman, Thomas L. 2006. "The First Law of Petropolitics." *Foreign Policy*, 154(3): 28–36.
- Gleditsch, Kristian Skrede and Michael D Ward. 2006. "Diffusion and the International Context of Democratization." *International Organization*, 60(4): 911–933.
- Gourevitch, Peter. 1986. *Politics in Hard Times: Comparative Responses to International Economic Crises*. New York: Cornell University Press.
- Haber, Stephen and Victor Menaldo. 2011. "Do Natural Resources Fuel Authoritarianism? A Reappraisal of the Resource Curse." *American Political Science Review*, 105(1): 1–26.
- Haggard, Stephan and Robert R Kaufman. 1997. "The Political Economy of Democratic Transitions." *Comparative Politics*, 29(3): 263–283.
- Leite, Mr Carlos and Jens Weidmann. 1999. *Does Mother Nature Corrupt: Natural Resources, Corruption, and Economic Growth*. Washington, DC: International Monetary Fund.
- Lipset, Seymour Martin. 1959. "Some Social Requisites of Democracy: Economic Development and Political Legitimacy." *American Political Science Review*, 53(1): 69–105.
- Manion, Melanie. 2004. *Corruption by Design: Building Clean Government in Mainland China and Hong Kong*. Cambridge, MA: Harvard University Press.



- Marshall, Monty G, Ted Robert Gurr and K. Jagers. 2017. "Polity IV Project Manual." Polity IV Project. Accessed July 1, 2018. URL: <https://www.systemicpeace.org/polityproject.html>.
- Mechkova, Valeriya, Anna Lührmann and Staffan I. Lindberg. 2017. "How Much Democratic Backsliding?" *Journal of Democracy*, 28(4): 162–169.
- Montinola, Gabriella R. and Robert W Jackman. 2002. "Sources of Corruption: A Cross-Country Study." *British Journal of Political Science*, 32(1): 147–170.
- Paler, Laura. 2013. "Keeping the Public Purse: An Experiment in Windfalls, Taxes, and the Incentives to Restrain Government." *American Political Science Review*, 107(4): 706–725.
- Prichard, Wilson, Paola Salardi and Paul Segal. 2018. "Taxation, Non-Tax Revenue and Democracy: New Evidence Using New Cross-Country Data." *World Development*, 109: 295–312.
- Robinson, James A, Ragnar Torvik and Thierry Verdier. 2006. "Political Foundations of the Resource Curse." *Journal of Development Economics*, 79(2): 447–468.
- Rodrik, Dani. 1996. "Understanding Economic Policy Reform." *Journal of Economic Literature*, 34(1): 9–41.
- Ross, Michael. 2004. "Does Taxation Lead to Representation?" *British Journal of Political Science*, 34(2): 229–249.
- Ross, Michael. 2015. "What Have We Learned about the Resource Curse?" *Annual Review of Political Science*, 18: 239–259.
- Ross, Michael and Paasha Mahdavi. 2014. "Oil and Gas Data." Dataverse: <http://hdl.handle.net/1902.1>. Tsui, Kevin K. 2011. "More Oil, Less Democracy: Evidence from Worldwide Crude Oil Discoveries." *The Economic Journal*, 121(551): 89–115.
- World Bank. 2016. *World Development Indicators 2016*. Washington, DC: World Bank Publications.
- Wright, Joseph, Erica Frantz and Barbara Geddes. 2015. "Oil and Autocratic Regime Survival." *British Journal of Political Science*, 45(2): 287–306.



## **Байгалийн баялгийн ашгаараа сонгуулийн санал худалдан авах нь: Эдийн засгийн популизм ба байгалийн баялгаас хамааралтай ардчилсан орнууд дахь клиентелизм**

**Самбуугийн Болдсайхан**

Яагаад зарим орон байгалийн баялгаа үр дүнтэй ашиглаж байхад зарим нь үрэн таран хийдэг вэ? Сонгуулийн өрсөлдөөн байгалийн баялгийн гай гамшгийг хүндрүүлэх эсвэл бууруулахад ямар үүрэг гүйцэтгэдэг вэ? Сонгогчдын ихэнх нь орлого багатай, ядуу байгаа нөхцөлд сонгуулийн хүчтэй өрсөлдөөнд оролцож буй улс төрийн нам баялгийн орлогоо эдийн засгийн популизм болон клиентелизмд зарцуулж санал худалдаж авдаг талаар Монгол, Гана, Ботсван зэрэг баялгаас хамааралтай ардчилсан орны нөхцөл байдалд тулгуурлан судлан үзлээ. V-Dem төслийн эксперт шинжээчдийн санал асуулгын өгөгдлийг ашиглан, уг онолын гол үндэслэлийг эмпирик аргаар шалгасан. Нөөц баялаг заавал гай зовлон авчрах албагүй, харин яаж зарцуулахаас хамааран үр өгөөжтэй ч байж болно гэдгийг энэхүү судалгаа харуулсан ба сонгуулийн өрсөлдөөн бага байвал байгалийн баялгаас хамааралтай байх нь програматик буюу бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрийн хүрээнд нам ба сонгогчийн хэлхээ холбоо эерэг шинжтэй байдаг. Харин өрсөлдөөн нэмэгдэж, ядууралд өртсөн үед улс төрийн намууд илүү клиентелист байдалтай болдгийг энэ судалгаа харууллаа. Ардчиллын гол институци буюу улс төрийн намуудад байгалийн баялаг хэрхэн нөлөөлж байгааг судлах замаар баялгийн хараалын (resource curse) талаарх өнөөгийн хуримтлагдсан онолын мэдлэгийг өргөжүүлэхээр зорьсон болно. Энэ судалгаа нь хоорондоо хамааралгүй хоёр томоохон салбар сэдэв болох баялгийн хараал болон улс төрийн нам, сонгогчид хоорондын хариуцлагын хамаарал гэсэн сэдвүүдийг холбож буй юм.

### **Оршил**

Байгалийн нөөц баялаг нь эдийн засгийн хөгжил, сайн засаглалд үр шим бий болгох бус, хор хохирол учруулахыг “баялгийн хараал” хэмээн нэрлэдэг (Auty, 1993; Sachs and Wagner, 1995; Gylfason, 2001; Humphreys et al., 2007; Ross, 2015). Судлаачдын олонхын үзсэнээр, баялаг нь заавал хараал байх албагүй, харин ч тухайн улс орон ашигт малтмалаас олж буй ашгаа хэрхэн удирдаж зарцуулж буй нь энэхүү сөрөг үр дүнгээс зайлсхийж чадах эсэхийг тодорхойлж байдаг ажээ (Imi, 2007; van der Ploeg, 2011). Тиймээс судлаачид ашигт малтмалаас хамааралтай улс орнуудыг орлогын хэлбэлзлээ удирдан тэнцвэржүүлэхийн тулд түүхий

эдийн үнийн өсөлт, уналтын мөчлөгийг сөрсөн төсвийн зарлагын бодлого хэрэгжүүлэх (van der Ploeg and Poelhekke, 2007), түүхий эдийн хамаарлыг бууруулах урт хугацааны хөрөнгө оруулалтуудыг эрэмбэлэх, бүтээмжээ сайжруулахын тулд хүмүүн капиталын хуримтлалыг нэмэгдүүлэхийг (Humphreys et al., 2007; van der Ploeg, 2011) зөвлөдөг.

Ашигт малтмалын орлогынхоо дийлэнх хэсгийг хөрөнгө оруулалтын санд хадгалж урт хугацааны, олон нийтэд хэрэгцээтэй, байнгын өгөөж өгөх төслүүдэд ашиглах замаар баялгийн хараалаас зайлсхийж чадсан Ботсван, Норвеги зэрэг улс орны түүхэн туршлага дээрх бодлогын зөвлөмжийн үр дүнг илтгэх тод жишээ юм (Mehlum et al., 2006; Lewin, 2011). Гэвч олон орон эдийн засгийн популизм, клиентелизмийн замаар байгалийн баялгаас олсон орлогоо үрэн таран хийжээ. Жишээ нь газрын тос олборлогч Мексик, Венесуэл, Нигери зэрэг орон түүхий эдийн үнийн өсөлт уналтын мөчлөг дагасан зарцуулалт, хэт их зээлээс үүдэн 1980-аад онд дампуурч байжээ (Humphreys et al., 2007). Хамгийн сүүлийн жишээ Гана, Монгол Улс их хэмжээний зээл авч богино настай үнийн өсөлтийн үеэр хэт өндөр зардал гаргаж байсан ба эдгээр ашигт малтмалаар баялаг ардчилсан засаглалтай улсуудыг Олон улсын валютын сан (ОУВС)-гийн хөтөлбөр аварсан түүхтэй.

Байнгын бодлогын зөвлөмж, түүхийн их сургамж байхад зарим улс яагаад байгалийн баялгаа эдийн засгийн популизм, клиентелизмээр дамжуулан үрэн таран хийж, зарим нь яагаад илүү өндөр бүтээмжтэй төсөлд хөрөнгө оруулалт хийдэг вэ? Энэхүү судалгааны өргөн хүрээний асуултад хариулт өгөхийн тулд судлаачийн зүгээс клиентелизм, эсвэл бодлого мөрийн хөтөлбөрт суурилагүй (программатик бус) улс төрийн нам болон сонгогчдын уялдаа холбоо нь баялгийн засаглал муу байх, буруу удирдахад хүргэдэг хэмээн таамаглаж байна. Байгалийн баялаг ихтэй, ардчилсан улс оронд байгалийн баялаг, ашигт малтмалын орлогыг тухайн улсын эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулахад зарцуулах, эсвэл ашигт малтмалаас төвлөрсөн орлогыг ирээдүйн өндөр бүтээмжтэй хөрөнгө оруулалтад зориулан хуримтлуулж буй улс төрийн нам л зөвхөн сонгуулиар санал авахын тулд өнөөдрийн зарцуулалтдаа түлхүү анхаарч буй улс төрийн намаас илүүтэй “бодлогод суурилсан мөрийн хөтөлбөртэй” (программатик) нам хэмээн тооцогдож болно. Бэлэн мөнгө тараах, бэлэг сэлт амлах эсвэл төрийн албан хаагчдын тоог хэт олноор нэмэгдүүлж санал худалдан авч байгаа нам бол “бодлогод суурилсан хөтөлбөргүй” эсвэл “клиентелист” нам хэмээн тооцогдоно. Тиймээс энэхүү бүлэгт “Ямар нөхцөлд баялаг нь улс төрийн намуудыг бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрөөс татгалзахад хүргэдэг вэ?” хэмээх асуултад хариулна.

Миний зүгээс, байгалийн баялаг нь улс төрийн нам, сонгогчдын холбоо хамааралд нөхцөлт байдлаар нөлөөлдөг хэмээн үзэж байна. Улс

төрийн нам нь сонгуулийн хүчтэй өрсөлдөөнтэй нүүр тулж, сонгогчдын дунд ядуурал их бий болсон тохиолдолд баялаг нь сонгогчидтой хийх бодлого хөтөлбөрт суурилсан харилцааг сарниулж, клиентелизмийг өдөөж өгдөг. Эсрэгээр байгалийн баялаг нь улс төрийн өрсөлдөөн бага, ядуурлын түвшин доогуур, эсвэл аль аль нь бага байвал нам болон сонгогч хоорондын холбоог илүү бодлогод суурилсан болгож бэхжүүлдэг. Сонгуулийн өрсөлдөөн өндөр байвал цөөн тооны санал сонгуулийн эцсийн үр дүнг хааш нь ч савлуулах магадлалтай гэсэн үг. Улс төрийн нөхцөл байдал тодорхойгүй байх нь улс төрийн намуудын зүгээс сонгогчдын саналыг ашигт малтмалын орлогоор худалдан авч, боломжит бүх саналыг өөртөө татан баталгаажуулж авах бохир санаа төрөх суурь болдог. Тиймээс өрсөлдөөн нь сэдэл төрүүлж, баялгийн орлого нь намуудын хувьд санал худалдан авах хэрэгсэл болно. Түүнчлэн сонгуулийн хүчтэй өрсөлдөөнд намуудын зүгээс хийх хариу үйлдэл нь сонгогчдын эдийн засгийн нөхцөл байдлаас мөн хамааралтай. Сонгогчдын бүрэлдэхүүнд харьцангуй чинээлэг иргэд зонхилох тохиолдолд санал худалдаж авах улс төрийн намын оролдлого хэт зарлагатай учир үр дүнд хүрэхгүй юм. Харин ядуурал ихээхэн газар авсан нөхцөлд улс төрийн намууд, ашигт малтмалын орлогоор санал худалдан авах хамгийн боломжит, үр дүн бүхий сонгуулийн стратеги хэмээн үздэг.

Эмпирик судалгааны аргаар улс төрийн нам, сонгогчид хоорондын холбоо хамаарлыг “Varieties of Democracy” (V-Dem) буюу В-ДЕМ төслийн экспертүүдийн хийсэн өгөгдөлд үндэслэн судалсан. Улс орнуудын хооронд хийсэн регрессийн шинжилгээний үр дүн нь судлаачийн дэвшүүлсэн гол тайлбарыг нотолж байна. Сонгуулийн өрсөлдөөн сул байгаа тохиолдолд баялгаас хамааралтай байдал нь бодлогод суурилсан улс төрийн нам болон сонгогчид хоорондын харилцаанд эерэг нөлөөлөх ч сонгуулийн өрсөлдөөн ширүүсэхийн хэрээр дээрх нөлөөлөл сөрөг болох нь нэмэгдэж байна. Энэ нь хөгжиж буй орнуудад байгалийн баялаг заавал гай зовлон авчрах албагүй, харин яаж зарцуулахаас хамааран үр өгөөжтэй ч байж болохыг харуулж байна. Сонгуулийн өрсөлдөөн сул байх үед баялаг нь бодлогод суурилсан мөрийн хөтөлбөр бүхий улс төрийн намыг улам бэхжүүлж болно. Гэсэн ч улс төрийн намуудын ширүүн өрсөлдөөн, ихээхэн газар авсан ядууралтай хослох тохиолдолд клиентелизмийг улам өдөөж байна.

Энэхүү бүлэг нь дараах хэсгээс бүрдэнэ. Эхлээд баялгийн хараалын талаар хийсэн судалгааг тоймлосон ба эдгээр судалгаа нь байгалийн баялгийн ардчилсан тогтолцоотой улс оронд үзүүлэх нөлөөг хангалттай хэмжээнд судлан үзээгүй болохыг дурдсан. Дараагийн хэсэгт байгалийн баялгаас хамааралтай байдал нь хэрхэн улс төрийн нам-сонгогчид хоорондын холбоо хамааралд нөлөөлөх нь тухайн улсын улс төрийн нам хоорондын сонгуулийн өрсөлдөөний болон сонгогчдын ядуурлын

түвшнээс хамаардаг болохыг харуулсан ерөнхий онолын загвар дэвшүүлсэн. Энэхүү загварыг эмпирик байдлаар дараагийн хэсэгт шалгаж, өгөгдлийн эх сурвалж, загварын тодорхойлолт, үр дүнг тусган харуулсан. Сүүлийн хэсэгт судалгаанаас гарсан дүгнэлтийг тусгасан.

## Өмнөх судалгааны тойм

Байгалийн баялгийн хараал сэдвээр өмнө хийсэн судалгаанд ашигт малтмалын баялгийг төрөл бүрийн эдийн засаг, нийгэм болон улс төрийн гажуудалтай холбон үзсэн байдаг. Зарим судалгаа нь тодорхой төрлийн байгалийн баялаг (жишээ нь газрын тос, байгалийн хий болон ашигт малтмал) нь эдийн засгийн хөгжил, сайн засаглалыг сааруулж болно гэж тусгасан байдаг (Isham et al., 2005; Boschini et al., 2007). Олон улс орныг хамарсан эконометриксийн судалгаа нь баялгаас хамааралтай байдал, нөөцөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг баталсан байдаг ч, эдгээр үр нөлөө бий болдог далд учир шалтгааны механизмыг бүрэн хэмжээнд тогтоон гаргаагүй байна. Өмнө хийсэн судалгаа нь “Голланд өвчинтэй” хамаарах цэвэр эдийн засгийн механизмд л төвлөрөн хийгдэж ирсэн (Corden and Neary, 1982; Gelb et al., 1988; Auty, 1993) бол сүүлийн үед хийсэн судалгаа нь “rent seeking” буюу ашиг хөөцөлдөх явдлыг байгалийн баялгийг эдийн засгийн өсөлт бага байх, засаглал муудахтай холбож буй гол механизм хэмээн үзэх болжээ. Зарим эрдэмтний зүгээс гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг хязгаарлах хяналт болон эрх мэдлийн тэнцвэрийн ач холбогдлыг онцгойлон дурджээ (Tornell and Lane, 1999; Mehlum et al., 2006). Бусад судлаачийн зүгээс, институциуд нь өөрсдөө байгалийн баялгийн нөлөөнд угийн өртөмтгий, баялаг нь авлигыг өөгшүүлж, цаг хугацаа өнгөрөх тусам институцийн чанарыг гажуудуулж байдаг хэмээн үзжээ (Sala-i-Martin and Subramanian, 2003; Isham et al., 2005; Bulte et al., 2005).

Сүүлийн үеийн ихэнх судалгаанд институтийн чанарын асуудлаар шинжилгээ хийхдээ Polity IV буюу Полити IV төслийн гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн хязгаар (executive constraints) зэрэг хэт өргөн хүрээний хэмжигдэхүүнийг ашиглах болжээ. Эдгээр уламжлалт өгөгдөл, хувьсагчид нь тухайн улс орны засаглалын нийтлэг чанарын түвшнийг үнэлэх олон тооны давхцал бүхий хэсгээс бүрдсэн байдаг. Үүнд төрийн албаны чадвар, хуулийн засаглал, авлигын цар хүрээ, хяналт ба тэнцвэр, хөрөнгийн эрхийг хамгаалах байдал зэрэг өгөгдөл багтсан байдаг. Ахмадов болон Гуляев (2016) нарын зүгээс эдгээр хэт өргөн хүрээний үзүүлэлтийг ашиглах нь яг ямар институци—ардчилсан улс төрийн, эсвэл ердөө л өндөр чанарын—баялгийн хараалыг бууруулахад чухал үүрэгтэй болохыг тодорхойлоход хүндрэлтэй хэмээн үзэж байна.

Өнөө үед хийж буй судалгаанд улс орнуудад тогтсон засаглал хоорондын ялгаатай байдал нь ашигт малтмалын баялгийн үзүүлэх

нөлөөг өөрчлөх боломжтой эсэхийг тэр бүр харгалзан үзэхгүй байна. Тиймээс ч судлаачид автократ дэглэмтэй харьцуулбал, хэдийн хэвшиж тогтсон ардчилсан дэглэмтэй улсуудад байгалийн баялгийн хараал хэрхэн үйлчилдэг тухай асуултыг алгасах хандлагатай байдаг. Байгалийн баялаг ихтэй ихэнх улс өмнө нь сул хөгжсөн институци бүхий, автократ улсууд байсныг харгалзан өмнө хийсэн судалгаа нөөц баялаг нь авторитари дэглэм (Ross, 2001; Dunning, 2008) болон төр-нийгмийн холбоосны сулралд (Karl, 1997) хөтөлдөг эсэхийг л ихээр судалжээ. Гэвч одоогийн байдлаар дундажлан авч үзвэл, байгалийн баялгаар баян улс орнууд 1980-аад оны үед тохиосон ашигт малтмалын үнийн хэт өндөр өсөлтөөс хойш илүү ардчилгдаж (Collier and Hoeffler, 2009), мөн ардчилсан дэглэмийг хэдийн тогтоосон Монгол, Зүүн Тимор болон Гана зэрэг улс орон ч их хэмжээний ашигт малтмалын нөөцийг нээн илрүүлээд байгаа юм. Шинээр үүсэн гарч буй энэхүү улс төр-эдийн засгийн нөхцөл байдал нь ардчилсан дэглэмтэй улс орнуудын сайн засаглалд байгалийн баялаг сөрөг нөлөө хэрхэн үзүүлэх магадлалтай тухай ойлголтоо шинэчлэх шаардлага үүсгэж байна.

Өмнө хийсэн судалгаанд байгаа энэхүү цоорхойг нөхөхийн тулд миний зүгээс байгалийн нөөцөөс хамааралтай байдал нь ардчилсан нийгэм дэх дотоодын улс төрийн институтүүдэд үзүүлэх нөлөөллийг онолын үүднээс тодорхойлохыг зорилоо. Тиймээс миний судалгаа нь хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал бөгөөд зөвхөн чөлөөт шударга сонгууль явагдаж, улс төрийн өрсөлдөөн бодитоор өрнөж буй улс орнуудын суурь нөхцөл байдлын хүрээнд хийгдсэн болно. Мөн хэт өргөн хүрээний институцийн чанар хэмээх ойлголтыг задлан авч, нэг хувьсагч буюу улс төрийн намуудын хэрхэн сонгогчидтойгоо холбогдож буй талаар судалсан болно.

## Онолын загвар

Жубилейн газрын тосны орд нээгдсэний дараахан, 2007 онд, Гана улсын парламент газрын тосны орлогын 30 хувийг улсынхаа газрын тосны санд хуримтлуулж, үнийн хэлбэлзлийн үед ашиглах хуулийг баталжээ (Sovereign Wealth Institute, 2017). Байгалийн баялгийн хараалаас ирэх болзошгүй эрсдэлийг сайтар тооцоолсон Гана улсын парламент тухайн сангийн зарцуулалтыг хязгаарласан хатуу журам гарган мөрдүүлжээ. Гэвч Засгийн газар нь гадаадаас 2 тэрбум гаруй долларын зээл авахдаа газрын тосны ирээдүйн орлогоо шууд бус барьцаалах замаар энэхүү журмаас зайлсхийжээ. Улмаар Засгийн газар энэхүү мөнгөний дийлэнхийг клиентелист шинжтэй зардалд зарцуулжээ. Жишээ нь төрийн албан хаагчдын цалинг 50 хүртэл хувиар нэмж, энэ мөнгөөр санхүүжүүлжээ (Collier, 2017). Газрын тосны үнэ унахад Гана улс өрийн дефолт болохоос сэргийлэн ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдах арга замыг 2015 оноос эрэлхийлэх шаардлага үүсжээ (IMF, 2015).

Гана улстай гайхалтай адил хэлбэрээр Монгол Улсын Засгийн газар ч 2004-2014 онд ашигт малтмалын үнийн өсөлтийн үеэр их хэмжээний гадаад бонд гарган, олон улсын санхүүгийн зах зээлээс асар их мөнгө зээлсэн түүхтэй. Үүнээс, төвлөрсөн мөнгөний ихэнхийг төрөл бүрийн “цагаан зааны”<sup>1</sup> төсөл, эдийн засгийн хувьд популист санал худалдан авахад л зарцуулжээ. Энэхүү их өр нь төрийн зардлын өсөлттэй хавсран Монгол Улсыг санхүүгийн сүйрлийн ирмэгт авчирсан билээ. 2017 онд Монгол Улс улам өсөн нэмэгдэж байгаа өрийн хямралаас сэргийлэхийн тулд ОУВС-аас санхүүгийн дэмжлэг хүсэх шаардлагатай болжээ (Saker, 2017). Байгалийн баялгийн хараалын талаар өргөн мэдлэгтэй, үүний нөлөөллийг бууруулах улс төрийн олон арга зам байсаар байхад Монгол, Гана зэрэг ардчилсан улсууд яагаад байгалийн баялгийн ашгаа буруу зарцуулах болсон бэ?

### ***Байгалийн баялагтай орны улс төрийн намуудын сонгуулийн стратеги***

Их хэмжээний байгалийн баялаг нь тухайн улс орон төсвийн орлого бүрдүүлэхэд тулгарах сорилтыг бууруулж ашигт малтмалын олборлолтоос татвар, роялти болон хүүгийн төлбөр зэргээр дамжуулан их хэмжээний орлогыг төсөвт төвлөрүүлдэг. Ашигт малтмалын үнийн өсөлтийн үед эрх барьж буй засгийн газар нь дараагийн сонгуульд ялалт байгуулахын тулд ашигт малтмалын үнийн хөөрөгдлийн улмаас нэмэгдэж буй орлогыг олон хэлбэрээр ашиглах магадлал өндөртэй байдаг. Үүнийг хялбаршуулан авч үзвэл, эрх баригч намд буй хөрөнгө зарцуулах сонголтыг сонгуулийн стратегийн хоёр тусдаа, өргөн хүрээний ангилалд хуваан авч үзэж болох ба эдгээр нь нэг талаас клиентелист стратеги, нөгөө талаас бодлогод суурилсан мөрийн хөтөлбөр боловсруулах буюу “программатик” стратеги юм (Stokes et al., 2012).

Клиентелист стратеги баримталсан эрх баригч нам, байгалийн баялгийн орлогыг зөвхөн өөрийн үнэнч сонгогчдод болон саналаа аль намд өгөхөө хараахан шийдээгүй сонгогчдод материаллаг бэлэг сэлт, бэлэн мөнгө, ажлын байр гэх мэт зүйлс өгч саналыг нь худалдан авах зорилгоор зарцуулах боломжтой (Kitschelt and Wilkinson, 2007). Программатик стратеги баримталсан бол эрх баригч улс төрийн нам илүү өргөн хүрээний, олон тооны сонгогчдын сайн сайхны төлөө баялгийн орлогыг зарцуулна. Байгалийн баялгийн ашгийг бодлогод суурилсан хөтөлбөрийн дагуу дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, төрийн албыг сайжруулах, шинэчлэл хийх, төрөөс үзүүлж буй эрүүл мэнд, боловсрол, бусад үйлчилгээг сайжруулах зорилгоор зарцуулдаг. Мөн уг

---

1 Цагаан заан гэдэг нь хэт үнэтэй боловч амин чухал биш томоохон төсөл, хөрөнгө оруулалт, эд зүйлс зэргийг илэрхийлдэг.



стратегийг баримталсан нам нь ашигт малтмалаас олсон ашгаа цаашид тогтворжуулах зорилгоор хуримтлуулах, эсвэл урт хугацааны байнгын өгөөжийг өнөөгийн, ирээдүй үед хүргэхээр баялгийн санд байршуулж болно.

Онолын үүднээс үзвэл, сөрөг хүч ч гэсэн эрх баригч намын нэгэн адил ижил төрлийн л сонгуулийн стратегийг сонгох боломжтой бөгөөд бодлогод суурилсан мөрийн хөтөлбөр үү, эсвэл клиентелист байдлаар санал худалдан авах уу гэсэн асуулттай нүүр тулгарна. Гэвч бодит байдал дээр баялгаас олж буй орлого нь төрийн санд хуримтлагдаж эрх баригч намын шийдвэрээр зарцуулагдах тул сөрөг хүч нь тухайн баялгийг, ялангуяа ашигт малтмалаас олж буй ашгийг захиран зарцуулах боломжгүй юм. Энэ тохиолдолд сөрөг хүч нь баялгаас олж буй ашгийг сонгуульд дэмжлэг авах зорилгоор ашиглах боломжгүй нь намуудын хооронд эдийн засгийн нөөцийн ялгаатай байдал үүсэж сөрөг хүчний сул тал болдог. Сөрөг хүч, уламжлалт клиентелист стратегийг баримтлан өрсөлдөх боломжгүй тул “эдийн засгийн популизм” хэмээн нэрлэгдэх сонгуулийн шинэ стратеги ашиглах замаар эрх баригчдын эдэлж буй клиентелизмийн давуу талыг сөрөх бодлого хэрэгжүүлнэ.

Өргөн хүрээнд авч үзвэл, эдийн засгийн популизмыг “хэрэглээгээ хэт нэмэгдүүлж төсвийн хөрөнгөөр “цагаан заан” бий болгоход чиглэсэн зарцуулалт хийх” хэмээн тодорхойлдог (Collier, 2017, 217). Сонгуулийн стратеги болохын хувьд, энэ нь олон нийтэд хандсан албан ёсны компани ажлын хүрээнд сонгогчдын олонход хандан их хэмжээний “ирээдүйн” өгөөж амлахыг хэлдэг. Хэдий эдийн засгийн популизм нь клиентелизмийн адилаар орлого багатай, ядуу сонгогчдын бүлгийг онилдог ч, харьцангуй чинээлэг сонгогчдыг ч татах стратеги байдлаар ашиглагдаж болно. Клиентелист материаллаг амлалттай харьцуулбал эдийн засгийн популист стратегийн хүрээнд сонгогчдод өгч буй амлалтууд нь баялгаас ногдох хувийг нэн өндөр амлах ба энэ нь бэлэн мөнгө тараах, ноогдол ашиг өгөх эсвэл төрийн өмчит компаниудын хувьцааг амлах зэргээр илэрдэг. Гэвч эдгээр нь “ирээдүйн өгөөж” буюу ам өгч байгаа нам сонгуульд ялалт байгуулсан тохиолдолд л сонгогчид хүрэх амлалт юм. Энэхүү далд, шууд бус болзолт нөхцөл (зөвхөн ялбал, ялсны дараа) нь эдийн засгийн популизмыг клиентелизмтэй ижил төстэй болгож буй гол шинж юм (Hicken, 2011).

Сонгогчдын томоохон сегментэд хандсан албан ёсны мөрийн хөтөлбөртэй байдаг тул, эдийн засгийн популизм нь бодлогод суурилсан мөрийн хөтөлбөр, програм бүхий стратегитай ижил төстэй харагдаж болно. Гэвч эдгээр ижил төстэй юм шиг байдал нь өнгөц хэсэг нь юм. Программик стратеги нь ихэнхдээ иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой бодит бодлого, үзэл суртлын жишээг багтааж байдаг (Kitschelt and Wilkinson, 2007). Тиймээс уг стратеги нь

зөвхөн сонгуулийн мөчлөгийн хооронд хэрэгжээд дуусах бус, харин урт хугацааны үр шимийг бий болгох алсыг харсан бодлого байдаг (Stokes, 2005; Kitschelt and Kselman, 2012). Эсрэгээр эдийн засгийн популист амлалт нь нэг удаагийн, агшин зуурын үр өгөөжийг л амлах ба энэ нь зөвхөн сонгогчдыг худалдан авах гэсэн оролдлогоос илүү гарахгүй юм.

Ивээн тэтгэх хөрөнгө мөнгө хомс, төсвийн хөрөнгө, орлогыг зарцуулах эрхгүй сөрөг хүчний баримтлах стратеги болох эдийн засгийн популизм нь клиентелизмийг ашиглаж буй эрх баригчдын эсрэг хэрэгжүүлэх гол арга болдог. Тиймээс эдийн засгийн популизмын үндсэн бай нь мөн л орлого багатай, ядуу сонгогчид байх ба популизм болон клиентелизмын аль аль нь ямар нэгэн материаллаг зүйлсээр сэтгэлийг нь хялбархан эргүүлж болно хэмээн үздэг. Үндсэндээ сонгогчдын саналыг шууд худалдан авах арга зам нь хомс болсон популист сөрөг хүч нь хэрэв тухайн намыг сонгох тохиолдолд, ойрын ирээдүйд сонгогчдод өгөх их хэмжээний материаллаг төлбөрийн амлалтаар дэнчин тавьдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 7 дугаар сард болсон сонгуулийг жишээ болгон авч үзье. Сөрөг хүч болох АН-аас нэр дэвшигч Х.Баттулга сонгуулийн сурталчилгааны үеэр өөрийн өрсөлдөгч, жилийн өмнө болсон УИХ-ын сонгуульд ялж, УИХ болон Засгийн газрыг бараг бүрэн мэдэлдээ авсан эрх баригч МАН-ын нэр дэвшигч М.Энхболдод саналаа худалдахгүй байхыг сонгогч олон нийтэд байнга уриалж сонгогчдод хандаж, “мөнгийг нь ав, харин саналаа надад өг... би та бүхний өрийг хүчингүй болгоно” хэмээн уриалж байжээ (Sambuу, 2017).

### ***Улс төрийн намууд хэзээ эдийн засгийн популизм болон клиентелизмийг програмтик стратегиас илүү сонгодог вэ?***

Дээр дурдсан сонгуулийн зарим стратеги дээр үндэслэн байгалийн нөөц ихтэй улс орны эрх баригч нам сонгуулийн өрсөлдөөн өндөр байвал, мөн ядуу, орлого багатай сонгогч олонтой үед клиентелист стратеги сонгон хэрэгжүүлдэг. Сонгуулийн улс төрийн өрсөлдөөн ширүүн байх нь сөрөг хүчин харьцангуй өндөр санал авах боломжтой тул, цөөн тооны ахиу санал хоёр талын хооронд хэлбэлзэн шилжиж, эцсийн ялагчийг тодруулах магадлалтай. Улс төрийн тодорхойгүй нөхцөл бүрдсэн энэ тохиолдолд улс төрийн нам өөрийн боломжит сонгогчдыг орхиж (Kitschelt and Wilkinson, 2007), харин саналаа хэнд өгөхөө мэдэхгүй (санал нь хэлбэлздэг) эсвэл сонголтыг нь ятган өөрчлөх боломжтой хэсэгт төвлөрч ажилладаг. Ядуу сонгогчид чинээлэг хэсэгтэй харьцуулбал, зарлага багатай нөлөөнд автаж тэдний санал ч чинээлэг хэсэгтэй харьцуулбал багахан хэмжээний материаллаг амлалтаар нөгөө талдаа шилждэг тул (Robinson and Verdier, 2002; Kitschelt and Wilkinson, 2007; Stokes et al., 2012) сонгуулийн санал асуулгаар улс төрийн ширүүн өрсөлдөөнтэй тулгарч буй эрх баригч нам клиентелизмийг баримтлах илүү сэдэлтэй болдог. Тиймээс

улс төрийн хүчирхэг өрсөлдөгчтэй нүүр тулах нь эрх баригчдад санал худалдан авахад түлхэц болж баялгаас олсон орлогоо энэхүү санаагаа хэрэгжүүлэхэд ашигладаг.

Эрх баригчдын зүгээс улам ширүүсэж буй сонгуулийн өрсөлдөөнд хэрэгжүүлэх хариу арга нь клиентелизм ашиглан ядуу сонгогчдоос олж авах саналын тоо нь клиентелизм ашигласны улмаас алдаж болох чинээлэг иргэдийн дэмжлэгээс илүү байж чадах эсэхээс хамаарна. Клиентелизмийн зардлын хувьд (Weitz-Shapiro, 2012) ядуу бус сонгогчдын тодорхой хувь нь ямар ч нөхцөлд клиентелист үйл ажиллагаанд дургүй байдаг ба уг стратегийг ашиглаж буй намыг дэмжихгүй байх магадлалтай. Эсрэгээр клиентелизмийн өгөөж нь саналаа худалдах ядуу сонгогчдын нийт тоо, тэдэнд зарцуулах нөөц хөрөнгийн хэмжээнээс хамааран өөрчлөгдөнө. Тиймээс клиентелизмээс хүлээх эрх баригчдын хүлээлт нь ядуурлын болон баялгийн хэмжээ өндөр нөхцөлд гарах зардлаасаа илүү байх магадлалтай. Товчоор хэлбэл, сонгуулийн өрсөлдөөн ширүүн, олон тооны ядуу сонгогч саналаа худалдахад бэлэн буй тохиолдолд эрх баригч нам их хэмжээний орлогын эх үүсвэрээ ашиглан клиентелист зарцуулалт хийхийг хичээх болно.

Өмнө дурдсанчлан, төрийн эрхэнд байгаа улс төрийн нам баялгаас олсон орлогоо клиентелизмд зарцуулах тохиолдолд сөрөг хүчинд сул тал үүсдэг. Халуун өрсөлдөөн бүхий, өрсөлдөгч нь клиентелизмд төвлөрч буй сонгуулийн үеэр баримтлах сөрөг хүчний хамгийн боломжит стратеги нь эдийн засгийн популизм болно. Сонгогчдод амлаж буй “ирээдүйн өгөөж” хэр сэтгэл татам байхаас хамааран эдийн засгийн хувьд популист сонгуулийн стратеги нь ядуу сонгогч нартай хамааралтайгаар эрх баригчдын эдэлж буй давуу талуудыг сааруулах эсэх нь тодорхой болно. Сонгогчид нэн тэргүүн материаллаг хэрэгцээгээ хангах сонголт хийх бус харин ирээдүйд ирэх их хэмжээний өгөөж харж сонголтоо хийхийг ятгахын тулд сөрөг хүчний өгөх сонгуулийн амлалт нь сонгогчдод итгэл төрүүлэхүйц байх шаардлагатай. Энэ үед их хэмжээний баялгийн орлого улсын төсөвт төвлөрч байгаа нь намын популист амлалтыг иргэдэд илүү итгэл үнэмшилтэй болгож өгдөг.

Клиентелизмийг сөрөх стратеги болгон сөрөг хүч эдийн засгийн популизмыг сонговол, эрх баригч хүчин нь тухайн амлалтаас үүдэн олон тооны сонгогчийн санал эргэж сөрөг хүчинд урваж, сонгуулийн үр дүнд нөлөөлж болно гэж үзвэл бас л ижил хэмжээний популист амлалтыг өгөхөөс өөр аргагүй болно. Ингээд хоёр нам нэгэн ижил эдийн засгийн популист амлалтыг өгснөөр, аль ч тал нь амлалтаасаа буцах аргагүй болж, баялгийн хуваарилалтаас хамгийн ихийг амласан талууд дээр төвлөрч, сонгууль үргэлжилнэ. Эдийн засгийн популист өрсөлдөөн нэгэнт л эхэлсэн бол баялгийн үнийн өсөлт үргэлжлэх бүхий л хугацааны туршид явагдана. Цаашид, цаг хугацаа өнгөрөхөд улс төрийн намуудын

өмнөх үзэл суртлын чиглэл нь алдагдаж, ихэнх сонгогч энэ талаар мартана. Ийм төрлийн сонгууль хэд хэдэн удаа давтагдан явагдсаны дараа сонгогчид нь сонгуулийн шинэ хэм хэмжээнд дасаж, сонгууль нь бодлогын хувилбаруудаас сонголт хийх бус, харин төрөөс ямар нэгэн зүйл авах хэмээх шинэ хэм хэмжээ тогтоно.

Бодлогын сонголтот хувилбаруудыг хомс болгосноор ардчилсан хариуцлагын тогтолцооны чухал үр дүнтэй механизм болох сонгуулийн гол шинж чанарыг эдийн засгийн популизм нь доройтуулна гэсэн үг юм. Учир нь, баялгийн орлогоос санхүүжсэн материаллаг зүйлсийг хүлээн авсан сонгогчид нь бодлогын алдаа гаргасны төлөө улс төрчдийг шийтгэх эсвэл амжилтынх нь төлөө урамшуулах боломжгүй болно. Түүнчлэн, эдийн засгийн популизм нь сонгогчдын итгэн саналаа өгсөн, эсвэл өгөөгүй үндэслэлийг тодорхойлоход хүндрэл учруулах тул, улс төрийн намууд сонгогчдын зан төлөвийг ойлгох боломжгүй болох ба жишээ нь тухайн нам бодлогын алдаанаас болж сонгуульд ялагдсан уу, эсвэл сөрөг нам нь илүү мөнгө амласнаас болж ялагдсан уу гэдгийг ялган салгаж чадахгүйд хүрнэ. Хэрэв сонгуулийг улс төрийн хариуцлага бий болгох зорилготой бус харин сонгогчдод сайн төрлийн гэж болох удирдагчийг сонгох боломж олгодог үйл явц хэмээн үзвэл (Fearon, 1999) улс төрийн бүх нам ижил төстэй эдийн засгийн популист схемийг ашигласнаар сонгогчид нь сайн, муу нэр дэвшигчийг ялгахад хүндрэл үүснэ. Боломжит сайн нэр дэвшигчийг олж тогтоосон ч, сонгогчид нь материаллаг амлалтаас үүдэн, өөрсдийн улс төрийн бодит үзэл баримтлалаас татгалздаг.

Ашигт малтмалын орлогын өсөлттэй, намуудын өрсөлдөөн ширүүн, ядуурал өндөртэй улсад болж буй сонгууль нь улс төрийн намуудын цаг хугацааны баримжааг алдагдуулж, улмаар ашигт малтмалын орлогыг бодлогод суурилсан хөтөлбөрийн хэрэгжүүлэлтэд зарцуулах явдлыг сонгуулийн стратеги, бодлогын сонголт болгохыг нь практик ач холбогдолгүй болгоно. Ширүүн өрсөлдөөн нь улс төрийн намуудад ирээдүйн талаарх тодорхой төсөөллийг арилгана. Ялангуяа, олон тооны ядуу, орлого багатай сонгогчидтой бол сонгуульд дахин ялалт байгуулах эсэх дээрээ эргэлзэж буй эрх баригч нам зөвхөн урт хугацаандаа л үр шимээ өгөх бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд баялгийн орлогоор хөрөнгө оруулалт хийж чадахгүйд хүрнэ. Энэ нөхцөл байдалд эрх баригч нам улс төрийн дэмжлэг худалдан авахын тулд баялгаас төвлөрөх орлогоо зарцуулахад яаравчилна. Эрх баригчид санал худалдан авахаар шийдсэн бол нөгөө талаас сөрөг хүч нь эдийн засгийн популизмыг сонгох үндэслэл бий болсноор эрх баригч дээрх нөхцөлийн дагуу мөн л ижил арга хэмжээ авах сэдлийг нь улам нэмэгдүүлж өгнө.

Байгалийн баялгаас хамааралтай ардчилсан улсад эдийн засгийн популизм хэрхэн үүсэн гарч болохыг Монгол Улс дахь сонгуулийн өрсөлдөөн харуулж байна. Монгол Улсад 1990 оноос хойш найман

удаагийн УИХ-ын сонгууль явагдаж, засгийн эрх улс төрийн хоёр гол намын хооронд тайван замаар шилжиж ирсэн түүхтэй. Эдийн засгийн асуудлаар бодлогын эрс ялгаатай нь ашигт малтмалын үнийн өсөлтөөс өмнө явагдсан дөрвөн сонгуульд нео-либерал чөлөөт зах зээлийн шинэтгэлийн цар хүрээн дээр тод илрэн гарч байжээ. Энэ хугацаанд хуучин коммунист нам болох МАХН үзэл баримтлалын хувьд шинээр үүсэн бий болсон “Ардчилсан Холбоо” эвсэл хэмээх сөрөг хүчний дэвшүүлсэн “цочир эмчилгээний” аргыг сөргүүлэн “социалист” байр суурийг баримталж иржээ. МАХН-ын сонгуулийн стратеги төрийн албыг намын дэмжигчдэд өгч ивээн тэтгэх буюу “patronage” болон зүүний үзэлд суурилсан бодлого суурьт мөрийн хөтөлбөртэй хослуулан хэрэгжүүлж ирсэн бол, сөрөг хүчин АН нь ивээн тэтгэж санал худалдан авах нөөц үүсвэргүйн улмаас баруун-төвийн үзэл баримтлал бүхий мөрийн хөтөлбөр, бодлогод найдаж иржээ. Энэхүү мөрийн хөтөлбөр бүхий, тогтсон тодорхой үзэл суртлын байр суурьтай, бодлогын олон хувилбарт олон намын тогтолцоо Монгол Улсад ардчилал төлөвшихөд нөлөөлсөн шалтгааны нэг хэмээн тогтоосон байдаг. Судлаач Фиш (Fish 1998, 135) монголын улс төрийн намуудын системийг “пост коммунист бүс нутаг дотроо хамгийн сайн боловсорсон систем” хэмээн дүгнэсэн байдаг.

Гэвч 2000-аад оны эхээр улс төрийн намуудын үзэл баримтлал эдийн засгийн популизмд шилжсэн нь эдийн засгийн хувьд цорын ганц боломж болох уул уурхайн салбарын өсөлттэй давхацсан байна. Өмнө явагдсан сонгуулиудаас эрс ялгаатай нь, уул уурхайн салбарын өсөлтийн үеийн сонгуулиуд (2004–2012) үндсэндээ аль нам сонгогчдод илүү их бэлэн мөнгө амлах талаарх өрсөлдөөнт сонгууль болжээ. Жишээ нь 2008 оны УИХ-ын сонгуулиар сөрөг хүчин болох АН иргэн бүрт 1 сая төгрөгийг (ойролцоогоор 855 ам.доллар) “Эрдэнийн хувь” болгон хүртээхээр амлаж байв. АН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт сонгуульд ялсан тохиолдолд энэ мөнгийг хүн бүхэнд тараана хэмээн тусгасан байв. Үүний хариу болгон эрх баригч МАХН-ын зүгээс 1,5 сая төгрөг буюу 1282 орчим ам.долларыг иргэн бүрт өгөхийг санал болгож байв (Uradyн, 2009). 2012 оны УИХ-ын сонгуульд хоёр улс төрийн нам монголын хамгийн том уурхайн нэг болох төрийн өмчит Эрдэнэс Таван Толгойн хувьцааг ард түмэнд эзэмшүүлэх амлалтыг дэвшүүлжээ. Монгол Улс олборлох үйлдвэрлэлийн орлогоос хамааралтай болж улс төрийн томоохон намуудын өрсөлдөөн ширүүсэхийн хэрээр улс төрийн намууд программик мөрийн хөтөлбөрөөс гажих явдал гарах болжээ. 1990-ээд оноос сонгогчдын дунд ядуурал газар авч өндөр хувьтай болсон нь цаашид монголын сонгуулийн өрсөлдөөнийг үзэл бодлын тэмцлээс эдийн засгийн гаж бодлогод хүргэсэн эдийн засгийн популизм газар авчээ.

### **Улс төрийн намууд бодлогод суурилсан хөтөлбөрт баялгийн орлогоо зарцуулах замыг хэзээ сонгодог вэ?**

Ашигт малтмалын үнийн өсөлтийн үед эрх барьж байгаа нам хоёр нөхцөлд л бодлогод суурилсан хөтөлбөрийн хэрэгжилтэд орлогоо зарцуулах сонголт хийнэ. Нэгдүгээрт, тухайн нам хэдий сөрөг хүчин нь эдийн засгийн популист амлалтаар санал худалдан авах оролдлого хийсэн ч, өөрийн эрх мэдлээ үргэлжлүүлэн хадгалж сонгуульд ялна гэдэгтээ итгэлтэй байгаа бол бодлогод суурилсан хөтөлбөрт л төсвийн хөрөнгийг зарцуулна. Улс төрийн нэг нам давамгайлж өрсөлдөөн бага, эсвэл сөрөг хүчин нь олон жижиг намд хуваагдаж эрх баригч хүчний хувьд давамгайлах нөхцөлд энэхүү хувилбар тохиох магадлалтай. Аль ч нөхцөлд эрх баригч нам, бодит өрсөлдөөнтэй нүүр тулахгүй бол, ядуурал өндөртэй улсад ч гэсэн улс төрийн дэмжлэгийг худалдан авах сэдэл нь маш бага байна. Өрсөлдөөн байхгүй тохиолдолд эрх баригчдад төсвийн бодлогын олон хувилбараас сонголт хийж, улмаар намын үйл ажиллагааг цаг хугацааны хувьд илүү өргөн хүрээнд төлөвлөн, хэрэгжүүлэх боломжтой. Хоёрдугаарт, сонгуулийн өрсөлдөөн ширүүн ч, сонгогчдын бүтэц нь үндсэндээ чинээлэг сонгогчоос бүрдсэн тохиолдолд эрх баригч болон сөрөг хүчний аль аль нь хөтөлбөрт суурилсан зарцуулалтыг илүүд үзнэ. Санал худалдан авахтай эвлэрэхгүй чинээлэг сонгогчид олон байх тусам улс төрийн намууд нь ширүүсэж буй өрсөлдөөнд программик мөрийн хөтөлбөрт түшиглэсэн бодлогын онцлогоо улам тодруулахаар хичээх нь зүй ёсны болно (Kitschelt and Wilkinson, 2007).

Төрөл бүрийн судалгаанд Ботсван улсыг олон удаа дурдаж, амжилтын жишээ болгон харуулдаг бөгөөд энэ улс эхний хувилбарт багтана. Монгол Улсын нэгэн адил Ботсванын хүн ам тархан суурьшсан, далайд гарцгүй, ардчилсан орон юм. 1966 онд тусгаар тогтнолоо зарлах үед Африкийн хамгийн ядуу орны нэг байсан тус улсын нэг хүнд ногдох ДНБ нь тогтмол 2000 ам.доллартой харьцуулбал 70 ам.доллар байжээ. Тусгаар тогтнолоо олсон эхний жилүүдэд тус улсын төсвийн 60 гаруй хувийг гадаадын тусламж бүрдүүлж ердөө 12 км хатуу хучилттай замтай, эдийн засаг нь хөдөө аж ахуйд түшиглэсэн улс байжээ (Lewin, 2011). Улмаар Ботсван улс алмазын экспорт дээрээ түшиглэн эдийн засгийн хөгжлийн чиглэлээр асар их амжилт гаргажээ. Хэдийгээр хөдөө аж ахуйн эдийн засаг нь уул уурхайгаас их хамааралтай эдийн засаг болж хувирсан ч өсөлт нь тогтворжиж 1966- 1999 оны хооронд жил тутам дунджаар 7 хувиар өсөж иржээ (Lewin, 2011). Одоогоор Ботсван улсын нэг хүнд ногдох ДНБ нь тогтмол 2000 ам.доллараар тооцоход 7000 хүрсэн нь дундаас дээд орлоготой орны тоонд оржээ.

Ашигт малтмалаас хамааралтай байдал нь олон улс орны эдийн засгийн хөгжлийг удаашруулж (Sachs and Warner, 1995), иргэний дайн дэгдээж (Collier and Hoeffler, 2004), авторитари дэглэм тогтоход хүргэж

(Rose, 2001) байсан ч, Ботсваны хувьд улс төрийн нөхцөл байдал тогтвортой байж эдийн засаг хөгжин цэцэглэсэн нь тус улсын удирдагчид олсон ашгаа ухаалаг зарцуулснаас үүдэлтэй юм. Тус улсын ардчиллын түүхэнд огт ялагдал хүлээж байгаагүй эрх баригч Ботсваны Ардчилсан Нам, (BDP) алмаз олборлолтоос төвлөрсөн ашгийг бодлогод суурилсан хөтөлбөр, нийтийн сайн сайхны төлөө зарцуулжээ. Үүний гол шалтгаан нь Ботсваны хүн амын дийлэнх нь ядуу ч, Ботсваны Ардчилсан Намд аюул учруулахуйц улс төрийн өрсөлдөгч байхгүйд оршино. Улс төрийн дэмжлэг худалдан авах шаардлагагүй тул Ботсваны Ардчилсан Нам уул уурхайн салбараас олсон ашгаа иргэдэд хүрэх эрүүл мэнд, боловсрол, нийтийн үйлчилгээг сайжруулахад ашигласан байна. Үндсэндээ боловсролын салбар төрийн санхүүжилтийн хамгийн том хүлээн авагч байж, төсвийн хөрөнгө оруулалтын бараг тал хувь нь энэ салбарт ногдож байжээ (Hjort, 2006). Эрх баригч намын зүгээс мөн дэд бүтцэд их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн ба ялангуяа алмазын орлогоос баялгийн санд хуримтлуулснаар, тухайн улс нь төсвийн илүүдлийг зөв хадгалж, төлбөрийн тэнцлээ хэвийн хэмжээнд барьж иржээ.

Ашигт малтмалаар баян ардчилсан дэглэм бүхий, байнгын жишээ болдог Норвеги улс нь дараагийн жишээ юм. Анх, 1960-аад оны эхээр Умард тэнгисийн газрын тос, байгалийн хийн орд нээгдсэн тэр мөчид ч Норвеги улс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь бараг 28,000 ам доллар байсныг Дэлхийн хөгжлийн үзүүлэлт харуулж байна. Газрын тосны үйлдвэрлэл 1970-аад оноос эхэлж, улмаар 10 жилийн хугацаанд нийт экспортын тал хувийг, нийт ДНБ-ний 15-20 хувийг бүрдүүлэх болжээ. Норвеги улс газрын тосны орлогоо үр дүнтэй зарцуулж байгаагаараа байнга шагшигдаж ялангуяа "Төрийн тэтгэврийн сан" хэмээх орлого хуримтлуулах зориулалт бүхий санг жишээ болгон олонтоо дурддаг. Энэхүү санг 1990 онд газрын тосны салбараас илүү гарсан орлогоор хөрөнгө оруулалт хийх зорилгоор байгуулжээ. Өнөөдөр тус сангийн нийт хөрөнгө 1 их наяд ам.долларын хэмжээнд хүрсэн нь норвегийн иргэн бүрт 192,000 ам.доллар ногдох хэмжээ юм (Norwegian Ministry of Petroleum and Energy, 2017).

Хөдөлмөрийн нам нь Норвегийн хамгийн том улс төрийн хүчин байсаар ирсэн түүхтэй ч, Ботсваны Ардчилсан Намын нэгэн адил улс төрийн тавцанд дангаар ноёрхох боломж тус намд олдоогүй юм. Харин ч 20 дугаар зууны дунд үеэс хойш Норвегит болсон сонгуулиуд нь улс төрийн намуудын хүчтэй өрсөлдөөнөөр тодорч байжээ. Үүний илрэл нь 1961 оноос хойш ямар ч нам дангаараа засгийн газар байгуулах хэмжээний ялалт байгуулсан түүхгүй, цөөнхийн, эсвэл эвслийн засгийн газрууд л тус улсыг удирдаж иржээ. Газрын тосны салбар хүчтэй үүсэн бий болж улмаар эрийн цээнд хүрч өссөн 1981- 2005 оны хооронд улс төрийн эрх мэдлийг Хөдөлмөрийн нам болон баруун төвийн чиглэлтэй

Консерватив намын тэргүүлсэн эвслийн засгийн газар барьж байжээ. Сонгуулиас үүдэлтэй хуваагдлаас үл хамааран ядуурлын хувь хэмжээ доогуур, сонгогчдын дийлэнх хэсгийг санал худалдан авахыг эсэргүүцдэг дунд давхаргынхан бүрдүүлдэг тул, Норвегийн улс төрийн намууд эдийн засгийн популизм, клиентелизмээс татгалзаж иржээ.

## Эмпирик дүн шинжилгээ

Өмнөх бүлэгт тайлбарласан онолын загварт үндэслэн намуудын сонгуулийн өрсөлдөөн хүчтэй үед баялгаас хамааралтай байдал ихсэх нь бусад хүчин зүйлийг үл харгалзан бодлогод суурилсан програматик улс төрийн нам -сонгогч хоорондын холбоог бууруулна гэсэн таамгийг дэвшүүлэн, шалгаж үзлээ. Баялгаас хамааралтай байдал нь эдийн засгийн төрөлжилт хомс байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ, буурай хөгжилтэй холбогддог. Аж үйлдвэржсэн, өндөр хөгжилтэй орнууд байгалийн баялгаас хамааралтай байх нь ховор, харин хөгжиж буй орнуудад энэ шинж элбэг ажиглагддаг. Тодорхойлолт ёсоор, нөөцийн хамаарал гэдэг нь байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн харилцан нөлөөлөл юм.

Бодлогод суурилсан хөтөлбөр болон баялгийн хамаарлын холбоо нь ардчилсан улс орнууд дахь улс төрийн өрсөлдөөнөөр тодорхойлогдож байдаг эсэхийг эмпирик байдлаар шалгахын тулд дараах статистик загварыг боловсруулсан:

$$\text{Хөтөлбөр}_{it} = \beta_0 + \beta_1 * \text{Баялаг}_{it} + \beta_2 * \text{Өрсөлдөөн}_{it} + \beta_3 (\text{Баялаг}_{it} * \text{Өрсөлдөөн}_{it}) + \beta_4 * \text{Хяналтын хувьсагч}_{it} + \delta_t + \varepsilon_{it}$$

Энд,  $i$  индекс нь улс орнууд,  $t$  нь онуудыг төлөөлнө. Хөтөлбөр гэсэн хувьсагч тухайн орны улс төрийн томоохон нам болон сонгогчид хоорондын програматик хөтөлбөрийн холбоог илэрхийлнэ. Баялаг гэсэн хувьсагч тухайн орон нөөц баялгаас хэр хамааралтай болохыг харуулна. Өрсөлдөөн гэсэн хувьсагч тухайн улсын томоохон улс төрийн намууд хоорондын сонгуулийн өрсөлдөөнийг илэрхийлнэ. Хянах хувьсагч нь бусад үл хамаарах хяналтын хувьсагчийг илэрхийлнэ. Дээрх тэгшитгэлийн үл хамааран хувьсагчдад хугацааны туршид гарсан боломжит хандлагыг хянах, нэг оны ажиглалтуудын хооронд корреляц үүсгэж болзошгүй, жилийн онцлогтой үл ажиглагдах хүчин зүйлсийг харгалзаж үзэхийн тулд  $\delta_t$  буюу хугацааны тогтмол нөлөөний (time fixed effects) үзүүлэлтийг ашигласан. Анхны таамаглал  $\beta_3$  сөрөг утгатай байх гэсэн таамаглал байв. Өөрөөр хэлбэл, баялгийн хамаарал нь улс төрийн өрсөлдөөн ширүүн үед намуудыг програматик буюу бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрөөс холдуулах нөлөөтэй. Баялгаас хамаарах хамаарал нь намуудын хөтөлбөрт суурилах хандлагад ахиуц түвшинд (marginal) нийтдээ ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тооцож болно:




$$\frac{\partial \text{Өрсөлдөөн}_{it}}{\partial \text{Баялаг}_{it}} = \beta_1 + \beta_3 * \text{Өрсөлдөөн}_{it}$$

Нам-сонгогчийн холбоо нь улс орнуудын хооронд ихээхэн ялгаатай боловч тухайн улс дотроо төдийлөн өөрчлөгддөггүй тул би хугацааны тогтмол нөлөөллийн загварыг сонгосон. Хамааран хувьсагч болох Хөтөлбөр нь улс бүрээр ямар ялгаатай болохыг Зураг 1-д харуулав. (Ү тэнхлэг нь Х тэнхлэгтэй харьцуулахад өргөн хүрээг хамарч байгааг анхаарна уу). Дундаж улсын хувьд нам болон сонгогчдын холбоос нь өөрчлөлт багатай тул энэхүү судалгаанд хамруулсан бүхий л хугацааны туршид улсын хувьд тогтмол нөлөөтэй (country-fixed) эсвэл санамсаргүй нөлөөний (random effect) загварууд тохиромжгүй юм. Түүнээс гадна, хугацааны хувьд тогтмол нөлөөтэй загвар нь гол хамааран хувьсагчид сөргөөр нөлөөлж болох түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл гэх мэт хугацаанаас нийтлэг тохиолдох гэнэтийн үйл явдлуудыг хамруулан тооцох боломж олгодог.

Нийт 97 орны 1980-2010 оныг хамрах 30 жилийн өөрчлөлтийг энэхүү шинжилгээнд хамруулсан. Энэ хугацааг сонгохдоо судалгаанд шаардлагатай гол хяналтын хувьсагчдын мэдээллийн олдцыг харгалзан үзсэн. Улсуудыг сонгохдоо Бойк тэргүүтэй судлаачдын (Voix et al. 2014) тодорхойлсон, хэрэв тухайн улсын удирдлага сонгогчдын дийлэнх нь оролцож саналаа өгсөн ардчилсан, чөлөөт, шударга сонгуулиар сонгогдож буй бол ардчилсан хэмээн тооцно гэсэн шалгуурыг баримталж, тухайн улс нь ардчилсан хэмээх ангилалд багтах эсэхийг нь тодорхойлсон.

Хөтөлбөрт суурилсан хэмээх хамааран хувьсагчаар V-Dem төслийн мэдээллийн сангийн “Улс төрийн намуудын холбоос” гэх үзүүлэлтийг сонгосон (Coppedge et al., 2017). Энэ хувьсагч нь “Гол улс төрийн намуудын дунд сонгогчидтойгоо харилцах хамгийн гол эсвэл хамгийн түгээмэл ямар төрлийн холбоо байдаг вэ?” хэмээх асуултад экспертүүдийн өгсөн хариулт дээр үндэслэдэг V-Dem төслийн мэдээллийн сангийн “Улс төрийн намуудын холбоос” гэх үзүүлэлтийг сонгосон (Coppedge et al., 2017). Аль ч улс орны хувьд улс төрийн намуудын сонгуульд дэмжлэг үзүүлэхийн тулд санал болгож буй “бараа үйлчилгээний” төрлийг хэмждэг бөгөөд интервалын түвшин 0-4 хооронд хэлбэлздэг. Оноо өндөр байх нь улс төрийн намууд илүү бодлогод суурилсан хөтөлбөртэйг илэрхийлнэ.

**Зураг 1. Хамааран хувьсагч болох нам, сонгогч хоорондын хариуцлагын холбоосны ялгаатай байдал**




Эх сурвалж: V-Dem мэдээллийн сангийн нам-сонгогчийн холбоо хамаарлын индекс  
Тайлбар: Улс орнуудын жагсаалт болон тэдгээрийн нэрийн товчлолыг Хавсралт А дээр үзнэ үү.

Энэ судалгаанд ашигласан өгөгдлийн хувьд, 97 ардчилсан улсын 1980-2010 оны *Хөтөлбөр* гэх хувьсагчийн дундаж оноо нь 2.60, медиан оноо нь 2.80 байсан. Энэ нь бага зэрэг сөрөг хэлбийлттэй тархсаныг илэрхийлж байна. Нийт түүврийн хэмжээнд хамгийн бага оноо нь 2004 оны Венесуэлийн 0.54 байгаа бол, хамгийн их нь Нидерландын 3.86 бөгөөд энэ оноо бүх хугацааны туршид өөрчлөгдөөгүй байна.

Энэ судалгааны хамгийн гол үл хамааран хувьсагч болох Баялаг-аар Дэлхийн хөгжлийн үзүүлэлтийн “Нийт байгалийн баялгийн орлого” үзүүлэлтийг сонгосон (The World Bank, 2011). Энэхүү үзүүлэлт нь байгалийн баялгийн олборлолтоос төвлөрүүлж буй нийт орлогыг ДНБ-д харьцуулдаг. Нийт байгалийн баялгийн орлого гэдэгт газрын тос, байгалийн хий, нүүрс, ашигт малтмал, ойн ашиглалтаас олж буй нийт орлого багтана. Бүтээгдэхүүн нэг бүрийн орлогыг тухайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ, олборлох зардлын зөрүүгээр тооцно. Гарсан зөрүүг тухайн улсын уг бүтээгдэхүүний, тухайн жилийн нийт үйлдвэрлэлийн хэмжээгээр үржүүлнэ. Тухайн улсын олсон байгалийн баялгийн нийт орлогыг ДНБ-д нь хуваан тооцдог тул, тус үзүүлэлт нь байгалийн баялгаас эдийн засаг хэр хамааралтайг тодорхойлно.

Баялгаас их хэмжээгээр хамааралтай байвал хүртвэр буюу нийт баялгийн орлогын дүн хэт өндөр, эсвэл хуваарь буюу ДНБ-ээр хэмжсэн нийт эдийн засгийн хэмжээ харьцангуй бага, эсвэл энэ хоёр нөхцөл хоёул үнэн болохыг илэрхийлнэ. Судалгаанд ашигласан өгөгдлийн түүвэрлэлтэд багтсан ардчилсан орнуудын дунд баялгийн хамаарал болон эдийн засгийн хөгжил нь сөрөг корреляц хамааралтай байв ( $r = -0.50$ ). Энэхүү сөрөг буюу урвуу хамаарлыг Зураг 2-т дүрсэлсэн ба энэ нь тус судалгаанд дэвшүүлсэн баялгийн хамааралтай байдал нь эдийн засгийн төрөлжилт, аж үйлдвэржилтийн түвшин доогуур, улмаар хөгжил буурай болохыг илэрхийлнэ гэсэн урьдач нөхцөлтэй нийцэж байна. Нийт түүврийн хувьд, баялгийн хамаарлын дундаж нь 5.34 хувь байсан. Баялгаас хамгийн бага хамааралтай ардчилсан улс нь Израйл бөгөөд байгалийн баялгийн нийт орлого нь ДНБ-ны 0.002 хүрэхгүй хувь байна. Харин Тринадад Тобаго улс байгалийн баялгаас хамгийн их хамааралтай бөгөөд 2006 онд байгалийн баялгаас олсон орлого нь ДНБ-ний 68.56-хувьтай тэнцэж байжээ. Баялгаас хамааралтай байдал нь хамааран хувьсагч болох Хөтөлбөрийн уялдаа холбоо хувьсагчтай урвуу корреляци ( $r = -0.45$ ) хамааралтай байна.

**Зураг 2. 2010 оны байдлаарх ардчилсан орнуудын баялгийн хамаарал болон эдийн засгийн хөгжил**



Эх сурвалж: Нийт нөөцийн түрээс болон ДНБ-ий мэдээллийг Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдээс (WDI) авсан болно.

Тайлбар: Улс орны нэрийн товчлолтой улсуудын бүрэн жагсаалтыг Хавсралт А-аас үзнэ үү.

Өөр нэг чухал тайлбарлах хувьсагч (conditioning variable) Өрсөлдөөнийг Ванханен Татугийн “Ардчиллын хэмжүүр” хэмээх багц өгөгдлөөс авсан (Vanhanen, 2014). Тус хувьсагч нь улс төрийн намууд хоорондын өрсөлдөөнийг хэмждэг. Тооцоолохдоо хамгийн том улс төрийн намын (сонгогчдын хамгийн их санал авсан) саналын хувь хэмжээг 100-аас хасаж тооцдог. Энд ашигласан өгөгдөлд Өрсөлдөөн нь хамгийн багадаа 7.8 хувь, хамгийн ихдээ 70 хувь, дунджаар 53.61 хувь байсан. Энэ үзүүлэлтийн утга их байх нь улс төрийн намуудын өрсөлдөөн өндөр буйг харуулна. Ач холбогдлоос нь хамааруулан парламентын эсвэл ерөнхийлөгчийн сонгууль эсвэл аль алийг нь тооцоолол хийхэд ашигласан.

Нэг хүнд ногдох ДНБ нь 2005 оны ам доллароор тогтвортой тооцсон нэг хүнд ногдох ДНБ-ий логарифм утга юм. Энэ хувьсагчийг эдийн засгийн хөгжлөөс улс төрийн нам болон сонгогчдын холбоонд үзүүлэх шууд нөлөөг тооцоход ашиглана. ДНБквадрат (GDPsq) нь нэг хүнд ногдох ДНБ-ий квадрат зэрэгт дэвшүүлсэн утга юм. Үүнийг бусад судалгаанд ашигласантай адилаар, хөгжил, холбоос хоёрын муруй шугаман хамаарлыг тооцоход ашиглана. Китшелт, Кселман нарын (Kitschelt and Kselman, 2012) судалгааны адилаар, энэ судалгаанд Ардчиллын нөөц хэмээх хувьсагчийг улс төрийн намуудын уялдаа холбооны чиглэлээрх хуримтлагдсан ардчилсан нөлөөллийг хянаж тооцох зорилгоор ашигласан. Герринг тэргүүтэй судлаачдын (Gerring et al., 2011) адилаар, энэхүү хувьсагчийг тухайн улсын ардчиллын туршлагыг 1900 оноос эхлэлтэй тооцсон Polity IV буюу Полити IV хэмээх ардчиллын индексийн бүх жилүүдийн нийлбэрээр авсан, ингэхдээ сүүлийн жилүүдийн ардчиллын туршлагад илүү жин өгөхийн тулд жилийн 1 хувийн хорогдуулах коэффициент ашигласан. Хувьсагчийн утгыг 0-1 завсарт байхаар тааруулсан бөгөөд утга их байх тусам ардчиллын туршлага илүү болохыг илэрхийлнэ. Ардчиллын институциудийн өнөөгийн чанарыг ардчиллын хуримтлагдсан түүхэн туршлагаас ялгаж тооцохын тулд тухайн он бүрийн Полити IV индексийг нэмж оруулсан. Системийн болон институтийн тодорхойгүй байдал нь улс төрийн намуудыг хөтөлбөрт суурилах хандлага бага байхад нөлөөлдөг байж болох юм. Тиймээс энэ шинжилгээнд Полити IV индексийн “Дэглэмийн тогтвортой байдал” үзүүлэлтийг оруулсан. Энэ нь тухайн улсад хамгийн сүүлд дэглэм өөрчлөгдсөнөөс хойш хэр хугацаа өнгөрснийг харуулна. Түүнчлэн эдийн засгийн тодорхой бус байдал буюу макро эдийн засгийн тогтворгүй байдал нь хөтөлбөрт суурилсан холбоог бий болгох улс төрийн намуудын хичээл зүтгэлд саад учруулж болох тул Китшелт, Кселман нарын (Kitschelt and Kselman, 2012) ашигласан урсгал тэнцэл, гадаадын шууд цэвэр хөрөнгө оруулалт, нийт худалдаа гэх мэт эдийн засгийн хувьсагчдыг загварт нэмсэн. Мөн, бүс нутгийн онцлогийг харгалзахын тулд, улс төр-газар зүйн дамми хувьсагчдыг оруулсан. Эцэст нь, угсаатны хуваагдал болон нийт хүн амын тоог мөн ашигласан.

Харин улс төрийн институцийн хувьсагчид болох сонгуулийн системийн ялгаа, засаглалын бүтэц (ерөнхийлөгчийн эсвэл парламентын) зэргийг энэ шинжилгээнд хамруулаагүй. Учир нь, өмнө хийсэн судалгаанд, ялангуяа Кийфер (Keefe, 2007)-ийн судалгаагаар, эдгээр хувьсагч улс төрийн нам болон сонгогч хоорондын холбооны улс хоорондын ялгаатай байдлыг тайлбарлаж чадахгүй нь тогтоогдсон. Судалгаанд хамруулсан улсын бүрэн жагсаалтыг Хавсралт А-д, хувьсагчдын тодорхойлолт, эх сурвалжийг Хавсралт Б-д оруулсан. Хавсралт В-д бүх хувьсагчийн тодорхойлох статистикийг харуулсан.


## Үр дүн

Хүснэгт 1 дээр хамгийн бага квадратын шугаман регрессийн (OLS) цуврал шинжилгээний үр дүнг харууллаа. 1-3 дугаар багана хоёр үл хамааран хувьсагч бусад хяналтын үзүүлэлтийг хамраан харилцан үйлчлэлгүйгээр бусад хамааран хувьсагчтай хийсэн регрессийг харуулсан. Загвар 1 улс төрийн өрсөлдөөнийг тооцолгүйгээр баялгийн хамааралтай байдал бодлогод суурилсан хөтөлбөрийн хамааралд үзүүлэх нөлөөллийг харуулсан бол Загвар 2 баялгийн хамааралгүй нөхцөлд улс төрийн өрсөлдөөний үзүүлэх нөлөөллийг харуулсан. Харин Загвар 3 дээр үл хамаарах хувьсагчууд харилцан бие биедээ нөлөөлөх байдлыг тусгасан.

Үүнээс үндсэн үл хамааран хувьсагч болох Баялаг нь хөтөлбөрийн холбоотой сөрөг хамааралтайг дундажлан харуулж байна. Загвар 1 дээр байгаа баялгийн хамаарлын хөтөлбөрийн холбоонд хамаарах сөрөг, статистикийн хувьд ач холбогдолтой коэффициент ( $p < 0.01$ ) нь Загвар 3 дээр өөрчлөлтгүй байна. Нөхцөлт хувьсагч болох Өрсөлдөөн нь бүхий л суурь загвар дээр хөтөлбөрийн уялдаа холбоотой эерэг хамааралтай ч, тухайн тооцсон коэффициент нь зөвхөн  $p < 0.1$  байхад л статистикийн хувьд ач холбогдолтой юм. 4 дүгээр багана дээр харуулсан үндсэн модель Баялаг\*Өрсөлдөөний харилцан үйлчлэлийг багтаах замаар Баялаг нь хөтөлбөрийн уялдаа холбоонд үзүүлэх нөлөөллийг задлан харуулж байна. Нэгдүгээрт, бид Баялаг болон Өрсөлдөөний зүгээс хөтөлбөрийн уялдаа холбоонд үзүүлэх шууд нөлөө нь энэхүү загвар дээр аль аль нь эерэг, статистикийн хувьд ач холбогдолтойг ажиглаж болно. Тус загвар нь хэрэв Өрсөлдөөн 0 бол Баялаг дээр нэмэгдэж буй хувь хэмжээ нэг бүр нь хамааралтай хувьсагч дээр дунджаар 0.017 пунктын өсөлттэй холбоотой байх тул илүү их хөтөлбөрт суурилсан чиглэлд хандахыг харуулж байна. Түүнчлэн Өрсөлдөөний тооцон гаргасан коэффициент нь жижиг улс төрийн намуудын авах сонгогчдын санал1 хувиар нэмэгдэх нь (илүү өрсөлдөөн үүсэх) Баялагийг 0 дээр байхад хамааран хувьсагч дээр 0.005 пунктын өсөлтийг харуулж байна.

Гэвч, Баялаг болон Өрсөлдөөн хоорондын харилцан үйлчлэл нь сөрөг болон статистикийн хувьд ач холбогдолгүй коэффициент буюу  $p < 0.01$  байна (мөр 3, багана 4). Энэ нь, баялгийн хамаарал улс төрийн нам, сонгогчдын уялдаа холбоонд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход улс төрийн өрсөлдөөн чухал үүрэгтэй болохыг харуулж байна. Байгалийн баялгаас хамааралтай байх нь сонгуулийн өрсөлдөөн өндөр үед улс төрийн нам болон сонгогчдын уялдаа холбоонд сөрөг нөлөөлтэй байх магадлал өндөр байна. Зураг 3 дээр улс төрийн намуудын өрсөлдөөний төрөл бүрийн түвшин дэх баялгаас хөтөлбөрийн холбоост үзүүлэх ахиуц нөлөөллийг зураглан харуулсан. Доош чиглэлтэй тод шугам нь Баялгийн өөрчлөлтөөс гарах ахиуц нөлөөг ажиглагдсан Өрсөлдөөний нөхцөл байдалтай холбон харуулсан бол дээд болон доод саарал өнгөөр тэмдэглэсэн хэсэг нь итгэх түвшин 95 хувийн интервальтайг харуулж байна (CI).

**Зураг 3. Улс төрийн намуудын өрсөлдөөний төрөл бүрийн түвшин дэх баялгийн хамааралтай байдлын хөтөлбөрийн холбоо хамааралд үзүүлэх ахиуц нөлөөлөл**




Тайлбар: Дунд нь буй тод шугам нь улс төрийн өрсөлдөөний төрөл бүрийн түвшинд баялгаас хөтөлбөрийн холбоо хамааралд үзүүлэх нөлөөлөл 1 хувь өсөхөд үзүүлэх ахиуц нөлөөллийг харуулсан. Саарал хэсгийн дээд болон доод хязгаар нь итгэх интервал 95 хувь байгааг харуулна.

**Хүснэгт 1. Цаг хугацааны үр нөлөөг хэмжсэн регрессийн шинжилгээ**

	<i>Dependent variable:</i>			
	(1)	(2)	(3)	(4)
	Programmatic			
Resources	-0.006*** (0.002)		-0.006*** (0.002)	0.017* (0.009)
Competition		0.003* (0.001)		0.005*** (0.002)
Competition*Resources				-0.0004*** (0.0002)
GDPpc	-0.416** (0.169)	-0.261 (0.168)	-0.369** (0.171)	-0.257 (0.176)
GDPpc*Sq	0.053*** (0.011)	0.043*** (0.011)	0.049*** (0.011)	0.042*** (0.011)
PolityIV	0.041*** (0.011)	0.047*** (0.011)	0.041*** (0.011)	0.037*** (0.011)
Democracy Stock	0.462*** (0.165)	0.376** (0.165)	0.451*** (0.165)	0.447*** (0.165)
Regime Durability	0.001 (0.001)	0.001** (0.001)	0.001 (0.001)	0.001* (0.001)
Trade	-0.001* (0.001)	-0.001* (0.001)	-0.001* (0.001)	-0.001* (0.001)
Current Account	0.002 (0.003)	-0.001 (0.003)	0.002 (0.003)	0.002 (0.003)
FDI	0.003 (0.004)	0.001 (0.004)	0.002 (0.004)	0.002 (0.004)
Population	0.006 (0.014)	0.009 (0.014)	0.005 (0.014)	0.001 (0.014)
Ethnicity	-0.306*** (0.086)	-0.350*** (0.084)	-0.302*** (0.086)	-0.322*** (0.086)
Post-Communist	0.697*** (0.063)	0.715*** (0.063)	0.691*** (0.063)	0.697*** (0.063)
Middle-East/Africa	0.671*** (0.055)	0.733*** (0.054)	0.682*** (0.056)	0.698*** (0.056)
Advanced	0.035 (0.086)	0.084 (0.086)	0.048 (0.087)	0.096 (0.088)
Asia/Pacific	0.518*** (0.066)	0.525*** (0.067)	0.507*** (0.067)	0.541*** (0.068)
Observations	1,931	1,942	1,931	1,931
R <sup>2</sup>	0.653	0.652	0.654	0.655
Adjusted R <sup>2</sup>	0.645	0.643	0.645	0.647
F Statistic	236.859*** (df = 15; 1885)	236.439*** (df = 15; 1896)	222.431*** (df = 16; 1884)	210.437*** (df = 17; 1883)

Note: \*p<0.1; \*\*p<0.05; \*\*\*p<0.01

#### Зураг 4. Өрсөлдөөний төрөл бүрийн түвшин дэх баялгийн хамаарлаас бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрт үзүүлэх нөлөөлөл



Тайлбар: Y тэнхлэг нь хамаарах хувьсагчийн таамагласан утга болон бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрийн хамаарлыг, X тэнхлэг нь хамаарах хувьсагч болох Баялгийн хамаарлыг харуулсан. Зураг дээрх дээд, дунд болон доод хэсгийн шугамууд нь улс төрийн өрсөлдөөнийг 10, 54 болон 70 хувь гэсэн утгаар илэрхийлсэн.

Өрсөлдөөний түвшин 95 хувийн хязгаарыг давахад л баялгийн хамааралтай байдлын ахиуц нөлөө статистикийн хувьд ач холбогдолтой буйг харж болно. Учир нь Өрсөлдөөнийг улс төрийн сонгуульд хамгийн их санал авсан хувь хэмжээг 100-гаас хасаж тооцсон тул 49 хувь нь бусад улс төрийн намуудын нийлж авсан хувь хэмжээ болно. Бусад бүх улс төрийн намын авсан саналын нийлбэр хувь нь 50-хувиас давах нь энгийн үзэгдэл юм. Улс төрийн нам абсолют олонхын санал авахгүйгээр сонгуульд ялах боломжтой ба энэ нь сөрөг хүчин нь олон хуваагдсан тохиолдолд тохионо. Зураг 3-ын доод хэсэгт буй улс төрийн өрсөлдөөний хистограмм нь мөн харилцан хамаарлын хугацаа нь өрсөлдөөн доогуур буй үед ажиглагдсан кейсийн тоо хомс буйгаас үүдэн статистикийн хувьд ач холбогдолгүйг харуулж байна. Харин кейсийн тоо өндөр байх тусмаа харилцан үйлчлэлийн хугацаа статистикийн хувьд ач холбогдолтой болно.



Энэхүү шинжилгээнд улс төрийн нам болон сонгогчдын хоорондын хамаарлыг харуулах бусад үзүүлэлтийг хяналтдаа авсан. Судалгааны шинжилгээний үр дүн нь Китшелт, Вилкинсон (Kitschelt and Wilkinson, 2012) нарын тогтоосончлон эдийн засгийн хөгжил нь мөрийн хөтөлбөрт эерэг болон мурий шугаман хамааралтай байхыг нотолсон. Үүнийг шинжилгээний бүх загварт ДНБквадрат коэффициент нь статистикийн хувьд ач холбогдолтой байгаагаас харж болно. Үндсэн загвар дахь Дэглэмийн өөрчлөлтийн тооцоолсон коэффициент мөн статистикийн хувьд ач холбогдолтой, эерэг байна. Энэ нь, дэглэмийн тогтвортой байдал нь хөтөлбөрийн уялдаа холбоотой эерэг хамааралтай болохыг харуулж байна. Түүнчлэн Ардчиллын нөөц хэмээх хувьсагч нь эерэг болон ач холбогдол бүхий коэффициент байгаа нь ардчиллын туршлага хуримтлуулсан байдал нэмэгдэх тусам хөтөлбөрийн холбоосыг нь сайжруулахад хөтөлдөг ажээ. Энэ нь Кийферийн (Keefe 2007) судалгаанаас гарсан үр дүнг баталж байна. Бүс нутгийн дамми хувьсагчийн коэффициент нь бүс нутаг бүр Латин Америкаас хэр ялгаатайг харуулна.

Харилцан үйлчлэлийн үндсэн агуулгыг тайлбарлахын тулд Зураг 4 дээр харуулсан улс төрийн хоёр намын харилцан нөлөөлөл үйлчлэлийн утгад анхаарал хандуулсан. Энэхүү утга дээр бүхий л хувьсагчийг өөрийн дунджаар харилцан үйлчлэлд хамааруулаагүй ба дараа нь хамааран хувьсагчийн таамаг утгыг  $Y$  тэнхлэг дээр, баялгаас хамааралтай байдлыг  $X$  тэнхлэг дээр тусгав. Зураг 4 дээрх гурван шугам нь Өрсөлдөөний хувьсагчийн утга төрөл бүрийн түвшинд байх үед баялгийн хамаарал нь бодлогод суурилсан хөтөлбөртэй хэрхэн хамааралтай буйг тус тусдаа харуулсан. Дунд талын шугам нь Өрсөлдөөн нь дундаж (mean) утга болох 54 хувь байх үед Баялаг нь Хөтөлбөртэй хэрхэн хамаарч буйг харуулж байна. Дээд талын шугам нь Өрсөлдөөн маш бага байх үед Баялгийн үзүүлэх нөлөөг харуулсан ба энэ тохиолдолд 10 хувь байна. Доод хэсгийн (тод) шугам нь бодлогод суурилсан хөтөлбөр болон баялгийн хамаарлын уялдаа холбоог өрсөлдөөн 70 хувь буюу өгөгдөл дээрх хамгийн өндөр утга дээр байх үеэр харуулж байна.

Сонгуулийн өрсөлдөөн бага байх үед баялгийн хамаарал нь бодлогод суурилсан мөрийн хөтөлбөртэй эерэг хамааралтайг дээд талд буй шугам дээш чиглэлтэй байгаагаас харж болно. Гэвч энэ хамаарал нь өмнө дурдсанчлан статистикийн хувьд өндөр ач холбогдолтой биш болохыг анхаарах хэрэгтэй. Өрсөлдөөний нөхцөл байдал дундаж (mean) утга дээрээ байх үед баялгаас хамааралтай байдлын таамагласан нөлөөлөл нь эрс сөрөг болж байгааг дунд хэсэгт буй шугам бага зэрэг доошилсноор харж болно. Харин улс төрийн маш өндөр өрсөлдөөнтэй нөхцөлд дээрх загвар нь баялгийн хамаарал бодлогод суурилсан мөрийн хөтөлбөрийн хамааралтай ихээхэн сөрөг нөлөө үзүүлэхийг огцом унаж буй доод

шугамаас харж болно. Тооцон гаргасан эдгээр үр дүн нь баялгаас хамааралтай байдал нь сонгуулийн өрсөлдөөн өндөр, ардчилсан улс орнууд дахь улс төрийн намууд мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалаасаа ухардаг хэмээх судалгааны таамгийг нотолж байна.

## Дүгнэлт

Ашигт малтмалын баялаг хөгжиж буй улс орнуудад эдийн засгийн өсөлтөө хурдасгах боломжийг нээн өгдөг ч, эдгээр боломжийг ашиглаж чадалгүй алдах нь түгээмэл байна. Судлаачийн зүгээс энэ бүлэгт байгалийн баялгийг хэрхэн, яагаад буруу ашиглаж байгааг тусган харуулсан. Сонгуулийн хүчтэй өрсөлдөөн нь ядуурлын өндөр түвшинтэй хавсарснаар улс төрийн намуудыг клиентелизм болон эдийн засгийн популизмд уриалдаг байна. Судалгааны хүрээнд миний бие кейс болон статистик шинжилгээгээр улс төрийн намууд болон сонгогчид хоорондын бодлогын шинжтэй хөтөлбөрийн уялдаа холбоонд байгалийн баялгийн үзүүлэх нөхцөлт нөлөөллийг тусган харууллаа.

Ядуурал өргөн тархсан, эдийн засгийн хөгжил сул улс орнуудад байгалийн баялаг нь тухайн улс орныг ашигт малтмалын орлогоосоо хэт хамааралтай байдалд оруулж байна. Байгалийн баялгаас хэт их хамааралтай байх нь улс төрийн өрсөлдөөн ширүүн улс орнуудад улс төрийн намуудыг бодлогод суурилсан хөтөлбөрөөс татгалзахад хүргэж байгаа юм. Харин сонгуулийн өрсөлдөөн хэт ширүүн бус, бага хэмжээнд буй улс орны хувьд байгалийн баялгийн хамаарал нь тэдний бодлогод суурилсан хэлхээ холбоог улам батжуулж байна. Харин эдийн засгийн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн улс орны хувьд байгалийн баялаг нь хамаарал үүсгэхгүй, улс төрийн намуудыг клиентелист болоход ч хүргэхгүй байна.

Энэхүү бүлгийн гол дүгнэлт: Эдийн засаг өндөр хөгжсөн, эсвэл улс төрийн өрсөлдөөн сул ардчилсан улс орнуудынзасаглалд байгалийн баялаг хор хөнөөл үзүүлэхгүй болохыг тогтоосон. Хөгжиж буй, ядуувар, ардчилсан оронд ч нам хоорондын сонгуулийн өрсөлдөөн бага байх тохиолдолд, байгалийн баялаг, улс төрийн намуудын хэвийн, бодлогын үйл ажиллагааг бэхжүүлдэг байна. Харин эдийн засгийн хөгжил өндөр биш, улс төрийн ширүүн өрсөлдөөн бүхий нөхцөлд байгалийн баялаг нь клиентелизм болон популист зардлыг хөөрөгдөхөд хувь нэмэр оруулж байна. Тиймээс ардчилал хөгжиж буй, асар их байгалийн баялаг бүхий улс орон баялгийн хараалаас зайлсхийхийн тулд улс төрийн нам хоорондын өрсөлдөөнийг доод хэмжээнд барьснаар баялгийн хараалаас зайлсхийж чадна.

## Ном зүй

- Ahmadov, Anar and Farid Guliyev. 2016. "Tackling the Resource Curse: The Role of Democracy in Achieving Sustainable Development in Resource-Rich Countries." Stockholm: International IDEA.
- Alesina, Alberto, Arnaud Devleeschauwer, William Easterly, Sergio Kurlat and Romain Wacziarg. 2003. "Fractionalization." *Journal of Economic Growth*, 8(2): 155–194.
- Auty, Richard M. 1993. *Sustaining Development in Mineral Economies: The Resource Curse Thesis*. London: Routledge.
- Boix, Carles, Michael Miller, and Sebastian Rosato. 2014. "Boix-Miller-Rosa to Dichotomous Coding of Democracy, 1800–2010." doi:10.7910/DVN/28468, *Harvard Dataverse*, V1, UNF:5:x3P4QDm6R349bpyygm/g1Q== (accessed January 19, 2015).
- Boschini, Anne, Jan Pettersson, and Jesper Roine. 2007. "Resource Curse or Not: A Question of Appropriability." *The Scandinavian Journal of Economics*, 109(3): 593–617.
- Bulte, Erwin, Richard Damania, and Robert Deacon. 2005. "Resource Intensity, Institutions, and Development." *World Development*, 33(7): 1029–1044.
- Collier, Paul. 2017. "The Institutional and Psychological Foundations of Natural Resource Policies." *The Journal of Development Studies*, 53(2): 217–228.
- Collier, Paul and Anke Hoeffler. 2004. "Greed and Grievance in Civil War." *Oxford Economic Papers*, 56(4): 563–595.
- Collier, Paul and Anke Hoeffler. 2009. "Testing the Neocon Agenda: Democracy in Resource Rich Societies." *European Economic Review*, 53(3): 293–308.
- Coppedge, Michael, John Gerring, Staffan I. Lindberg, Svend-Erik Skaaning, Jan Teorell, David Altman, Michael Bernhard, M. Steven Fish, Adam Glynn, Allen Hicken, Carl Henrik Knutsen, Joshua Krusell, Anna Lührmann, Kyle L. Marquardt, Kelly McMann, Valeriya Mechkova, Moa Olin, Pamela Paxton, Daniel Pemstein, Josefina Pernes, Constanza Sanhueza Petrarca, Johannes von Römer, Laura Saxer, Brigitte Seim, Rachel Sigman, Jeffrey Staton, Natalia Stepanova, and Steven Wilson. 2017. "V-Dem [Country-Year/Country-Date] Dataset v7.1" Varieties of Democracy (V-Dem) Project. URL: [https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract\\_id=3172791](https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3172791).

- Corden, Max W. and Peter J. Neary. 1982. "Booming Sector and De-Industrialisation in a Small Open Economy." *The Economic Journal*, 92(368): 825–848.
- Dunning, Thad. 2008 *Crude Democracy: Natural Resource Wealth and Political Regimes*. Cambridge, UK: Cambridge University Press.
- Fearon, James D. 1999. "Electoral Accountability and the Control of Politicians: Selecting Good Types versus Sanctioning Poor Performance." In Adam Przeworski, Susan C. Stokes, and Bernard Manin (eds), *Democracy, Accountability, and Representation*, 55-76. Cambridge, UK: Cambridge University Press.
- Fish, Steven. 1998. "Mongolia: Democracy Without Prerequisites." *Journal of Democracy*, 9(3): 127–141.
- Gelb, Alen, Mauricio Garcia Araujo, Bela Balassa, Martha de Melo, Jack Duloy, Joan Nelson, and Graham Pyatt. 1988. *Oil Windfalls: Blessing or Curse?* Washington DC: World Bank Publications. <http://documents.worldbank.org/curated/en/536401468771314677/pdf/296570paper.pdf> (accessed December 2, 2017).
- Gerring, John, Philip Bond, William T. Barndt, and Carola Moreno. 2005. "Democracy and Economic Growth: A Historical Perspective." *World Politics*, 57(3): 323–364.
- Gleditsch, K.S. 2002. "Expanded Trade and Global Data." *Journal of Conflict Resolution*, 46(5), 712–724.
- Gylfason, Thorvaldur. 2001. "Natural Resources, Education, and Economic Development." *European Economic Review*, 45: 847–859.
- Hicken, Allen. 2011. "Clientelism." *Annual Review of Political Science* 14: 289–310.
- Humphreys, Macartan, Jeffrey D. Sachs, and Joseph E. Stiglitz, eds. 2007. *Escaping the Resource Curse*. New York: Columbia University Press.
- Hjort, Jonas. 2006. "Citizen Funds and Dutch Disease in Developing Countries." *Resource Policy*, 31(3): 183–191.
- limi, Atsushi. 2007. "Escaping from the Resource Curse: Evidence from Botswana and the Rest of the World." *IMF Staff Papers*, 54(4): 663–699.
- IMF. 2015. "Press Release: IMF Approves US\$918 Million ECF Arrangement to Help Ghana Boost Growth, Jobs and Stability." *The International Monetary Fund*. URL: <https://www.imf.org/en/News/Articles/2015/09/14/01/49/pr15159> (accessed December 1, 2017).

- Isham, Jonathan, Michael Woolcock, Lant Pritchett, and Gwen Busby. 2005. "The Varieties of Resource Experience: Natural Resource Export Structures and the Political Economy of Economic Growth." *World Bank Economic Review*, 19(2): 141–174. URL: <https://www.openknowledge.worldbank.org/handle/10986/16480> (accessed December 20, 2017).
- Karl, Terry Lynn. 1997. *The Paradox of Plenty: Oil Booms and Petro States*. Berkeley, CA: University of California Press.
- Keefer, Philip. 2007. "Clientelism, Credibility, and the Policy Choices of Young Democracies." *American Journal of Political Science*, 51(4): 804–821.
- Kitschelt, Herbert and Danial M. Kselman. 2012. "Economic Development, Democratic Experience, and Political Parties' Linkage Strategies." *Comparative Political Studies*, 46(11): 1453–1484.
- Kitschelt, Herbert and Steven I. Wilkinson, eds. 2007. *Patrons, Clients, and Policies: Patterns of Democratic Accountability and Political Competition*. Cambridge: Cambridge University Press.
- Lewin, Michael. 2011. "Botswana's Success: Good Governance, Good Policies, and Good Luck." In Punam Chunan-Pole and Manka Angwafo (eds), *Yes Africa Can: Success Stories from a Dynamic Continent*, Washington D.C: The World Bank Publications, 81–90.
- Mehlum, Halvor, Karl Moene, and Ragnar Torvik. 2006. "Institutions and the Resource Curse." *The Economic Journal*, 116(508): 1–20.
- Norwegian Ministry of Petroleum and Energy. 2017. "The Government's Revenues." *Norwegian Petroleum Directorate*. URL: <http://www.norskpetroleum.no/en/economy/governments-revenues/> (accessed December 2, 2017).
- Robinson, James A. and Thierry Verdier. 2002. "Political Economy of Clientelism." *CEPR Discussion paper* no 3205. URL: <https://ssrn.com/abstract=303185> (accessed June 2, 2016).
- Ross, Michael. 2001. "Does Oil Hinder Democracy?" *World Politics*, 325–361.
- Ross, Michael. 2015. "What Have We Learned About the Resource Curse." *Annual Review of Political Science*, 18: 239–259.
- Sachs, Jeffrey and Andrew M. Warner. 1995. "Natural Resource Abundance and Economic Growth." *Journal of Development Economics*, 59(1): 43–76.
- Saker, Neil. 2017. "Mongolia Turns the Corner with \$5.5 Billion IMF-Led Financial Package." *The International Monetary Fund*. URL: <https://www.imf.org/en/News/Articles/2017/05/31/NA053117Mongolia-Turns-the-Corner-with-5-5-Billion-IMF-Led-Financing-Package> (accessed December 1, 2017).

- Sala-i-Martin, Xavier and Arvind Subramanian. 2003. "Addressing the Natural Resource Curse: An Illustration from Nigeria." *Journal of African Economies, Centre for the Study of African Economies (CSAE)*, 22(4): 570–615.
- Sambuу, Boldsaikhan. 2017. "Mongolia Just Elected a Former Wrestler as its President, After its Most Divisive Election Ever." *The Monkey Cage-Washington Post*. URL: <https://www.washingtonpost.com/news/monkey-cage/wp/2017/07/13/mongolia-just-elected-a-former-wrestler-as-its-president-after-its-most-divisive-election-ever/> (accessed January 1, 2018).
- Sovereign Wealth Institute. 2017. "Ghana Petroleum Funds: The Jubilee Oil Field and the Creation of Ghana Petroleum Funds." URL: <http://www.sovereignwealthcenter.com/fund/44/ghana-petroleum-funds.html#.WipEL0tx0fE> (accessed December 8, 2017).
- Stokes, Susan C. 2005. "Perverse Accountability: A Formal Model of Machine Politics with Evidence from Argentina." *American Political Science Review*, 99(3): 315–325.
- Stokes, Susan C., Thad Dunning, Marcelo Nazareno, and Valeria Brusco. 2012. *Brokers, Voters, and Clientelism*. Cambridge: Cambridge University Press.
- Tornell, Aaron and Philip R. Lane. 1999. "The Voracity Effect." *American Economic Review*, 89(1): 22–46.
- Uradyn, Bulag E. 2009. "Mongolia in 2008: From Mongolia to Mine-golia." *Asian Survey*, 49(1): 129–134.
- van der Ploeg, Frederick. 2011. "Natural Resources: Cure or Blessing?" *Journal of Economic Literature*, 49(2): 366–420.
- van der Ploeg, Frederick and Steven Poelhekke. 2007. "Volatility, Financial Development and the Natural Resource Curse." *OxCarre Research Paper No.2008-03*. URL: <https://www.oxcarre.ox.ac.uk/images/stories/papers/ResearchPapers/oxcarrerp200803.pdf> (accessed January 1, 2018).
- Vanhänen, Tatu (University of Tampere). 2014. Measures of Democracy 1810–2014 [dataset]. Version 7.0 (2016-05-30). Finnish Social Science Data Archive [distributor]. URL: <http://urn.fi/urn:nbn:fi:fsd:T-FSD1289>.
- Weitz-Shapiro, Rebecca. 2012. "What Wins Votes: Why Some Politicians Opt Out of Clientelism." *American Journal of Political Science*, 56(3): 568–583.
- World Bank. 2011. "The Changing Wealth of Nations: Measuring Sustainable Development in the New Millennium." Washington, DC: World Bank.

## Хавсралт А. Улс орны жагсаалт

Улсууд	Товчлол	Улсууд	Товчлол
Албани	ALB	Мадагаскар	MDG
Аргентин	ARG	Малави	MWI
Австрали	AUS	Мали	MLI
Австри	AUT	Мавритан	MUS
Бангладеш	BGD	Мексик	MEX
Беларусь	BLR	Молдова	MDA
Бельги	BEL	Монгол	MNG
Бенин	BEN	Мозамбик	MOZ
Боливи	BOL	Балба	NPL
Босни Герцоговина	BIH	Нидерланд	NLD
Ботсван	BWA	Шинэ Зеланд	NZL
Бразил	BRA	Никарагуа	NIC
Болгар	BGR	Нигер	NER
Бурунди	BDI	Нигериа	NGA
Канад	CAN	Норвеги	NOR
Төв Африкийн БНУ	CAF	Пакистан	PAK
Чили	CHL	Панам	PAN
Колумб	COL	Папуа Шинэ Гвиней	PNG
Коста Рика	CRI	Парагвай	PRY
Хорват	HRV	Перу	PER
Чех	CZE	Филиппин	PHL
Дани	DNK	Польш	POL
Доминикан	DOM	Португал	PRT
Эквадор	ECU	Румын	ROU
Сальвадор	SLV	ОХУ	RUS
Эстони	EST	Сенегал	SEN
Финланд	FIN	Серби	SRB
Франц	FRA	Сиерра Леоне	SLE
Гамби	GMB	Словак	SVK
Гүрж	GEO	Словени	SVN
Герман	DEU	Өмнөд Африк	ZAF
Гана	GHA	Өмнөд Солонгос	KOR
Грек	GRC	Испани	ESP
Гватемал	GTM	Шри Ланк	LKA
Гвиней Биссау	GNB	Швед	SWE
Гондурас	HND	Швейцар	CHE
Унгар	HUN	Тайланд	THA

## Хавсралт А. Улс орны жагсаалт

Улсууд	Товчлол	Улсууд	Товчлол
Энэтхэг	IND	Тринадад ба	TLS
Индонези	IDN	Тобаго Tobago	TTO
Ирланд	IRL	Турк	TUR
Израйл	ISR	Уганда	UGA
Итали	ITA	Украйн	UKR
Ямаик	JAM	Англи Kingdom	GBR
Япон	JPN	АНУ	USA
Кени	KEN	Уругвай	URY
Латви	LVA	Венесуэл	VEN
Лесото	LSO	Замби	ZMB
Либери	LBR		
Литва	LTU		
Македони	MKD	Нийт улсын тоо 97	

## Хавсралт Б. Хувьсагчуудын тодорхойлолт, эх сурвалж

Хувьсагч	Тайлбар	Эх сурвалж
Програмастик (бодлогод суурилсан хөтөлбөр)	Томоохон улс төрийн намуудын сонгогчидтойгоо уялдаа холбоотой байх хамгийн гол, түгээмэл хэлбэрийг хэмжих индекс.	Ардчиллын төрөл зүйлс (V-Dem) төслийн багц өгөгдөл 7.1
Баялаг	ДНБ-д хамаарах нийт байгалийн баялгаас төвлөрүүлсэн орлого. Үүнд газрын тос, байгалийн хий, нүүрс, ашигт малтмал болон ойн нөөцийн олборлолтын ашиг багтана. Бүтээгдэхүүн нэг бүрийн орлогыг тооцохдоо тухайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ болон олборлох зардлын зөрүүгээр тооцогдоно. Үүнээс гарсан зөрүүг тухайн улсын тэрхүү бүтээгдэхүүн, тухайн жилийн нийт үйлдвэрлэлийн хэмжээгээр үржүүлэн гаргана.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн багц (WDI).
Өрсөлдөөн	Парламентын, эсвэл Ерөнхийлөгчийн сонгуульд жижиг намуудын авсан саналын хувь	Ванханен Татугийн “Ардчиллын хэмжүүрийн” өгөгдөл (“Measures of Democracy” (Vanhanen, 2014).
Нэг хүнд ногдох ДНБ	Нэг хүнд ногдох ДНБ нь 2005 ам доллароор тогтвортой тооцсон нэг хүнд ногдох ДНБ-ний логарифм	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн багц (WDI)



Полити IV	Полити IV төслийн автократ/ардчиллын хэмжүүр	Полити IV төсөл
Ардчиллын нөөц	1900 оноос эхлэлтэй тооцсон Полити IV хэмээх ардчиллын индексийг, жилийн 1 хорогдуулсан хэлбэрээр нийт индексийн нэмж ардчиллын туршлагыг тооцон, өнөөгийн ардчиллын туршлагын жинг тогтоон гаргасан хэмжээ.	Герринг болон бусад (Gerring et al. (2005))
Дэглэмийн бат бэх байдал	Хамгийн сүүлд хийсэн дэглэмийн өөрчлөлтөөс хойш нийт хугацаа.	Полити IV төсөл
Худалдаа	ДНБ-д эзлэх худалдааны хувь хэмжээ.	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн багц (WDI)
Урсгал тооцооны тэнцэл	Урсгал тооцооны тэнцэл	ОУВС
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	ДНБ-тэй харьцуулан хувиар гаргасан гадаадын шууд хөрөнгө оруулалт	Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүдийн өгөгдлийн багц (WDI)
Хүн ам	1000,аар тооцсон хүний амын тооны логарифм	Гледитш болон бусад (Gleditsch (2002))
Үндэстэн	Тухайн улсын санамсаргүй сонгосон хоёр хүн ижил бус үндэстний хүмүүс байх магадлалыг харуулсан үндэстний хуваагдал.	Алешина болон бусад (Alesina et al (2003))
Пост коммунист	Хуучин бүх коммунист улсыг хамруулан 1 хэмээн кодолсон хуурмаг (Дамми) хувьсагч	Өөрөө кодолсон
Ойрх Дорнод/ Африк	Ойрх Дорнод болон Африкийн орнуудыг хамруулан 1 хэмээн кодолсон хуурмаг (Дамми) хувьсагч	Өөрөө кодолсон
Ахисан түвшний	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудыг хамруулан 1 хэмээн кодолсон хуурмаг (Дамми) хувьсагч	Өөрөө кодолсон
Ази Номхон Далайн бүс	Ази, Номхон Далайн орнуудыг хамруулан 1 хэмээн кодолсон хуурмаг (Дамми) хувьсагч.	Өөрөө кодолсон

## Хавсралт В. Дескриптив статистик

Variable	n	Min	q <sub>1</sub>	$\tilde{x}$	$\bar{x}$	q <sub>3</sub>	Max	s	IQR	#NA
Year	2049	1980.0	1991.0	1998.0	1997.2	2004.0	2010.0	8.4	13.0	0
Programmatic	2049	0.5	1.7	2.8	2.6	3.6	4.0	1.0	1.9	0
Competition	2049	7.8	47.0	54.6	53.6	62.7	70.0	11.9	15.7	0
Resources	1982	0.0	0.7	2.2	5.3	6.3	68.6	8.3	5.6	67
Resources (log)	1982	0.0	0.5	1.2	1.3	2.0	4.2	1.0	1.5	67
GDP (log)	2022	4.9	7.3	8.5	8.5	10.1	11.1	1.6	2.8	27
Current Account	2025	-54.8	-5.3	-2.2	-2.3	0.8	45.6	6.6	6.1	24
FDI	1984	-16.1	0.6	1.6	2.9	3.6	87.4	4.6	3.0	65
Trade	2015	9.1	36.7	50.6	56.9	73.0	180.9	28.8	36.3	34
Stock	2039	0.2	0.4	0.6	0.6	0.8	1.0	0.2	0.4	10
Regime	2046	0.0	7.0	17.0	32.0	44.0	201.0	37.6	37.0	3
Polity IV	2034	-5.0	7.0	9.0	8.3	10.0	10.0	1.9	3.0	15
Ethnicity	2024	0.0	0.2	0.4	0.4	0.6	0.9	0.2	0.4	25
Population (log)	2043	6.4	8.4	9.2	9.4	10.5	14.0	1.4	2.2	6



## Ардчилагдах үйл явцад олон улсын харилцааны үзүүлсэн нөлөөлөл, 1972–2005

Матиас Де Роек, Ронан Ван Россем

Дэлхийн бодлогын онолын (world polity theory) үндсэн тайлбар бол олон улсын харилцаа нь ардчиллыг тархалтыг хөнгөвчилж өгдөг хэмээн үздэг. Гэвч 1990-ээд оны дунд үеэс эхлэн дэлхийн хэмжээнд ардчилал зогсонги байдалд орж эхэлсэн тул уг онол олон бэрхшээлтэй тулгарах болсон байна. Тиймээс энэ бүлэгт, тухайн улс орны ардчилагдсан байх эсэх нь түүний хамаарч буй олон улсын хэлхээ, холбоо бүхий тогтолцооноос шалтгаалахыг харуулахыг зорино. Хүйтэн дайны үед олон улсын тогтолцоо маш хатуу байсан ба ардчилал нь Дорно-Өрнө гэсэн чиг баримжаагаар тодорхойлогдож байсан бол Хүйтэн дайны дараах богино хугацааны Өрнийн ноёрхол суларч даяаршил дэлгэрэх болсноор улс орны хамаарч буй хэлхээ, холбоо улам төрөлжиж эхэлжээ. Өөрөөр хэлбэл, улс орнуудад засаглалын шинэ загварууд (жишээ нь зах зээлийн авторитарианизм) бий болоод зогсохгүй тэд Өрнийн ардчилал бол цорын ганц зам хэмээх шахалтыг тэнцвэржүүлэх боломжтой болсон нь ардчилсан үзлийн дан ноёрхол буурахад нөлөөлөв. Судалгааны энэхүү бүлэгт уг онолын дэвшүүлсэн санааг шалгах ба ингэхдээ 1972-2005 онууд дахь улс орнууд хоорондын хамаарч буй хэлхээ, холбооны талаарх олон хэмжээст мэдээллийн санд шинжилгээ хийж ардчиллын алтернатив хэмжигдэхүүнд тулгуурласан болно. Тус бүлэгт тухайн улсыг хамаарч буй улс орнуудын сүлжээ нь ардчилсан түншүүдээс бүрдэж байвал тухайн улс ардчилсан байх хандлагатай байсан бол, эсрэгээрээ хамаарч буй сүлжээ нь авторитари засаглал бүхий түнш орнуудтай нэгдэж байвал ардчилалд саад тотгор учруулдаг болохыг олж тогтоосон. Түүнчлэн судалгааны энэхүү бүлэгт, ардчилсан түнш орнуудын хамаарч буй сүлжээ нь ардчилсан үйл явцад үзүүлэх эерэг нөлөө нь Хүйтэн дайны дараа ихээхэн хэмжээгээр буурсан бөгөөд энэ үзэгдэл нь олон улсын худалдааны талбарт Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын нөлөө ихэссэнтэй холбоотой болохыг олж тодорхойлсон болно.

### Оршил

Ардчиллын гурав дахь давалгаатай зэрэгцээд, либерал ардчилал нь улс төрийн засаглалын хувьд дэлхийд давамгайлсан загвар болсон мэт байлаа (Fukuyama, 1992; Huntington, 1991)<sup>1</sup>. Илүү олон орон ардчилсан болохын хэрээр судлаачид бусад орон ч мөн энэ хандлагыг эрчтэй дагах болно гэж итгэж байв. Гэвч 1990-ээд оны дунд үеэс дэлхий даяар тархаж байсан ардчилал нь бүх улс орнуудад ижил хэмжээнд нөлөөлж чадаагүй нь тодорхой болж эхлэв. Ардчилалд шилжих эрч буураад зогсохгүй, олон

---

1 Хантингтон (Huntington, 1991, 15) нь “ардчилагдах үйл явцын давалгаа”-г “тодорхой заасан хугацаанд ардчилсан бус дэглэмээс ардчилсан дэглэм рүү шилжсэн бүлэг улс орнууд бөгөөд энэ нь эсрэг чиглэлд шилжилт хийсэн улс орнуудын тооноос хамаагүй их хэмжээгээр давсан” байна гэж тодорхойлжээ.

улс орон харьцангуй тогтвортой, “холимог-гибрид” дэглэмтэй болсон бол, зарим орон цэвэр авторитари засаглалтай хэвээр үлдсэн байна (Carothers, 2002; Diamond, 2002). Тиймээс судалгааны энэхүү бүлэгт Хүйтэн дайны дараах эрин үед яагаад ардчиллын үйл явц зогсонги байдалд орсныг тайлбарлахыг хичээсэн болно.

Дэлхийн полити буюу соёлын онолд (World Polity Theory-ДПО) тайлбарласнаар улс орнууд олон улсын байгууллагуудад нэгдэхийн хэрээр ардчилагдах үйл явц дэлхий дахинд тархах аж. Олон улсын түвшинд интеграцчилагдах нь улс орнуудыг засаглалын рациональ үзэл санааг хүлээн авах, ардчилал гэх зэрэг Барууны загварыг нэвтрүүлэх үйл явцыг дэмждэг байна (Meyer et al., 1997). Эдгээр ардчилах үйл явцын суурь механизмыг Паул болон ДиМаггио (Powell and DiMaggio, 1991) нар норматив изоморфизм хэмээн нэрлэсэн. Улс орнууд өөр хоорондоо улам бүр холбогдсон дэлхийн нийгэмлэг дэх өөрийн байр суурь, хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөх легитим байдлыг бэхжүүлэхийн тулд ардчиллыг сонгох болжээ. Хэдийгээр ДПО нь институтчиллийн ижилсэх (homogenization) үйл явцыг дэлгэрэнгүй тайлбарлаж чаддаг ч институтчиллийн ялгаргах (divergence) үйл явцыг тайлбарлахдаа учир дутагдалтай байв (Beckert, 2010). Уг онолыг баримтлагчид ардчилсан үзэл санаанаас хазайж гажих үйл явцыг түр зуурын, албан бус үзэгдэл бөгөөд бодит ач холбогдолтой зүйл биш гэж үзэж байв.

Бүтцийн загвар (structural model) нь орчин ба ардчиллын уялдуулсан үзэл санааны өөр хувилбарыг санал болгодог. Уг загвар нь world polity буюу дэлхийн түвшин дэх соёлын хэм хэмжээ, байгууллага, өөрчлөлтийг илэрхийлэх дэлхийн соёлын агуулга ба механизм аль алиныг нь үндэслэлгүй болохыг нотолдог. Механизмын хувьд бүтцийн загварын тайлбарласнаар олон улсын тогтолцоо нь хатуу бүтэцлэгдсэн байдаг ба үүнийг гол төлөв “эрх мэдлээс-хамаарч буй сүлжээ” буюу power-dependency network болохынх нь хувьд тайлбарлах ёстой гэж үздэг (Galtung, 1971; Van Rossem, 1996). Улс орнууд “Дурхэйм (Durkheimian) эсвэл Зиммелийн (Simmelian)” тодорхойлсон интеграцичилал гэхээс илүүтэй харилцан хамаарал бүхий үйл ажиллагаануудаас бүрдсэн шатлан захирагдах ёсны тогтолцоонд нэгдэн ордог аж (Meyer et al., 1997, 175). Улс орнууд өөртөө материаллаг (ба материаллаг бус) нөөц эрэлхийлэх явцдаа өөр хоорондоо хамааралтай (өөрөөр хэлбэл, салахад ихээхэн зардалтай) болдог тул түнш орнуудаас аливаа шаардлага, дарамт ирэх тохиолдолд хамгаалалтгүй, эмзэг болсон байдаг байна. Ийнхүү үзэх нь “нээлттэй тогтолцооны онол” (open systems theory), “нөөцөөс хараат байх онол” (resource-dependency theory) зэрэг эрх мэдлийн харилцааны бусад онолуудтай нийцдэг. Ардчилсан, хүчирхэг түнш орнууд өөрсдөөс хараат бусад орнуудыг ардчилсан загвар руу шилжихийг албадах үед ардчилал нэвчих магадлал ихэсдэг. Дэлхийн соёлын агуулга талаас нь авч үзвэл, бүтцийн загвар нь соёлын хэв шинжийг заяамал биш гэж үздэг.

Тухайлбал, зөв зохистой зан үйлдэл (behaviour) нь хүчирхэг гүрнүүдийн сонголт ба ашиг сонирхлоор тодорхойлогддог (Krasner, 2009). Энэ утгаар норматив агуулга нь үргэлж өөрчлөгдөж байдаг аж.

Уг судалгааны үндсэн аргумент нь “хамаарч буй хэлхээ холбоо”-ны (dependency ties) бүтэц ба агуулга нь ардчиллыг нэвчүүлэх үйл явцад чухал үр нөлөө үзүүлдэг хэмээх үндэслэл юм. Энэхүү судалгаагаар 1990-ээд оны дунд үеэс эхлээд ардчилал зогсонги байдалд орж эхэлсэн учир шалтгааныг тайлбарлав. Хүйтэн дайны турш болон дараахан үед олон улс дахь нөөц, эх үүсвэрүүд цөөн хүрээнд төвлөрсөн байв. Улс орнууд Зүүний коммунист эсвэл Барууны ардчилсан гэдэг ангилалд хамаарч үүнээс өөр хувилбар маш цөөн байлаа. Энэ үед хоёр туйлт олон улсын дэг журам тогтож байв. Хэдийгээр Барууны хүчнүүд коммунизмыг дарж байхын тулд зарим дарангуйлагчдыг дэмжиж байсан ч 1979 оноос Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ)-ын хүч суларч эхлэхтэй зэрэгцэн дээрх ажиллагааг цаашид үргэлжлүүлэх шаардлагагүй болов (Cohen, 2015, 83; Mann, 2013, 113). ЗХУ аажмаар нуран унаж богино хугацаанд нэг туйлт үе эхэлсэн нь ардчилахыг шаардсан Барууны дарамтыг улам ихэсгэв. Үүний улмаас Төв болон Зүүн Европын улс орнууд ардчилагдаж улмаар Европын нийгэмлэгийн нэгэн хэсэг болов. Өмнөд Сахарын улс орнууд анхны ардчилсан сонгуулиа зохион байгуулж Латин Америкт урт настай хэд хэдэн дарангуйлалд улс төрийн либералчлал явагдаж эхлэв<sup>2</sup>. Зарим судлаачдын хувьд эдгээр өөрчлөлтүүд нь ардчиллын онцгой, дөрөв дэх давалгаа үүссэн гэж үзэхэд хүргэв (McFaul, 2002).

Гэвч 1990-ээд оны дунд үеэс эхлэн Хүйтэн дайны дараах үеийн дэглэм нь улам олон туйлт бөгөөд даяарчлагдсан эрин зуунд хөл алхан оров. Материаллаг талаас нь үзвэл дэлхийн харилцаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) ба бусад бүсийн хэмжээний томоохон хүчнүүд хурдацтай төрөн гарсан нь хамаарч буй хэлхээ холбоо илүү төрөлжиж улс орнуудын зөвхөн Барууны нөөцөөс хамаарах бус нөөцийн өөр хувилбарууд бий болсныг илэрхийлж байв (Jenkins, 2012; Mason, 2017; Taylor, 2014). Жишээ нь 1989-2006 оны хооронд Хятад болон Сахар орчмын Африкийн (COA) хоорондын хоёр талт худалдаа эрчимтэй нэмэгдсэн (Taylor, 2009; Tull, 2006)<sup>3</sup>. Түүгээр зогсохгүй Хятад болон бүсийн хэмжээний бусад томоохон гүрнүүдийн нөлөө нэмэгдсэнээр

---

2 Левицкий болон Вэй нарын (Levitsky and Way, 2015, 50) тайлбарласнаар бол: “нөөц эх үүсвэр, гадаад холбоотон, эсвэл албадлагын найдвартай байгууллагууд хомс нөхцөлд, авторитари дэглэмтэй олон улс орон 1989 оны дараа ноцтой хямралд унасан байна. Үр дүнд нь өрсөлдөөнтэй, өргөн хүрээний “анхны утгаараа олон үргэлч үзэл” бий болсон юм. Учир нь “төрийн хувьд сөрөг хүчний сорилтуудыг дарах, ядаж л хамгийн энгийн арга хэрэгслүүд багатай байжээ”.

3 Латин Америкийн хувьд, Женкинс (Jenkins, 2012)-ийг үзнэ үү.

зах зээлийн авторитарианизмын дэглэмийг даруй сэргээн тогтоож Вашингтоны зөвшилцлийн байгууллагуудын нөлөөг бууруулав (Halper, 2010). Энэхүү нөхцөл байдал нь олон улсын харилцаанд тогтсон байсан Барууны ноёрхлыг дордуулаад зогсохгүй мөн зах хязгаар нутгууд дахь гол хүчнүүдийн хоорондох өрсөлдөөнийг өдөөж өгсөн байна. Энэ нь эргээд хараат улс орнуудад Барууны ардчилсан үзэл санаанаас ангижрах боломжийг олгож, улмаар гадаадад ардчиллыг сурталчлан түгээх Барууны сэдлийг бууруулсан байх магадлалтай (Cooley, 2015).

Уг судалгаа нь ардчиллын нэвчилтийн судалгаанд хоёр төрлийн хувь нэмэр оруулах болно. Нэгдүгээрт, энэ бүлэгт улс орнууд зөвхөн худалдаа хийгээд зогсохгүй мөн улс төр ба цэрэг армийн арилжаа солилцооны арга хэмжээнд оролцдог “олон хэмжээст эрх мэдлийн хүчний сүлжээ” (multidimensional power network) болсон олон улсын орчны талаар танилцуулах болно (Mann, 2013). Өмнөх судалгаанууд олон улсын солилцоог зөвхөн орон зайн (Brinks and Coppedge, 2006; Gleditsch and Ward, 2006; O’Loughlin et al., 1998), улс төрийн (Pevehouse, 2002; Wejnert, 2005), эсвэл эдийн засгийн (Beck et al., 2006; Li and Reuveny, 2003) сүлжээ талаас нь тусгаарлаж тайлбарлаж ирсний улмаас олон улсын орчны олон талт шинж чанарыг орхигдуулсаар иржээ. Хоёрдугаарт, уг судалгаанд ардчиллыг тайлбарлахын тулд олон улсын харилцаанд буй хамаарч буй хэлхээ холбооны бүтцийг онцгойлон авч үзэв. Дээр дурдсан олон судалгаанд эдгээр нарийн түвэгтэй бүтцийг хайхралгүй орхисон байдаг. Хэдийгээр “дэлхийн тогтолцооны дүн шинжилгээний” (world-system analysis) хүрээнд бүтцийн асуудлыг тайлбарлахыг оролдсон байдаг боловч эдгээр тайлбар нь голцуу худалдааны харилцаанд ач холбогдол өгсөн байдаг тул мөн л хязгаарлагдмал байдаг (Balaev, 2009; Bollen, 1983; Clark, 2012). Энэхүү судалгаа нь Торфасон ба Инграм нарын (Torfason and Ingram, 2010) ардчиллын нэвчилтийн судалгаанаас ялгаатай бөгөөд даяаршил ба нэн ялангуяа хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөлөл дэлхий даяарх ардчилагдах үйл явцад сорилт учруулж байгааг шинжилснээрээ давуу талтай юм.

Уг бүлгийн эхний хэсэгт ардчилагдах үйл явцын тухай дэлхийн полити буюу соёлын загварын талаар товч хэлэлцэнэ. Хоёрдугаар хэсэгт бүтцийн хандлагыг танилцуулж ардчилсан болон авторитари засаглалтай түнш орнуудад хамаарч буй сүлжээ нь ардчиллын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлдөг талаарх таамаглал дэвшүүлсэн. Гуравдугаар хэсэгт эмпирик дүн шинжилгээний үр дүнг мөн бүлгийн төгсгөл хэсэгт судалгааны дүгнэлтийг танилцуулсан болно.

## **Олон улсын харилцаа ба ардчилагдах үйл явц: Дэлхийн полити онол**

Дэлхийн полити онол (ДПО) нь улс үндэстнүүдийн ижилсэх асуудалд голлон анхаардаг. Уг онолоор олон улсын интеграци нь улс орнуудын

хувьд нэгэн хэв загвартай соёлын орчныг бүрдүүлж орчин үеийн төрийн зан үйлийн хэм хэмжээний талаарх үзэл баримтлал нь дотоодын институциуд тодорхойлж улмаар дэлхий даяар институциуд хоорондоо ижил төстэй болно гэж үздэг. Бүгд биш юм гэхэд эдгээр үзэл баримтлалуудын дийлэнх нь Өрнийн Соён гэгээрлийн үеийн сэтгэгчдээс үүсэлтэй. Өөрөөр хэлбэл олон улсын тогтолцоонд капитализм ба христийн шашинд тулгуурласан дэвшил ба шударга ёсыг эрхэмлэгч Өрнийн сэтгэлгээ ноёлох болсон. Ийнхүү либерал ардчиллын тухай ойлголт нь дэлхийн системд давамгайллагч хэм хэмжээ, үзэл санааны нэг юм (Torfason and Ingram, 2010).

ДПО-ын хувьд олон улсын төрийн ба төрийн бус байгууллагууд (ОУТБ ба ОУТББ) нь ардчилсан үзэл санааг гол тээгчид юм. Дэлхийн II дайны дараа эдгээр байгууллага гайхалтай хэмжээгээр өргөжин тэлсэн байдаг ба дэлхийн нийгмийн (world society) гол бүтцийг бүрдүүлдэг байна. Улс орнууд эдгээр байгууллагатай нэгдэж холбоо тогтоосноор, олон улсын соёлын нөлөөнд автдаг байна. Тодруулбал, эдгээр байгууллагуудад нэгдэх улс орны тоо өсөх тусам ардчилал тархах магадлал нэмэгдэнэ гэсэн үг юм. Жишээ нь, Вейнерын судалгаагаар (Wejnert, 2005, 67) улс орнууд ОУТБ-уудад нэгдсэн эсэх нь тэдгээрийн ардчилсан улс болох эсэхийг таамаглагч болдгийг тогтоожээ. Бусад судалгаанууд мөн ижил үр дүнтэй гарсан байдаг (Gleditsch and Ward, 2006; Pevehouse, 2002). Тухайлбал, Хафнер-Буртон ба Цуцуй (Hafner-Burton and Tsutsui 2005) нар судалгаагаараа ОУТББ-ууд дахь иргэдийн оролцоо нь засгийн газар хүний эрхийг дээдлэхэд эергээр нөлөөлдөг болохыг харуулсан байна. ОУТББ-уудад илүү олон иргэд холбогдох тусам иргэдийнхээ эрхийг удирдагчид нь зөрчих асуудал төдий хэмжээгээр бага байх магадлалтай.

Сонирхолтой нь ДПО-д ардчиллын нэвчилт нь олон улсын бүтцээс хамаардаггүй гэж үздэг (Strang and Meyer, 1993). Олон улсын систем бол соёлын интеграци бүхий харилцан холбоотой орчин нь олон улсын шатлан захирах ёсноос давамгайлсан орчин нөхцөлийг илэрхийлдэг. Тиймээс ардчиллын нэвчилтийг соёлын хувьд хүлээн зөвшөөрөх үйл явц ба норматив изоморфизмийн үр дүн хэмээн тайлбарлах нь зохимжтой хувилбар юм (DiMaggio and Powell, 1983). Олон улсын орчин нь зөв, зохистой зан үйлийн талаарх дүрмүүдээс бүрдсэн байх ба ардчилалд хүрэх тодорхой арга замыг санал болгодог. “Дэлхийн нийгмийн хууль ёсны гишүүд гэж хүлээн зөвшөөрөгдөхийн тулд” улс орнууд дэлхийн хэм хэмжээ болон ардчилсан үзэл санааг дагаж мөрддөг (Krücken and Drori, 2009, 15). Ардчилсан загваруудыг батлан хэрэгжүүлснээр улс орнууд олон улсын төрийн системд гүйцэтгэх өөрсдийн үүрэг болон статусыг баталгаажуулахыг хичээдэг байна (Simmons et al., 2008).

## Олон улсын харилцаа ба ардчилагдах үйл явц: Бүтцийн хандлага

Бүтцийн хандлага нь ДПО-оос хэд хэдэн талаар ялгаатай. Нэн тэргүүнд, бүтцийн хандлага нь олон улсын системийг холбоо гэдэг талаас бус харин түүнийг “эрх мэдэлээс хамаарах сүлжээ” (power-dependency network) гэж үздэг. Улс орнууд материаллаг (ба материаллаг бус) нөөцийг харилцан солилцож байдаг харилцан бие биеэсээ хамааралтай үйл ажиллагааны системд татагдан орсон байдаг. Галтуны хувьд (Galtung, 1971, 85) эдгээр харилцан үйлдлийн бүтэц зохион байгуулалт нь босоо ба феодалын шинж чанартай аж. Босоо гэдгийн утга нь харилцан үйлдлээс бий болсон үр дагаврууд нь үндэстний болон олон улсын хувьд ихээхэн тэгш бус байдаг гэсэн үг. Тухайлбал, зарим орнуудын хувьд, энэ нь түүхий эдийн экспорт болон байгалийн нөөцийн хомсдол гэсэн утгыг илэрхийлж байдаг бол бусад орны хувьд, энэ нь түүхий эд материалыг импортлон, үйлдвэрлэл явуулж боловсруулсан эцсийн бүтээгдэхүүн гаргах явдал байдаг. Эдгээр харилцан үйлдлийн феодалын шинж чанар тасралтгүй үргэлжилж байдаг. Энэхүү системийг гартаа атгасан нэгэн эрх ашгаа хамгаалахыг хичээх бол, харин энэ тоглоомд ялагдагчид ерөнхийдөө нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болдог. Учир нь улс орнууд үндэстний эрэлт хэрэгцээгээ хангах, материаллаг болон материаллаг бус нөөцийг олж авахын тулд бусад улс орнуудтай харилцах хэрэгтэй болдог ба үүнээс улбаалан олон улсын хамаарч буй сүлжээ болон эрх мэдлийн харилцаа үүсэж бий болдог (Krasner, 2009, 129). Улс орнууд солилцооны харилцаагаа таслах зардал ихсэх тусам, хамааралтай байдал бий болж эхэлдэг. Энэхүү загварт олон улсын системийг нөөцийг хянаж байдаг албадлагын шинж чанартай гэж үздэг байна (Van Rossem, 1996).

Бүтцийн хандлага нь олон улсын харилцааны соёлын агуулгыг маш ялгаатайгаар тайлбарладаг. Бүтцийн хандлага нь реалист байр суурийг буюу улс орнуудыг тусгаар бүрэн эрхт ба рациональ тоглогчдыг олон улсын харилцаан дахь анхдагч нэгж гэж авч үздэг. Улс орнуудын үйл ажиллагаа нь үндсэн хоёр логикт хөтлөгдсөн байдаг: үр дагаврын логик (logic of consequences) ба зохистой байдлын логик (logic of appropriateness) (Krasner, 2009, 213). Үр дагаврын логик гэдэг нь улс орнууд гадаадад буй өөрийн нөөц, эх үүсвэрээ баталгаажуулах гэх мэт үндэсний эрх ашгаа өргөжүүлэх хэрэгцээ шаардлагад тулгуурласан төрийн үйл ажиллагаа юм. Зохистой байдлын логик гэдэг нь норматив зарчмуудад тулгуурласан үйлдэл байдаг. Энэ нь тухайн улсын дүр төрхийн нэг хэсэг болсон байдаг ба тус улсын хувьд юуг зөв, ёс зүйтэй гэж үзэх тухай юм. Төрийн үйлдлийн эдгээр хоёр логик ихэнх тохиолдолд хоорондоо зөрчилддөг болохыг ихэнх судлаач хүлээн зөвшөөрдөг. Гэвч үүнээс илүү чухал зүйл бол үйлдэл хийх болсон логикууд нь зөвхөн тухайн үндэсний зан төлөвийг тодорхойлоод зогсохгүй өөрөөс хамааралтай бусад улс



орнуудтай хэрхэн харилцах хүлээлтийг мөн тодорхойлж байдаг. Жишээ нь, АНУ-ын гадаад бодлогын нэг хэсэг нь хүний эрх, ардчиллыг дээдлэх явдал байдаг. Энэ нь улс орнууд нь орчин тойрноосоо хамааралтай гэдгийг илэрхийлээд зогсохгүй олон улсын харилцааны орчны хэлбэр ба агуулгыг тодорхойлж байдаг. Тийнхүү төр нь олон улсын төрийн ба төрийн бус байгууллагуудаас хамаагүй илүүтэйгээр нэвтрүүлэгч агентын үүргийг гүйцэтгэдэг байна. Тэд хэм хэмжээ, үзэл санааг гадаадад идэвхтэйгээр төлөвлөн гаргаж түгээж байдаг. Гэвч тэдний хэм хэмжээ, үзэл санаа түгээх нөлөө, боломж нь тэдний олон улсын харилцаанд дахь холбоотнуудын цар хүрээ, өөрөөс хамааралтай орнуудыг татах ур чадвараас ихээхэн шалтгаалдаг. Харин олон улсын төрийн ба төрийн бус байгууллагуудын ач холбогдол бага бөгөөд зөвхөн аль нэг төрийн үйл ажиллагаа, зарчмыг баримталж байна гэдэг талаас л ач холбогдолтой аж. Тиймээс, бүтцийн загварын хувьд ардчиллын нэвчилт гэдэг бол харилцааны ба албадлагын шинж чанартай үйл явц бөгөөд энэ үйл явц нь нийгэм-бүтцийн бодит орчинд өрнөдөг (socio-structural realities).

Дээрх шалтгааны улмаас ардчиллын нэвчилтийн талаарх тайлбарыг ДПО-оос ялгаатайгаар тайлбарлах боломжтой нь харагдаж байна. Тодруулбал, ардчиллын үзэл санаа нь дэлхий дахинд гэхээс илүүтэй ардчилсан түнш орнууд хоорондын хамаарч буй сүлжээнд оршин байдаг. Эдгээр сүлжээ нь хамааралтай улс орнуудын дотоод орчныг бүрдүүлдэг. Ардчилсан түнш орнуудтай холбоотой байх нь бусад орнууд ардчиллыг хүлээн зөвшөөрөх хөшүүрэг болдог. Энэхүү хөшүүрэг нь яваандаа ардчилалд шилжих дарамт шахалт болж хувирах үед түүнээс татгалзах нь хамааралтай орны хувьд өндөр зардалтай болдог. Хамааралтай улс орнууд хэрэв эсэргүүцвэл нэг бол байр сууриа алдах эрсдэлд орох эсвэл нөөцийн чухал урсгалаас хасагдах болдог. Эдгээр механизмуудыг өмнөх судалгаануудад шууд бус аргаар туршиж үзсэн байдаг. Жишээ нь, Буа (Boix, 2011)-ын олж мэдсэнээр АНУ-тай холбоотон болох нь ардчилалд эергээр нөлөөлдөг гэсэн бол, Гүницки (Gunitsky, 2014)-гийн харуулснаар АНУ-ын худалдаа нь ардчиллыг түгээхэд түлхэц болдог гэж үзжээ. Цаашлаад, Гүүдлиф ба Хаукинс (Goodliffe and Hawkins, 2017) нар худалдаа болон улс төр, цэрэг армийн түнш орнууд ардчилсан байгаа тохиолдолд ардчилалд шилжих үйл явц өрнөх тун магадлалтай гэжээ. Энэ ойлголтод үндэслэн судалгааны эхний таамаглалыг дэвшүүлэв.

## **Таамаглал 1. Ардчилсан түнш орнуудтай хамаарч буй сүлжээнд нэгдэн орох нь ардчилсан шилжилт хийх магадлалыг нэмэгдүүлдэг**

Үүний адилаар авторитари засаглалтай түнш орнуудын хамаарч буй сүлжээнд байх нь ардчиллын нэвчилтийн эсрэг үр дүнд хүргэдэг. Энэ тохиолдолд авторитари засаглал бүхий загварууд нь хамааралтай

орнуудад зориулсан дотоодын орчныг буй болгож авторитари засаглалыг тулган шаардахад тухайн хөшүүргүүдийг гол төлөв ашиглаж эхлэх болно. Жишээ нь, улс орнууд ЗХУ-тай эвсэл болсноор ардчилалд шилжих эрсдэлээс сэргийлж чаджээ (Voix, 2011). Зөвлөлтийн удирдагчдын хувьд, ардчилал бус харин төрийн социализм гэдэг бол зөв зүйтэй зан төлөв юм гэж үзэж байсан<sup>4</sup>. Үүнтэй ижил, Гуницкий (Gunitsky, 2014)-гийн харуулснаар, дэлхийн авторитари засаглалуудын (жишээ нь Нацист-Герман улс болон ЗХУ) эрх мэдэл өсөн нэмэгдсэнээр ардчилагдах үйл явцыг дордуулсан юм гэжээ. Эдгээрээс үзэхэд аливаа үйлдлийн логикууд нь ардчилсан түнш орнуудтай хамт эсвэл авторитари засаглал бүхий түнш орнуудын хамаарч буй сүлжээнд нэгдэж орсноос шалтгаалан өөр өөр байна гэж үзээд дараах таамаглалыг дэвшүүлэв.

## **Таамаглал 2. Авторитари засаглал бүхий түнш орнуудын хамаарч буй сүлжээнд харьяалагдах нь ардчилалд шилжих магадлалыг бууруулдаг**

Гэвч ардчилсан түнш орнуудын хамаарч буй сүлжээ нь тухайн улс оронд үзүүлэх үр нөлөө цаг хугацаа, орон зайнаас хамаарч өөр өөр байдаг ба бүх зүйл материаллаг ба материаллаг бус нөөц, төр улсын ашиг сонирхлуудын төвлөрлөөс хамаардаг. Нөөцийн төвлөрөл их байх тусам хамааралтай улс орнуудын хувьд цөөн сонголттой үлддэг тул, ардчиллыг хөшүүрэгдэхэд хялбар болдог. Хүйтэн дайны үед, түүний дараахан яг л ийм байдалтай байлаа. Хүйтэн дайны үеийн олон улсын систем нь хоёр томоохон хүчний хооронд тогтсон тэнцвэрт байдал буюу эдгээр хүчийг бүрдүүлэгч геополитикийн хувьд харилцан хөшүүрэг бий болгосон нэгжүүдээс бүрдэж байв. (Cohen, 2015, 9)<sup>5</sup>. Төгс бус ч гэлээ уг системийг “хэрэв чи миний дагуул орнуудаас хол байвал би бас чинийхээс хол байна” гэсэн зарчим удирдаж эхэлсэн байдаг (Galtung, 1971, 89). Тийнхүү засаглалын хоёр хэлбэр ноёлж байв. ЗХУ нь “төрийн социализмыг” хэрэгжүүлсэн бол Барууныхан “либерал ардчиллыг” хэрэгжүүлжээ. Гэвч хоёр тал хоёулаа хүчний хувьд тэгш бус байсан. ЗХУ Төв болон Зүүн Европын ихээхэн хэсгийг хяналтдаа байлгаж харилцагч хэд хэдэн улс орнуудтай тогтвортой харилцааг хөгжүүлж чадсан байсан ба Сталины дараа дэлхийн Гуравдагч ертөнцөд илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон байна. Гэвч ЗХУ хэзээ ч үнэндээ АНУ-ын эрх мэдэл/хүч чадалд хүрч

---

4 Төрийн социализм хэмээх утгыг голдуу “хамтаар хорших (төрийн арга туршлагын хувьд ч бас) үйл ажиллагаанд тулгуурлан, зах зээлийг түүнтэй дүйцэхүйц ижил иж бүрэн бүтэц тогтолцоогоор орлуулахыг эрэлхийлж буй улс төрийн болон эдийн засгийн удирдлагын систем” хэмээн тодорхойлсон байдаг (Clapham, 1992, 15).

5 Өөрөөр хэлбэл ЗХУ ба АНУ.

нийцэж чадаагүй юм<sup>6</sup>. Үүний нэг шалтгаан нь, Зөвлөлтийн эдийн засаг сул байсан явдал. Эдийн засгийн өсөлт 1970-75 онд 3 хувь байсан бол, 1980-85 онд 1.8 хувь болж унасантай холбоотойгоор нас баралтын хувь, улсын өрийн хэмжээ нэмэгдэж, технологийн хөгжил дэвшил суларсан гэх мэт асуудал гарах болов (Mann, 2013, 182). Афганистан дахь цэрэг армийн бэрхшээлтэй зэрэгцэн эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, АНУ илүү итгэлтэй болж эхэлсэн нь Зөвлөлтийн удирдагчдыг олон улсын түвшинд шийдмэг бус байдалд хүргэжээ. Зөвлөлтийн хэд хэдэн дагуул оронд төрийн социализм байгуулах үйлс нь бүтэлгүйтэж байсан нь Баруунд либерал ардчилал амжилттай хөгжиж байсантай харьцуулахад эрс ялгаатай байв. Тиймээс социалист загвар нэр хүндээ маш хурдан алдаж либерал ардчилал байр сууриа тэлж байлаа<sup>7</sup>. ЗХУ аажмаар нуран унахад энэ байдал маш тодорхой болж ирэв. Левицкий болон Вэй (Levitsky and Way, 2015, 50) нарын үзсэнээр, ЗХУ нуран унана гэдэг нь “дэлхий даяарх дарангуйлагчдын хувьд шуурга мэт нөхцөл байдлыг бий болгов”. Төрийн олон удирдагч Баруун руу чиглэхээс өөр сонголтгүй хоцров. Үүний улмаас, улс орнуудыг ардчилалд шилжих хүчтэй дарамт бий болж, ардчиллыг дэлхий даяар огцом тэлэхэд хүргэсэн байна.

Гэвч Хүйтэн дайны дараах дэглэм нь либерал ардчилалд чөлөөтэй нэвтрэх эрх өгсөнгүй. Фукуяамагийн (Fukuyama, 1992) тунхагласан шиг “түүхийн төгсгөл” болоогүй ч, энэ цаг үед сонирхолтой, чухал бүтцийн өөрчлөлтүүд гарч эхэлсэн байна. Урьдчилан таамаглаагүй АНУ-ын хүч, эрх мэдэл мөн ардчиллын ихээхэн дарамттай байсан “нэг туйлт богино цаг мөч”-өөс эхлээд (Krauthammer, 1990), даяаршлын улмаас олон улсын систем нь олон талт дэлхийн дэг журам руу илүү хурдтайгаар орж хөгжсөн байна. Халпер (Halper, 2010, 27)-ийн үзэж буйгаар “Хүйтэн дайны дараах дэлхийн улс орнуудын зах зээл рүү хийсэн шилжилт нь хоёр төрлийн шинэ хандлагыг төрүүлэв. Эдгээр нь: “Барууны хил хязгаараас гадуурх эд хөрөнгийн нөөц ба ардчилалгүй капитализмын талаарх шинэ үзэл санаа” юм.

Хэдийгээр либерал ардчилсан загвар нийтэд дэмжигдэж түгээмэл болсон байсан ч 1990-ээд оны дунд үеэс эхлэн шохоорхол татахаа больж эхэлсэн байна (Kagan, 2008). Учир нь, нэгдүгээрт уг загварыг Вашингтоны

---

6 Киссенжерийн (Kissinger, 2014, 313) үзсэнээр, “хуваагдал болон сул орон зайгаа үл хайхран, АНУ нь хүч чадлын нөхцөл байдлын гол бүрэлдэхүүн хэсгүүдээ хадгалж авч үлдсэн байдаг; хоёр ч үеийг дамнасан цаг хугацаанд бусад бүх гол томоохон аж үйлдвэрийн төв ба хөгжиж буй эдийн засаг бүхий улс орнуудын ихэнхийг нь хамарсан Зөвлөлтийн-эсрэг албан бүс эвслүүдийг бүтээн байгуулсан байдаг.”

7 Манн (Mann, 2013, 182) дараах байдлаар дүгнэжээ: “Капитализм амжилттай байсан ба Зөвлөлтийн бие бүрэлдэхүүнүүд үүнийг мэдэж байсан. Хэрэв социализм нь капитализмаас давуу биш байсан бол, түүний оршин тогтнолыг зөвтгөх аргагүй юм. Тиймээс дэлхийд манлайлахын төлөөх тэдний түүхэн хүсэл зориг замаасаа хазайжээ.”

зөвшилцөлтэй холбогдсон байгууллагуудтай шууд холбож ойлгох болсон байна<sup>8</sup>.

Бараг ихэнх тохиолдолд эдгээр байгууллага тойргийн гадна шахуу байдаг улс орнуудын санааг зовоосон асуудлыг харгалзан ажиллаж чадахгүй байв. Орос болон “Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг” зэрэг улсад Вашингтон зөвшилцлийн байгууллагууд хүмүүсийн амьдралд сөргөөр нөлөөлж зарим тохиолдолд тэднийг зовлон шаналалд унагахад хүргэсэн байна (Mann, 2013, 201–214). Бусад улсуудын хувьд, тэд эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг нь саатуулж зогсоосон байна (Stiglitz, 2002). Үүнтэй холбогдуулан, Врийланд (Vreeland, 2003)-ийн судалгаагаар тухайн цаг үед Олон улсын валютын сангийн (ОУВС) дэмжлэг болон эдийн засгийн өсөлт хоёрын хооронд урвуу хамаарал байсан бол, Пийренбүүм (Peerenboom, 2008)-ийн хувьд 1990 оны үетэй харьцуулахад 2000 онд олон төрлийн Барууны дэмжлэгийг авч байсан улс орнууд бүүр ч дордсон байна. Хөгжил дэвшлийг авчирсан талаас нь харвал, эдгээр бүх нөхцөл байдал нь зах зээлийн ноёрхол бүхий авторитари амжилтын хажууд эрс ялгарч харагдаж байлаа (Mann, 2013, 169; Kurlantzick, 2013, 64–76)<sup>9</sup>. Зах зээлийн ноёрхол ба авторитари дэглэмтэй Хятадын хөгжлийн загвар гэхэд жишээ нь, харьцангуй богино хугацаанд хэдэн сая энгийн иргэнийг ядуурлаас гаргасан, түүнчлэн, энэ зах зээлийн ноёрхлын үр дүнд “Азийн бар”-ууд маш хурдан хөгжсөн байна (Leftwich, 1995)<sup>10</sup>. Гор (Gore, 2000, 789)-ийн үзсэнээр, Зүүн Азийн хөгжлийн загвар Барууныхаас илүү сайн өрсөлдөж чадсан, учир нь “эдийн засгийн өсөлтийн шалгуур үзүүлэлттэй уялдсан тэдний гүйцэтгэл үнэхээр гайхалтай сайн ажилласан” аж. Эдгээр загварууд нь дэлхий даяар олон удирдагчийг сэдэлжүүлж, тэдний сэтгэлд нийцэж байсан нь тэд засгийг барих эрхийг шилжүүлэхгүйгээр

---

8 Вашингтоны зөвшилцлийн хүрээний байгууллагууд нь эдийн засгийг гол төлөв, жишээ нь төрийн зарцуулалтыг танах, зээлийн өндөр хүү ногдуулах, тогтвортой валютыг хамгаалах, дотоодын капиталын зах зээлийг нээх гэх мэт олон зүйлтэй холбон тайлбарладаг. Гэвч бид Халпертай (Halper, 2010, 55) санал нэг байна. Үүнд тэрээр “зах зээлийн хүч чадал эдийн засгийн эрх чөлөөнд тулгуурладаг, гэвч эдийн засгийн эрх чөлөө гэдэг бол хувь хүн хэрхэн амьдрах, юу худалдан авах, юу үйлдвэрлэхээ сонгох эрх чөлөөтэй байсан, тийм л улс төрийн эрх чөлөөний агуулгын хүрээнд оршин тогтнох боломжтой юм.”

9 Зах зээлийн авторитарианизм гэдэг нь засаглалын нэг загвар бөгөөд эдийн засгийн либералчлалыг улс төрийн хаагдмал байдалтай хослуулсан засаглалыг хэлнэ.

10 Хөгжлийн төр (developmental state) гэдэг нь Лефтвич (Leftwich, 1995, 401–410)-ийн тодорхойлсноор, “төр нь улс төрийн хангалттай хэмжээний эрх мэдэл, бие даасан байдал ба нөөц чадавхыг төвдөө төвлөрүүлж улмаар тодорхой заасан хөгжлийн зорилтуудаа амжилттай биелүүлэхэд чиглүүлэн, хэрэгжүүлж дэмжиж чадсан улс орнууд юм” гэжээ. Зохиогч үзэхдээ, зөвхөн цөөн хөгжлийн төр бүхий улс орнууд, тухайлбал “Сингапур, Ботсван, Малайз тогтворжсон ардчилсан эсвэл ардчилсан-мэт улс төртэй хөгжлийн мөн (хагас) ардчилсан хөгжлийн төрт улс байдаг ба эдгээр оронд “нэг намын удирдлага” давамгайлсан байдаг гэжээ.

цаашид улс орноо удирдсаар байх боломж олгож байсантай холбоотой. Тийнхүү улс орны элитүүд, Зүүн Ази ялангуяа Хятадтай ойр дотно холбоо тогтоох сонирхол нэмэгдэж байв<sup>11</sup>. Энэхүү шилжилт нь эргээд ноёрхогч, авторитари засаглалын нөлөөлөл тэлэхэд хувь нэмэр болж байв. Хятадын гадаад харилцааны бодлогын үндсэн шинж чанаруудын нэг бол төрийн бүрэн эрхт байдлыг хүндэтгэдэг мөн ардчилалд шилжихийг шаардсан дарамт үзүүлдэггүй нөхцөл юм (Taylor, 2009).

Материаллаг талаас нь авч үзвэл, либерал ардчилалд тулгарсан нэг сорилт нь Барууны нөөц, тусламж Барууны хил хязгаарыг давж чадаж байна уу гэдэгт эргэлзэх явдал байв. Үүнтэй холбогдуулан, Пиетерсэ (Pieterse, 2011, 25) шинээр гарч ирж буй нийгмүүд “хөгжлийн жишиг загварын” үүргийг гүйцэтгэж бас “Хятад тэргүүтэй хүчинтэй хамтран тогтвортой зах зээл, зээл, тусламж, аюулгүй байдал” зэргийг хангах болсон нь “дэлхийн эдийн засгийг дахин өөрчилсөн” ажээ. Хүн амынх нь хэмжээг харгалзан үзсэн ч, БНХАУ-ын эдийн засаг агуу том эсэх талаар маргаан бараг үүсдэггүй байв. Түүнчлэн, Хятад улс дэлхийн хэмжээнд нөлөөлж эхлэв. 1990-ээс 2009 оны хооронд тус улс Африк тивийн хамгийн том худалдааны түнш болов (De Grauwe et al., 2012). 2001 онд, Хятад улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг (ШХАБ) байгуулснаараа Азийн улс орнуудын хооронд стратегийн болон ихээхэн өсөн нэмэгдэх болсон эдийн засгийн түншлэлийг бий болгов (Henderson, 2008). Дээр нь нэмээд, Хятад болон Латин Америкийн хоорондын эдийн засгийн холбоос өсөн нэмэгдэж Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх болсон (Jenkins, 2012). Хамгийн чухал нь, эдгээр олон шилжилт хөдөлгөөн зөвхөн Хятадаар хязгаарлагдаагүй юм. Нөгөө талаар, эдийн засаг нь төрөлжөөгүй нөхцөлийг үл харгалзан, Орос улс дэлхийн бас нэг хүчин болох үүргээ аажмаар дахин эргүүлэн авав. Мөн Турк, Иран, Венесуэль зэрэг бүс нутгийн олон хүчин бүс нутгийн интеграци болон хоёр талт хамтын ажиллагааг дэмжиж ажиллах замаар аажмаар дэлхийн системийг өөрчлөв (Vom Hau et al., 2012). Эдгээр бүх өөрчлөлт нь авторитари нөлөөллийн цар хүрээг улам өргөжүүлэв.

---

11 Тухайлбал, Камбожийн улс төрчид зах зээлийн эрх мэдлийг ганхашгүй ардчиллын нэг хэсэг гэж үздэг (Kurlantzick, 2013, 127). Түүнчлэн Ираны төрийн албаныхан Хятад руу “улс төрийн хяналтаа алдахгүйгээр эдийн засгийн хараат байдлаа хэрхэн сулруулах арга сүвэгчилсэн айлчлал хийх” хүртэл багтана (Higgins, 2007). Хятадын систем дор дунд анги, 4-с дээш жил алба хашдаг удирдагчтай, жилийн 10% өсөлтийг хүртэж буй талаар 2016 онд МУ-н ерөнхийлөгч тайлбарласан байдаг (Halper, 2010, 129). Түүнчлэн, SSA-д Хятадыг барууны загваруудын амжилттай хувилбарын нэг гэж тайлбарладаг. Бие махбодь болон оюун санааны хувьд сүүлийн 20 жилийн турш туйлдсан барууны төр засгаас өөр шинэ ертөнц байх боломжтой гэдгийг Хятад улсын жишээгээр харах боломж үүсч байна (Taylor, 2009, 23).

Нөгөө талаас, даяаршилтай зэрэгцэн хамааралтай улс орнуудад маш олон боломж шинээр бий болов. Гэвч энэ нь эдгээр улс орон Барууныхны эсрэг “нэгдэн жагссан” гэсэн үг биш юм. Харин эсрэгээрээ, өнөөдрийн байдлаар, хамааралтай олон улс орнууд Барууныхантай гүн холбоотой хэвээр байна. Жишээ нь, Барууны орнууд СОА-ийн олон орны худалдааны чухал түнш хэвээр байна (De Grauwe et al., 2012). Мөн Латин Америкийн улс орнууд Барууныхантай тогтоосон харилцаагаа үнэлсээр байгаа бол, хамааралтай улс орнууд “стратегийн хамгаалалт хийх” эсвэл “тэнцвэржүүлэх” арга хэмжээг авч байна (Tessman, 2012; Waltz, 2000). Тэд бусад орнуудтай холбоотон болох замаар хөрвөх чадвараа сайжруулна гэж үзсэн боловч уламжлалт түншүүдтэйгээ шууд тулахаас зайлсхийсэн байна. Эдгээр орнуудын эцсийн зорилго нь өөрсдийн нөөц, эх үүсвэрүүдийг төрөлжүүлэх явдал байв. Нөөцийг төрөлжүүлэх нь аль нэг түншээс хамааралтай байх байдлыг сулруулж үндэсний бие даасан, тусгаар байдлыг баталгаажуулахад нэмэртэй байдаг. Нөгөө талаас, холбоотноо алдахаас сэргийлэх шаардлагатай болсон нь Барууныхны ардчиллыг сурталчлан таниулах хүчин чармайлтыг ээдрээтэй болгох магадлалтай аж. Жишээ нь, Барууны үзэл санаа, номлол давамгайлах, олон улсын байгууллагуудын ашиг сонирхол тулгах байдлыг сөргүүлэн улс орнууд бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудыг байгуулах болжээ. Үүний адилаар харилцаа нь үр ашгаа өгөхөө болих үед, эсвэл ардчилгдах дарамт хэт гүнзгийрэх үед улс орнууд түншлэлээ өөрчилж байгаа талаар олон жишээ байдаг<sup>12</sup>. Бойле (Boyle, 2016, 42) -гийн хувьд, Хүйтэн дайны дараах эвслүүд нь “хаалттай, статик хөдөлгөөнгүй биш харин гишүүн улс орнуудынхаа өөрчлөгдөж буй ашиг сонирхолд хариу үзүүлж буй, харьцангуй уян хатан төлөвтэй болсон.” Эдгээр нөхцөл байдалд тулгуурлан сүүлийн буюу гурав дахь таамгийг дэвшүүлсэн болно.

---

12 АНУ-ын зүгээс хүний эрхийг зөрчсөн гэсэн эргэлзээтэй мэдэгдэл гаргасантай холбогдуулан Филиппин улсын ерөнхийлөгч Родриго Дутертегийн үзүүлсэн хариу үйлдэл бол нэгэн бодит кейс баримт юм. Дутерте хариу үзүүлэхдээ, зөвхөн хатуу хандаад зогсоогүй, Хятад руу хурдан шилжсэнийг нь Хятад улс таатай хүлээн авсан байна. Гэвч энэ нь Филиппин улсын гадаад бодлогод АНУ-тай тогтоосон хүйн холбоос нь үүрэг гүйцэтгэхээ больсон гэсэн үг биш юм. Жишээ нь, АНУ үндэсний аюулгүй байдлын баталгааг тэдэнд өгсөн хэвээр байна. Өөр нэгэн жишээ бол, Орос улс Крымыг хавсаргандаа оруулсан нь Беларусь улс. Хэдийгээр хоёр улс хоёулаа ойр түнш хэвээр үлдсэн боловч Орос улсын хилийн чанад дахь сайхан сэтгэлийн хандлагад Беларусь улс илүү сэжигтэй хандах болсон байна. Үр дүнд нь, Лукашенко нөөц олж авахын төлөө Барууныханд ханддаг байна.

### **Таамаглал 3. Ардчиллын шилжилтийн улс орнуудад ардчилсан түншүүдээс бүрдэх сүлжээний үр нөлөө нь Хүйтэн дайны дараах эринд авторитари төр засагтай орнуудтай худалдааны хамааралтай болсноор**

#### **Эмпирик дүн шинжилгээ**

##### ***Судалгааны мэдээлэл, өгөгдөл***

###### ***(i) Хамаарах хувьсагч***

Энэ судалгаанд ашигласан хамаарах хувьсагч нь ардчилсан шилжилт буюу утгачилбал улс төрийн хаалттай дэглэмээс илүү нээлттэй хэлбэр лүү шилжсэн хөдөлгөөнүүд байна (O'Donnell and Schmitter, 1986, 6). Ардчилсан шилжилтийн хэд хэдэн тогтсон хэмжүүр байдгийн зэрэгцээ энэхүү судалгаа нь ардчиллын (ба ийнхүү ардчилсан шилжилтүүд) хэмжүүрийн өөр хувилбарыг санал болгож байна. Ингэснээр онолын дараах сул талыг нөхөхийг оролдсон болно. Ардчиллын талаарх одоогоор байгаа олон шалгуур үзүүлэлт нь ардчиллыг дан ганц сонгуулийн зохион байгуулалттай адилтган авч үзсэн, ардчиллын цэвэр процедурын тодорхойлолтод үндэслэсэн байдаг. Ийм зөвхөн нэг өнцгөөс харсан үзэл санаанаас энэхүү судалгаа даван гарч чадсан ба ардчиллыг олон хэмжээст ойлголт юм хэмээн тодорхойлсон. Ардчиллын онолд тулгуурлан, энэ бүлэгт ардчиллын гурван ялгаатай хэмжигдэхүүнийг авч үзсэн. Үүнд (i) улс төрийн оролцоо болон өрсөлдөөн, (ii) хүний эрхийг дээдлэх ёс, (iii) гүйцэтгэх засаглалын институцийн хязгаарлалт. Эдгээр гурван хэмжигдэхүүн нийлээд ардчиллын үзэл санааны амин зүрхийг бүрдүүлдэг.<sup>13</sup> Эхний хэмжигдэхүүн буюу улс төрийн оролцоо, өрсөлдөөн нь ард түмэн эрх барина гэсэн ардчиллын үзэл санааг хамарсан байдаг (Schumpeter, 1942). Хоёр дахь хэмжигдэхүүн нь иргэний эрх чөлөө, хүний эрхийг дээдлэх ардчиллын үзэл санааг авч үзсэн байдаг (Paine, 1963). Гурав дахь хэмжигдэхүүн буюу институцийн хязгаарлалт нь ардчиллыг эрх мэдлийг хуваарилах систем гэж авч үздэг (Madison, 1952 [1788];

---

13 Энэ ажиглалт нь Ардчиллын олон янз байдал төслийн харьцуулсан хэмжүүрт шинэ судалгааны аргачлалыг нэвтрүүлэх шаардлага бий болгож байна (V-DEM талаар Coppedge et al. 2015-с харна үү). Уг төсөл нь ардчиллын олон талт үзэл баримтлалыг танилцуулдаг боловч зарим чухал үзэл баримтлалыг орхигдуулдаг. Тухайлбал, ардчиллын тодорхойлолтод эдийн засгийн сайн сайхан байдлын индексийг тусгасан байдаг. Энэ нь улс төрийн хувьд хаалттай боловч эдийн засаг нь өсч буй Руанда, Хятад зэрэг орнуудад ардчилсан гэх цолыг олгож байна. Энэ нь ардчиллын онолоос хол давсан эмпирикийн чухал үр дагаврыг бий болгож байгаа тул өөр аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Montesquieu, 1748). Ардчиллын гурван хэмжигдэхүүнийг хооронд нь харьцуулшгүй бөгөөд эдгээр нь нийлээд улс төрийн хүчийг олж авах, улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх асуудлыг зохицуулан журамлаж байдаг.

Судалгааны шинжилгээг V-DEM (v.6.2) мэдээллийн сангаас авсан тоон мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн. V-DEM (v.6.2)-ийн тоон мэдээллийг ардчиллын гурван хэмжигдэхүүнт ойлголтод нийцүүлэн дахин бүлэглэсэн болно. Хэмжигдэхүүн тус бүрд хамаарах шалгуур үзүүлэлтийг сонгож, бүлэглэхдээ “баталгаажуулсан хүчин зүйлийн шинжилгээ” (confirmatory factor analysis буюу CFA)-ний аргыг ашигласан. Хэмжигдэхүүн тус бүрт хэд хэдэн шалгуур үзүүлэлт ашиглах нь хэмжилтийн хүчинтэй (measurement validity) байдлыг нэмэгдүүлдэг. CFA шинжилгээний аргыг ашигласнаар утгыг хэмжих шалгуур үзүүлэлтийг жинлэхэд гардаг нийтлэг алдаа болох хамааралгүй, хэт нарийн түвэгтэй дүрмүүд ашиглахаас сэргийлж чадсан (Bollen, 1989).

Ардчиллын процедурын хэмжигдэхүүнийг таван шалгуур үзүүлэлтээр хэмжсэн. Сонгуулийн санал өгөх эрхийн үзүүлэлтийг тооцохдоо сонгуулийн санал өгөх de jure хууль ёсны эрхийг de facto бодит амьдрал дээр хэрэгжсэн байдлаар нь үржүүлсэн. Сонгуулийн санал өгөх de jure эрх нь санал өгөх хууль ёсны эрхтэй насанд хүрсэн иргэдийн хувь хэмжээг хэмжинэ. Сонгуулийн санал өгөх de facto эрх нь хуулиар сонгуульд оролцох эрхтэй энэ эрхээ эдэлж чадаагүй иргэдийн хувийг хэмжсэн. Эдгээрийг хослуулж ашигласнаар сонгуулийн үеэр гардаг практик доголдлыг хянах боломжтой болсон. Хоёр дахь шалгуур үзүүлэлт нь парламентын болон гүйцэтгэх засаглалын төлөв байдал болон чанарыг хэмждэг (Чөлөөт\_Шударга\_Сонгууль). Эдгээр шалгуур үзүүлэлтийн хоёуланг нь сонгуулийн жилийн түвшинд хэмжсэн. Хамгийн сүүлийн сонгуулийн мэдээллийг дараагийн сонгуулийн жилд өөр хэсэгт шилжүүлэх замаар улс орноор жилээр нь боловсруулсан бүтцийг гаргаж авсан. Гэвч дөрвөн жилийн дараа гэхэд (сонгуулийн санал өгөх эрхийн) хоёр дахь хүчин зүйлийн улмаас, эсвэл (Чөлөөт\_Шударга\_Сонгуулиудын) нэг нэгжээр унасан нөхцөл нь улс орнууд сонгуулиа хойшлуулах эсвэл сонгуулиа болих, зогсоох явдлаас үүсэж болох хэмжилтийн алдаа гарч болох нөхцөлөөс хамгаалж чадсан. Дараагийн гурван үзүүлэлт нь улс төрийн намуудын талаарх мэдээлэлтэй холбоотой. Нэг үзүүлэлт нь улс төрийн намуудыг улс төрийн үйл явцад оролцохыг хориглосон эсэхийг хэмжсэн (Намын\_хориг). Өөр бас нэг үзүүлэлт нь сөрөг хүчний намууд нь эрх баригч намын дэглэмээс хэр зэрэг бие даасан болохыг тодорхойлсон (Сөрөг\_хүчин). Гурав дахь нь нам байгуулахад учирч буй саад бэрхшээлүүдийг тодруулсан (Нам\_Байгуулах).

Хүний эрхийг хэмжих дөрвөн шалгуур үзүүлэлтийг ашигласан. Нэг нь хэлэлцүүлэг өрнүүлэх эрх чөлөө, (Хэлэлцүүлгийн\_эрх). хоёр дахь нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой мэдээллийг гаргаж өгсөн (Үзэл бодлын\_эрх). Мөн шашин шүтэх эрх чөлөө (Шашны\_эрх) болон төр нь хувийн өмчийг хүндэтгэх (Өмчийн\_эрх) талаарх үзүүлэлтүүд багтсан.



Эдгээр дөрвөн үзүүлэлт нь төр нь иргэний эрхийг ямар цар хүрээнд дээдэлдэг вэ гэдгийг хэмжих юм.

Эцэст нь, институцийн хязгаарлалтыг таван үзүүлэлтээр хэмжсэн. Нэг дэх үзүүлэлт гүйцэтгэх засаглал үндсэн хуулиас гадуур үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хууль тогтоох байгууллага мөрдөн шалгалт явуулах магадлалыг тооцож үзсэн (Хууль\_тогтоох\_байгууллагын\_мөрдөн\_шалгалт). Хоёр дахь үзүүлэлт нь гүйцэтгэх засаглалын албан тушаалтнууд хууль тогтоогчдод тогтмол дуудагдаж байсан эсэх талаар онцлон авч үзсэн (Хууль\_тогтоогчийн\_асуултууд). Хууль тогтоох байгууллага хаагдсан эсвэл үйл ажиллагаа нь зогссон үед эдгээр хоёр үзүүлэлтэд мэдээлэл, утга байхгүй байв. Гэвч энэ нь маш чухал мэдээлэл учраас, V-DEM-ийн бусад мэдээллийн эх үүсвэрүүдээс уг мэдээллийг илрүүлж орлуулж тооцсон. Гурав дахь үзүүлэлт нь гүйцэтгэх засаглалын хяналтын хувьсагч (Гүйцэтгэх\_засаглалын\_хяналт) нь хууль тогтоох байгууллагаас бусад хуулийн этгээд (омбудсман эсвэл ерөнхий прокурор гэх мэт) гүйцэтгэх засаглалд хяналт тавьж буй эсэхийг тодорхойлсон. Үлдсэн хоёр үзүүлэлт нь дээд (Дээд\_шүүхийн\_хараат бус) болон доод шатны шүүх (Доод\_шүүхийн\_хараат) нь гүйцэтгэх засаглалд шүүхийн хязгаарлалт үзүүлдэг эсэхийг тодорхойлон гаргасан. Ардчиллын талаарх гурван хэмжигдэхүүн нь далд хувьсагчууд бөгөөд үзүүлэлтийн хувьсагчуудад гарч буй өөрчлөлтийг тайлбарлаж байгаа. Тэдгээрийг регрессийн аргыг ашиглан хүчин зүйлийн коэффициентийг тооцоолсон болно<sup>14</sup>.

Уг судалгаанд ардчиллын гурван хэмжигдэхүүнд К дунджийн кластер шинжилгээ хийж гурван төрлийн улс төрийн дэглэмийг тодорхойлсон – авторитари, холимог ба ардчилсан дэглэм. Кластерийн аргачлалын давуу тал бол категориуд нь онолын гэхээс илүүтэй, эмпирик туршлага дээр үндэслэн олж авсан мэдээлэлд тулгуурладаг. Энэ нь дээрх улс төрийн дэглэмийн ангилал нь бодит байдалд нийцсэн гэсэн үг юм.<sup>15</sup>

Ангилал хоорондын зааг нь хэт хялбаршуулсан мэт харагдаж болох ч энэ нь бусад нийтлэг типологи-хэв шинжүүдээс төдийлөн ялгарахгүй.

---

14 (Энд үзүүлээгүй) CFA загварын диаграм нь ардчиллын гурван хэмжээс нь хоорондоо маш хүчтэй харилцан уялдаатай болохыг харуулсан, үүнд иргэний эрх чөлөө ба институцийн хязгаарлалтын хувьд  $r = 0.82$  байсан бол, институцийн хязгаарлалт ба улс төрийн оролцоо ба өрсөлдөөний хувьд  $r = 0.86$  болсон бол, улс төрийн оролцоо ба өрсөлдөөн ба иргэний эрх чөлөөний хувьд  $r = 0.94$  болж өсөн өөрчлөгдөж байна. Хэмжээс хоорондын харилцан хамаарлууд маш хүчтэй боловч, эдгээр нь ардчиллын нэг-хэмжээст загварыг дэмжих хэмжээний хүчтэй биш байлаа. Гурван-хэмжээст загварын таарсан индексүүдийн сайн тал нь нэг-хэмжээст загварын мөн үзүүлэлтээс илүү давж байлаа.

15 Сонгуулийн ардчиллын Лексикал индекс” зэрэг зарим типологи хэв шинжүүд нь ангилал бий болгохдоо зөвхөн цөөн эмпирик нотолгоонд үндэслэдэг (Skaaning et al., 2015). Хэрэв бодит амьдрал дээр зөвхөн хааяа л ажиглагддаг юм бол зарим онолын ангиллуудын ач холбогдолтой эсэхэд эргэлзэх нь зүй.

Типологи буюу хэв шинжүүд ардчиллын нэг хэмжигдэхүүнээс илүү олон тооны хэмжигдэхүүнд тулгуурласан байдаг<sup>16</sup>. Энэ судалгаанд ардчилал гэдгээр ардчиллын бүх гурван хэмжигдэхүүнээр хамгийн өндөр оноотой гарсан улс орнуудыг тодорхойлсон. 2005 оны байдлаар жишээ болгож болох орнууд гэвэл: АНУ, Мексик, Их Британи, Гурж, Замби юм. Авторитари дэглэмийн хувьд 2005 оны байдлаар уг гурван хэмжигдэхүүнээр дундаж оноо нь хамгийн бага гарсан дараах орнууд байв. Үүнд Бүгд Найрамдах Солонгос Ард Улс, Египет, Хятад, Куба, Судан зэрэг орнууд хамрагдсан байна. Ардчиллын гурван хэмжигдэхүүний хувьд дундаж оноо нь дунд гэж тодорхойлогдсон холимог тогтолцооны хувьд, 2005 оны байдлаар Руанда, Армен, Морокко, Иордан, Беларусь улсууд байв. Сонирхолтой нь, тогтолцоонуудын бүлэглэлүүдийг ойртон ажиглавал цаг хугацаа өнгөрөхийн хэрээр холимог тогтолцооны хувь хэмжээ нэмэгдсэн байна. Энэ нь Хүйтэн дайны дараа зөвхөн авторитари улс орнууд биш мөн засаглалын олон тогтолцооны хувьд ардчилсан шилжилт хийх эрсдэлтэй хэвээр үлдсэн гэсэн дүгнэлттэй нийцдэг.

Эцэст нь ардчилсан шилжилт гэдэг бол илүү нээлттэй хэлбэрийн тогтолцоо руу чиглэсэн хөдөлгөөн юм. Уг судалгаанд 1972-оос 2005 оны хооронд явагдсан нийт 116 шилжилтүүдийг авч үзсэн. Авторитари засаглалаас холимог засаглал руу шилжсэн ойролцоогоор 55 шилжилт байсан бол ардчилалд шилжсэн 25 шилжилт ба холимог тогтолцооноос ардчилалд шилжилт хийсэн 36 орон байв. Эдгээр шилжилтийг Хүснэгт 1-д жагсаасан байгаа. Уг шилжилтүүдийг өмнөх тогтолцооных нь хямрал болон дараагийн тогтолцоо руу шилжиж улмаар бэхжиж тогтворжих үе шаттай нь хамт кодолн дугаарласан. Ингэснээр улс төрийн систем нь гурваас илүү жил (харьцангуй) нээлттэй хэвээр байсан тохиолдлыг л бид ардчилсан шилжилт гэж авч үзсэн. Гурваас илүү жил үргэлжилж чадаагүй тогтолцоонуудын хувьд шилжилтийн улс орон гэж тодорхойлсон. Нийт сонгууль болсон улс орнуудын-жилийн 3046 кэйсийн ойролцоогоор 3.8хувьд нь шилжилт тохиолдсон байна).

---

16 Жишээ нь, Геддес нар (Geddes et al. 2014) аль нэг улс хүн амынх нь 10% нь санал өгөх эрхтэй, шүүд болон “харьцангуй” чөлөөтэй шударга сонгууль явуулж эхэлсэн цаг мөчөөс эхлээд тухайн улсыг ардчилсан улс гэж ангилдаг байна. Бойкс нар (Voix et al. 2013) гүйцэтгэх засгийн газар болон хууль тогтоох байгууллагуудын сонгуулиуд явагдсан бол мөн насанд хүрэгчдийн ихэнх нь санал өгөх хууль эрх зүйн эрхтэй бол ардчилсан засаглалтай улс орон гэж тодорхойлсон байна. Цаашлаад Чэйбүб (Cheibub et al. 2009) болон Polity IV нар зөвхөн маргаантай асуудлыг харж, улс төрийн оролцооны талаарх мэдээллийг хамруулдаггүй байна. Эдгээр типологи хэв шинжүүдийн хувьд ардчиллын зөвхөн нэг хэмжээс, оролцооны түвшин бага байгааг хүлцэн тэвчихийг илүүд үзэж байгаа нь судалгааны энэхүү бүлэгт танилцуулж буй типологи хэв шинжээс тэднийг ялгаруулж байгаа юм.

**Хүснэгт 1. Олон улсын систем дэх ардчилсан шилжилтүүд, 1972–2005**

Улс, орнууд	Шилжилтийн жилүүд	Шилжилт Хаанаас/ Хаашаа	Улс, орнууд	Шилжилтийн жилүүд	Шилжилт Хаанаас/ Хаашаа
Афганистан	2003–2004	A>H	Эл Салвадор	1991–1992	A>H
Албани	1990–1992	A>D	Эл Салвадор	1994–1995	H>D
Алжир	1989–1990	A>H	Фижи	1992–1993	H>D
Ангол	2004–2005	A>H	Габон	1989–1990	A>H
Аргентин	1972–1973	A>H	Гамби	1996–1997	A>H
Аргентин	1982–1984	A>D	Гүрж	2003–2004	H>D
Азербайджан	1999–2000	A>H	Гана	1978–1979	A>H
Бенин	1989–1990	A>D	Гана	1991–1993	A>D
Бутан	1997–1998	A>H	Грек	1973–1975	A>D
Болив	1981–1982	A>H	Гватимал	1985–1986	A>H
Болив	1984–1985	H>D	Гвиней	1991–1992	A>H
Бразил	1978–1979	A>H	Гвиней-Биссау	1993–1994	A>H
Бразил	1985–1986	H>D	Гүяана	1996–1997	H>D
Болгар	1989–1990	A>D	Гайт	1989–1990	A>H
Буркина Фасо	1990–1991	A>H	Гондурас	1979–1980	A>H
Бурунди	1980–1981	A>H	Гондурас	2002–2003	H>D
Камерүүн	1988–1989	A>H	Унгар	1988–1990	A>D
Кэйп Верде	1990–1991	H>D	Индонез	1997–1999	A>D
Төв Африкийн БНУ	1986–1987	A>H	Иран	1990–1991	A>H
Чад	1995–1996	A>H	Ирак	2003–2004	A>H
Чили	1988–1990	A>D	Иордан	1988–1989	A>H
Колумб	1990–1991	H>D	Кени	2001–2002	A>H
Коморос	1989–1990	H>D	Өмнөд Солонгос	1979–1980	A>H
Конгогийн БНУ	1990–1992	A>D	Өмнөд Солонгос	1987–1988	H>D
Хорват	1999–2000	H>D	Леван	2004–2005	H>D
БНЧех Улс	1989–1990	A>D	Лесото	1972–1973	A>H
Джубути	1991–1992	A>H	Лесото	1990–1992	H>D
Доминиканы БНУ	1977–1978	A>H	Либер	1984–1985	A>H
Доминиканы БНУ	1997–1998	H>D	Либер	2003–2004	H>D
Эквадор	1977–1979	A>D	Македон	2001–2002	H>D

**Хүснэгт 1. (үргэлжлэл)**

Улс, орнууд	Шилжилтийн жилүүд	Шилжилт Хаанаас/ Хаашаа	Улс, орнууд	Шилжилтийн жилүүд	Шилжилт Хаанаас/ Хаашаа
Египт	1980–1981	A>H	Мадагаскар	1991–1992	H>D
Малави	1993–1995	H>D	Орос	1988–1989	H>D
Малайз	2000–2001	A>D	Орос	1991–1992	A>H
Малдив	2004–2005	A>H	Руанда	1990–1991	H>D
Мали	1979–1980	A>H	Руанда	2003–2004	A>H
Мали	1991–1992	H>D	Сао-Томе ба Принцепе	2003–2004	H>D
Мавритан	1991–1992	A>D	Сенегал	2001–2002	H>D
Мексик	1999–2000	A>H	Серби	1991–1992	H>D
Монгол	1989–1991	A>D	Серби	1999–2000	H>D
Морокко	1976–1977	A>H	Өмнөд Африк	1993–1994	H>D
Мозамбик	1989–1990	A>H	Испани	1976–1978	A>D
Непал	1989–1991	A>D	Судан	1984–1985	A>H
Никарагуа	1983–1984	A>H	Сүринэйм	1986–1987	H>D
Никарагуа	1989–1990	H>D	Тайвань	1986–1987	A>H
Нигер	1988–1990	A>D	Тайвань	1992–1993	H>D
Нигер	1999–2000	H>D	Тажикистан	1997–1998	A>H
Нигерия	1978–1979	A>H	Танзани	1991–1992	H>D
Нигерия	1997–1999	A>D	Тайланд	1979–1980	A>H
Пакистан	1985–1986	A>H	Тайланд	1992–1993	H>D
Панам	1989–1990	A>D	Того	1990–1991	A>H
Парагвай	1989–1992	A>D	Тунис	1979–1980	A>H
Перу	1977–1978	A>H	Турк	2001–2002	H>D
Перу	1980–1981	H>D	Уганда	1979–1980	A>H
Перу	2000–2001	H>D	Уганда	1995–1996	H>D
Филиппин	1985–1987	A>D	Уругвай	1984–1985	A>D
Польш	1988–1990	A>D	Вьетнам	1995–1996	A>H
Португаль	1973–1974	A>D	Иемен	1990–1991	A>H
Румын	1989–1990	A>D	Замби	1991–1992	H>D

(i) Тайлбар

A = Авторитари дэглэм, H = Холимог тогтолцоо бүхий дэглэм, D = Ардчилсан дэглэм. Жишээ нь A>D гэж байвал, Авторитари дэглэмээс ардчилсан дэглэм рүү шилжсэн шилжилт гэж уншина. Хэрэв тухайн дэглэм нь гурван жилээс илүү хугацаанд үргэлжилсэн бол харьцангуй бодитой дэглэмийн ангилал байна гэж үзсэн. Шилжилтийн үе шатуудын мөчид уг шилжилтийг кодчилон дугаарласан болно.

*(ii) Үл хамаарах хувьсагч*

Олон улсын систем эрх мэдлийн нийлмэл систем болохынх нь хувьд “хамааралтай байдал”-ын асуудлыг шинжилгээнд хувьсагчаар оруулав. Ингэхдээ улс орнууд хоорондын харилцаа, холбоо биш (ямар нэг харилцан үйлдэл байгаа эсэх) харин хамааралтай байдлыг (тэгш бус харилцан үйлдэл байгаа эсэх) судалсан болно. Судалгаанд нийт гурван төрлийн “хамаарлын сүлжээ”-г тодорхойлсон ба эдгээр нь-эдийн засгийн, улс төрийн, цэргийн болно.

Эдийн засгийн сүлжээнүүд нь худалдааны хувьд хараат байдлыг хэмждэг. Импорт ба экспортын урсгалын мэдээллийг ОУВС-гийн Худалдааны статистикийн заавар, Дайны уялдаа, хамаарлууд (ДУХ-COW), Хоёр талт худалдааны тоон мэдээлэл өгөгдлийн багц зэрэг эх үүсвэрүүдээс олж авсан (Barbieri and Keshk, 2012; International Monetary Fund, 2015a). Импортын урсгал дээр олж авч чадаагүй тоон мэдээллийг экспортын урсгалын мэдээллээс, эсрэг тохиолдолд импортын урсгал мэдээллээс гэх мэтээр тооцож гаргаж авсан. Сонгож авсан гол улс орнуудын ДНБ-ий нэг хувиас давсан импорт эсвэл экспортын урсгалтай байвал үүнийг “хамааралтай байдал” гэж кодолсон. Учир нь худалдааны урсгал ДНБ-ий нэг хувь байна гэдэг нь ихээхэн том дүн юм. Тиймээс эдгээр худалдааны урсгалыг алдах нь тус улсын эдийн засагт болон бусад салбаруудад сөрөг нөлөө үзүүлж болно (Van Rossem, 1996). ДНБ-ий өгөгдлийг Дэлхийн банкны Дэлхийн хөгжлийн үзүүлэлтээс авсан ба бусад эх үүсвэрүүдээс гүйцээн бүрдүүлсэн (International Monetary Fund, 2015b; United Nations, 2017; World Bank, 2017).

Улс төрийн сүлжээг дипломат харилцааны сүлжээ болон ОУТБ-ын гишүүнчлэлд нэгдсэн байдлаар харьцуулж судалгаанд тусгасан. Европын Дэлхийн жил бүрийн тайлан ном (Europa Publications 1972-2005), COW IGO мэдээллийн бааз (Pevehouse et al., 2004)–ын мэдээллийг ашигласан. Дипломат харилцааны хувьд, А улс Булсад дипломат төлөөлөгчийн газраа байгуулсан тохиолдол бүрд хамааралтай байдлыг кодолсон. Ингэхийн учир нь байгалийн нөөц баялаг хязгаарлагдмал улс орнууд зөвхөн тэдний хувьд улс төрийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн орнууддаа л элчин сайдын яамдаа байгуулдагтай холбоотой. Харин эсрэгээрээ, олон улсын түвшинд амбицтай улс орнууд, өөрсдийн нөлөөллөө өргөжүүлэхийн тулд улс төрийн сүлжээг ашиглах болно (Van Rossem, 1996). Цаашлаад, ОУТБ-тай тогтоосон холбоосыг хэмжихдээ хоёр орны аль аль нь гишүүнчлэлтэй ОУТБ-ын тооны харьцаагаар хэмжсэн. Харьцаа нь 50 хувиас илүү бол хамаарал байна гэж үзсэн. Ингэж тасалсан хэрэг нь санаандгүй тогтоосон мэт харагдаж болох боловч ОУТБ-д хамтарсан гишүүнчлэлтэй байх явдал нэмэгдэх тусам нөлөөлөл үзүүлэх магадлал ихэснэ гэсэн санаа юм. Гэвч судалгааны шинжилгээний хэсэгт улс төр (ба эдийн засгийн) харилцааг ангилсан заагийг илүү уян хатан байдлаар тогтоож туршиж үзэх болно.

Эцэст нь, цэргийн сүлжээний хувьд гурван сүлжээг ашиглан хэмжсэн. Цэрэг армийн холбоотнуудын талаарх мэдээллийг Alliance Treaty Ob-

ligations and Provisions Project (АТОР) буюу “Эвслийн хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалт ба нөхцөлийн талаарх төсөл”-өөс авсан ба 2005 он хүртэл сунгаж авсан (Gibler, 2008; Leeds et al., 2002). Энэ сүлжээ нь бусад сүлжээнээс ихээхэн тэгш хэмтэй байдгаараа ялгардаг. Өөрөөр хэлбэл мэдээллээс харахад хамаарал байдаг ч энэ нь хоёр талд ижил хэмжээтэй байдаг. Учир нь геостратегийн амбицаасаа хамаараад цэрэг армийн холбоотнууд бие биедээ хэрэгтэй байдаг. Нөгөө талаар, зэвсгийн худалдаа болон цэрэг армийг аль нэг оронд байршуулах зэрэг нь тэгш хэмт бус сүлжээг илэрхийлнэ. Хэрэв тухайн улс нь бусад орноос томоохон зэвсгийн системийг худалдан авсан эсвэл цэргүүд хүлээн авсан бол хамааралтай байдал үүссэн гэж тодорхойлсон. Зэвсгийн системийн худалдаатай холбоотой мэдээллийг SIPRI-гээс (Стокольм хот дахь Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэн - SIPRI, 2016) авсан бол, цэрэг армийн талаарх мэдээллийг Military Balance буюу Цэрэг армийн тэнцвэр (Стратегийн судалгааны олон улсын хүрээлэн (IISS), олон жилийн дүн) гэх эх үүсвэрээс авч гар аргаар кодолн дугаарласан. 1972-2005 оны хувьд, эдгээр гурван сүлжээний дундаж корреляци бага байсан нь улс орнууд нарийн түвэгтэй олон улсын харилцаанд ордог гэсэн дүгнэлтийг бататгаж байгаа юм<sup>17</sup>.

Ардчилсан болон авторитари улс орны нөлөөллийн хувьсагчуудыг хэмжихдээ “ego-network analysis” буюу эго-сүлжээний шинжилгээний аргыг ашигласан бөгөөд тухайн орны  $t-1$  дэх жилд тухайн орны хамаарч буй сүлжээний ардчилсан эсвэл авторитари улсын хувь хэмжээг ашигласан. Хувь хэмжээг ашигласнаар уг хувьсагч олон улсын системийн өөрчлөгдөж буй бүтцийг харгалзан үзэх боломж олгосон<sup>18</sup>. Дэглэмийн талаарх мэдээллийг дээр танилцуулсан ангиллаас гаргаж авсан. Бид судалгаандаа холимог дэглэмтэй орнуудын нөлөөллийг тооцоогүй. Учир нь тэд улс төрийн өөрчлөлтийн хөдөлгөгч хүч гэхээс илүү өөрчлөлтийн нөлөөнд автагч байдаг. Хамаарлын харилцаа байхгүй байсан тохиолдолд, хувьсагчуудыг тэг (0) хэмээн кодолсон ба энэ нь ардчилсан/авторитари дэглэмийн нөлөөлөл байхгүй байсныг илэрхийлнэ. Эго-сүлжээний шинжилгээний үр дүнгээс зарим ерөнхий хэв шинжүүдийг ажиглаж болно. Нэгдүгээрт, улс төрийн болон цэргийн сүлжээнүүдийн хувьд цаг хугацаа өнгөрөх тусам илүү олон улс орнууд авторитари гэхээс илүү ардчилсан орнуудаас хамааралтай болсон байна. Энэ өөрчлөлтөд хоёр хүчин зүйл нөлөөлсөн. Тодруулбал, улс орнууд (Барууны) ардчилсан засаглал бүхий оронтой эвсэл болохоор шийдэж байгаа бол, нөгөө хүчин зүйл

---

17 Эдийн засгийн болон улс төрийн сүлжээний харилцан хамаарал (1972–2005 онуудад)  $r = 0.165$ , эдийн засгийн болон цэрэг армийн сүлжээ  $r = 0.198$  ба улс төр болон цэрэг армийн сүлжээний хувьд  $r = 0.282$ .

18 Улс орнуудын тоо хэмжээ 1972 онд 185-аас 2005 онд 212-т хэлбэлзэнэ.

нь одоогийн түнш орнууд өөрсдөө илүү ардчилсан болж хувирч байгаа явдал юм. Хоёрдугаарт, эдийн засгийн сүлжээний хувьд, цаг хугацаа өнгөрөхийн хэрээр ардчилсан засаглалд итгэх найдвар бага хэмжээгээр буурч байгааг харуулж байна. Гуравдугаарт, олон улсын түвшинд уялдан нэгдэж байгаа байдал нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр илүү төрөлжиж Барууны бус шинж чанартай болж байгааг дүн шинжилгээ харуулж байна.

Судалгааны таамаглалуудыг шалгах үүднээс бусад хэд хэдэн гол хувьсагчийг шинжилгээнд нэмж оруулсан. Хятадын худалдаанаас хамааралтай байдал (t-1) гэдэг бол 1) тухайн улс худалдааны хамьд Хятадаас хамааралтай болсон нэгэн цаг мөчийн дүнг авсан дамми хувьсагч юм. Бусад сүлжээнд гэхээс илүү, худалдаанд төвлөрсөн сүлжээг анхаарах нь олон улсын түвшинд цар хүрээгээ тэлсэн Хятадын нөлөө голчлон эдийн засгийн агуулгатай байдгаас улбаатай. Тиймээс энэхүү сүлжээнээс хамгийн хүчтэй нөлөөлөл гарах болно гэж зарим нь таамагладаг байж болох юм. Тэгвэл 1972 онд (нийт 184 орноос) зөвхөн 12 орон Хятадын худалдаанаас хамааралтай байсан бол энэ тоо 2005 онд (212 улс орноос) 150 болтлоо өсөн нэмэгдсэн байна. Авторитари засаглалтай орноос худалдааны хамааралтай байх байдлыг мөн ижил төстэй логикоор тодорхойлсон. Эцэст нь Хүйтэн дайны дараах хувьсагчийг 1989 оноос хойшхи бүх жилүүдэд нэг гэж кодлон дугаарласан.

### *(iii) Хяналтын хувьсагч*

Ардчилагдах үйл явцын боломжит корреляци хамаарлуудын жагсаалт маш урт юм. Тиймээс шинжилгээндээ Улфэлдэр болон Лустик нарын (Ulfelder and Lustik, 2007, 358) тодорхойлсон ардчилсан шилжилтийн хамгийн чухал “эрсдэлийн хүчин зүйлс”-ийг хамруулсан. Улфэлдэр болон Лустик нар эдгээр хувьсагчийг ардчилагдах үйл явцын боломжит тайлбаруудын өргөн хүрээний тоон мэдээ, өгөгдөлд мета-дүн шинжилгээ хийсний үндсэн дээр сонгосон байдаг.

Хувьсагчуудын эхний багцыг эдийн засгийн хүчин зүйлсийг судлахад ашигласан. Липсетийн хувьд (Lipset, 1959) эдийн засгийн сайн сайхан байдал гэдэг нь нийгмийн анги бий болох нөхцөл болон үндэсний ухамсар бий болоход хүргэдэг ба энэ нь ардчиллын эрэлт хэрэгцээ нэмэгдэх нөхцөлийг буй болгож байдаг гэж үзсэн байна. Гэвч судалгааны энэ сэдэв нь маргаантай хэвээр байна (энэ талаарх тоймыг Хаггард ба Кауфман нарын (Haggard and Kaufman, 2016) өгүүллээс үзнэ үү). Эдийн засгийн баялгийг хянахад нэг хүнд ногдох ДНБ-ний хувьсагчийг ашигласан. Бусад судлаачид эдийн засгийн хямрал болон ардчилагдах үйл явц хооронд маш тодорхой холбоос байгааг олж тогтоосон байна (Haggard and Kaufman, 1995; Przeworski and Limongi, 1997). Эдийн засгийн хямралууд нь дэглэм-тогтолцоон дахь хуваагдлыг улам гүнзгийрүүлж мөн олныг хамарсан эсэргүүцлийг өдөөж болох юм. Эдийн засгийн өсөлтийн түвшин хувьсагч нь энэхүү нөлөөг хянаж байдаг (World Bank, 2017). Цаашлаад баялгийн хараалын онол нь байгалийн баялаг нь ардчилагдах

үйл явц, боломжид хортой нөлөө үзүүлдэг болохыг олж тогтоосон байдаг (Ross, 2001; Ulfelder, 2007). Байгалийн баялаг нь нийгмийн элит хэсгийн дэмжлэгийг худалдан авах, тухайн улсын дарангуйлагч аппаратыг бэхжүүлэх, төр болон нийгмийн хооронд тогтсон холбоосыг гуйвуулах боломжийг олгодог. Энэ онолыг хянаж үзэхийн тулд бид судалгааны загвартаа байгалийн баялгаас хамаарсан ДНБ-ий хувь хэмжээг хэмжих хувьсагчийг нэмж оруулсан (World Bank, 2017). Судалгааны бас нэг гол шугам нь төрийн эрх мэдэл болон ардчилал дахь олон янз байдлыг харгалзаж үзсэн байгаа (Andersen et al., 2014). Авторитари төртэй улс орнууд ардчилагдах үйл явцыг таслан зогсоодог гэж үздэг. Тэд нийгэмд гүн нэвтэрч бослого гаргах өдөөгч хүчин зүйлсийг багасгадаг байна. Эдгээр улс орнуудын хувьд шаардлагатай тохиолдолд ардчилсан эрэлт хэрэгцээг нухчин дарах арга хэрэгслийг эзэмшдэг. Төрийн эрх мэдлийг хэмжихдээ тухайн төрийн үндэсний үйлдвэрлэлээс нөөцийг татан авах чадавхаар хэмжсэн (Kugler and Tammen, 2012). Зарим оюутан ардчиллын туршлагатай эсэх нь ардчилсан шилжилтэд нөлөөлдөг гэж үздэг. Тухайн улс оронд өмнө нь ардчилсан институт бий болсон бол, энэ нь өнөөгийн институтэд нөлөөлдөг, ардчиллын суурийг тавихад хялбар байдаг байна. (Ulfelder and Lustik, 2007). Энэхүү нөлөөг хянахдаа тухайн орны өмнөх жилүүдийн ардчилсан туршлага- цаг хугацааг (жилээр илэрхийлсэн) ашигласан. Түүнчлэн, Тоерэлли (Teorell, 2010) хүчтэй тэмцэл хийхийн оронд нийгмийн оролцоог хангасан тайван эсэргүүцэл нь ардчилалд хүргэх илүү магадлалтай гэжээ. Тайван эсэргүүцлийг хэмжихдээ тухайн жилд төрийн бодлогыг эсэргүүцэж цугласан доод тал нь 100 хүнээс бүрдсэн олон нийтийн цуглааны тоогоор хэмжинэ (Banks and Wilson, 2015). Улфедер ба Люстик (Ulfelder and Lustik, 2007) нарын үзсэнээр авторитари удирдагч солигдох нь ардчилагдах үйл явцад эерэг нөлөөтэй байж болох аж. Учир нь авторитари дэглэмтэй орнуудад удирдагч солигдох үйл явц нь маш эмзэг байдаг. Шинэ удирдагчийн хувьсагчийг тодорхойлохдоо, тухайн шинэ удирдагч албан тушаалдаа томилогдсон эхний 5 жилийг нэгтэй (1) тэнцүү гэж авч үзэв. Эцэст нь улс төрийн газар зүйчдийн хувьд ардчиллын тархалтын орон зайн асуудлыг онцлон чухалчилдаг (Gleditsch and Ward, 2006; Starr, 1991). Газар зүйн байршлын хувьд ардчилалтай ойрхон байна гэдэг нь либерал үзэл санааны урсгалыг дэмжиж ардчилсан хүчнүүдийг бэхжүүлж ардчиллыг илүү их ажиглан дуурайх магадлал өсөн нэмэгддэг байна. Энэхүү газар зүйн нөлөөллийг хянахын тулд ардчиллаас орон зайн хувьд алслагдсан байх хяналтын хувьсагчийг ашиглав. Хэрэв хоёр улс 400 эсвэл түүнээс бага милийн зайнд усаар тусгаарлагдсан байвал эдгээр орныг газар зүйн хувьд холбогдсон байна гэж үзэв (Correlates of War Project, 2016). Бүх хувьсагчдыг нэг жилийн хоцрогдолтой авсан нь зэрэгцсэн нөлөөллөөс сэргийлэх зорилготой байв. (Энд хараахан үзүүлээгүй) корреляцийн хүснэгтээр үл хамаарах хувьсагчууд нь үргэлжилсэн шугаман нэгдэл биш болохыг харуулсан.



### **Дүн шинжилгээ, судалгааны үр дүн**

Хүснэгт 2-т харуулсан 1 дүгээр загварт 1972–2005 оны хугацаанд ардчилсан сүлжээнд харьяалагдах нь ардчилсан шилжилт хийхэд нөлөөлөх эрсдэлийг шинжилсэн болно. Судалгааны дараагийн загваруудад түүхэн үйл явдлын шинжилгээний аргыг ашигласан (cloglog буюу ардчилсан шилжилтийн үйл явцын нарийвчилсан бүртгэл) ба түр зуурын хугацаанаас хамааралтай үйл явдлыг хянахдаа насжилтын-шугам (age-linear), насжилтын-квадрат (age-square), насжилтын-куб (age-cube) зэрэг аргыг ашигласан. Цаашлаад, алдааны нөхцөлүүд нь хомосэдастик (homoscedastic) буюу цуврал байдлын ямар нэгэн уялдаа холбоогүй байв<sup>19</sup>. Орхигдсон утгыг орлуулан тооцох аргаар тооцсон (Honaker et al., 2011). Шинжилгээний үр дүнгээс харахад, ардчилсан түншүүдээс улс төрийн хамааралтай байх нь ардчилсан шилжилт хийх харьцангуй эрсдэлийн хувьд статистик ач холбогдолтой бөгөөд эерэг нөлөөг үзүүлж байна. Улс төрийн сүлжээн дэх ардчилсан түншүүдийн эзлэх хувь нэг нэгжээр өөрчлөгдөх тутамд (ө.х сүлжээн дэх бүх орон ардчилсан, эсвэл нэг ч орон ардчилсан бус байх заагт), ардчилсан шилжилтийн логик загвар (cloglog) нь 2.759 нэгж байна ( $p < 0.05$ ). Түүнчлэн тухайн хувьсагчийн өөрчлөлтийн шинжилгээ хийж үзсэн бөгөөд бусад бүх хувьсагчийг дундаж утгаар нь авч зөвхөн ардчилсан түншүүдийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулахад ардчилсан шилжилтийн магадлал даруй 10 хувиар ( $p < 0.01$ ) өөрчлөгдөж байсныг тогтоосон. Энэ бол харьцангуй хүчтэй нөлөө юм. Худалдаа ( $\beta = 0.458$ ;  $p = 0.238$ ) ба цэрэг армийг ( $\beta = 0.199$ ;  $p = 0.540$ ) түшиглэсэн сүлжээнд нэгдэж орсон ардчилсан түншүүдийн коэффициент нь мөн эерэг байсан боловч статистикийн хувьд тийм ч ач холбогдолтой байгаагүй. Бүх тохиолдолд, гарсан үр дүнгүүд  $H_1$  [таамаглал 1]-ийг дэмжиж байгаа юм. Хүснэгт 2 дахь 2 дугаар загварт мөн ижил төрлийн дүн шинжилгээг авторитари дэглэмтэй түншүүдтэй хамаарч буй сүлжээнд хийсэн. 2 дугаар загварт, авторитари түнш орнуудын сүлжээнд нэгдэх нь эдийн засгийн утгаараа ардчилгдах үйл явцад сөрөг нөлөө үзүүлж байсан бол, улс төрийн утгаараа эерэг нөлөө үзүүлж байсан. Харин цэрэг армийн хамаарч буй сүлжээний утгаараа коэффициент нь статистикийн талаасаа тэгээс (0) бага зэрэг ялгаатай, сөрөг утгыг илэрхийлж байсан. 2 дугаар загварын үр дүнг ажиглавал, авторитари орнуудтай цэрэг армийн хувьд түнш байх, нэг сүлжээнд байх үзүүлэлт нэг нэгжээр өөрчлөгдөх

---

19 Копеджийн хувьд (Coppedge, 2013, 282–284), ардчилалтай холбоотой өнгөрсөн арга туршлагыг хянах нь олон янзын статистик (heteroscedasticity)-д зориулсан техникийн зохицуулалт байдаг бол, цуврал автомат харилцан хамаарал (serial autocorrelation) гэдэг нь “ардчиллын түвшин гэхээс илүү ардчилалд гарсан өөрчлөлтийг” тайлбарлахад тохируулсан байдаг.

тутамд *ceteris paribus* ардчилсан шилжилтийн хийх логик загварыг 0.655 нэгж ( $p < 0.05$ )-ээр бууруулж байв. Хувьсагчийн өөрчлөлтийн утгаар мөн бусад бүх хувьсагчдыг дундаж утгаар нь авч үзэхэд, цэрэг армийн сүлжээнд нэгдсэн авторитари дэглэмтэй түнш орнуудын харьцаа хэмжээнд хойшлуулшгүйгээр шууд гарсан нэг өөрчлөлт бүр нь ардчилсан шилжилтийн магадлалыг 2 хувиар ( $p < 0.05$ ) бууруулдаг болохыг олж мэдлээ. Хэдийгээр нотолгоо нь тийм хүчтэй биш ч судалгааны үр дүн H2 [таамаглал 2]-ыг баталж байна.

## Хүснэгт 2. Ардчилсан шилжилт хийх эсэх эрсдэлд эдийн засаг, улс төр, цэрэг армид хамаарч буй сүлжээний үзүүлэх нөхцөлт нөлөө, 1972–2005

	Загвар 1	Загвар 2	Загвар 3	Загвар 4 (Хүйтэн-дайны дараа)
Насжилт Шугаман	0.414*** (0.143)	0.438*** (0.143)	0.406*** (0.142)	0.563*** (0.206)
Насжилт Квадрат зэрэгт	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)	-0.000 (0.000)
Насжилт Куб зэрэгт	0.000 (0.000)	-0.000 (0.000)	0.000 (0.000)	-0.000 (0.000)
Хүйтэн дайны дараах (89+)	0.363 (0.242)	0.624* (0.342)	1.851* (1.001)	
Ардчилсан түнш орнууд (Эдийн засгийн сүлжээ)	0.458 (0.388)		0.112 (0.474)	0.305 (0.693)
Ардчилсан түнш орнууд (Улстөрийн сүлжээ)	2.759** (1.325)		5.388*** (1.728)	-0.133 (1.911)
Ардчилсан түнш орнууд (Цэрэг армийн сүлжээ)	0.199 (0.325)		0.515 (0.433)	-0.235 (0.503)
Авторитари түнш орнууд (Эдийн засгийн сүлжээ)		-0.765 (0.521)		
Авторитари түнш орнууд (Улстөрийн сүлжээ)		0.731 (1.114)		
Авторитари түнш орнууд (Цэрэг армийн сүлжээ)		-0.665** (0.333)		
Ардчилсан түнш орнууд * Хүйтэн дайны дараа (Эдийн засгийн сүлжээ)			1.017 (0.812)	
Ардчилсан түнш орнууд * Хүйтэн дайны дараа (Улстөрийн сүлжээ)			-5.202** (2.271)	

<b>Хүснэгт 2. (үргэлжлэл)</b>				
	Загвар 1	Загвар 2	Загвар 3	Загвар 4 (Хүйтэн-дайны дараа)
Ардчилсан түнш орнууд * Хүйтэн дайны дараа (Цэрэг армийн сүлжээ)			-0.741 (0.644)	
Хятадаас худалдааны хамааралтай байх				-0.758** (0.358)
Эдийн засгийн өсөлт	-0.005 (0.015)	-0.003 (0.014)	-0.004 (0.015)	0.031* (0.019)
Нэг хүнд ногдох ДНБ (бүртгэж оруулсан)	-0.025 (0.116)	0.087 (0.111)	-0.054 (0.115)	-0.228 (0.162)
Байгалийн баялаг	-0.013 (0.009)	-0.017** (0.009)	-0.012 (0.009)	-0.009 (0.011)
Төрийн эрх мэдэл	0.233 (0.211)	0.201 (0.207)	0.242 (0.212)	0.572* (0.324)
Дотоодын жагсаал цуглаан	0.062* (0.036)	0.070** (0.035)	0.056 (0.036)	0.041 (0.088)
Гүйцэтгэх засаглалын шинэ удирдагч	0.326 (0.199)	0.385* (0.198)	0.326* (0.198)	0.378 (0.285)
Ардчиллын өмнөх туршлага	0.019 (0.021)	0.030 (0.020)	0.029 (0.021)	0.063*** (0.023)
Ардчиллаас орон зайн хувьд алслагдсан байдал	-0.141 (0.260)	-0.159 (0.266)	-0.162 (0.263)	-0.212 (0.378)
Тогтмол тоо	-6.035*** (0.925)	-5.592*** (1.083)	-6.573*** (1.026)	-4.093*** (1.365)
Ажиглалт	3,046	3,046	3,046	1,221
Улс орны тоо	132	132	132	107

Тайлбар: Хаалтад буй стандарт алдаанууд. \*\*\*  $p < 0.01$ , \*\*  $p < 0.05$ , \*  $p < 0.1$ . Бүх үл хамааран хувьсагчууд нэг хугацаагаар хойшлуулагдсан.

Хүснэгт 2-ын 3 дугаар загварт, ардчилсан түнш орнуудтай хамаарч буй сүлжээнд нэгдэж орох нь Хүйтэн дайны өмнөх болон дараах цаг үед дэхнөхцөлт нөлөөллийг судалж үзсэн. Уг загвар нь, Н1 таамаглалтай нийцэж байгаа ба Хүйтэн дайны үед эдийн засгийн ( $\beta = 0.112$ ;  $p = 0.814$ ), улс төрийн ( $\beta = 5.388$ ;  $p < 0.01$ ), цэрэг армийн ( $\beta = 0.515$ ;  $p = 0.235$ ) сүлжээнүүдэд илүү олон ардчилсан түнш орнууд нэгдэж орсноор ардчилсан шилжилтийн харьцангуй эрсдэл төдий хэмжээгээр нэмэгдэж байсныг харуулж байна. Авторитари дэглэмтэй түнш орнуудын хувьд байдал эсрэгээрээ байсан (тооцооллын үр дүнг харуулаагүй) ба энэ нь мөн Н2 таамаглалтай нийцэж байсан<sup>20</sup>. Сонирхолтой нь, нөхцөлт загварын үр дүнгээс харахад (ардчилсан түнш орнууд ба Хүйтэн дайны үеийн дамми

хувьсагч хоорондын харилцан үйлчлэх нөлөөллийн хувьд) Хүйтэн дайны дараах [ардчиллын] нэвчилтийн үр дүн огцом өөрчлөгдсөн байна. Харин худалдааны болон цэрэг армийн зорилгоор нэгдсэн сүлжээнд нөлөөлөх ардчиллын нөлөөлөл статистикийн хувьд тэгээс ялгаагүй хэвээр байв. Гуравдугаар загвар нь Хүйтэн дайны дараа ардчилсан түнш орнуудын улс төрийн сүлжээнд эзлэх хувь нэмэгдэхийн нөлөөлөл сул байсныг харуулж байна ( $\beta = 0.186$ ;  $p < 0.01$ ). Харилцан үйлчлэлийн нөхцөлийн талаар хийгдсэн Валдын тест хийж үзэхэд коэффициентууд нэгэн зэрэг тэгтэй тэнцүү байна гэсэн таамаглалыг няцаасан болно. Тиймээс судалгааны үр дүн зарим талаараа НЗ таамаглалыг дэмжиж байна. Хүйтэн дайны дараа ардчилсан түнш орнуудаас бүрдсэн улс төрийн сүлжээнд нэгдсэн байх нь ардчилсан шилжилтэд нөлөөлөх эерэг нөлөөлөл нь буурч байсан байна.

Гэвч НЗ таамаглалын хувьд зарим талаар хосолмол утгатай болохыг орхигдуулж болохгүй. Хүйтэн дайны дараа ардчилагдах үйл явцад дах ардчиллын мөн чанарын үр нөлөө буурсан учир шалтгааныг даяаршилтай холбон тайлбарласан. Яг энэ үед Барууны бус авторитари хүчнүүд, ялангуяа Хятад улс нөлөөллөө тогтоож чадсан. Хэрэв ардчилагдах дарамт хэт гүнзгий болох тохиолдолд улс орнуудын хувьд өөр сонголтууд бий болдог ба ардчилсан засаглалтай орнуудын дунд ардчиллыг гадаадад сурталчлан таниулах урамшууллыг бууруулсан. Тиймээс НЗ таамаглалыг гүнзгийрүүлэн судлахын тулд бид нэг нэмэлт загварыг тооцоолж үзсэн. Ингэхдээ бид судалгааны субъектээ анхаарал татаж буй Хүйтэн дайны дараах цаг үед байхаар хязгаарлаж дүн шинжилгээгээ худалдаанд түшиглэн байгуулагдсан сүлжээний хүрээнд хязгаарласан. Судалгааны онолын хэсэгт бид Хүйтэн дайны дараах олон улсын худалдаанд Хятад улс (бусад орнууд) огцом бөгөөд гайхалтай өсөлт гаргасан гэдгийг тодорхойлсон байгаа.

Хүснэгт 2 дахь 4 дүгээр загварт Хятад улсаас худалдааны хувьд хамааралтай байх нь ардчилсан шилжилт хийх эрсдэлд хэрхэн нөлөөлдгийг регрессийн аргаар шинжилсэн<sup>21</sup>. Судалгааны үр дүнд худалдааны хувьд Хятадаас хамааралтай улс орнуудын ардчилсан шилжилтийн эрсдэлийн хэмжээ нь худалдааны хувьд Хятадаас хамааралгүй улс орнуудын

---

20 Хүйтэн дайны үед эдийн засаг ( $\beta = -0.138$ ;  $p = 0.819$ ), улс төр ( $\beta = -4.251$ ;  $p < 0.01$ ), цэргийн ( $\beta = -0.967$ ;  $p < 0.05$ ) сүлжээнд авторитар байдал өөрчлөгдөх тусам ардчилсан шилжилтийн аюул буурдаг.

21 Эхний алхмаар бид авторитари орнуудаас худалдааны хувьд хамааралтай байх нь нэг нэгжийн өөрчлөлт буюу бусад бүх хувьсагчийг хянасны дараа (*ceteris paribus*), ардчилах үйл явцад сөргөөр нөлөөлнө. [Үр дүнг нь харуулаагүй] Уг дүн шинжилгээ нь авторитар орнуудаас худалдааны хувьд хамааралтай оронд ардчилсан шилжилтийн аюулыг, худалдааны хувьд хамааралгүй улс орны аюулыг 0.08-аар үржүүлсэнтэй тэнцүү байна гэж тооцсон ( $\beta = -2.521$ ;  $p < 0.05$ ). Өөр талаас нь харвал, авторитар орнуудаас худалдааны хувьд хамааралтай байдалд нэг-нэгжийн өсөлт гарах бүрт, ардчилсан шилжилтийн аюул 92%-иар буурдаг. Гэвч бидний үзэж буйгаар, энэ ангилалд Хятад улс байсан нь судалгааны үр дүнг хөтөлсөн байх магадлалтай байсан тул, үүнд анхаарал хандуулсан байгаа.

эрсдэлт хэмжээг 0.5-аар үржүүлсэнтэй тэнцүү болохыг тодорхойлсон ба мэдээж энэхүү загварт орсон бусад бүх хувьсагчуудаа давхар хянаж явсан болно. Хятадаас худалдааны хувьд хамааралтай улс орнууд Хятадаас хамааралгүй улс орнуудтай харьцуулахад ардчилсан шилжилт хийх эрсдэл нь 50 хувиар доогуур эрсдэлтэй байна ( $\beta = -0,758$ ;  $p < 0.05$ ). Хүйтэн дайны дараах үед энэхүү загвар нь ардчилсан түнш орнуудтай нэгдсэн сүлжээнээс ямар нэгэн томоохон нөлөөлөл гарсныг илрүүлсэнгүй. Цаашлаад дараагийн гурван загварт (үр дүнг энэ бүлэгт харуулаагүй) Хүйтэн дайны дараах цаг хугацаанд ардчилсан орнуудаас бүрдэж буй сүлжээний нөлөөнүүд нь худалдааны хувьд Хятадаас хамааралтай байдлаас шалтгаалан ялгаатай байсан эсэхийг тандан судалсан болно. Эдийн засгийн нөөц эх үүсвэрийн талаас нь улс орнууд Хятадад найдсан тохиолдолд улсын удирдагчид нөлөөлөлд өртөх нь бага болж ардчилсан улс орнууд [уг] холбоотноо алдахаас зайлсхийх үүднээс ардчилгдах дарамт үзүүлэхээ тэвчин түдгэлздэг гэсэн таамаглал байна. Хэдийгээр нөхцөлт байдлын нөлөө статистикийн хувьд ач холбогдолгүй байсан ч, энэхүү судалгаагаар ардчилсан түнш орнуудаас хамааралтай байх нь ардчилгдах үйл явцад эергээр нөлөөлж байсан (Хүйтэн дайны цаг үетэй харьцуулахад маш доогуур байсан ч) үүнийг Хятадаас худалдааны хувьд хамааралтай байдалтай хамт авч үзвэл, уг эерэг нөлөө сөрөг нөлөө болон хувирч байгаа талаар илрүүлсэн. Бүх тохиолдолд судалгааны эдгээр үр дүн нь НЗ таамаглалыг дахин дэмжиж байна.

Хяналтын хувьсагчуудын коэффициентуудтай холбоотой дараах зүйлсийг тодруулах шаардлагатай. Юуны өмнө, байгалийн баялаг болон ардчилах үйл явцын хоорондын харилцаа нь статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд сөрөг байгаа нь баялгийн хараалын онолтой нийцэж байна. Байгалийн баялаг харьцангуй өндөртэй улс орнууд ардчилалд шилжих боломжгүй болох магадлалтай байгааг харуулж байна. Байгалийн баялгийг ямар нэгэн [хөдөлмөрийн] үр шимээр олж авсан биш гэдэг утгаараа төр болон нийгмийн хоорондын “төрөлхийн” динамик харилцаанд сөргөөр нөлөөлдөг. Хоёрдугаарт, Теорел (Teorell, 2010)-ийн тодорхойлсонтой ижил үр дүнг энэ судалгаа харуулсан. Тодруулбал, дотоодын хүч хэрэглээгүй тайван тэмцэл болон ардчиллын боломжуудын хооронд эерэг харилцаа байгааг бид олж тогтоосон. Үндэсний хэмжээний эсэргүүцэл, тэмцэл нь ардчиллын хүчтэй зэвсэг болдог бололтой. Гэвч байгалийн баялагтай орнуудад байсан шиг тухайн цаг үед болон ардчиллын нэвчилтийн хувьсагчуудын хувьд судалгааны үр дүн тийм ч баттай байсангүй. Уг загварууд цаашлаад Хүйтэн дайны дараа ардчилсан шилжилтүүд хийгдэх илүү магадлалтай ба мөн энэ хугацаанд эдийн засгийн өсөлт, ардчилал болон төрийн эрх мэдлийн өндөр түвшинд өмнө нь хуримтлуулсан туршлага зэрэг нь ардчилсан өөрчлөлтийн өндөр эрсдэлүүдтэй холбогдсон байдаг (харин Хүйтэн дайны үеэр бол ийм байгаагүй байна). Эдийн засгийн өсөлт болон ардчилал хоёрын хоорондын харилцааны асуудал нь энэхүү судалгааны цар хүрээнээс

давсан асуудал тул тодорхой цаг хугацааны үеэс хамааран нөлөөллүүд нь өөрчлөгдөж байсан баримт нь өөрөө ирээдүйн судалгааны сэдэв болох юм. Мөн эдгээр загвар нь шинэ удирдагчид албан тушаалд томилогдох болон ардчиллын талаар өмнөх туршлага зэрэг нь ардчилагдах үйл явцад үр ашигтай байсан болохыг харуулж байна.

Нэгдүгээрт, судалгааны үр дүнгийн найдвартай байдлыг шалгаж үзэхийн тулд, хамаарах болон үр хамаарах (энд тайлагнаагүй болно) хувьсагчуудын вариантыг туршсан. Судалгаанаас гарсан үр дүн нь ардчилсан шилжилтүүдийг хэрхэн кодолноос хамаарсан, хөтлөгдсөн эсэхийг шалгасан. Ингэхдээ, Полити IV мэдээллийн сангийн хэмжигдэхүүнийг мөн ашигласан болно (Marshall et al., 2016). Полити IV нь улс орнуудыг институцийн эрх мэдлийн түвшнээс хамааран 21-онооны хэмжээсээр [-10-аас +10-ын хооронд] эрэмбэлсэн байдаг. Гурван жил эсвэл түүнээс бага хугацаанд энэхүү оноогоор гурван оноо эсвэл түүнээс илүү оноогоор өссөн тохиолдол бүрт ардчилсан шилжилтийг кодчилж дугаарласан болно. Шилжилтийн энэхүү хувьсагчийг ашиглах нь уг судалгааны үр дүнг томоохон хэмжээгээр өөрчлөөгүй болно. Ардчилсан засаглалтай орнуудаас улс төрийн ( $\beta = 2.586$ ;  $p < 0.01$ ) болон цэрэг армийн ( $\beta = 0.894$ ;  $p < 0.01$ ) хувьд хамааралтай байдал нь ардчилагдах үйл явцад эергээр нөлөөлж байсан бол авторитари орнуудаас цэрэг армийн хувьд хамааралтай байдал нь ( $\beta = -1.787$ ;  $p < 0.01$ ) ардчилагдах үйл явцыг доройтуулж байсан байна. Мөн Хүйтэн дайны дараа ардчилсан түнш орнуудаас хамааралтай байхын ардчилах үйл явцад нөлөөлөх нөлөө буурсан эсвэл онцын ач холбогдолгүй болсон ба үүнтэй зэрэгцэн Хятадаас худалдааны хувьд хамааралтай байх нь ардчиллын боломжийг (*ceteris paribus* – бусад бүх нөхцөлийг хянасны дараа) бууруулж байсан. Гэвч бид Хүйтэн дайны дараа ( $\beta = -0.801$ ;  $p = 0.499$ ) авторитари орнуудаас эдийн засгийн хувьд хамааралтай байсны улмаас үүдсэн сөрөг үр нөлөөг хуулбарлан давтаж чадаагүй ба ийм байдал мөн энэхүү цаг хугацаанд байсныг олж мэдсэн. Хятадаас худалдааны хувьд хамааралтай байдал нь ардчилсан засаглалтай орнуудаас улс төрийн хувьд хамааралтай байсны улмаас үүссэн ( $\beta = -3.103$ ;  $p < 0.01$ ) жижиг боловч эерэг үр нөлөөг дордуулдаг болохыг илрүүлсэн.

Хоёрдугаарт, судалгааны үр дүн нь хамааралтай байдлыг кодлоход ашигласан интервал-хүрээнээс хамаарч хөтлөгдсөн байх магадлалтай. Энэ магадлалыг нягтлах үүднээс кодын интервал-хүрээг өөр хувилбараар тодорхойлж загвараа дахин тооцоолж үзсэн. Эдийн засгийн сүлжээний хувьд бид хамааралтай байдлыг 0.5 ба гол улс орнуудынхаа ДНБ-ийн 2 хувиар (энэ хувь харин өмнө нь 1 байсан) бодож шинээр хэмжсэн. Улс төрийн сүлжээний хувьд ОУТБ-ын сүлжээг тооцохдоо хамтарсан гишүүнчлэлийн хувь хэмжээг 36 хувь (дундаж дүн, харин өмнө нь 50 хувь гэж байсан) гэж тогтоох замаар дахин кодчилж дугаарласан. Гарсан үр дүн нь судалгааны өмнөх үр дүнг тодорхой хэмжээнд дэмжсэн үр дүн гарсан. Гэвч энд тэмдэглэн хэлбэл зохих нэг зүйл гэвэл, худалдааны

сүлжээний интервал-хүрээг 0.5 хувьд зааж өгөх үед ардчилсан болон авторитари улс орнуудаас худалдааны хувьд хамааралтай байсан шинж тэмдэг нь хилийн мэдэгдэхүйц ач холбогдолтой ( $p < 0.11$ ) болж мөн Н1, Н2 таамаглалуудтай нийцэж байв. Хүйтэн дайны дараа ардчилсан шилжилтийн харьцангуй эрсдэлийн тал дээр ардчилсан түншүүдээсээ худалдааны хувьд хамааралтай байсны улмаас үүдсэн эерэг нөлөө дахин илэрсэн ч Хятадаас худалдааны хувьд хамааралтай байдлыг хянасны дараа энэхүү нөлөө хүчингүй болж байв. Шинжилгээгээр мөн ардчилсан түнш орнуудтай нэг сүлжээнд байхын ардчилагдах үйл явцад үзүүлэх эерэг нөлөө нь тухайн улс Хятадаас худалдааны хувьд хамааралтай бол сөрөг нөлөө болон хувирч байгааг харуулсан ба энэ нь мөн кодын интервал-хүрээг 0.5 хувьд тогтоосон үед гарсан үр дүн юм.

## Дүгнэлт

Судалгааны энэ бүлэгт олон улсын харилцаа болон ардчилагдах үйл явцын хоорондын харилцааны талаар шинэ ойлголт өгсөн үр дүн гарлаа. Олон улсын харилцаа болон ардчилагдах үйл явцын хооронд эерэг холбоос байна гэж онцлон тодорхойлдог ардчиллын нэвчилтийн талаарх Дэлхийн полити загвартай эсрэгцүүлэн энэхүү судалгаагаар ардчиллын нэвчилтийн талаарх бүтцийн загварыг гаргаж ирсэн. Уг судалгааг Хүйтэн дайны дараах цаг үед ардчиллыг нэвтрүүлэн хэрэгжүүлсэн улс орнуудын хувь хэмжээ буурсан байдлыг ажигласны үндсэн дээр хийх болсон юм. Хүйтэн дайны дараах үед олон төрлийн дэглэм ардчилал болон авторитарианизмын хоорондын “саарал бүс”-д нэг бол гацчихсан эсвэл цэвэр авторитари хэвээр үлдсэн байдаг. Судалгааны үндсэн аргумент нь ардчилагдах үйл явц яагаад 1990-ээд оноос эхлээд зогсонги байдалд орсныг тайлбарлахад Дэлхийн полити буюу соёлын загвар нь хязгаарлагдмал байна гэсэн үндэслэл байв.

Ардчиллын нэвчилтийн талаар бүтцийн загварыг ашигласан нь уг судалгааны гол хувь нэмэр юм. Өөрөөр хэлбэл, улс орнуудын хоорондын эрх мэдлийн хамааралтай харилцаануудад гарсан өөрчлөлтийг энэхүү бүтцийн загварыг ашиглан судалж үзсэн ба эдгээр төрлийн динамикууд нь дэлхий даяар явагдаж буй ардчилагдах үйл явцыг ойлгоход нэн чухал юм. Эдгээр динамикууд нь хамааралтай улс орнуудад тулгарч буй дарамт болон хөшүүргийн төрлүүдийг ил болгоод зогсохгүй мөн үйл явц үргэлж хөдөлгөөнд байж дэлхийн [олон улсын] харилцаанд нөөц баялаг хаана төвлөрч байгаагаас хамаараад тэдний үр нөлөө нь цаг хугацаа, орон зайнаас хамаараад өөрчлөгдөж байдаг аж. Уг судалгаанд ардчиллыг хэмжих дэлхийн хэмжээний, олон хэмжээст мэдээллийн санг ашиглаж, улс орон хоорондын хамааралтай байдлын харилцааг 1972-2005 оны хооронд шинжилсэн. Шинжилгээний үр дүнд ардчилсан түншүүдтэй улс төрийн хувьд хамааралтай харилцаанд байх нь ардчиллыг дэмждэг

бол, авторитари орнуудтай цэрэг, армийн хувьд хамааралтай байх нь ардчиллын боломжуудыг сулруулдаг байна.

Судалгааны бүх үр дүн нь бүтцийн загварын дэвшүүлсэн албадлагын механизмтай нийцэж байна. Түүнчлэн 1990-ээд оны дунд үеэс ямар шалтгааны улмаас ардчилал зогсонги байдалд орсон бэ гэдэгт харьцангуй онцгой, нарийн ойлголт өгч байна. Хамааралтай байдал нь ардчилсан болон авторитари орнуудын аль алинд нь өөрсдийн загвараа гадаадад экспортлох эрх мэдэл болон хөшүүргийг өгдөг бөгөөд энэхүү тойргийн захад буй улс орнууд тухайн загварыг хүлээж авахгүй байх тохиолдолд зардлыг нэмэгдүүлдэг гэдэг нь үнэн юм. Гэхдээ энэхүү логик нь хоёр туйлтай болон нэг туйлтай системүүдэд гол төлөв хэрэглэгддэг болохыг онцлон тэмдэглэсэн байна. Энэ нөхцөлд тойргийн захын улс орнуудын хувьд хурдан шуурхай хөдлөх чадвар нь харьцангуй хязгаарлагдмал байх бөгөөд тэдэнд ирэх аль нэг загварыг сонгох дарамт хүчтэй байдаг. Гэвч эдгээр бүх өөрчлөлтүүд нь олон туйлт эсвэл маш их даяарших болсон ертөнцөд өөрчлөгддөг. Ийм орчин нөхцөл нь хамааралтай улс орнуудад өөрсдийн нөөц эх үүсвэрүүдийг төрөлжүүлэх зэрэг шинэ боломж бий болгож байдаг. Эргээд энэхүү төрөлжүүлэлт нь ардчиллыг гадаадад сурталчлан дэмжих Барууны сонирхол ба чадавх аль алиныг нь бууруулдаг. Дээр нь даяаршил нь хэрэв хамааралтай улс орнууд Барууны нэгдсэн сүлжээнээс хасагдсан тохиолдолд, тэдэнд өөр хувилбар санал болгодог ба авторитарианизм дэлгэрэх шинэ хөшүүрэг болдог байна. Судалгааны үр дүнгээс харахад, Хүйтэн дайны дараах дэглэм нь дэлхий даяарх дарангуйлагч нарт илүү таатай орчин нөхцөл болж өгсөн байх магадлалтайг харуулж байна.

Цаашдын судалгаа нь судалгааны энэхүү бүлэгт танилцуулсан үр дүнгүүдийг ашиглах боломжтой. Үүнийг гүйцэлдүүлэх нэг арга бол уг судалгаанд тайлбарласан механизмууд тодорхой орнуудад хэрхэн биеллээ олж байгааг ажиглах явдал юм. Бас нэг өөр арга бол, шинжилгээгээ энэхүү судалгааны бүлэгт авч үзсэн цаг хугацааны хамрах хүрээнээс гадуур үргэлжлүүлэх арга юм. Үнэндээ, энэхүү судалгаанд зураглан гаргасан динамик хөдөлгөөн нь цаг хугацаа өнгөрөхийн хэрээр улам хүчтэй болж байсан. Жишээлбэл, сүүлийн үед гаргаад буй “Зам ба Бүс санаачилга”-тай хамт Хятадын нөлөөлөл улам бүр дэлхийн хэмжээний болж ирж байна. Эдгээр дэлхийн шинж чанартай чухал өөрчлөлтүүд нь олон газарт өрнөж буй ардчилагдах үйл явцад яг ямар нөлөө үзүүлэх магадлалтай талаар илүү дэлгэрэнгүй судалж мэдэх нь ач холбогдолтой байх болно. Үүний адилаар Турк, Орос улсуудын олон улсын тавцан дахь нөлөө нэмэгдсээр байгаа билээ. Олон улсын харилцаанд гарч буй уг өөрчлөлт бусад улс орнууд дахь ардчилагдах үйл явц, шилжилтэд ямар нөлөө үзүүлж болохыг судлах хэрэгтэй. Эдгээр өөрчлөлт нь орчин үед яагаад олон улс орнууд ардчиллаас ухрах болов гэдэгтэй холбоотой эсэхийг судлан нягталж үзэх хэрэгтэй. Цаашлаад судлаачид дэлхийн [засаглалын] системийн динамик хөдөлгөөнийг судлах илүү боловсронгуй



судалгааны дизайн боловсруулах эсвэл судалгааны асуултыг ардчилалд төвлөрсөн биш харин өөр бусад институцийн загварт хандуулж болох юм. Ямар ч тохиолдолд бидний хувьд, энэхүү судалгаа нь олон улсын харилцаа болон ардчилагадх үйл явц хоорондын нарийн цогц холбоосыг судлаачид цаашид гүнзгийрүүлэн судлах сонирхлыг нь хөхиүлэн дэмжих болно гэж найдаж байна.

## Ном зүй

- Andersen, David, Jørgen Møller and Svend-Erik Skaaning. 2014. "The State-Democracy Nexus: Conceptual Distinctions, Theoretical Perspectives, and Comparative Approaches." *Democratization*, 21(7): 1203–1220.
- Balaev, Mikhail 2009. "The Effects of International Trade on Democracy: A Panel Study of the Post-Soviet World-System." *Sociological Perspectives*, 52(3): 337–362.
- Banks, Arthur S. and Kenneth A. Wilson. 2015. "Cross-National Time-Series Data Archive." *Databanks International*. Jerusalem, Israel. URL: <https://www.cntsdata.com/>.
- Barbieri, Katherine and Omar M. G. Keshk. 2012. "Correlates of War Project Trade Data Set Codebook. Version 3.0." URL: [https://data.nber.org/ens/feldstein/Harvard\\_Library\\_Sources/Correlates%20of%20War/Bilateral%20Trade/Trade\\_Codebook\\_3.0.pdf](https://data.nber.org/ens/feldstein/Harvard_Library_Sources/Correlates%20of%20War/Bilateral%20Trade/Trade_Codebook_3.0.pdf).
- Beck, Nathaniel, Kristian Skrede Gleditsch and Kyle Beardsley. 2006. "Space is More than Geography: Using Spatial Econometrics in the Study of Political Economy." *International Studies Quarterly*, 50(1): 27–44.
- Beckert, Jens. 2010. "Institutional Isomorphism Revisited: Convergence and Divergence in Institutional Change." *Sociological Theory*, 28(2): 150–166.
- Boix, Carles. 2011. "Democracy, Development, and the International System." *American Political Science Review*, 105(04): 809–828.
- Boix, Carles, Michael K. Miller and Sebastian Rosato. 2013. "A Complete Data Set of Political Regimes, 1800-2007." *Comparative Political Studies*, 46(12): 1523–1554.
- Bollen, Kenneth. 1983. "World-System Position, Dependency, and Democracy: The Cross-National Evidence." *American Sociological Review*, 48(4): 468–479.
- Bollen, Kenneth. 1989. *Structural Equations With Latent Variables*. New York: John Wiley & Sons.
- Boyle, Michael J. 2016. "The Coming Illiberal Order." *Survival*, 58(2): 35–66.

- Brinks, Daniel and Michael Coppedge. 2006. "Diffusion is No Illusion—Neighbor Emulation in the Third Wave of Democracy." *Comparative Political Studies*, 39(4): 463–489.
- Carothers, Thomas. 2002. "The End of the Transition Paradigm." *Journal of Democracy*, 13(1): 5–21.
- Cheibub, José A., Jennifer Gandhi and James R. Vreeland. 2009. "Democracy and Dictatorship Revisited." *Public Choice*, vol. 143, No. 2–1, pp. 67–101.
- Clapham, Christopher. 1992. "The Collapse of Socialist Development in the Third World." *Third World Quarterly*, 13(1): 13–25.
- Clark, Rob. 2012. "World-System Position and Democracy, 1972–2008." *International Journal of Comparative Sociology*, 53(5–6): 367–399.
- Cohen, Saul Bernard. 2015. *Geopolitics: The Geography of International Relations*. New York: Rowman & Littlefield.
- Cooley, Alexander. 2015. "Countering Democratic Norms." *Journal of Democracy*, 26(3): 49–63.
- Coppedge, Michael. 2013. *Democratization and Research Methods*. New York: Cambridge University Press.
- Coppedge, Michael, John Gerring, Staffan I. Lindberg, Svend-Erik Skaaning, Jan Teorell, David Altman, Michael Bernhard, Steven Fish, Adam Glynn, Allen Hicken, Carl H. Knutsen, Kelly McMann, Pamela Paxton, Daniel Pemstein, Jeffrey Staton, Brigitte Zimmerman, Rachel Sigman, Frida Andersson, Valeriya Mechkova and Farhad Miri. 2015. "V-Dem Codebook v7.1." *Varieties of Democracy (V-DEM) Project*. URL: <https://www.v-dem.net/en/data/archive/previous-data/data-version-7-1/>.
- Correlates of War Project. 2016. Direct Contiguity Data, 1816–2006. URL: <https://www.correlatesofwar.org/data-sets/direct-contiguity>.
- De Grauwe, Paul, Romain Houssa and Giulia Piccillo. 2012. "African Trade Dynamics: is China a Different Trading Partner?" *Journal of Chinese Economic and Business Studies*, 10(1): 15–45.
- Diamond, Larry. 2002. "Thinking About Hybrid Regimes." *Journal of Democracy* 13(2): 21–35.
- DiMaggio, Paul J. and Walter W. Powell. 1983. "The Iron Cage Revisited: Institutional Isomorphism and Collective Rationality in Organizational Fields." *American Sociological Review*, 48(2): 147–160.
- Europa Publications. 1972–2005. *The Europa World Yearbook*. London: Routledge.
- Fukuyama, Francis. 1992. *The End of History and the Last Man*. New York: The Free Press.

- Galtung, Johan. 1971. "A Structural Theory of Imperialism." *Journal of Peace Research*, 8(2): 81–117.
- Geddes, Barbara, Joseph Wright and Erica Frantz. 2014. "Autocratic Break down and Regime Transitions: A New Data Set." *Perspectives on Politics*, 12(2): 313–331.
- Gibler, Douglas M. 2008. *International Military Alliances, 1648–2008*. Vol. 2. Washington, D.C.: CQ Press.
- Gleditsch, Kristian Skrede and Michael D. Ward. 2006. "Diffusion and the International Context of Democratization." *International Organization*, 60(4): 911–933.
- Goodliffe, Jay and Darren Hawkins. 2017. "Dependence Networks and the Diffusion of Domestic Political Institutions." *Journal of Conflict Resolution*, 61(4): 903–929.
- Gore, Charles. 2000. "The Rise and Fall of the Washington Consensus as a Paradigm for Developing Countries." *World Development*, 28(5): 789–804.
- Gunitsky, Seva. 2014. "From Shocks to Waves: Hegemonic Transitions and Democratization in the Twentieth Century." *International Organization*, 68(3): 561–597.
- Hafner-Burton, Emily M. and Kiyoteru Tsutsui. 2005. "Human Rights in a Globalizing World: The Paradox of Empty Promises." *American Journal of Sociology*, 110(5): 1373–1411.
- Haggard, Stephan and Robert R. Kaufman. 1995. *The Political Economy of Democratic Transitions*. Princeton, New Jersey: Princeton University Press.
- Haggard, Stephan and Robert R. Kaufman. 2016. "Democratization During the Third Wave." *Annual Review of Political Science*, 19: 125–144.
- Halper, Stefan. 2010. *The Beijing Consensus: Legitimizing Authoritarianism in Our Time*. New York: Basic Books.
- Henderson, Jeffrey. 2008. "China and Global Development: Towards a Global-Asian Era?" *Contemporary Politics*, 14(4): 375–392.
- Higgins, Andrew. 2007. "Iran Studies China Model To Craft Economic Map." *The Wall Street Journal*, May 18.
- Honaker, James, Gary King and Matthew Blackwell. 2011. "Amelia II: A Program for Missing Data." *Journal of Statistical Software*, 45(7): 1–47.

- Huntington, Samuel P. 1991. *The Third Wave: Democratization in the Late Twentieth Century*. Norman: University of Oklahoma press.
- International Institute for Strategic Studies (IISS). Various Years. *The Military Balance*. London: Routledge.
- International Monetary Fund. 2015a. *Direction of Trade Statistics (DOTS)*. Washington D.C.: International Monetary Fund (IMF).
- International Monetary Fund. 2015b. *International Financial Statistics (IFS)*. Washington D.C.: International Monetary Fund (IMF).
- Jenkins, Rhys. 2012. "Latin America and China—a New Dependency?" *Third World Quarterly*, 33(7): 1337–1358.
- Kagan, Robert. 2008. "The End of the End of History." *The New Republic*, April 23.
- Kissinger, Henry. 2014. *World Order*. New York: Penguin Books.
- Krasner, Stephen D. 2009. *Power, the State, and Sovereignty: Essays on International Relations*. New York: Routledge.
- Krauthammer, Charles. 1990. "The Unipolar Moment." *Foreign Affairs*, 70(1): 23–33.
- Krücken, Georg and Gili S Drori. 2009. *World Society: The Writings of John W. Meyer*. New York: Oxford University Press.
- Kugler, Jacek and Ronald L. Tammen. 2012. *The Performance of Nations*. Lanham, Maryland: Rowman & Littlefield Publishers.
- Kurlantzick, Joshua. 2013. *Democracy in Retreat. The Revolt of the Middle Class and the Worldwide Decline of Representative Government*. New Haven & London: Yale University Press.
- Leeds, Brett, Jeffrey Ritter, Sara Mitchell and Andrew Long. 2002. "Alliance Treaty Obligations and Provisions, 1815–1944." *International Interactions*, 28(3): 237–260.
- Leftwich, Adrian. 1995. "Bringing Politics Back In: Towards a Model of the Developmental State." *The Journal of Development Studies*, 31(3): 400–427.
- Levitsky, Steven and Lucan Way. 2015. "The Myth of Democratic Recession." *Journal of Democracy*, 26(1): 45–58.
- Li, Quan and Rafael Reuveny. 2003. "Economic Globalization and Democracy: An Empirical Analysis." *British Journal of Political Science*, 33(1): 29–54.

- Lipset, Seymour Martin. 1959. "Some Social Requisites of Democracy—Economic-Development and Political Legitimacy." *American Political Science Review*, 53(1): 69–105.
- Madison, James. 1952 [1788]. edited by Adler J. Mortimer, Clifton Fadiman and Philip W. Goetz. "American State Papers. The Federalist. On Liberty; Representative Government; Utilitarianism." In *Great Books of the Western World*. Chicago: Encyclopedia Britannica.
- Mann, Michael. 2013. *The Sources of Social Power. Volume 4: Globalizations, 1945-2011*. New York: Cambridge University Press.
- Marshall, Monty G., Ted Robert Gurr and Keith Jagers. 2016. Polity IV Project: Political Regime Characteristics and Transitions, 1800–2016. Dataset Users' Manual. edited by Center for Systemic Peace. URL: <http://www.systemicpeace.org/inscr/p4manualv2016.pdf>.
- Mason, Robert. 2017. "China's Impact on the Landscape of African International Relations: Implications for Dependency Theory." *Third World Quarterly*, 38(1): 84–96.
- McFaul, Michael. 2002. "The Fourth Wave of Democracy and Dictatorship—Noncooperative Transitions in the Postcommunist World." *World Politics*, 54(2): 212–244.
- Meyer, John W., John Boli, George M. Thomas and Francisco O. Ramirez. 1997. "World Society and the Nation-State." *American Journal of Sociology*, 103(1): 144–181.
- Montesquieu, Charles-Louis de Secondat. 1748. *De L'Esprit Des Lois*. Genève: Barrillot & Fils.
- O'Donnell, Guillermo and Philippe C. Schmitter. 1986. *Transitions from Authoritarian Rule: Tentative Conclusions About Uncertain Democracies*. Baltimore, Maryland: John Hopkins University Press.
- O'Loughlin, John, Michael D. Ward, Corey L. Lofdahl, Jordin S. Cohen, David S. Brown, David Reilly, Kristian S. Gleditsch and Michael Shin. 1998. "The Diffusion of Democracy, 1946-1994." *Annals of the Association of American Geographers*, 88(4): 545–574.
- Paine, Thomas. 1963. *The Rights of Man*. London: Everyman's Library.
- Peerenboom, Randall. 2008. *China Modernizes: Threat to the West or Model for the Rest?* New York: Oxford University Press.
- Pevehouse, Jon C. 2002. "Democracy from the Outside-In? International Organizations and Democratization." *International Organization*, 56(3): 515–549.

- Pevehouse, Jon C., Timothy Nordstrom and Kevin Warnke. 2004. "The Correlates of War 2 International Governmental Organizations Data Version 2.0." *Conflict Management and Peace Science*, 21(2): 101–119.
- Pieterse, Jan N. 2011. "Global Rebalancing: Crisis and the East–South Turn." *Development and Change*, 42(1): 22–48.
- Powell, Walter W. and Paul J. DiMaggio. 1991. *The New Institutionalism in Organizational Analysis*. Chicago: The University of Chicago Press.
- Przeworski, Adam and Fernando Limongi. 1997. "Modernization: Theories and Facts." *World Politics*, 49(02): 155–183.
- Ross, Michael L. 2001. "Does Oil Hinder Democracy?" *World Politics*, 53(3): 325–361.
- Schumpeter, Joseph A. 1942. *Capitalism, Socialism and Democracy*. New York: Harper & Row.
- Simmons, Beth A, Frank Dobbin and Geoffrey Garrett. 2008. *The Global Diffusion of Markets and Democracy*. New York: Cambridge University Press.
- Skaaning, Svend-Erik, John Gerring and Henrikas Bartusevicius. 2015. "A Lexical Index of Electoral Democracy." *Comparative Political Studies*, 48(12): 1491–1525.
- Starr, Harvey. 1991. "Democratic Dominoes - Diffusion Approaches to the Spread of Democracy in the International System." *Journal of Conflict Resolution*, 35(2): 356–381.
- Stiglitz, Joseph. 2002. *Globalization and its Discontents*. New York: W.W. Norton & Company.
- Stockholm International Peace Research Institute—SIPRI. 2016. *Arms Transfers Database*. Stockholm.
- Strang, David and John W. Meyer. 1993. "Institutional Conditions for Diffusion." *Theory and Society*, 22(4): 487–511.
- Taylor, Ian. 2009. *China's New Role in Africa*. Boulder, Colorado: Lynne Rienner Publishers.
- Taylor, Ian. 2014. *Africa Rising? BRICS-Diversifying Dependency*. Woodbridge: Boydell & Brewer.
- Teorell, Jan. 2010. *Determinants of Democratization: Explaining Regime Change in the World, 1972–2006*. New York: Cambridge University Press.
- Tessman, Brock F. 2012. "System Structure and State Strategy: Adding Hedging to the Menu." *Security Studies*, 21(2): 192–231.

- Torfason, Magnus Thor and Paul Ingram. 2010. "The Global Rise of Democracy: A Network Account." *American Sociological Review*, 75(3): 355–377.
- Tull, Denis M. 2006. "China's Engagement in Africa: Scope, Significance and Consequences." *Journal of Modern African Studies*, 44(3): 459–479.
- Ulfelder, Jay. 2007. "Natural-Resource Wealth and the Survival of Autocracy." *Comparative Political Studies*, 40(8): 995–1018.
- Ulfelder, Jay and Michael Lustik. 2007. "Modelling Transitions To and From Democracy." *Democratization*, 14(3): 351–387.
- United Nations. 2017. *United Nations Statistical Yearbook/Annuaire Statistique des Nations Unies, Various Years*. New York: United Nations.
- Van Rossem, Ronan. 1996. "The World System Paradigm as General Theory of Development: A Cross-National Test." *American Sociological Review*, 61(3): 508–527.
- Vom Hau, Matthias, James Scott and David Hulme. 2012. "Beyond the BRICs: Alternative Strategies of Influence in the Global Politics of Development." *European Journal of Development Research*, 24(2): 187–204.
- Vreeland, James Raymond. 2003. *The IMF and Economic Development*. New York: Cambridge University Press.
- Waltz, Kenneth N. 2000. "Structural Realism after the Cold War." *International Security*, 25(1): 5–41.
- Wejnert, Barbara. 2005. "Diffusion, Development, and Democracy, 1800-1999." *American Sociological Review*, 70(1): 53–81.
- World Bank. 2017. *World Development Indicators 2017*. Washington, DC: World Bank.





## Каталоны 10 сарын 1-ний ардчиллын төлөөх тэмцэл

### Нурия Суэро Комеллас

Испанийн засгийн газар санал хураалтыг хууль бус гэж зарласны улмаас Каталаны 2017 оны 10 дугаар сарын 1-ний ард нийтийн санал асуулга (referendum) олон нийтийн эсэргүүцлийн цуглаан болж хувирав. Иргэд сонгох эрхээ хамгаалахын тулд нэгдэж ардчиллыг тэмцлийн гол зорилгоо болгосон байна. Энэ бүлэгт Каталаны салан тусгаарлах хөдөлгөөн хэрхэн ардчиллын төлөөх хөдөлгөөн болж хувирсан бэ? Иргэд ямар хэлбэрээр оролцож хэрхэн ардчиллыг дэмжиж байв? зэрэг асуултын хариултыг эрэлхийлэх болно. Мөн олныг хамарсан иргэний эсэргүүцэл хүчирхийллийн бус хэлбэрээр илэрч байсан тухай өгүүлнэ. Үндэсний хэмжээнд болон Европ дахь үндэстэн-улсын тогтолцооны хямрал, төлөөллийн ардчиллын талаарх хурц шүүмжлэл өрнөж буй энэ цаг үед Каталаны ард нийтийн санал асуулга нь иргэний нийгмийн байгууллагууд ардчиллыг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаанд оролцох арга замын нэг жишээ болсон. Энэхүү бүлгийг 10 сарын 1-ний ард нийтийн санал асуулгын үеэр хоёр нутгийн удирдлагын байгууллагын санал авах дөрвөн байранд хийсэн оролцоот ажиглалтын судалгааны үр дүнд үндэслэн бичсэн. Ажиглалтын судалгааны үр дүнгээр хэрхэн иргэд зохион байгуулалтад орсон явдал нь ардчиллыг түгээх үйл хэргийн талбар болсныг харуулна. Тэр дундаа “Ард нийтийн санал асуулгыг хамгаалах хороод” нь 10 сарын 1-ний ард нийтийн санал асуулгаас хойш “Бүгд найрамдах улсыг хамгаалах хороод” болон өөрчлөгдөн байгуулагдсан жишээг авч үзнэ.

### Оршил

Каталоны 2017 оны 10 сарын ард нийтийн санал асуулга нь газар нутгийн асуудлын хүрээнээс хальж ардчиллын төлөөх тэмцэл болж хувирсан үйл явдал байв. Энэхүү үйл явдал нь ард нийтийн санал асуулгыг хууль бус хэмээн зарласан Испанийн төр засгийн шийдвэрийн хариу болгон санал өгөх эрхээ хамгаалах, эдлэх боломжийг бий болгохыг зорилгоо болгосон олон нийтийн хөдөлгөөн байв. Энэ бүлэгт 10 сарын 1-ний ард нийтийн санал асуулгын үеэр хийсэн ажиглалтын судалгаанд тулгуурлан ардчиллыг хөгжүүлэхэд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг ролийг шинжлэн судлах болно. Тус бүлэгт 10 дугаар сарын 1-ний бүх нийтийн санал асуулгын үеэрх ажиглалтын судалгаанд тулгуурлан ардчиллыг бэхжүүлэхэд иргэний нийгмийн үүрэг ролийг судлах болно. 10 дугаар сарын 1-ний үйл явдал Каталаны салан тусгаарлагч хөдөлгөөний цар хүрээ, агуулгыг өргөжүүлж эсэргүүцлийн хөдөлгөөний төвд ардчиллыг гүнзгийрүүлэх үзэл санааг оруулж ирснээрээ сонирхол татаж байна.

Үндэстэн-улсын тогтолцоо ба төлөөллийн ардчилалд дэлхий даяар хямрал нүүрлэсэн цаг үед Каталаны салан тусгаарлах хөдөлгөөн нь Испани улс болон Европын холбооны ардчиллыг сорьсон томоохон үйл

явдал болж байв. Каталонд болсон үйл явдлууд нь дэлхий даяар гарч байсан өөрчлөлтийн үр дагавар болохын зэрэгцээ, иргэдийн оролцоо, ардчилсан оролцооны шинэ хэлбэрүүд төдийгүй, иргэний нийгмийн байгууллагаас үүдэн гарсан ардчиллыг хөгжүүлэх үйл явцын эхлэл байв.

Энэхүү бүлэг Каталонь салан тусгаарлах хөдөлгөөн хэрхэн ардчиллын төлөө хөдөлгөөн болж хувирсан бэ? Иргэд ямар хэлбэрээр оролцож хэрхэн ардчиллыг дэмжиж байв? зэрэг асуултад хариулах болно. Ард нийтийн санал асуулгыг тэмдэглэх бололцоог бий болгосон гол хүчин зүйл бол хүчирхийллийн бус иргэний эсэргүүцэл, олон нийтийн эсэргүүцлийн жагсаал бүхий иргэний дайчилгаа (mobilisation) болохыг энэхүү бүлэгт харуулав. Иргэний нийгмийн зохион байгуулалт ба дайчилгаа нь чухамдаа 10 сарын 1-ний ард нийтийн санал асуулга явагдах боломжийг бий болгосон юм. Ингэснээр эсэргүүцлийн жагсаал нь Үндсэн хууль ба хуульд үндэслэн, төр ба ардчиллын тухай ойлголтыг хурцаар хөндсөн. Жагсагчдын үзсэнээр, төрийн ардчиллын тухай хязгаарлагдмал ойлголтыг сэргүүлэн тавихад *prefigurative politics*<sup>1</sup> чухал үүрэг гүйцэтгэсэн аж. Оролцоо, энх тайванч байдал, эвлэлдэн нэгдэх, хамтын шийдвэр гаргалт, өөрийн удирдлага, халамж, сэтгэл хөдлөл зэрэг ардчиллын шинж чанар нь ардчиллыг бэхжүүлэхэд нэн чухал хүчин зүйлс болдог. Эсэргүүцлийн хөдөлгөөнд оролцогчид цогцлоон байгуулахаар эрмэлзэж буй шинэ бүгд найрамдах улсаа бодитоор бий болгоход чиглэсэн хамтын хүчин чармайлт гаргаж байв.

Сүүлийн арван жилийн хугацаанд дэлхий дахинд ард нийтийн санал асуулга зохион байгуулах нь түгэн дэлгэрсэн бөгөөд тэдгээрийн ихэнх нь үндсэн хуулийн өөрчлөлт хийхэд чиглэсэн байв. Гэвч Тиерни (Tierney, 2013)-гийн үзсэнээр үндсэн хууль боловсруулах, өөрчлөх үйл явцад түүний нэрлэсэнчлэн, нийгмийн цөөнх, элитэд тулгуурласан байдал давамгайлах хандлагатай байна. Ийнхүү төлөөллийн байгууллагад голчлон анхаарах нь элитийн улс төр дэх дургүйцэл нэмэгдэж буй энэ цаг үед үндсэн хуульд нийцсэн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог ойлгож судлах боломжийг боогдуулдаг. Тиймээс энэхүү бүлэг иргэний хөдөлгөөн, тодруулбал ард нийтийн санал асуулгын зохион байгуулалтад оролцож буй иргэний нийгмийн байгууллагуудыг онцлон судлах болно. Иргэний нийгмийн чиг үүрэг нь эрчимтэй түгэн дэлгэрч буй ард нийтийн санал асуулга хэмээх үзэгдлийг илүү сайн ойлгоход чухал ач холбогдолтой бүрэлдэхүүн хэсэг мөн хэдий ч түүнд ач холбогдол өгөхгүй орхигдуулсаар иржээ.

---

1 Тус ойлголтыг нийгмийн хөдөлгөөний онол, практикт өргөнөөр ашигладаг. Ирээдүйн хүсэмжит нийгмийг цогцлооход шаардлагатай нийгэм, бүтцийн өөрчлөлт хийх аргуудыг ашиглахыг *prefigurative politics* хэмээн нэрийддэг.

Уг бүлгийн эхний хэсэгт ардчилал ба иргэний нийгэм хоорондын харилцааг олон улсад гарч буй өөрчлөлтийн хүрээнд (үндэстэн-улс болон төлөөллийн ардчиллын хямрал) авч үзнэ. Мөн ардчиллыг бэхжүүлэх нийгмийн хөдөлгөөний урт хугацаанд хийсэн тэмцэл, ард нийтийн санал асуулгын өнөөгийн ардчилсан тогтолцоонд гүйцэтгэх чиг үүргийг тоймлох болно. Хоёр дахь хэсэг нь Каталаны ард нийтийн санал асуулгад төвлөрөх бөгөөд 10 сарын 1-ний өдөр хийсэн ажиглалтын судалгаанд үндэслэнэ. Бүлгийн эцэст цаашдын судалгааны сэдэв, асуултыг дэвшүүлсэн дүгнэлт хэсгийг танилцуулна.

## Иргэний нийгэм ба ардчилал

### *Дэлхий дахинд гарч буй өөрчлөлт*

Бүтцийн системтэй өөрчлөлт явагдаж буй энэ цаг үе бол Каталаны салан тусгаарлах хөдөлгөөнтэй ижил хөдөлгөөнүүд үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Воллэрштэйний (Wallerstein, 2013) үзсэнээр “бид алсран хоцорч буй капиталист дэлхийн эдийн засгаас аль нэг шинэ төрлийн тогтолцоонд шилжих бүтцийн өөрчлөлтийн үе шатыг туулж яваа” бөгөөд уг тогтолцоо нь яг ямар байх нь мэдэгдэхгүй хэвээр байна. Энэ цаг үеийн гол шинж нь хэд хэдэн хямралын (санхүүгийн, эдийн засгийн, байгаль орчны, ардчиллын...) давхцал юм. Буман (Bauman, 2012) энэ цаг үеийг хэд хэдэн хямрал давхацсан нөхцөл байдал төдий бус, харин шилжилтийн буюу “interregnum - завсрын үе”<sup>2</sup> хэмээн тодорхойлсон байдаг. Тогтворгүй байдал давамгайлсан энэ нөхцөлд иргэний нийгмийн байгууллагууд нэг бол дарангуйлагчдын эсрэг эсхүл одоо ноёлж буй либерал ардчиллыг сөрөн ардчиллын үзэл санааг тээгч болж байна.

Либерал ардчиллын үзэл санаанд аюул учруулж буй нэг хүчин зүйл бол неолиберал даяаршилд тулгуурласан ардчилалд шилжих үйл явц болоод байна. Делла Порты (Della Porta, 2013, 24)-гийн тайлбарласнаар эрх мэдэл намаас (болон төлөөллийн байгууллагуудаас) гүйцэтгэх засаглалд, үндэстэн-улсаас олон улсын төрийн байгууллагуудад, мөн төрөөс зах зээлд шилжсэн явдал нь “иргэдийн сонгуульт оролцооны талаарх элитийн үзэл санаа, ашиг сонирхлоо чөлөөтэй лоббидох, төрийн оролцоог хязгаарлах зэрэг неолиберал ардчиллын үзэл санаа давамгайлахад нөлөөлсөн” аж.

Үндэстэн-улсын ардчиллын суурь зарчмуудыг (газар нутагтай байх, олонхын зарчмууд болон албадлага хэрэглэх зэрэг) дэлхий нийтээр баримталдаггүй. Тийм боловч эдийн засгийн даяаршил нь төрийн

---

2 Засаглал, тогтолцоо хоорондын завсрын үеашиглахыг *prefugrative politics* хэмээн нэрийддэг.

хөндлөнгөөс оролцох эрх хэмжээг бууруулж улмаар өөрийнх нь легитим байдалд нөлөөлдөг (Della Porta, 2013). Олон улсын тавцанд “олон улсын байгууллагуудын тоо, эрх мэдэл болон нөлөө улам бүр өсөж буй нь иргэдийн хүсэл зоригийг төлөөлөх тухай либерал ардчиллын өөрийнх нь үндсэн легитим зарчимд том сорилт учруулдаг” бөгөөд сонгуулийн хариуцлага, ил тод байдал, иргэний оролцоог хязгаарлаж байна (Della Porta, 2013, 29). Төлөөллийн ардчиллын хямрал бүхий энэхүү нөхцөл байдалд иргэний нийгмийн байгууллагууд ардчилсан туршилт, шинэчлэлийн үйл явцад оролцож иржээ.

Үндэстэн-улсын дэг ёс сулрах нь улсын бүрэн эрхт байдал алдагдах, мөн улс төр ба эрх мэдэл хоорондын уялдаа алдагдахад нөлөөлөх эрсдэлтэй. Энэ нь хариуцлага хүлээх чадамжгүй, ил тод бус, иргэдийн хяналтаас гадуурх байгууллагууд шийдвэр гаргах үр дагаварт хүргэдэг. Буман ба Бордони (Bauman and Bordoni, 2014) нарын үзсэнээр жинхэнэ эрх мэдэл нь дэлхий нийтийн хөрөнгийн урсгалд байршдаг бөгөөд үндэсний болон орон нутгийн түвшний улс төрийн үйл явцаас ангид байдаг нь асуудал дагуулдаг байна.

Түүнчлэн Сүбиратс (Subirats, 2013) зах зээл ба эдийн засгийн эрх мэдэл даяарчлагдах зуурт улс төрийн байгууллагууд, тэдгээрийн эрх мэдэл нь даяарчлагдаагүй, газар нутагтаа уягдсан хэвээр байна хэмээн тайлбарласан. Энэ утгаар төр бол нэг л тоглогч бөгөөд дийлэнхдээ хамгийн хүчтэй нь биш байдаг. Төрийн бодлого, хувийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөхөд эрх хэмжээ нь улам бүр буурч буй төр ардчилалд гажуудал учирч буй асуудлыг шийдвэрлэхэд түвэгтэй болдог.

Оффе (Offe, 2011) биднийг ардчиллын хоёр дахь шилжилтийн үедээ яваа хэмээн үздэг нэр хүнд бүхий, ардчиллын онолчдын дүгнэлтэд дүн шинжилгээ хийсэн байна. Эхний шилжилт бол шууд ардчиллаас улс төрийн нам давамгайлсан төлөөллийн, нийтийн ардчилал руу хийсэн шилжилт байв. Түүний дүн шинжилгээнд дурдсанаар эрдэмтэд “ардчиллын хямрал” ба уг хямралд нөлөөлөгч хүчин зүйлс болох “эдийн засгийн даяаршил ба үндэстэн дамнасан үр дүнтэй зохицуулалт байхгүй байдал; туйлдсан зүүний төвийн улс төрийн бодлого ба олон нийтийн сэтгэлгээнд ноёрхсон либерал-зах зээлийн номлол, төрийн эсрэг үзэл санаа; санхүү, эдийн засгийн хямралын нөлөө ба түүнээс улбаалсан төрийн чадавхыг доройтуулах аюултай үндэстэн дамнасан үргийн өлсгөлөн” зэрэгт анхаарлаа хандуулсан байна (Offe, 2011, 457).

Оффе (Offe, 2011)-гийн тодорхойлсон шинж тэмдгүүдийн заримаас дурдвал сонгуулийн идэвх буурах, улс төрчдөд итгэх иргэдийн итгэл сулрах, дургүйцэл ихсэж урам хугарах, нийгмийн цөөнх элит иргэдийн эрх мэдлийг боогдуулах, улс төрөөс ангид байх, үл хайхрах ба арга тасрах байдал нэмэгдэх зэрэг болно. Гэвч олон нийт ардчилсан үзэлтэн Дальтоны нэрлэсэнчлэн хүмүүс “цөхөрсөн ардчилагчид” хэвээр үлджээ (Offe, 2011, 458). Улс төрч хийгээд зонхилох улс төрийн бодлогод үл итгэх ийм нөхцөлд нийгмийн хөдөлгөөн уламжлалт байгууллагуудын байр

суурийг ганхуулдаг. Иймд засаглал ба ардчиллын хямралаас шалтгаалан төлөөллийн ардчиллын тогтолцоог эсэргүүцсэн нийгмийн хөдөлгөөн ээлж дараалан үүсдэг байна (Bauman and Bordoni, 2014).

Нийгмийн хөдөлгөөнүүд нь төлөөллийн ардчиллын хямрал, түүний алдаа дутагдал болон боломжит шинэчлэлтийн талаарх анхаарууштай дохио өгсөөр ирсэн ба төлөөллийн ардчиллыг тойрсон эргэлзээ урт хугацаанд үргэлжилсээр иржээ. Кеане (Keane, 2009, 13)-ийн тайлбарласнаар “төлөөллийн ардчиллын эрин үе улиран одсон бөгөөд ‘төлөөллийн дараах ардчилал’ хэмээх түүхэн шинэ хэлбэр бий болж дэлхий нийтийн ардчилсан улсуудад түгэн дэлгэрч байна”.

Тэрээр (Keane, 2009) энэхүү түүхэн өөрчлөлтийн тод илрэл бол өнөө үед ардчиллыг хэрхэн тодорхойлж үнэлж буй байдал юм хэмээн тайлбарласан. Ардчиллыг хариуцлагагүй байдал, эрх мэдэл төвлөрөхөөс сэргийлэх зэвсэг гэж зарим прагматик хандлагынхан үзэх нь бий. Ардчилал нь төр засаг, улс хоорондын төрийн байгууллага, төрийн бус байгууллага эсхүл иргэний нийгмийн байгууллага, бизнес, үйлдвэрчний эвлэл, спортын холбоо гэх мэт байгууллагын алинд хамаарахаас үл шалтгаалан шийдвэр гаргагчдад тавих олон нийтийн хяналтыг шаарддаг (Keane, 2009).

Өнөөгийн цаг үед болж буй өөр нэг чухал нөхцөл бол дэлхий нийтийн өөрчлөлтөд нөлөөлж буй мэдээллийн хувьсгал юм. Нийгмийн шинэ хөдөлгөөнүүд бол мэдээллийн эрин үеийн хөдөлгөөнүүд юм. Мэдээллийн хувьсгал нь улс төр ба эрх мэдэлд гүнзгий нөлөө үзүүлсэн (Nye, 2013). Хэдэн арван жилийн өмнөхтэй харьцуулбал өнөөдөр төрөөс гадна өөр олон төрлийн тоглогч олон улсын байгууллагын хэлэлцэх асуудалд нөлөөлөх болсны зэрэгцээ төр мэдээллийн технологийг ашиглан хяналт тогтоох гэх мэт шинэ сорилтууд бий болсоор байна. Энэхүү үйл явц нь эрх мэдлийн мөн чанарыг хурдацтай өөрчлөөд зогсохгүй дэлхийн улс төрд нөлөөлөх болжээ (Nye, 2013).

Кастеллс (Castells, 2009) нийгмийн сүлжээний ойлголтод тулгуурлан харилцаа холбооны тоон сүлжээнд суурилсан 21 дүгээр зууны нийгмийн эхэн үед дүн шинжилгээ хийжээ. Энэхүү зохион байгуулалт болон технологийн шинэ нөхцөл байдалд эрх мэдлийн харилцаа эрчимтэй хувьсан өөрчлөгдсөн хэмээн тэрээр тайлбарласан. Олон нийт өөртэйгөө харилцах хэмээн Кастеллс (2009)-ийн нэрлэсэн энэхүү нөхцөлд харилцаа холбоо нь шатлан захирах ёсны загвараас ялгаатай тоо томшгүй олон загварт шилжсэн улс төрийн шинэ хэлбэрийг үүсгэх замаар бүрэн хувиран өөрчлөгдсөн байна. Мөн олон нийтийн хүч болон түүний өөрийгөө удирдан зохион байгуулах чадавх нэмэгджээ. Делейз ба Гуаттари (Deleuze and Guattari, 1988) нар энэхүү шинэ нөхцөл байдлыг тайлбарлахдаа Web цахим сүлжээнээс санаа авсан “rhizome” буюу ургамлын үндэстэй адилтгасан ойлголтыг ашиглажээ. Технологийн арга хэрэгсэл нь уламжлалт мэдээллийн хэрэгслээс үл хамаарсан, мэдээллийг зохион байгуулах, гадаад ба дотоодод түгээх чухал хэрэгсэл болдог ажээ.

Дээр дурдсан бүх зүйл нь 10 сарын 1-ний ард нийтийн санал асуулга өрнөх болсон тогтолцооны урьдач нөхцөлүүд юм. Мөн 2007-оос 2008 онуудад тохиолдсон санхүү, эдийн засгийн хямрал Испани улсад улс төрийн гүн хямрал үүсгэсэн бөгөөд үүнтэй холбогдуулан авсан эдийн засгийн хатуу арга хэмжээнүүд нь үндэстэн-улсын нийгэм эдийн засгийн болон улс төрийн байгуулалд ихээхэн эргэлзэхэд хүргэсэн байна. Зарим судлаачдын (McAdam, 2002; Tilly, 2007) нарын онцолсноор эдийн засаг, улс төрийн хямрал зэрэг тогтолцооны томоохон өөрчлөлт нь сүүлийн үед гарч буй хамтарсан үйл ажиллагааны шинэ хэлбэрүүдийг бий болгосон ажээ.

### **Ардчиллын төлөөх нийгмийн хөдөлгөөний тэмцэл**

Иргэний нийгмийн байгууллагууд, ялангуяа дэвшилтэт нийгмийн хөдөлгөөнүүд ардчиллыг гүнзгийрүүлэх болон оролцооны тухай ойлголтыг түүнд багтаахын тулд урт хугацаанд тэмцсээр иржээ. Нийгмийн хөдөлгөөний түүх болон ээлж дараалан өрнөсөн эсэргүүцлийн хөдөлгөөнүүд ардчиллын талаарх ойлголтыг улам өргөжүүлж тус ойлголт дахь оролцооны ач холбогдлыг онцолж чадсан билээ. Нийгмийн хөдөлгөөнүүд либерал ардчиллын үзэл санааг шүүмжилж ардчиллыг илүү өргөн ойлголтоор баяжуулж ирсэн ба ингэхдээ ардчиллын өөр бусад хэлбэрийн талаар онол боловсруулж туршиж иржээ. Ялангуяа ажилчны хөдөлгөөн нь “хамтын болон нийгмийн эрхүүдийг хувийн (сөрөг) эрх чөлөөнөөс мөн иргэдийн оролцоог улс төрчдийн төлөөллөөс илүү чухалчлан үзэж либерал ардчиллаас ялгаатай ардчиллын өөр үзэл санааг дэвшүүлэн гаргасан” (Della Porta, 2013, 37). Шууд, хэвтээ, өөрөө удирдах ардчиллын үзэл санааг эсэргүүцлийн компани үйл ажиллагааны явцад хэрэгжүүлсэн байна. 19-20 дугаар зууны үед ажилчин анги нь иргэний эрхийг эдлэх болсон бөгөөд улс төрийн намуудыг бүрэлдүүлэгч улс төрийн холбоо, нийгэмлэгийн нэг хэсэг болжээ. Олон нийт санал үл нийлэх эрх, ардчиллын үндсэн хэмжүүр болох нээлттэй, шууд, хэвтээ оролцоог хангах зэрэг ойлголтыг тэлэв (Della Porta, 2013).

1968 оны тэмцэл хөдөлгөөний үеэр улс төрийн оролцоог өргөжүүлэх тухай шаардлага тавигдаж байв. Тэдгээр хөдөлгөөнүүд өөрсдийн дотоод дахь захиргаадалтын бус тогтолцоог бэхжүүлэв. 1970 болон 1980-аад онуудад шинээр үүссэн нийгмийн хөдөлгөөнүүд нь өөрөө удирдах ёсонд тулгуурлан улс төрийн намуудын бодлогыг шүүмжилжлиберал ардчиллыг орлуулах хувилбарыг хайх болсон. Эдгээр хөдөлгөөний хэлэлцүүлэг нь төрд нөлөөлж улмаар олон нийтийн байгууллагуудын улс төрийн оролцоог нэмэгдүүлсэн, санал үл нийлэх эрхийг улс төрийн хувьд хүлээн зөвшөөрүүлсэн шинэчлэл болсон (Della Porta, 2013).

Вайнврайт (Wainwright, 2012) эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь доороос урган гарсан хувилбар, шинэ санаа дэвшүүлэхэд чухал ач холбогдолтой байсныг дараах байдлаар илэрхийлжээ. Тэрбээр 1960, 1970-аад онуудад

эмэгтэйчүүдийн хөдөлгөөн нь шатлан захирах ёсыг халж хэвтээ, хоорондоо сүлжээгээр холбогдсон тогтолцоотой байгууллагыг үүсгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзжээ. Эдгээр хөдөлгөөн нь шатлан захирах ёс ба ардчиллын талаарх тэдгээрийн явцуу тодорхойлолтыг эвдэхийг оролдсон байдаг.

Эдгээр нийгмийн хөдөлгөөн ардчиллын үйл явцад шахалт үзүүлсэн нь эрх мэдэлтнүүдийг айлгаж байлаа. Тухайлбал, удирдагч анги цугласан олноос эмээхдээ “хэтийдсэн ардчилал” хэмээх нэр томъёог хэрэглэж байсан нь үнэндээ тэд “ухаалаг, зохион байгуулалттай, эсэргүүцэхэд амаргүй сөрөг хүчнээс айж байсныг илтгэж байв” (Wainwright, 2012). Энэхүү айдсын учир шалтгаан нь эдгээр хөдөлгөөн, төслүүдийн онцлог шинж чанар, тухайлбал тэдний зохион байгуулалтын арга (хараат бус байдлыг хамтын ажиллагаатай хослуулах, мэдлэгийг бодитоор хуваалцах хамтын оролцооны нөхцөлийг бий болгох), тэдний бий болгосон оюуны санааны нэгдэл (эдийн засаг, соёл, хөдөлмөр ба нийгмийн уламжлалт хуваагдлыг даван туулсан) болон алсын хараа (төр, зах зээлийн эсрэг, хувь хүн нийгмийн эсрэг гэдгээс цаадахыг харсан)-нд оршиж байв. Тэд хувилбарт, оролцоог хангасан, хамтын ажиллагаа бүхий улс төрийн эдийн засгийг бололцоотой зүйл юм гэдэг итгэл төрүүлсэн” (Wainwright, 2012).

Араараасаа дараалсан нийгмийн хөдөлгөөнүүд оролцоонд тулгуурласан зөвлөлдөх загварыг хөгжүүлжээ (1999 оны “Дэлхийн шударга ёсны хөдөлгөөн”, хамгийн сүүлийн үеийнхээс дурдвал “Эзэлцгээе хөдөлгөөн” болон эдийн засгийн хатуу бодлогын эсрэг хөдөлгөөнүүд). Эдийн засгийн хатуу бодлогын эсрэг хөдөлгөөнүүд нь өнөөгийн Европын холбоон дахь ардчиллын тухай үзэл санаанд сорилт болсон. Өнөөгийн ардчилалд сэтгэл ханамжгүй байдал нэмэгдсэн нь өөр хоорондоо сүлжээгээр холбогдсон эсэргүүцлийн арга хэмжээнүүд дараалан гарах гол шалтгаан байв. Ардчилал амжилттай хэрэгжихгүй байна гэсэн нэгдсэн үзэл болон ардчиллын гажуудлын (иргэдийн амьдралд чухал шийдвэр гаргахад нөлөөлөх чадвараар нь хэмжсэн) улмаас нийгэм хямралд орлоо гэсэн шүүмжлэл нь Европ даяар бодитой ардчиллыг бий болгох хэрэгцээ байгаа эсэх талаар асуудал дэвшүүлэхэд хүргэсэн.

Зөвлөлдөх ардчилал нь “нийтийн баялгийг тодорхойлоход чиглэсэн дараалсан хэлэлцүүлгийн үед сонголт хэрхэн хийхэд анхаардаг” (Della Porta, 2013, 61). Нийтийн ашиг сонирхлыг эрэлхийлэхэд харилцаа холбоо, харилцан яриа, мэдээлэл ба мэдлэгийн баялаг, хүртээмжтэй урсгал болон зөвшилцөлд хүрэх арга замуудыг ашигладаг нь энэхүү үзэл санааны гол онцлог юм (Della Porta, 2013). Бие биеэ сонсох, олон ургалч үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх нь энэхүү загварын чухал шинж болдог. Гэвч ялгаатай үзэл бодлуудыг холбох гүүр нь асуудлыг шийдвэрлэх гэсэн нийтлэг хүсэл зориг байх ёстойг онцлон тэмдэглэжээ.

Оролцоо, зөвлөлдөх үйл явц нь төлөөллийн ба олонхын шийдвэр гаргах үйл явцтай зөрчилддөг ардчиллын онцлог шинжүүд юм. Либерал үзэл санаа нь зөвхөн нийтийн төрийн байгууллагуудыг ардчилсан талбар гэж

хардаг. Харин зөрчилтэй ашиг сонирхолтой тоглогчдыг тогтолцооны эсрэг хэмээн үздэг (Sartori, 1976). Зөвлөлдөх ардчилал нь либерал ардчилал иргэдийн оролцоог бүрэн хангадаггүй хэмээх уламжлалт шүүмжлэлээс цаашлаад ардчилал нь сонгуулийн санал тоолох арга зам төдий бус, харин оролцоот, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар иргэдийн үзэл санаа, сонголтыг бүрдүүлэгч арга зам юм гэж тодорхойлдог. Зөвлөлдөх ардчилал олонхын шийдвэрт үндэслэх зарчим дээр суурилж төлөөллийн ардчиллыг хууль ёсны болгодог зарчмаас ихээхэн ялгаатай. Энэ нь сонгуулиар сонгогдон дараагийн сонгууль хүртэл саадгүйгээр төрийн эрх барих эрхтэй болдог мэргэжилтнүүдийн ардчиллаас эсрэг ойлголт юм (Della Porta, 2013). Бүлгийн дараах хэсэгт, ард нийтийн санал асуулга ардчиллын чанарыг алдагдуулдаг талаарх маргааныг шийдвэрлэх зөвлөлдөх ардчиллын зарчмуудаас танилцуулна.

Ардчиллыг бэхжүүлэх, чанарыг сайжруулахад чиглэсэн нийгмийн хөдөлгөөний тэмцлийн түүх нь энэхүү судалгааны гол сэдэв болох Каталаны ард нийтийн санал асуулгыг авч үзэх ерөнхий хүрээ болж байна. Энэхүү эсэргүүцлийн жагсаал нь нийгмийн хөдөлгөөний өмнөх түүхэн үйл явдлаас сургамж авсан. Каталон даяарх мянга, мянган иргэдийн хөдөлгөөний үр дүнд ард нийтийн санал асуулгыг тэмдэглэн өнгөрүүлэх боломжтой болсон нь ардчиллыг бэхжүүлэхэд гүйцэтгэх иргэдийн оролцооны үүргийг тод харуулсан.

### **Ард нийтийн санал асуулга ба иргэд**

Дэлхий даяар өрнөж буй иргэний оролцоог шаардсан иргэний нийгмийн байгууллагуудын шахалттай зэрэгцэн ард нийтийн санал асуулга явуулах олон нийтийн шаардлага мөн нэмэгдэж байна. Улс төр судлаачид уламжлалт, зонхилох улс төрийн бодлогод итгэл алдран дургүйцэх хандлага бий болсон талаар урт хугацаанд сануулж ирсэн бөгөөд улс төрийн намын гишүүнчлэл, сонгуулийн идэвх буурах болсон нь дээрхийн тод жишээ юм. Иргэдийн дургүйцэл нь элит хэсэг шийдвэр гаргах эрхийг дангаараа эдлэх, улс төрийн үйл ажиллагаанд бизнесийн нөлөө зонхилох болсон зэрэгтэй холбоотой юм (Tierney, 2013).

Түүнчлэн, иргэдийн улс төр дэх сэтгэл ханамж буурахад даяаршил, тухайлбал эрх мэдэл төрөөс улс дамнасан корпорацид шилжсэн явдал нөлөөлж байна. Төлөөллийн ардчилал иргэд эрх мэдлээ алдахад хүргэж байгаа нь тэд ард нийтийн санал асуулга гэх мэт шууд ардчиллын арга хэрэгслийг ашиглахад түлхэц болдог. Тиерни (Tierney, 2013, 2193)-гийн дурдсанаар “ард нийтийн санал асуулга эрчимтэй тархах болсон нь богино хугацааны үзэгдэл төдий бус, ялангуяа технологийн хөгжил дэвшлийн нөлөөгөөр үндсэн хуулийн асуудлуудад иргэд шууд оролцох хэлбэрт чиглэсэн илүү өргөн цар хүрээтэй, урт хугацааны алхам гэж үзвэл зохино” гэжээ.



Хэдийгээр ард нийтийн санал асуулга олны анхаарал, сонирхлыг татаж буй боловч үүнд эргэлзэх, ардчиллын зарчмын хувьд асуудалтай гэдэг байр суурь нийтлэг бий. Улс төрийн шинжлэх ухааны зарим онолд ард нийтийн санал асуулгад үндсэн гурван дутагдал бий гэж үздэг. Нэгдүгээрх сул тал нь ард нийтийн санал асуулгыг зохион байгуулагчид санал асуулгын үйл явц, үр дүнг гуйвуулах, нөлөөлж болзошгүй бөгөөд улмаар нийгмийн элит хэсэг төр барих боломж олгох шинж юм. Хоёрдугаарт, саналаа өгсөн асуудлуудын талаар бодит хэлэлцүүлэг өрнүүлэн, тэдгээрийг тусгаж чаддаггүй явдал. Гуравдугаарт, ард нийтийн санал асуулга нь олонхоор шийдвэр гаргах загварыг илэрхийлдэг тул цөөнхийг эрсдэлд оруулдаг олонхын дарангуйллыг бий болгодог хэмээн эсэргүүцэх нь бий. Хэдийгээр шууд ардчиллын арга хэрэгслүүд нь эдгээр товч дурдсан аюулуудыг дагуулдаг боловч зарим судлаачид зөвлөлдөх онолын тусламжтайгаар тэдгээрийг даван туулах оролдлого хийсэн байна (Tierney, 2016). Тиерни (Tierney, 2016) зөвлөлдөх онол ба ард нийтийн санал асуулгын хосолсон хэлбэр болох “ард нийтийн зөвлөлдөх санал асуулга” (deliberative referendum) оновчтой талаар саналыг дэвшүүлсэн ба тус хосолмол хэлбэр нь ард нийтийн санал асуулгыг олон нийтийн зөвлөлдөх талбар болгоход анхаардаг. Тэрээр (Tierney, 2016) ард нийтийн санал асуулгыг эсэргүүцэх үзлийг даван туулах арга зам нь зөвлөлдөх ардчиллын онолын үндсэн зарчмууд хэмээн үзсэн. Эдгээр зарчмууд нь олон нийтийн оролцоо, (олон нийтийн эргэцүүлэл, хэлэлцүүлэг), тэгш хамруулах, талуудад үзэл бодлоо илэрхийлэх тэнцвэртэй боломж өгөх болон хамтын шийдвэрийг зөвшилцөл дээр үндэслэн гаргах зэрэг зарчмууд юм (Tierney, 2016).

Бусад судлаачид ард нийтийн санал асуулгатай холбоотой асуудлыг хөндөхдөө “хэд хэдэн судалгааны үр дүнгээс үзэхэд ард нийтийн санал асуулга, санаачилгууд нь бодлогод нөлөө үзүүлдэг бөгөөд шууд ардчилал бүхий улсуудын төрийн төлөөлөгч нар нь сонгогчдын санал бодолд ач холбогдол өгөх нь илүү байдаг (Qvortrup, 2018, 62). Түүгээр ч зогсохгүй, шууд ардчилал нь төрийн бодлогын үр дүнд нөлөөлдөг болохыг судалгаа харуулсан” гэжээ. Эндээс үзэхэд ард нийтийн санал асуулгатай холбоотой сөрөг ойлголт, шүүмжлэлээс гадна, эдгээр нь ардчилсан үйл явцад илүү зэрэг нөлөө үзүүлдэг бөгөөд төлөөллийн ардчиллын тогтолцооны сул талыг нөхөх боломжтой үйл явц юм гэж үзэж болохоор байна (Qvortrup, 2018).

Делла Порта (Della Porta, 2017) болон түүний хамтрагчдын онцолсноор ард нийтийн өнөөгийн дэлхий нийтийн санал асуулгын талаарх гарч буй чиг хандлага бол “доороос урган гарсан ард нийтийн санал асуулга” гэх үзэл санаа юм. Эдгээр судлаачдын цохон тэмдэглэснээр ард нийтийн санал асуулга нь урьдынх шиг “эрх мэдэлтнүүд, институцмиүд гаргасан технократ шийдвэрээ нөхөж хууль ёсны шийдвэр болгох зорилгоор ашигладаг арга хэрэгсэл байхаа больж иргэний нийгмийн олон жилийн санаачилга, эсэргүүцлийн үр дүн ба иргэдийн хөдөлгөөнөөс үүсэлтэй

оролцооны үйл явц болж өөрчлөгдсөн”. Делла Порта нарын үзсэнээр Шотланд ба Каталаны ард нийтийн санал асуулгууд нь огт өөр арга замаар явагдсан хэдий ч, уг “доороос урган гарсан ард нийтийн санал асуулга” ангилалд хамаарагддаг. Жишээлбэл Шотландын хувьд иргэдэд шийдвэр гаргах эрх нь байсан бол Испанид ард нийтийн санал асуулга явуулахын тулд эхлээд Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байв. Ингэхдээ Үндсэн хуулийн 168 дугаар зүйлд заасны дагуу нэмэлт өөрчлөлт оруулах ёстой бөгөөд уг нэмэлт өөрчлөлтийг хийхэд хамгийн түвэгтэйд тооцогддог. Шийдвэр гаргах эрх тодорхойгүй байх, улс төрийн онолчдын тодорхойлсончлон ардчиллын хил хязгаар хаагуур зааглагдах, гол нь шийдвэр гаргах эрхтэй ард түмэн гэж яг хэн бэ гэх мэт маргаантай асуудал дагуулсан учир Каталаны үйл явдал нь бусдаас онцгойрдог.

Каталаны ард нийтийн санал асуулга нь Испанийн Үндсэн хууль (1978)-ийн 2 дугаар зүйлтэй зөрчилдөж байсан учраас Испанид түүнийг зохион байгуулахыг зөвшөөрөөгүй ажээ. Тус 2 дугаар зүйлд “Үндсэн хууль нь Испани үндэстний салшгүй нэгдэл, бүх испаничуудын нийтээр эзэмшдэг, хуваагдашгүй газар нутагт үндэслэсэн ба тус улсыг бүрдүүлэгч үндэстнүүд, бүс нутгийн өөрөө удирдах эрх, тэдний хоорондын эв нэгдлийг хүлээн зөвшөөрч баталгаажуулахаар заасан”. Мөн 1.2 дахь заалтад “Үндэсний бүрэн эрхт байдал нь Төрийн бүх эрх мэдлийн эх сурвалж болох Испанийн ард түмэнд хамаарагдана” гэж заасан байдаг. Испанийн жишээнээс үзэхэд тэдгээр заалтуудыг өөрчлөх боломжгүй байсан учраас ард нийтийн санал асуулга зохион байгуулахыг шаардсан олон нийт ба байгууллагуудын хүчтэй шаардлагын дор нийгмийн үл захирагдах байдал нь тоглоомын дүрмийг өөрчлөхөд хүргэж улмаар ард нийтийн санал асуулга явуулах боломжтой болгожээ.

Испанийн Ерөнхийлөгч Мариано Ражое (Mariano Rajoy, 2017) 10 дугаар сарын 1-ний нөхцөл байдалтай холбогдуулан “Каталонд өнөөдөр тусгаар тогтнох талаар ард нийтийн санал асуулга болоогүй” хэмээн мэдэгдэл хийжээ. Тэрээр мөн “Испанийн бүх ард түмэн өнөөдөр бидний эрх зүйт төр бат бөх бөгөөд хүчин төгөлдөр, хууль зөрчигчдөд хариуг нь өгдөг, түлхэн унагаах гэсэн санаархалд хариу барьдгаас гадна, өдөөн хатгасан аливаа үйлдлийг хуульд заасан боломжтой бүх арга хэрэгслээр үр дүнтэйгээр, тайван байдлаар зогсоодог гэдгийг харах боломжтой байлаа. Бид өнөөдөр ард нийтийн санал асуулгын ямар нэгэн эхлэвэрийн гэрч болсонгүй. Гэвч ердийн нэг үзэгдэл, ардчилал ба хууль зэрэгцэн оршихын төлөөх хэрэг явдлын гэрч боллоо” гэж мэдэгджээ (Mariano Rajoy, 2017).

Мөн Мариано Ражое (Mariano Rajoy, 2017) ард нийтийн санал асуулга хууль бус, ардчилалд аюул учруулж буйг нотлохыг зорихдоо: “Та бүхний мэдэж байгаачлан, Засгийн газар бүхий л цаг хугацаанд энэхүү ард нийтийн санал асуулгыг зохион байгуулахгүй гэсэн байр суурьтай байсан бөгөөд үүнийг энэхүү сорилтыг бий болгосон тэдгээр хүмүүс олон сарын турш мэдэж байсан. [...] Тэд ард нийтийн санал асуулга

хууль бус, зөвшөөрөгдөхгүй, боломжгүй гэдгийг мэдэж байсан хэдий ч үүнийг үл хайхран явуулахаар шийдэж эрх зүйт төр болон бидний ардчилсан тогтолцоонд халдлаа [...]; урьдаас төлөвлөж зохион байгуулан, ухамсартайгаар үйлдсэн халдлагад Төр тайван замаар, шийдвэртэй хариуг өгөв. Испанийн Үндсэн хуулийг устгахыг зорьж Испанийн ард иргэдийн саналыг авахгүйгээр манай улсын газар нутгийн нэг хэсэгт тусгаар тогтнолоо зарлахыг оролдсон ард нийтийн санал асуулга амжилттай болсонгүй.” гэж хэлсэн байдаг.

### ***Каталоны бүх ард нийтийн санал асуулга***

2017 оны 10 сарын 1-ний Каталони ард нийтийн санал асуулга нь инээмсэглэлийн хувьсгал гэдгээр дурсагдах болно. Зарим нь үүнийг тэврэлтийн өдөр хэмээн нэрлэсэн нь хүмүүс нэг нэгнээ тэврэн баярлацгааж нөхөрсөг харьцсан дүр төрх санал авах байр бүрт харагдаж байснаас үүдэлтэй байв. Харин эсрэгээрээ цагдаа нарын хүч хэрэглэсэн байдал, зодуулж, гэмтсэн иргэд тэр өдрийн онцлох дүр зураг болж дэлхий нийтэд цацагджээ. Испанийн цагдаа болон Испанийн Иргэний хамгаалалт хүч хэрэглэсэн нь улс орныг бүхэлд нь цочролд оруулсан. Тэр өдөр олон каталончуудын хувьд гайхалтай амжилтад хүрсэн авчдурсахад бэрх өдөр болон үлджээ.

Гэвч 10 сарын 1-ний өдөр цагдаа нарын хүчирхийллээс илүү гайхалтай үйл явдал болсон нь ард нийтийн санал асуулгыг хамгаалах зорилгоор Каталон даяар зохион байгуулсан мянга мянган иргэдийн тайван жагсаал байсан бөгөөд олон нийт, байгууллагууд төрд үл захирагдахыг илтгэсэн том арга хэмжээ байв. Энэхүү хөдөлгөөн нь эцсийн дүндээ оролцоо болон өөрийн зохион байгуулалтын ачаар ард нийтийн санал асуулгыг явуулах боломжтой болгожээ.

### **Арга зүй**

Тус бүлэгт дурдсан тайлбар нь оролцоот ажиглалтын аргаар цуглуулсан мэдээлэлд үндэслэсэн болно. Ажиглалтын тэмдэглэлийг 10 сарын 1-ний Каталони ард нийтийн санал асуулгын үеэр Каталони Кардона ба Манреса орон нутаг дахь санал авах дөрвөн байранд хийсэн. Мэдээллийг ажиглалтын удирдамжийн дагуу цуглуулсан ба дараах зургаан сэдвийн хүрээнд ангилав: 1) оролцоо, 2) оролцооны хэлбэр, 3) эсэргүүцэл ба бэлгэ тэмдгийн нэр төрөл, 4) хамтын ижилсэл (collective identity), 5) сэтгэл хөдлөл, 6) дискурсив элемент<sup>3</sup> ба уриа лоозонгууд.

---

3 Дискурс гэдэг нь аливаа ойлголт, ухагдахуун өөртөө тогтсон үнэлэмж, үзэл бодлыг тээж байх, түүхэн үйл явцад тогтсон тайлбарлах арга замтай болсон байхыг хэлдэг.

Эхний асуудал болох оролцооны хувьд, хэн оролцсон (оролцогчдын онцлог шинж, тэдний тоо, төрөл), хэнийг оролцохыг хориглосон (санал асуулгад хэнийг оролцуулаагүй вэ) гэдгийг ажигласан. Хоёр дахь асуудал болох оролцооны хэлбэрийн хувьд, оролцоо идэвхтэй эсхүл идэвхгүй байсан эсэх, удирдагчид биечлэн оролцсон байдал, шийдвэр гаргах үйл явц, зохион байгуулалтын хэлбэр (босоо эсхүл хэвтээ) ба төрөл (хурал, цуглаан), дэд бүтэц (нийгмийн сүлжээ, WhatsApp, Telegram гэх мэт) зэргийг хамарсан. Гурав дахь асуудал болох эсэргүүцэл ба бэлгэл тэмдгийн нэр төрөл нь тухайн үед эзлэлт, суулт, ажил хаялт зэрэг болсон уу гэдгийг судалсан. Дөрөв дэх асуудал буюу хамтын ижилслийн хувьд гадаад хязгаар (хэний эсхүл юуны эсрэг?) ба дотоод хязгаар (бид хэн бэ? Юу биднийг нэгтгэдэг вэ? Тухайн үйл явдлын үеэр ажиглагдсан үнэт чанар, зарчмууд) гэсэн хоёр асуудлыг ажигласан. Сэтгэл хөдлөл гэдгээр тухайн үйл явдлын үеэр ямархуу уур амьсгалтай байсан бэ, сэтгэл хөдлөлд ямар нэгэн өөрчлөлт гарсан уу, гарсан бол энэ нь юунаас хамааралтай байсан бэ зэргийг хамаарсан. Эцэст нь зургаа дахь асуудал буюу дискурсив элемент ба уриа лоозонгууд нь жагсагчдын ашигласан гол үгс, дуу нь юу байсан бэ гэдгийг тэмдэглэсэн.

Эдгээр асуудлуудын талаар тухайн үед ажилласан санал авах байруудад бүтэн өдрийн турш тэмдэглэл үйлдсэн. Ажиглалтын явцад бодит байдлаас зөрүүтэй мэдээлэл цугларахаас сэргийлж тэмдэглэлийг тухайн өдрийн турш нийгмийн сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлтэй тулгаж харьцуулсан. Дор дурдсан дүн шинжилгээг энэхүү ажиглалтын үр дүнг ашиглан хийсэн болно.

## **Сонгох эрхийг хамгаалахын төлөөх олон нийтийн хөдөлгөөн**

Дээр дурдсанчлан Испанийн засгийн газар үх ард иргэдийн санал асуулгыг хууль бус гэж зарласан тул түүнийг зогсоох түрэмгий бодлого баримтлав. Засгийн газраас авсан хариу арга хэмжээ нь санал асуулгын өмнөх өдөр улам бүр хурцдав. Санал авах хайрцаг, саналын хуудас зэргийг хураан авч сонин хэвлэл болон хэвлэх үйлдвэрүүдэд дайран орж ард нийтийн санал асуулгыг дурдсан вэб сайтуудыг хааж, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхийг хориглон, Каталаны засгийн газрын 14 албан тушаалтныг баривчилж бие даасан нэг улс төрийн намын төв байр болон зарим орон нутгийн захиргааны байгууллагуудад Испаний цагдаа нар ямар ч шүүхийн шийдвэргүйгээр нэгжлэг хийсэн байна. Түүнчлэн ард нийтийн санал асуулга зохион байгуулахад хамтран ажилласан 700 гаруй хотын дарга нарыг мөрдөн шалгаж Испанийн прокурорын газраас тэднийг баривчлахаар сүрдүүлжээ.

Ард нийтийн санал асуулга зохион байгуулахыг зогсоохын тулд Испанийн 12,000 цагдаагийн ажилтныг Каталон руу илгээсэн нь засгийн газраас хүч хэрэглэхээр заналхийлэх, айлган сүрдүүлэхийг гол бодлого

болгон хэрэгжүүлснийг харуулж байна. Энэ нь “дайн”-ы нөхцөл байдал бий болгож айдас төрүүлэх зорилготой байсан боловч үнэн хэрэгтээ эзлэн түрэмгийлэгдсэн мэт мэдрэмж, засгийн газраас хөндийрөх үйл явцыг дэвэргэсэн.

Ард нийтийн санал асуулга явуулахын өмнөх хэдэн өдөрт Испанийн засгийн газраас үзүүлсэн хариу үйлдлүүд нь тус санал асуулгыг дэмжигчдийн тоог улам нэмэгдүүлж төсөөлөөгүй үр дагаврыг бий болгожээ. Тусгаар тогтнолын төлөөх өргөн олныг хамарсан том жагсаалууд 2010 оноос хойш үргэлжилсээр байсан хэдий ч, 10 сарын 1-ний үйл явдал нь чанарын хувьд өмнөх жагсаалуудаас даван гарчээ.

Каталон тусгаар тогтносон улс байх ёстой эсэх талаарх гол асуудал нь улс төрийн эрх чөлөө, хүний үндсэн эрх, ардчиллыг хамгаалах тэмцлээр солигдож тусгаар тогтнолын төлөө тэмцэгч анхдагч бүлгүүд дээр нэмэгдэх жагсагчдын тоог ихэсгэжээ. Иргэд санал авах байрыг хамгаалахын тулд санал хураалт явагдахын өмнөх Баасан гараг болон амралтын өдрүүдэд сайн дураараа зохион байгуулалтад орж байв. Тэдгээр санал авах байрыг битүүмжилнэ гэсэн цагдаагийн байгууллагын анхааруулга дор иргэд санал авах байрыг эзэлж хуралдан тэдгээрийг хамгаалахаар бэлтгэсэн байв.

Иргэдийн дайчилгаа нь ардчилсан тогтолцооны үндсэн бүрэлдэхүүн хэсэг болсон сонгох эрхийг хамгаалахын төлөө хийсэн иргэдийн үйлдэл байжээ. Ард нийтийн санал асуулгыг зохион байгуулахын тулд олон түмний тэмцэл өрнүүлсэн нь шинэлэг зүйл байв. Шууд ардчиллын энэхүү арга хэрэгслийг хамгаалсан нь иргэдэд шууд шийдвэр гаргах эрхийг олгох тухай ойлголтод суурилсан бөгөөд энэхүү ойлголт нь төрийн хариу үйлдэлтэй тулгарсан нөхцөлд маш хүчирхэг үзэл санаа болж хувирсан. Эзлэгдсэн санал авах байранд хийсэн ажиглалтаас үзэхэд ардчиллын төлөөх тэмцэл буцаад гудамжинд гарсан нь жинхэнэ ардчиллыг эрж хайн ардчиллын онцлог шинж, үйл явцад ач холбогдол өгсөн хэрэг байв.

## **Өөрийн зохион байгуулалт**

Ард нийтийн санал асуулга нь 10 сарын 1-ний өдөр болон түүний өмнөх сар, долоо хоногуудад Каталон даяар жагссан мянга мянган иргэдийн хөдөлгөөний ачаар явагдах боломжтой болсон билээ. Мянга мянган нэр нь үл мэдэгдэх иргэд саналын хайрцаг болон саналын хуудсуудыг гэртээ нуусан байна. Дундын мэдээлэл, хамтын ажиллагааны үр дүнд хэдийгээр олон тооны саналын хайрцаг, хуудсыг хураан авсан байсан боловч хууль бус гэж зарлагдсан ард нийтийн санал асуулгыг эцэстээ зохион байгуулж чаджээ. Сайн дураар зохион байгуулагдсан мянга мянган иргэд саналын хайрцаг, хуудсыг санал авах байранд авчирсан нь сонгуулийн хороог бий болгож санал авах байрыг хамгаалан улмаар санал өгөх боломжтой болгожээ.

Санал асуулгыг зохион байгуулах, төрийн хараа хяналтаас зайлсхийх үүднээс зохион байгуулалт, харилцаа холбооны нууц хэлбэрийг ашигласан байна. Хакерууд Каталаны засгийн газрын хаагдсан албан ёсны вэбсайтыг дуурайлган шинээр хийсэн байв. Санал авах байр болгон ашигласан улсын сургуулиуд нээлттэй байх үүднээс “нээлттэй сургууль” санаачилга гарган амралтын өдрүүдэд эцэг эх, сурагчдад зориулсан арга хэмжээ зохион байгуулж байсан. Каталаны засгийн газраас энэхүү өөрийн зохион байгуулалтыг дэмжиж тусалж байв.

10 сарын 1-ний өдөр WhatsApp, Telegram болон Twitter-т маш их хөдөлгөөнтэй байжээ. Тэдгээрийг мэдээлэл солилцох, бүх ард нийтийн санал асуулгын үйл явц хэрхэн өөрчлөгдөж буй талаар мэдээлэх суваг болгон ашигласан. Дотоод харилцаа холбоо нь санал авах байрууд дахь хэрэгцээ шаардлага, иргэд аль санал авах байрыг хамгаалбал зохих талаар мэдээлэл солилцоход нэн чухал байжээ.

Дарангуйлал, цагдаа нарын хүчирхийлэл, саналын хайрцгуудыг хураасан, (нийт 2315 байрнаас 319 санал авах байрыг хаасан) зэргээс үл хамааран 2,2 сая иргэд ард нийтийн санал асуулгад оролцож (43.03хувийн оролцоо) 90.18 хувь нь “тийм”, 7,83 хувь нь “үгүй”, 1,98 хувь нь хоосон санал өгчээ (Catalan Government, 2017).

## **Олон талт байдал ба оролцоог хангасан нь**

10 сарын 1-ний үйл явдал нь олон талт байдлаар тодорхойлогдсон хөдөлгөөн байв. Улс төржөөгүй, бүх насны эрэгтэй, эмэгтэйчүүд нээлттэй, тайван замаар нэгдэцгээсэн. Энд ахимаг насны хүмүүс, тэр дундаа эмэгтэйчүүд урам зоригтойгоор санал авах байрыг хамгаалах тэргүүн эгнээнд зогсож цагдаа нарын дайралтын үеэр ч эгнээгээ алдалгүй хамгаалж оролцсоныг дурдах нь зүйтэй. Манай нийгэмд ахмад настнуудыг бүтээмжгүй гэж үздэг тул асрах төвд тусгаарлах нь элбэг байсан бол үнэт зүйл гэнэт өөрчлөгдөж ахмадууд гол үүрэгтэй хүмүүс болцгоож шийдвэртэй байдал, эр зориг, итгэл үнэмшлээрээ олны бахархал төрүүлж байв. Жагсагчид саналаа өгөхөөр ирсэн настайчуудыг чөлөөтэй нэвтрүүлэхээр зай гаргаж өгч байв. Ийнхүү зай тавьж өгсөн нь амар, хялбар нэвтрэх боломжийг бий болгосноос гадна нийтээрээ тэдэнд хүндэтгэл үзүүлж байв.

Ард нийтийн санал асуулгын үйл явц нь сонгох эрх болон өөртөө захирах эрхийг хамгаалах боломжийг бүх талд өгсөн, өргөн хүрээний оролцоо бүхий орон зай байв. Санал өгөх бололцоог бий болгох, оролцогчдын ирцийг өндөр байлгах зорилгоор Каталон даяар тархсан “Ард нийтийн санал асуулгыг хамгаалах хороо”-нуудыг байгуулсан байна. Энэхүү санаачилгыг дэвшүүлсэн гол байгууллага нь CUP (Popular Unity Candidacy) хэмээх Каталаны засгийн газрыг дэмжигч, хөрөнгөтний эсрэг нам байсан боловч тун удалгүй хүрээгээ тэлж маш олон төрлийн

оролцогчидтой болсон байна. Үүнд оролцоо ба дайчилгаа чухал үүрэгтэй байв. Тэдний санааг зовоож байсан зүйлсийн нэг нь бүгдийн оролцоог хангахын тулд тусгаар тогтнолд “Үгүй” гэж хэлэх аян өрнүүлэх хэрэгцээ шаардлага байв.

Санал авах байруудад төвийг сахих байр суурь хангалттай байсан ба санал асуулгын үр дүнг зарлахад “Тийм” болон “Үгүй” гэсэн хариуг аль алиныг нь цугласан хүмүүс алга ташин дэмжиж байв. Испанийн төрийн далбаагаар биеэ ороосон хүү саналаа өгөхөөр явж харагдсанд цугласан олон сайшаан дэмжсэн нь тэгш оролцоог хангах явдалд ямар их ач холбогдол өгснийг харуулах нэг жишээ юм. Цөөн тооны хүмүүс санал авах байрны хажуугаар Испанийн төрийн далбааг барин явж өнгөрөхөд тэдний хэн рүү нь ч орилж хашхиран, чичилж зааж байсангүй.

10 сарын 1-ний үйл явдал нь ижилслийн хөдөлгөөн биш байв. Хэдийгээр иргэд өөрсдийгөө айл хөрш, хот, зарим тохиолдолд Каталоний нэгэн хэсэг гэдгээ мэдэрч, илэрхийлж байсан ч ингэхдээ явцуу утгаар биш илүү нээлттэй байдлаар илэрхийлж байв. Оролцогчдын дунд Каталон, Испани хэлээр яригсад, мөн Каталонаас өөр Испанийн бусад нутаг дэвсгэрт төрсөн хүмүүс ч байв. Жишээ дурдвал, тэнд Морокко эсхүл Латин Америкаас Каталонд саяхан нүүж ирсэн хүмүүс бас байжээ. Уг бодит байдал нь заримдаа Каталоны хөдөлгөөнийг дүрслэхдээ буруугаар хэрэглэдэг төрөлх нутгийнхны хөдөлгөөн хэмээх дүрслэлтэй зөрчилддөг. Энэ нь зөвхөн тэр өдөр л тохиолдсон зүйл биш юм. Тусгаар тогтнох хөдөлгөөнийг зохион байгуулсан иргэний нийгмийн үндсэн байгууллагууд (Omnium Cultural ба Assamblea Nacional Catalana) хоёулаа 2017 оны 2 сарын 18-ны дүрвэгсдийг дэмжих жагсаал “Volem Acollir”-д оролцож байжээ.

Хөдөлгөөний тэгш оролцоог хангах болон олон талт байдал нь Каталоны талаарх элит хэсгийн үзэл бодлын үндсэн асуудал болох нийгмийн хагарал оршин байгаа тухай яриа хэр үнэн болохыг сорьсон үйл явдал байв. Өөр үзэл бодолтой хүмүүсийг хүлээн зөвшөөрч дэмжин, тэдэнтэй тэвчээр, эв найрамдалтайгаар хамтран оршиж байсан нь дээрх үзэл бодол эргэлзээтэй болохыг харуулж байв.

## **Бэлгэ тэмдэг: Цэцэг ба тракторууд**

Энэхүү жагсаалд үндсэндээ хоёр төрлийн бэлгэ тэмдэг байсан нь цэцэг ба трактор байв. Энх тайвны бэлэг тэмдэг болохынх нь хувьд цэцгийг (лиш цэцэг) цагдаа нарт өгч, ширээ, цонхны тавцан дээр тавьж, сонгогчид биедээ авч явж байв. Тракторууд нь тариачдын хөдөлгөөний чухал хэсэг байсан бөгөөд санамсаргүйгээр газар нутгаа хамгаалах бэлгэ тэмдэг болсон байдаг. Олон тооны санал авах байранд тракторуудыг бэлгэ тэмдэг болгон хашааны бэхлэлт болгон байрлуулсан байв.

### **Ардчилал, энх тайванч үзэл ба фашизмын эсрэг үзэл**

Ард нийтийн санал асуулгын өдрийн уриа, дуу хоолой нь дийлэнхдээ ардчилал, энх тайван, фашизмын эсрэг үзлийн тухай байв. Жагсагчид “votarem” (бид саналаа өгнө) ба санал асуулга дууссаны дараа “hem votat” (бид саналаа өгсөн) хэмээн хашхиралдаж байв. Сонгох эрхээ хамгаалах нь өнөөгийн ардчиллын талаарх асуулт, жинхэнэ ардчилал дутагдалтай байдал зэрэгтэй холилдон, өмнөх 15M<sup>4</sup> зэрэг хөдөлгөөнүүдтэй холбогдсон байв. Ардчилал, улс төр жинхэнэ утгаараа гудамжинд өрнөж байв.

Хоёрдугаарт, иргэдийн дайчилгаа нь энх тайванч шинж чанартай байсан тул ялангуяа цагдаа нартай нүүр тулсан газруудад “Som gent pacífica” (бид энх тайванч хүмүүс) гэх уриа хашхирч байжээ. Энх тайванч байдал болон хүч үл хэрэглэх бодлого нь анхнаасаа тусгаар тогтнолын төлөөх олон нийтийн жагсаалын үндсэн шинж байв. Энэ нь олонхын хүсэлд нийцсэн хөдөлгөөн байх, дотоодод болон олон улсад дэмжлэг авах, ингэснээр хүчирхийлэл болон дайныг хүсээгүй, тэдгээр нь зөрчлийг шийдвэрлэх арга зам биш гэсэн хүсэл эрмэлзлийн илэрхийлэл байв. Энх тайванч үзэл нь өмнөх хөдөлгөөнүүдтэй мөн уялдаатай (15M, 2003 оны дайны эсрэг жагсаал гэх мэт).

Эцэст нь “No pasaran” (энэ бүтэхгүй, боломжгүй) ба “Els carrers seran sempre nostres” (гудамж үргэлж биднийх байх болно) зэрэг фашизмын эсрэг хэрэглэж байсан уриа лоозон бүх Каталон даяар өргөн ашиглагджээ. Фашизмын эсрэг үзэл нь төрийн захиргаадальт руу шилжих хандлагын улмаас тэмцлийн гол цөм нь болсон. Өнөөгийн төрийн машин (ба Испани дахь сул ардчилал)-ыг Франкист соёлыг агуулсан гэж Франкогийн цаг үетэй адилтгаж шүүмжилж байв. Улмаар үндсэн хуулийн талаарх зөвшилцөл нурж ардчилсан шилжилтийн хамгийн тохиромжтой хэв маяг гэсэн ойлголтыг дахин нягталж үзэхар үндсэн хуулийн талаарх зөвшилцөл нурж ардчилсан шилжилтийн хамгийн тохиромжтой хэв маяг гэсэн ойлголтыг дахин нягталж лэж байсан уриа лоозон бүх Каталон даяар өргөн абайдал гэх маргаан нь жагсагчдын хувьд ойлгомжтой асуудал байв: Легитим байдал байхгүй нөхцөлд хуулийг сахин биелүүлэх (легалити) нь ардчилал биш ажээ. Нэгдсэн улсыг дэмжигчдийн талаас жагсагчдыг шүүмжилж байсан гол санаа бол тэд Испанийн төрийг фашизмын талаарх улиг болсон ойлголтоор шүүмжилж эсэргүүцэж байна гэж үзэж байв.

---

4 15M хөдөлгөөний талаар мэдээлэл авахыг хүсвэл Castells (2012)-ийн Spanish Indignados тухай бүлгийг үзнэ үү.



Бусад уриа лоозон нь иргэдийг хамгаалахад идэвх зүтгэлтэй, нээлттэй ажилласан гал сөнөөгчдийн талаар байжээ. Тэднийг нэг санал авах байрнаас нөгөөд ирэх бүрт “Els bombers seran sempre nostres” (гал сөнөөгчид үргэлж биднийх байх болно) гэсэн хөгжилтэй уриагаар угтдаг байв. Мөн настай эмэгтэйчүүд өөрсдийгөө хамаатуулж “Sense les àvies no hi ha revolució” (эмээ наргүйгээр хувьсгал хийгддэггүй) хэмээн настай эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдлыг тодотгосон уриа (энэ уриа нь “sense les dones no hi ha revolució”—эмэгтэйчүүдгүйгээр хувьсгал хийгддэггүй хэмээх феминист уриаг дуурайн) хэлж байв.

## Сэтгэл хөдлөлийн гүйцэтгэсэн үүрэг

Бүхий л томоохон хөдөлгөөнүүдийн адилаар сэтгэл хөдлөл нь үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэдийг холбоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Яспер (Jasper, 1998)-ийн онцолсноор сэтгэл зүйн хүчин зүйл нь оролцогчдод урам зориг өгч зорилгоо бодит үйл хэрэг болгоход тусалдаг ажээ. Эсэргүүцлийн жагсаал нь эв нэгдэлт үйлдэл, хэн нэгэнтэй хуваалцах, нэгнээ халамжлах нь чухал гэсэн үзэл санаанд суурилсан. Хүмүүс нэг нэгэндээ ундаа, хоол хүнс санал болгож хоолоо хамтдаа хийж идэцгээн, дуулж хөгжилдөж байв... Тэд анх удаа уулзаж байсан хэдий ч урам зоригтойгоор нэг нэгэнтэйгээ харилцаж байлаа. Жагсагчдын сэтгэлийн хөдөлгөөн нь тэврэлт, инээмсэглэлээр илэрч хамтын аз жаргалын хүчийг харуулж байсан. Шийдвэртэй байдал нь эсэргүүцлийн жагсаал болсон газар бүрт нийтлэг, бусдад нөлөөлдөг хандлага байв. Энэ нь учир шалтгаан тэдний талд байгаа гэх гүн итгэл үнэмшилд суурилсан байсан ба Испанийн төр эрх мэдлээ хадгалж үлдэхийн тулд хүч хэрэглэх, албадлага, хүчирхийллийн хэрэгсэл ашиглах арга замыг сонгосон нь тэдний итгэл үнэмшлийг улам батжуулжээ.

Үүний зэрэгцээ дарангуйлал, харгислалын талаар мэдээ гарах үед эсхүл санал авах байранд цагдаа нар ирж яваа тухай цуу яриа, сэрэмжлүүлэг тарах үед айдас, цөхрөл, тодорхойгүй хурцадмал байдал тэнд мөн бий болж байв. Энэ өдөр маш их сэтгэлийн хөдөлгөөнтэй, нэг талаас хөгжилтэй (хүмүүс санал авах хайрцгийг цагдаагаас нуух эсвэл тэд санал хураалтыг хамгаалж байгаа бус тоглоом тоглож буй мэтээр жүжиглэх зэрэг) нөгөө талаас эмгэнэлтэй (цагдаа нар эсэргүүцлийг нухчин дарах арга хэмжээ авах үед) өдөр байсан. Зовлон зүдгүүр (хүчирхийллээс шалтгаалсан) болон бахархах (санал авах байр ба санал хураалтыг хамгаалж чадсан учир) аль аль мэдрэмж, тэр дундаа нэр төрөө хамгаалсан мэдрэмж холилдсон өдөр байв.

## 10 сарын 3-ны нийтийн ажил хаялт

Эсэргүүцлийн жагсаал нь 10 сарын 3-ны өдрийн нийтийн ажил хаялтаар өндөрлөсөн. Иргэний нийгмийн байгууллагууд ба үйлдвэрчний эвлэлийн холбоодын бий болгосон “Taula per la Democràcia” хөдөлгөөн нь улс орон даяар хэвийн үйл ажиллагааг зогсоож төрийн дарангуйллын эсрэг жагсаалд нэгдэхийг, эрх чөлөө ба үндсэн эрхийн төлөө уриалга гаргасан. Энэ нь 10 сарын 1-ний хүчирхийллийн эсрэг жагсаал байв.<sup>5</sup>

Цаг хугацаа ердийн хэмнэлээ өөрчлөн, улам хурдлах мэт болов. Хүмүүс ямар нэгэн гайхалтай зүйл болж байна, бүх зүйл дахиж хэзээ ч урьдынх шигээ байхгүй гэж ярьж байв. Энэ өдрийг хэн ч мартахгүй болжээ. Түүх бүтээж буй мэдрэмж, их нэр төртэй үйл бүтээсэн мэт сэтгэгдэл хүн бүрт төрж байв. Каталони эрүүл мэндийн газрын мэдэгдсэнээр 1066 хүн цагдаатай сөргөлдсөний улмаас гэмтэж бэртсэн бөгөөд резинэн сумаар (Каталонд хориглосон) буудуулсны улмаас нэг хүүгийн нүд нь хараагүй болсон гэх мэтээр тэдний зарим нь хүнд гэмтэл авчээ. Эрүүл мэндээ хүртэл эрсдэлд оруулан, маш өндөр зардал гаргасан хэдий ч дайчилгаа ба өргөн олны оролцоо нь цаашид өрнөжээ. Өөрсдөд нь цагдаа нар тусгайлан хандахгүй, адилхан бай болгоно гэдгийг мэдэж байсан ч өндөр настай иргэд болон эцэг эхчүүд эрсдэлийг үл харгалзан жагсаалд оролцож байв. Цагдаа нарын харгислалыг харуулсан зураг, дүрс бичлэг тэр өдөр мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээнд түгсэн нь иргэдийн уур хилэнг улам бадраажээ. 10 сарын 3-ны өдөр бүх Каталон даяар төрийн дарангуйллыг эсэргүүцсэн том жагсаалууд өрнөсөн юм. Тэдгээрийн ихэнх нь чимээгүй жагсаал байлаа.

Эсэргүүцлийн хөдөлгөөн 10 сарын 1-ний өдрийн хөдөлгөөнөөс ч илүү олныг хамрав. Ард нийтийн санал асуулга бол зөрчлийг шийдвэрлэх хууль ёсны арга хэрэгсэл гэж хэзээ ч хүлээн зөвшөөрч байгаагүй иргэд хүртэл гудамжинд гарч жагсаал цуглаанд нэгдэцгээж байв. Нийгмийн бараг бүх салбарууд цагдаа нарын харгислал, хүчирхийллийг буруушаасан байдаг. Энэ зуурт Испанийн засгийн газар ард нийтийн санал асуулга явагдсаныг үгүйсгэж, цагдаа нарын үйлдлийг зүй ёсны, хэтрүүлэггүй үйлдэл хэмээн үзэж буйгаа мэдэгдэв. Энэ нь эсэргүүцлийн хөдөлгөөнийг улам бүр томруулж, Испанийн засгийн газрын хүчийг сулруулсан байна.

Ханна Арентд (Hannah Arendt, 1970)-ийн тайлбарласанчлан, эрх мэдэл нь хүчирхийллээс бус, харин хүндэтгэл, легитим байдлаас үүсдэг бөгөөд хэрэв хүч хэрэглэх нь хамгийн сүүлчийн, цорын ганц арга зам болж

---

5 10 сарын 3-ны нийтийн ажил хаялтын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл дараах холбоосыг үзнэ үү: <https://www.elperiodico.com/es/economia/20171002/parode-pais-y-huelga-general-en-catalunya-6327570> ба <https://www.lavanguardia.com/politica/20171003/431755246244/catalunya-prepara-paron-pais.html>.

үлдсэн бол төр эрх мэдлээ алдаж эхэлсний шинж юм. Тиерни (Tierney, 2016, 118) легитим байдлыг зөвшилцөлтэй салшгүй холбоотой гээд “хүмүүсийг зөвхөн тэдний зөвшөөрлөөр удирдаж болно. Эс тэгвээс, шинэ эсхүл хуучин төр аль нь ч ардчилсан улсын үндэс суурь болсон легитим ёсны анхдагч эх үүсвэрийг өөртөө нэгтгэж чадахгүй” хэмээсэн нь бий. Томоохон эсэргүүцлийн жагсаалууд нь тусгаар тогтнолыг дэмжсэн гэхээс илүүтэйгээр Испанийн засгийн газрын захиргаадалт руу шилжих хандлагыг эсэргүүцэн ихэнхдээ хариу үйлдэл үзүүлэх зорилгоор зохион байгуулагдсан байдгийг дурдах нь зүйтэй. Энэхүү дүгнэлтийг Опп ба Рохел (Opp and Rohel, 1990) нар хамтын бүтээлдээ дарангуйлал, шударга бус, зөвтгөж болшгүй нөхцөлд эсэргүүцлийн хөдөлгөөн үүсэх шалтгаан болдог хэмээн оновчтой илэрхийлсэн.

## Дүгнэлт

Каталоны ард нийтийн санал асуулга нь олон нийтийн хөдөлгөөнд үндэслэсэн өргөн олныг хамарсан томоохон жагсаал, иргэдийн үл захирагдах үйлдэл (disobedience) байв. Энэ үйл явдал нь эсэргүүцэл ба өөрийн зохион байгуулалтын хэмжээлшгүй хүчин чадлыг харуулсан. Мөн энэ нь ардчиллыг бэхжүүлэх иргэдийн улс төр дэх шууд оролцоо, оролцооны ардчиллын төлөөх тэмцэл, төрийн захиргаадалтыг эсэргүүцсэн үйл явдал байсан.

Энэхүү үйл явдал нь долоон жилийн хугацаанд үргэлжилсэн салан тусгаарлах хөдөлгөөний хамгийн сүүлчийн чухал үе байв. Өргөн олныг хамарсан, тайван, урт хугацаанд үргэлжилсэн, олон арга хэмжээ, эсэргүүцэл, жагсаалыг хамруулсан, хүчирхийлэл огт агуулаагүй үйл явдал байжээ. Эдгээр хөдөлгөөн нь улс төрийн дээд давхаргыг хөтөлбөр, байр сууриа өөрчлөх болон эрсдэл хүлээхэд хүргэсэн хүч, нөлөөтэй байв (жишээ нь PDeCAT нь Каталаны бүгд найрамдах улсыг тунхагласны дараа тусгаар тогтнол, иргэдийн үл захирагдах байдлыг хүлээн зөвшөөрөх эсхүл сонгогчдын оролцоог хангасан үйл явцыг эхлүүлэхээр ажиллахаа мэдэгдсэн). 10 сарын 1-ний үйл явдал нь ардчилал болон эзэрхэг ёсыг эсэргүүцэх үзлийг тэмцлийн гол зорилго болгосон. Энэхүү зорилго нь Испанийн засгийн газраас хэрэгжүүлсэн дарангуйллын бодлогын улмаас бий болсон бөгөөд тус бодлого нь эсэргүүцлийн хөдөлгөөнийг зогсоохын оронд утга санаа, хамрах хүрээ нь өөрчлөгдөх, ардчиллын төлөөх тэмцлийг дэлгэрүүлэх шалтгаан болсон байдаг.

Үүнээс хойш Испанийн засгийн газар нийгэм, улс төрийн удирдагчдыг хорих, Каталаны өөрийгөө удирдах эрхийг түдгэлзүүлэх зэргээр дарангуйллын бодлогоо үргэлжлүүлсэн. Гэвч “Ард нийтийн санал асуулгыг хамгаалах хороод” огт бууж өгөлгүй, “Бүгд найрамдах улсыг хамгаалах хороо” болон хувирав. 10 сарын 1-ний үйл явдал нь олон Каталончуудын хувьд амьдралынх нь түүхийн нэг хэсэг болсон ба эдгээр

дурсамжийг хуваалцах нь иргэдийн оролцоо болон ирээдүйд зохион байгуулах хөдөлгөөн, жагсаалуудад урам зориг өгөхөд чухал үүрэгтэй болсон. Ард нийтийн санал асуулгын өмнө болсон оролцооны энэхүү хэлбэр нь үргэлжлүүлэн хөгжсөөр байгаа бөгөөд бүгд найрамдах улсыг хамгаалах арга зам болгон ардчиллыг бэхжүүлэх үйл хэрэгт зүтгэж буй иргэдийн сүлжээг бэхжүүлсээр байна.

Каталоны ард нийтийн санал асуулга нь үндэсний хэмжээнд болон Европ дахь үндэстэн улсын тогтолцооны хямрал, төлөөллийн ардчиллын талаарх хурц шүүмжлэл өрнөж буй энэ цаг үед иргэний нийгмийн байгууллагууд ардчиллыг бэхжүүлэхэд хэрхэн оролцож буйг харуулсан ач холбогдолтой жишээ, үйл явдал болсон. Уг үйл явдал нь ардчиллын төлөөх нийгмийн хөдөлгөөнүүдийн туршлагад үндэслэсэн, оролцоо ба зөвлөлдөх аргад суурилсан тул өмнөх хэсэгт дурдсан ардчиллын талаарх неолибериал үзэл санаатай зөрчилддөг. Тиймээс ард нийтийн санал асуулга нь ардчиллыг дахин, шинээр тодорхойлоход ач холбогдолтой байж болох юм. Мөн энэ нь Европ дахь бусад тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөнүүдийг идэвхжүүлэхэд нөлөөлөх боломжтой тул Европын хувьд ач холбогдолтой үйл явдал болсон юм.

Цаашдын судалгаагаар иргэдийн оролцооны эдгээр талбарууд нь хэрхэн ардчилсан шинэтгэлд дэмжлэг үзүүлэх боломжтой болох, мөн тэдгээр нь ардчилсан тогтолцооны хувьсал, ардчиллын чанарт ямар үр нөлөө үзүүлэхийг илрүүлж болох юм. Түүнчлэн, Каталон дахь легитим шинж хоёрдмол байдалд орсон (Испанийн төв засгийн газар ба Каталони бүс нутгийн хууль тогтоох байгууллага хоорондын зөрчил) нь өнөөгийн ардчилсан төрийн байгуулал, эцсийн дүндээ үндэсний болон Европын түвшин дэх ардчилалд сорилт болж байна. Энэхүү зөрчлийг ажиглан, дүн шинжилгээ хийх нь 21 дүгээр зуун дахь ардчиллын хувьсал, түүний сорилт, цаашдын ирээдүйн талаар сонирхолтой ойлголт өгөх болно.

## Ном зүй

Arendt, Hannah. 1970. *On Violence*. New York: Harcourt, Brace & World.

Bauman, Zygmunt. 2012. "Times of Interregnum." *Ethics and Global Politics*, 5 (1): 49–56.

Bauman, Zygmunt and Carlo Bordoni. 2014. *State of Crisis*. Cambridge: Polity.

Catalan Government. 2017. "El Govern trasllada els resultats definitius del referèndum de l'1 d'octubre al Parlament de Catalunya." URL: <https://govern.cat/salaprensa/notes-premsa/303541/govern-trasllada-resultats-definitius-del-referendum-1-octubre-al-parlament-catalunya>.

Castells, Manuel. 2009. *Comunicación y poder*. Madrid: Alianza Editorial.

- Castells, Manuel. 2012. *Networks of Outrage and Hope: Social Movements in the Internet Age*. Cambridge, UK: Polity.
- Deleuze, Gilles and Félix Guattari. 1988. *Mil mesetas. Capitalismo y esquizofrenia*. Valencia: Pre-textos.
- Della Porta, Donatella. 2013. *Can Democracy Be Saved?* Cambridge: Polity Press.
- Della Porta, Donatella, Francis O'Connor, Martin Portos and Anna Subirats Ribas. 2017. "The Streets Will Always Be Ours—Catalonia a Referendum from Below." URL: <https://www.opendemocracy.net/can-europe-make-it/donatella-della-porta-francis-oconnor-martin-portos-anna-subirats-ribas/streets-w> (accessed December 15, 2018).
- Guéhenno, Jean Marie. 1993. *La fin de la démocratie*. Paris: Flammarion.
- Jasper, James. 1998. "The Emotions of Protest: Affective and Reactive Emotions in and around Social Movements." *Sociological Forum*, 13(3): 397–424.
- Keane, John. 2009. *Life and Death of Democracy*. London: Simon & Schuster.
- McAdam, Doug. 2002. "Movimientos 'iniciadores' y 'derivados': procesos de difusión en los ciclos de protesta." In Mark Traugott (ed), *Protesta social*. Barcelona: Hacer.
- Nye, Joseph S. 2013. "The Information Revolution Gets Political." URL: <http://www.project-syndicate.org/commentary/information-technology-s-political-implications-by-joseph-s-nye> (accessed December 15, 2018).
- Offe, Claus. 2011. "Crisis and Innovation of Liberal Democracy: Can Deliberation be Institutionalised?" *Czech Sociological Review*, 47(3): 447–472.
- Opp, Karl-Dieter and Wolfgang Roehl. 1990. "Repression, Micromobilization, and Political Protest." *Social Forces*, 69(2): 521–547.
- Qvortrup, Matt. 2018. "Mob Rule or the Wisdom of the Crowds? Reflections on Referendums and Policy." *Brown Journal of World Affairs*, 24(2): 57–69.
- Rajoy, Mariano. 2017. "'Today democracy has prevailed because the Constitution has been upheld', says Mariano Rajoy," URL: [http://www.lamoncloa.gob.es/lang/en/presidente/news/Paginas/2017/20171001\\_referajoy.aspx](http://www.lamoncloa.gob.es/lang/en/presidente/news/Paginas/2017/20171001_referajoy.aspx) (accessed February 22, 2019).
- Sartori, Giovanni. 1976. *Parties and Party System: A Framework for Analysis*. Cambridge: Cambridge University Press.
- Spanish Constitution. 1978. URL: <http://www.congreso.es/consti/constitucion/indice/index.htm> (accessed February 22, 2019).

- Subirats, Joan. 2013. "¿Nuevos movimientos sociales para una Europa en crisis?" URL: [https://ddd.uab.cat/pub/caplli/2013/192745/futeur\\_gob\\_a2013p67iSPA.pdf](https://ddd.uab.cat/pub/caplli/2013/192745/futeur_gob_a2013p67iSPA.pdf) (accessed December 15, 2018).
- Tierney, Stephen. 2013. "Whose Political Constitution? Citizens and Referendums." *German Law Journal*, 14(12): 2185–2196.
- Tierney, Stephen. 2016. "'Should the People Decide?' Referendums in a Post-Sovereign Age, the Scottish and Catalan Cases." *Netherlands Journal of Legal Philosophy*, 45(2): 99–118.
- Tilly, Charles. 2007. *Contienda política y democracia en Europa, 1650–2000*. Barcelona: Hacer.
- Wainwright, Hilary. 2012. "An Excess of Democracy." URL: <https://www.opendemocracy.net/ourkingdom/hilary-wainwright/excess-of-democracy> (accessed December 15, 2018).
- Wallerstein, Immanuel. 2013. "Uprisings Here, There, and Everywhere." URL: <http://www.iwallerstein.com/uprisings> (accessed December 15, 2018).

---

## Ном бүтээхэд хувь нэмэр оруулагчид

### ***Алдарын Долгион***

Алдарын Долгион нь IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд АНУ-ын Ардчиллын төлөөх үндэсний сангийн (National Endowment for Democracy) Рейган-Фасселийн ардчиллын зочин судлаач. Тэрээр мөн Олон улсын социологийн холбооны “Судалгааны индикаторууд” судалгааны хорооны нарийн бичгийн дарга юм.

### ***Андреа Хэфнер***

Доктор Андреа Хэфнер бол Австралийн Гриффетийн Азийн хүрээлэнгийн багш юм. Андреа нь Герман, Австрали, Зүүн өмнөд Ази даяар эрдэм шинжилгээний байгууллагууд, засгийн газар, олон улсын байгууллагуудтай хамтарч 15 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр мөн Меконг бүс нутагт ажилласан туршлагатай. Түүний судалгааны сэдэв уламжлалт бус аюулгүй байдал буюу байгаль орчны аюулгүй байдал, усны нөөцийн удирдлага болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд зэрэг болно. Сүүлд гаргасан бүтээл нь Меконг, Дунай, Ла Плата голын сав газрууд дахь “Усны нөөцийн талаар яриа хэлэлцээ хийх: Хил дамнасан голын сав газруудыг холбох” тухай байв.

### ***Далайбуяны Бямбажав***

Доктор Далайбуяны Бямбажав нь Монголын Инновацийн бодлогын хүрээлэнгийн захирал бөгөөд Австралийн Квинсландын Их Сургуулийн Уул уурхайн салбар дахь Нийгмийн хариуцлагын төвийн хүндэт эрдэм шинжилгээний ажилтан юм. Тэрээр Хоккайдогийн их сургуульд социологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан.

### ***Дашдэлэгийн Эрдэнэцэцэг***

Дашдэлэгийн Эрдэнэцэцэг нь IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн төслийн менежер бөгөөд Австралийн Брисбэн хотын Квинсландын их сургуулийн Хөгжил судлал, уул уурхайн засаглалын магистрант юм.

### ***Кристиан Сутер***

Кристиан Сутер бол Швейцарийн Невшателийн их сургуулийн Социологийн профессор бөгөөд Швейцарийн Цюрих хотод байдаг Дэлхийн нийгмийн сангийн ерөнхийлөгчөөр ажилладаг. Тэрээр даяаршил, улсын өрийн хямрал, нийгмийн тэгш бус байдал, нийгмийн үзүүлэлтүүд, амьдралын чанар зэрэг сэдвээр бүтээл туурвижээ.

**Майкл Сийберг**

Майкл Сийберг нь Өмнөд Данийн их сургуулийн Улс төрийн шинжлэх ухаан ба төрийн менежментийн тэнхимийн Харьцуулсан улс төрийн хэсгийн туслах профессор юм.

**Матиас Де Роек**

Матиас Де Роек бол Бельгийн Брюссель хот дахь Хааны цэргийн академийн (RMA) докторын дараах шатны судлаач юм. Тэрээр Бельгийн Антверпийн Их сургуулийн Хөгжлийн бодлогын хүрээлэнгийн (IOB) харьяа судлаач юм. Түүний судалгааны үндсэн чиглэл улс төрийн болон цэргийн социологи, дэлхийн системийн шинжилгээ, харьцуулсан ба түүхэн социологи зэрэг юм. Тэрбээр 2019 онд Докторын зэргээ амжилттай хамгаалсан ба энэ бүтээл нь олон улсын систем дэх холимог дэглэмийн талаар байв.

**Нурия Суэро Комеллас**

Нурия Суэро Комеллас нь улс төр судлаач, Барселоны автономит их сургуулийн Улс төр, бодлого, олон улсын харилцааны хөтөлбөрийн профессор юм. Түүний судалгааны сонирхол бол ардчилал, нийгмийн хөдөлгөөн, үндэстэн дамнасан хамтын ажиллагаа, улс дамнасан түвшинд үүсч буй эсэргүүцлийн үйл явдлын улс төрийн үр дагаварын асуудлууд юм.

**Одонхүүгийн Мөнхсайхан**

Одонхүүгийн Мөнхсайхан нь Монгол улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Хууль зүйн профессор юм. Тэрээр Япон улсын Нагоягийн их сургуульд Докторын зэрэг хамгаалсан (2011). Тэрээр “Монгол Улс дахь Үндсэн суурь эрхийг илүү сайн хамгаалахад чиглүүлэх нь: Үндсэн хуулийн тойм ба түүний тайлбар” хэмээх номын зохиолч юм.

**Ойдовын Хатанболд**

Доктор Ойдовын Хатанболд нь Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч бөгөөд ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганы гишүүн. Тэрээр АНУ-ын Төрийн департаментын Эрх зүйн тэггэлэгт судлаач (Legislative Fellowship), Кентаки их сургуулийн Төрийн бодлогын тэнхимт зочин судлаачаар ажиллаж байсан. Тэрбээр харьцуулсан улс төр, ардчилал судлал, монголын ардчилал, ардчилсан засаглалын төлөв байдал, иргэдийн болон залуучуудын улс төрийн идвэх оролцоо, улс төрийн соёлын төлөвшил болон засаглалын үр нөлөөллийн асуудлуудыг судалдаг.



**Ронан Ван Россем**

Ронан Ван Россем нь (Бельгийн) Гентийн Их сургуулийн социологийн профессор, Оролцоо, боломж, бүтцийн судалгааны бүлгийн гишүүн, Улс төр, нийгмийн ухааны факультетийн Эрдэм шинжилгээний судалгааны асуудал эрхэлсэн захирал юм. Тэрээр улс төрийн социологи, дэлхийн тогтолцоо, нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн сүлжээ зэрэг сэдвээр бүтээлээ нийтлүүлж байжээ.

**Самбуугийн Болдсайхан**

Болдсайхан Самбуу бол Японы засгийн газрын тэтгэлгээр суралцсан эрдэмтэн (MEXT) бөгөөд Японы Токио дахь Васеда их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны Докторант юм. Түүний судалгаа нь хөгжиж буй орнуудын байгалийн нөөцийн засаглалын улс төр, клиентелизм буюу ивээн тэтгэх харилцаанаас хамааралтай нийгмийн дэг журам, эдийн засгийн популизм зэрэг асуудалд голчлон чиглэгддэг. Болд нь Вашингтон Пост зэрэг олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд Монголын улс төрийн талаар тогтмол бичдэг. Тэрээр мөн “54 аяга кофе” хэмээх Монголын улс төрийн тухай нэр нөлөө бүхий подкастыг хамтран үүсгэн байгуулагч, хөтөлгөч юм.

**Стивен Броун**

Стивен Броун бол Канадын Оттавагийн их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор юм. Тэрээр гадаадын тусламж, ардчилал, улс төрийн хүчирхийлэл, энх тайвны бүтээн байгуулалтын талаар эрдэм шинжилгээний бүтээлээ өргөн хүрээнд нийтэлж байжээ.

**Стивен Фиш**

Доктор Стивен Фиш бол Беркли дэх Калифорнийн их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны профессор бөгөөд “Индонез: Ховордож буйг үл харгалзан орших ардчилал (Ардчиллын сэтгүүл)” ба “Няцалтын эсрэг тэмцэх нь: Хууль тогтоох хүчтэй байгууллага бол ардчиллыг бэхжүүлэх түлхүүр юм” (Натан Дж.Броун, хэвлэл., Ардчилах үйл явцын динамик: Диктатур, хөгжил ба сарнисан тодорхой бус байдал, Балтимор: Жонс Хопкинсийн их сургуулийн хэвлэл) зэрэг олон тооны нийтлэл болон номын зохиогч юм.

**Увшийн Дэлгэржаргал**

Увшийн Дэлгэржаргал нь Нью Йоркийн Их сургуулийн дэргэдэх Оросын талаарх Дэвшилтэт судалгааны Жордангийн төвийн докторын дараах эрдэм шинжилгээний ажилтан юм. Тэрээр 2020 онд Висконсин-Мэдисоны Их сургуулийн Улс төрийн шинжлэх ухааны тэнхимд докторын зэрэг хамгаалсан. Тэрээр байгалийн баялгаас хамаарах улс төрийн эдийн засаг, институцийн өөрчлөлтийн эх үүсвэр, Зөвлөлт холбоот улсын

дараах улс төрийн асуудлыг өргөнөөр сонирхдог. Дэлгэржаргалын өнгөрсөн туршлага гэвэл тэрээр Үндэсний нисэхийн болон сансрын захиргааны (NASA) Газрын бүрхүүл болон Газар ашиглалтын өөрчлөлтийн хөтөлбөрт Төслийн туслах ажилтан, Ардчилсан орнуудын холбооны Стрейтийн зөвлөлийн эрдэм шинжилгээний ажилтан, Өмнөд Африк дахь Ардчиллын хүрээлэн, Болгарын парламентад судлаач дадлагажигчаар ажиллаж байсан. 2015–2016 онд тэрээр Москва дахь Эдийн засгийн дээд сургуулийн зочин судлаачаар ажиллаж байсан. Дэлгэржаргал нь Нотр Дамийн Их Сургуульд Магистрын зэрэг хамгаалж, Болгар улс дахь Америкийн их сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн.

### ***Чүлтэмсүрэнгийн Тамир***

Доктор Чүлтэмсүрэнгийн Тамир нь Монгол Улсын их сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн эрхлэгч, IRIM Хараат бус судалгааны хүрээлэнгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн юм. Тэрээр Монгол болон Төв Ази дахь ардчилсан хөдөлгөөнүүд, олон нийтийн эсэргүүцэл, засаглал, нийгмийн бодлогын асуудлыг судалдаг.

### ***Элизабет Фокс***

Доктор Элизабет Фокс нь нийгмийн антропологич бөгөөд Монголыг эртнээс сонирхож иржээ. Тэрээр Их Британийн Лондон дахь Их сургуулийн коллежид докторын зэрэг хамгаалсан бөгөөд докторын бүтээл нь Монголын соёл, нийгэм, хэл ярианы олон асуудлыг хамарсан байдаг. Хотын амьжиргаа, ялангуяа Улаанбаатарын гэр хороололд төвлөрсөн түүний бүтээлүүд нь гэр хорооллын иргэдийн ахуй амьдрал, тэдний материаллаг болон нийгмийн дэд бүтцүүд, орон нутгийн хүнд сурталтнуудын гүйцэтгэж буй үүрэг, нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн үр нөлөө зэрэг сэдвийг хөндсөн байдаг.



Энэхүү боть нь өнөөгийн ээдрээтэй цаг үе дэх ардчиллын тэмцлийн олон хэлбэр, шинжийг судалсан. Номын эхний хэсэгт Хүйтэн дайны дараах ардчилагдах үйл явцын хамгийн бага судлагдсан талбар болох Монгол Улс дахь ардчилагдах үйл явцыг судлав. Хоёрдугаар хэсэгт дэлхийн бусад улс оронд өрнөсөн ардчилсан тэмцэл, тэр дундаа олборлох салбараас эдийн засгийн хувьд хамааралтай байдаг Монгол ба бусад орнуудын байгалийн нөөцийн засаглалын асуудлыг онцолсон. Энэхүү номыг бүтээхэд хувь нэмэр оруулагчид нь олон улс орон, салбар, мэргэжлийн үе шатуудыг төлөөлж байгаа билээ. Тэд ардчиллын дутуу судлагдсан асуудлуудыг тодруулахын тулд харилцан бие биенээ нөхсөн олон төрлийн хандлага, арга зүйг ашиглажээ.

Эмхэтгэсэн Кристиан Сүтэр, Стефен Броун,  
Алдарын Долгион, Чүлтэмсүрэнгийн Тамир